



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр, Пүрэв гараг**

|                                                                                                                                                                                                                                                              |                |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>                                                                                                                                                                                                                       | <i>1-2</i>     |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>                                                                                                                                                                                                                            | <i>3-56</i>    |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>                                                                                                                                                                                                                     | <i>57-173</i>  |
| <b>1. Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах</b>                                                                                                                                                                                                         | <b>60-67</b>   |
| <b>2. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>                                                   | <b>67-88</b>   |
| <b>3. “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</b>                                                                                                                   | <b>88-88</b>   |
| <b>4. Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>                                                                            | <b>88-90</b>   |
| <b>5. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 14 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>                         | <b>90-98</b>   |
| <b>6. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>                                                                  | <b>98-102</b>  |
| <b>7. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 14 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ санал хураалт үргэлжлэл</b> | <b>102-111</b> |
| <b>8. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>                             | <b>111-123</b> |
| <b>9. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>                                                              | <b>123-126</b> |
| <b>10. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>                                                                                        | <b>126-146</b> |
| <b>11. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>                                 | <b>146-149</b> |

---

|                                                                                                                                                                                                                |                       |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|
| <b><i>12. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i></b> | <b><i>149-152</i></b> |
| <b><i>13. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i></b>           | <b><i>152-173</i></b> |

---

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
05 дугаар сарын 16-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 14 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ё.Баатарбилэг, Б.Бейсен, С.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Сүхбаатар;*

*Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ш.Раднаасэд;*

*Хоцорсон: Г.Амартүвшин-07 минут, П.Анужин-35 минут, Ж.Батсуурь-47 минут, Х.Болорчулуун-24 минут, Г.Дамдинням-42 минут, Б.Жавхлан-25 минут, М.Оюунчимэг-07 минут, Д.Өнөрболор-41 минут, Ц.Туваан-1 цаг 01 минут, Г.Тэмүүлэн-01 минут, О.Цогтгэрэл-53 минут, Б.Энх-Амгалан-05 минут, Б.Энхбаяр-35 минут.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Б.Пүрэвдорж нарт төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлэв.

*Нэг.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах /Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүд/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.*

**Г.Занданшатар:** 1.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 9  
Бүгд: 50

82.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

2.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 9  
Бүгд: 50

82.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 9  
Бүгд: 50

82.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 9  
Бүгд: 50

82.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40  
Татгалзсан: 10  
Бүгд: 50

80.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 9  
Бүгд: 50

82.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40  
Татгалзсан: 10

Бүгд: 50  
80.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39  
Татгалзсан: 11  
Бүгд: 50  
78.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43  
Татгалзсан: 7  
Бүгд: 50  
86.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 9  
Бүгд: 50  
82.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40  
Татгалзсан: 11  
Бүгд: 51  
78.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43  
Татгалзсан: 9  
Бүгд: 52  
82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

13.Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43  
Татгалзсан: 10  
Бүгд: 53  
82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 9

Бүгд: 52

82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

17.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 9

Бүгд: 52

82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 12

Бүгд: 52

76.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

20.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

21. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

22. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 13

Бүгд: 52

75.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

23. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 12

Бүгд: 52

76.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

24. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 11

Бүгд: 52

78.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

25. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 11

Бүгд: 52

78.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

26. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 11



Бүгд: 52  
78.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

27.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42  
Татгалзсан: 10  
Бүгд: 52  
80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

28.Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43  
Татгалзсан: 9  
Бүгд: 52  
82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

29.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39  
Татгалзсан: 13  
Бүгд: 52  
75.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

30.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 11  
Бүгд: 52  
78.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

31.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43  
Татгалзсан: 9  
Бүгд: 52  
82.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

32.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40  
Татгалзсан: 12  
Бүгд: 52  
76.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

33.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

34.Нийтийн сонголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 12

Бүгд: 52

76.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

35.Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 10

Бүгд: 52

80.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

36.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 11

Бүгд: 53

79.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

37.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 10

Бүгд: 54

81.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

38.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 11

Бүгд: 54

79.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

39.Шинжлэх ухаан, технологийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 9

Бүгд: 54

83.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

40.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 9

Бүгд: 54

83.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

41.Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 9

Бүгд: 54

83.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

42.Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 15

Бүгд: 54

72.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

43.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 11

Бүгд: 54

79.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

44.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 15

Бүгд: 54

72.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

45.Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 10

Бүгд: 54

81.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

46.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 12

Бүгд: 54

77.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

47.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 11

Бүгд: 54

79.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

48.Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 10

Бүгд: 54

81.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

49.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 9

Бүгд: 55

83.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

50.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 8

Бүгд: 56

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

51.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 10

Бүгд: 56

82.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

52.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 11

Бүгд: 56

80.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

53.Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 10

Бүгд: 56

82.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

54.Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 12

Бүгд: 56

78.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

55.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 9

Бүгд: 56

83.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

56.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 14

Бүгд: 56

75.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

57.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 9

Бүгд: 56

83.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

58.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 8

Бүгд: 56

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

59.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 8

Бүгд: 56

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

60.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 10

Бүгд: 56

82.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

61.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 7

Бүгд: 56

87.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

62.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 6

Бүгд: 56

89.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

63.Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 8

Бүгд: 57

86.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

64.Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 8

Бүгд: 57

86.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

65.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 7

Бүгд: 57

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

66.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 14

Бүгд: 57

75.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

67.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 13

Бүгд: 57

77.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

68.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 12

Бүгд: 57

78.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

69.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 8

Бүгд: 57

86.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

70.Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 11

Бүгд: 57

80.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулж дууслаа.

*Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын мэргэжилтэн М.Ганбагана, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга М.Даваатогтох, мөн хэлтсийн албаны дарга Д.Дуламсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Д.Ганбат, Х.Булгантуяа, Д.Өнөрболор, Г.Ганболд, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга М.Даваатогтох, мөн хэлтсийн албаны дарга Д.Дуламсүрэн нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 32 минутаас 11 цаг 54 минутад хуралдааныг даргалав.*

**Г.Занданшатар:** Байнгын хорооноос гаргасан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 24 |
| Татгалзсан: | 19 |
| Бүгд:       | 43 |

65.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 25 |
| Татгалзсан: | 18 |
| Бүгд:       | 43 |

58.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 12 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*



***Гурав. “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, мөн газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга М.Даваатогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 24 |
| Татгалзсан: | 19 |
| Бүгд:       | 43 |

55.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 12 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-г заасны дагуу санал хураалтыг Баасан гарагт явуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 14 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахмад настны хөгжлийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ө.Гэрэлт-Од, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Баярболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, “Юзисан партнерс” хуулийн фирмийн зөвлөх хуульч Н.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрал, М.Оюунчимэг, Н.Учрал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 12 цаг 53 минутаас хуралдааныг даргалав.*

*Уг асуудлын санал хураалтыг 13 цаг 11 минутад түр хойшлуулав.*

***Зургаа.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Л.Алтангэрэл, мөн газрын Дэд дарга Д.Тэмүүлэн, Захиргааны удирдлагын газрын даргын

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Ууганбат, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Ариунаа, Санхүүгийн хэлтсийн дарга Ч.Бат-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 05 минут үргэлжилж, 13 цаг 19 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 29 минутад эхлэв.*

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 23  
Бүгд: 45  
48.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 18  
Бүгд: 44  
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Горимын санал дэжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 19  
Бүгд: 44  
56.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.*

*Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахмад настны хөгжлийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ө.Гэрэлт-Од, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Баярболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, “Юзисан партнерс” хуулийн фирмийн зөвлөх хуульч Н.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

### **Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Б.Жаргалмаа, Ц.Сандаг-Очир /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.1.11 дэх заалтын “дасгал хөдөлгөөн,” гэсний өмнө “зөв хооллолт,” гэж нэмж, тус заалтын “эрүүл мэнд, нийгмийн оролцоог” гэснийг “эрүүл мэндийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 19  
Бүгд: 45  
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.9<sup>1</sup>, 7.2.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.2.9<sup>1</sup> дэх заалтын дугаарыг 7.2.13 дахь заалт болгох:

“7.2.13.ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах, соёл, урлаг, спорт, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, сурч хөгжихөд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах;

7.2.11.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, өрх, сум, тосгоны эмч, эмнэлгийн мэргэжилтэн байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний эрүүл мэнд, ачааллыг үнэлэн ахмад настныг энэ хуулийн 4.1.9-д заасан үйлчилгээнд хамруулах, эсхүл гэр бүлийн бусад гишүүдийн асрамжид шилжүүлэх талаар санал гаргах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 21

Бүгд: 45

53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.12, 7.2.13 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 18

Бүгд: 45

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.8.Энэ хуулийн 7.6-д заасан “Ахмадын өргөө” болон бусад төв төрийн болон орон нутгийн өмчит барилга, байгууламжид байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа бол барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвөөс хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлж болно.” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.1.4, 9.1.5, 9.1.6 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.13 дахь хэсэг болгох:

“9.13.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран дараах чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ:

9.13.1.хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран ахмад настныг боловсролын байгууллагад ажиллуулах;

9.13.2.хөдөлмөрийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран ахмад настныг эрүүл мэндийн байгууллагад ажиллуулах;

9.13.3.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран эрхлэх асуудлын хүрээнд ахмад настныг ажиллуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 17  
Бүгд: 46  
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.1.4 дэх заалт болгох:

“9.1.4.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд ажилласан ахмад настны цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасны дагуу тооцон гэрээний дагуу олгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 22  
Бүгд: 44  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 19  
Бүгд: 44  
56.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Горимын санал дэжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 20  
Бүгд: 44  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.9.Ахмад настан хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллах бол Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасны дагуу тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 19  
Бүгд: 43

55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.11 дэх хэсгийн “өөрөө хүсэлт гаргаагүй” гэсний өмнө “65 насанд хүрээгүй бөгөөд” гэж нэмж, 9.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.11, 9.12 дахь хэсгийн дугаарыг 9.10, 9.11 дэх хэсэг болгох:

“9.12.Аж ахуйн нэгж, байгууллага Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.4-т заасны дагуу ахмад настныг ажлын байраар хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43

55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.10 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 11.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.4.ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг залуу үед хүргэх зэрэг арга хэмжээг ахмадын өдрийн хүрээнд бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд 10 дугаар сарын 01-ээс 07-ны өдрүүдэд зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.6, 13.7, 13.9, 13.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13.5, 13.6, 13.8, 13.9 дэх хэсэг болгох:

“13.5.Нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг нийгмийн хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлнэ.

13.6.Энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зориулан зарцуулах нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна.



13.8.Энэ хуулийн 9.13-д заасан арга хэмжээний зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, боловсрол, эрүүл мэндийн болон холбогдох асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

13.9.Энэ хуулийн 7.1, 8.1.1, 8.1.2, 10.1.2, 10.2-т заасан үйлчилгээг цахимжуулах, давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитоор олгох зорилгоор ахмад настны Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 19  
Бүгд: 44  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.5, 13.10 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 22  
Бүгд: 44  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 21  
Бүгд: 44  
52.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 18  
Бүгд: 44  
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14.9 дэх хэсгийн “ахмадын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал” гэснийг “Ахмадын сан”-ийн үйл ажиллагааны тайлан” гэж, “харьяалагдах дээд байгууллагадаа тайлагнаж, хамт олондоо мэдээлнэ.” гэснийг “байгууллагын нийт ажилтны хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 18  
Бүгд: 44



## 59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14.10, 14.11 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 19

Бүгд: 44

## 56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.5 дахь хэсгийн “үзүүлэх” гэснийг “үзүүлж” гэж, “ахмадын мэдээллийн санг бүрдүүлэн, баяжуулж, дүгнэлт гаргана” гэснийг “хяналт тавина” гэж, 15.8 дахь хэсгийн “15.2, 15.4, 15.7-д заасан гэрээ, хэрэгжүүлэх төсөл” гэснийг “15.2, 15.3-т заасан гэрээ, төсөл” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “дэмжлэг үзүүлэх, оролцох, хяналт тавих, хөдөлмөр эрхлэлтэд” гэснийг хасаж, 15.5, 15.8, 15.9 дэх хэсгийн дугаарыг 15.4, 15.6, 15.7 дахь хэсэг болгох:

“15.7.Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага 50 ба түүнээс дээш ахмад настантай бол ахмадуудтайгаа харилцах үндсэн чиг үүрэгт зөвлөх болон туслах үүрэгтэйгээр ахмад настныг төлөөлсөн нэг хүнийг гэрээгээр ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 18

Бүгд: 45

## 60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.4, 15.7 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 18

Бүгд: 45

## 60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 16.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 19

Бүгд: 45

## 57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “болон ахмад настны өмчлөлийн байр, орон сууц, газар, бусад эд хөрөнгө, тэтгэвэр, мөнгөн хөрөнгийг нь түүний зөвшөөрөлгүйгээр болон айлган сүрдүүлэх, дарамт, шахалт үзүүлэн хүч хэрэглэн авч ашиглах зэргээр” гэснийг “ахмад настны тэтгэвэр, тэтгэмж, Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд заасан хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан,” гэж өөрчилж, “7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7.2.5 заалтын “үйл ажиллагааг” гэсний өмнө “болон ахмад настны сайн дурын” гэж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 18  
Бүгд: 45  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Энэ хуулийн 4.1.7-4.1.9, 4.1.11, 7.1-д заасан үйл ажиллагааны журмыг дараах байдлаар баталж, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ.

7.3.1.энэ хуулийн 4.1.7-4.1.9, 4.1.11-д заасан үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ үзүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлэх;

7.3.2.энэ хуулийн 7.1.6, 7.1.12-т заасан үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн, эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

7.3.3.энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага 7.3.1-д заасан сонгон шалгаруулах журмын дагуу гэрээний үндсэн дээр иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 18  
Бүгд: 45  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг үзүүлэх зорилгоор нутгийн захиргааны байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага аймаг, дүүрэг, сум, тосгон, хороонд “Ахмадын өргөө”, сэргээн засах, идэвхтэй насжилтыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулах төвийг байгуулан ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 18  
Бүгд: 45  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 8.1.1 дэх заалтын “эрүүл мэндийн даатгалын сангаас олгох” гэснийг “нийгмийн халамжийн сангаас олгох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 20  
Бүгд: 45

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 15.1, 15.2 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 19

Бүгд: 45

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “үйлчилгээ, дэмжлэг хүндэтгэлийн хэмжээ” гэснийг “Хоёрдугаар бүлэгт заасан ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хүндэтгэлийн хэмжээ” гэж, “дэмжлэгийн хэмжээ” гэснийг “8, 10-12 дугаар зүйлд заасан ахмад настанд үзүүлэх дэмжлэгийн хэмжээ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 23

Бүгд: 45

48.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 18

Бүгд: 45

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 17

Бүгд: 45

62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлээс “13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “7.1-д заасан үйлчилгээ”” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн “тус тус” гэсний өмнө “, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “7.1-д заасан үйлчилгээ” гэснийг “7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээг нийгмийн халамжийн сан болон орон нутгийн төсвөөс” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 20

Бүгд: 45

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**Найруулгын санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.9 дэх заалтын “иргэн” гэсний өмнө “төрийн байгууллага” гэж нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.8 дахь заалтын “цогцоор” гэснийг “цогц үйлчилгээ” гэж, 4.1.9 дэх заалтын “өдрөөр, түр, урт хугацаанд байрлуулан асрах, байнга асрах төрөлжсөн асрамжийн, асралт гэр бүлээр асруулах, гэрээр асрах зэрэг бусад шаардлагатай үйлчилгээг” гэснийг “ахмад настныг төрөлжсөн асрамжийн, гэрээр, асралт гэр бүлээр, өдрөөр, түр, урт хугацаагаар, байнга асрах үйлчилгээг” гэж, 4.1.11 дэх заалтын “онол, арга зүй, мэргэшлийн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх” гэснийг “мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.14 дэх заалтын “зарим” гэснийг “шаардлагатай” гэж, 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.8 дахь хэсгийн “зээлийн зардлыг оруулахгүйгээр” гэснийг “зээлийн хэмжээг тооцохгүйгээр” гэж, 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.3 дахь хэсгийн “хэсэгчлэн болон бүрэн” гэснийг “хэсэгчлэн, эсхүл бүрэн” гэж, 2 дугаар зүйлийн “төсвийн байгууллага, тухайн жилийн төсвийн зардалдаа тусган” гэснийг “төсвийн байгууллага, тухайн жилийн төсөвт тусган” гэж, 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 8.1.6 дахь заалтын “үнэ төлбөргүй зорчих” гэснийг “ахмад настны нийтийн тээврээр зорчсон” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.9 дэх заалтын “төрийн бус” гэсний өмнөх “төрийн болон” гэснийг, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын “орох бөгөөд үнэлгээг хийхдээ ахмад настанд чирэгдэлгүй байхыг анхааран” гэснийг, 2 дугаар зүйлийн “хөнгөлөлтийн” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 21

Бүгд: 45

52.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**1.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19.12 дахь хэсгийн “хэмжээ,” гэсний өмнө “хэлбэр,” гэж нэмж, 19.14 дэх хэсгийн “19.11-д заасны дагуу ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулж байгаа” гэснийг “9.1.1-д заасан үйлчилгээг ахмад настанд үзүүлж байгаа” гэж, “хувийн хэвшил, төрийн бус байгууллагад” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагад” гэж, “заасан нормативын дагуу” гэснийг “заасны дагуу” гэж, “тооцох бөгөөд” гэснийг “тооцох” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 20

Бүгд: 44

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19.15 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 20  
Бүгд: 44  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19.11 дэх хэсгийг “хувийн хэвшил, төрийн бус байгууллагад” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 21  
Бүгд: 44  
52.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 15.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.16.нийгмийн халамжийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний үйл ажиллагааны зардал;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 19  
Бүгд: 44  
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 15.1.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.17.асрамж, халамжийн байгууллага үйл ажиллагаагаа явуулах байрыг шинээр барих, тохижуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх зорилгоор үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, хандив.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 17  
Бүгд: 44  
61.4 хувийн саналаар дэмжигдлээ

### **3.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 18  
Бүгд: 44  
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **4.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 16.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.8.“Ахмадын сан” байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 18  
Бүгд: 44  
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 76.1.19 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 18  
Бүгд: 44  
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **5.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 17  
Бүгд: 44  
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **6.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 16.1<sup>1</sup> дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.21 дэх хэсэг болгох:

“16.21.Энэ хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-д заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын дэргэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Эмнэлэг хяналтын комисс ажиллуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 17  
Бүгд: 44  
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16.1<sup>2</sup> хэсгийн “дүрэм” гэснийг, “ажиллах журам” гэж, “16.1<sup>2</sup>” дугаарыг, “16.22.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 17  
Бүгд: 44  
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

### **7.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “1.2<sup>1</sup>” дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 18  
Бүгд: 44  
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3. дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.тэтгэвэр, тэтгэмж, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 20  
Бүгд: 44  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

### **8.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.3<sup>1</sup> дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.4 дахь заалт болгох:

“4.4.Ахмад настны тэтгэвэр, тэтгэмжээ ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 19  
Бүгд: 45  
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**9.Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 35.2.6 дахь заалтын “түр байрлуулах, түр хоноглох зэрэг газар байрлаж байсан” гэснийг, “түр байрлуулах газарт байсан,” гэж, “бөгөөд” гэснийг “тохиолдолд” гэж, “садан” гэснийг, “садангийн хүн” гэж тус тус өөрчилж, тус заалтын “гэнэмэл амьдралтай” гэснийг, “иргэн нас барсан” гэснийг өмнөх “ганц бие” гэснийг, “түүний” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 18  
Бүгд: 45  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 35.2.7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 18  
Бүгд: 45  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 19  
Бүгд: 44  
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Хяналт шалгалтын газрын захирал Ц.Нарандалай, Зөвшөөрлийн албаны дарга Ш.Хандсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын



хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 26 минутаас 15 цаг 32 минутад хуралдааныг даргалав.*

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Б.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 19  
Бүгд: 40

52.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

***Найм.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Д.Баасандамба, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Х.Лхагвасүрэн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа хариулж, тайлбар хийв.

*Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 19  
Татгалзсан: 20  
Бүгд: 39  
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 19  
Бүгд: 40  
52.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 19  
Бүгд: 40  
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.*

**Ес. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Төгөлдөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Цэвэгдорж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Нийслэлийн Засаг даргын орлогч П.Сайнзориг, Сангийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Б.Баттөмөр, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Ш.Адъяаа, Д.Батлут, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар нарын тавьсан асуултад Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.*

*Арав.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Захиргааны удирдлагын газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга Б.Эрдэнэдалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

#### **Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 7.1.22 дахь заалтын “урамшууллыг” гэсний өмнө “мөнгөн” гэж, 2 дахь заалт буюу 8.1.11 дэх заалтын “дарамт шахалт” гэсний дараа “үзүүлэх” гэж тус тус нэмж, мөн заалтын “гадуурхалтаас ангид байх” гэснийг “гадуурхах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 22 |
| Татгалзсан: | 17 |
| Бүгд:       | 39 |

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

**“2 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “нисэх бүрэлдэхүүн,” гэсний дараа “алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар,” гэж нэмсүгэй.”** гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 25 |
| Татгалзсан: | 15 |
| Бүгд:       | 40 |

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.3 дахь заалтын “...хилийн отряд, застав болон...” гэснийг “алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар болон хилийн цэргийн анги,” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.*

*Арван нэг.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Захиргааны удирдлагын газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга Б.Эрдэнэдалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3.“цэргийн болон цагдаагийн баг” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон бүтэц, орон тооны дагуу бие бүрэлдэхүүн болон зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгслээр хангагдсан, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нэгжийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх- Амгалангийн амгалангийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “тохиролцсоны дагуу” гэснийг “тохиролцож, саналыг бичгээр авсаны дагуу” гэж өөрчилж, төслийн “4.5.Энэ хуулийн 4.4-т заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан тухайн цэргийн алба хаагчид мэдэгдэж, саналыг бичгээр авна.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 18  
Бүгд: 40  
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “бусад” гэснийг хасаж, 5.3.5 дахь заалтын “хууль тогтоомж, зан заншлыг хүндэтгэн дагаж мөрдөх” гэснийг “хууль тогтоомжийг мөрдөх, зан заншил” гэж, 5.3.6 дахь заалтын “үүрэг гүйцэтгэлтийн онцлогт нийцсэн” гэснийг “үүрэг гүйцэтгэх үеийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15

Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “төсөвт тусган, цэрэг, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах” гэснийг “төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “Монгол Улсаас оролцох боломжтой энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэл, тусламж, дэмжлэгийн” гэснийг, мөн 8.1.2 дахь заалтын “Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаа, энэ талаархи сургалт, бэлтгэлд оролцуулах болон хангалт, үйлчилгээтэй холбогдсон” гэснийг тус тус “энхийг дэмжих ажиллагаатай холбоотой” гэж өөрчилж, 8.1.3 дахь заалтын “энхийг дэмжих” гэсний өмнө “гадаад улсад” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “эгүүлэн татах” гэснийг “эгүүлэн татах ажлыг зохион байгуулах” гэж, 10.1.6 дахь заалтын “оролцуулах цагдаагийн баг, бие бүрэлдэхүүнийг” гэснийг “оролцох цагдаагийн алба хаагч, багийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 17  
Бүгд: 40  
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.1.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагч, багийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 17  
Бүгд: 40  
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн байгуулагдсан олон үндэстний цэргийн хүчний командлал” гэснийг “томилогдсон олон үндэстний цэргийн хүчний командлагч” гэж өөрчилж, 14.8



дахь хэсгийн “аливаа улстай байгуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 18  
Бүгд: 40  
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “хаагчийг” гэснийг “хаагчдыг” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “цэрэг, цагдаагийн” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч,” гэж, 5.5 дахь хэсгийн “алба хаагч болон цэрэг, цагдаагийн баг” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч, баг” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “амь насаа алдсан” гэснийг “нас барсан” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “алба хаагч, цэргийн” гэснийг “цэргийн алба хаагч,” гэж, 9.1.5 дахь заалтын “байдлыг” гэснийг “талаар” гэж, 9.1.11 дэх заалтын, мөн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтын “бие бүрэлдэхүүний” гэснийг “алба хаагчийн” гэж тус тус, 9.1.6, 9.1.9 дэх заалтын, 10.1.4 дэх заалтын “7.1.7-д” гэснийг “7.1.6-д” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Батлан хамгаалахын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын” гэснийг “батлан хамгаалахын болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэж тус тус өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын, мөн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “эсхүл” гэснийг хасах.

2.Төслийн “цэрэг, цагдаагийн алба хаагч” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч” гэж, “цэрэг, цагдаагийн баг” гэснийг “цэргийн болон цагдаагийн баг” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.



### **1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

**“1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.3.26 дахь заалт нэмсүгэй.

“5.3.26.Цагдаагийн хөгжлийн сан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 24 |
| Татгалзсан: | 16 |
| Бүгд:       | 40 |

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **2.Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “эрүүл мэнд” гэснийг “чөлөөлөгдсөн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 24 |
| Татгалзсан: | 16 |
| Бүгд:       | 40 |

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван хоёр.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, мөн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, мөн газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Энхсайхан, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Эм, биобэлдмэлийн хяналт хариуцсан

гаалийн улсын байцаагч М.Пүрэвсүрэн, “Эрүүл мэнд реформ” Төрийн бус байгууллагын гишүүн М.Халиунаа, Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн “Эм” холбооны гүйцэтгэх захирал И.Балжинням, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Анужин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа нар хариулж, тайлбар хийв.

*Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10.г дэд заалтыг, мөн зүйлийн 4.1.18 дахь заалтын “, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн” гэснийг хасаж, 4.1.27 дахь заалтын “иргэн,” гэсний дараа “гадаад, дотоодын” гэж нэмж, мөн зүйлийн 4.1.14 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэл” гэж, 4.1.17 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэлтэй” гэж, 4.1.32 дахь заалтын “, бэлтгэх арга, зааврыг тодорхойлон” гэснийг “хэрэглэх аргыг заан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 18 |
| Татгалзсан: | 23 |
| Бүгд:       | 41 |

43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 21 |
| Татгалзсан: | 22 |
| Бүгд:       | 43 |

48.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 17  
Бүгд: 40  
57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Горимын санал дэжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 16  
Бүгд: 39  
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.2 дахь хэсгийг хасах:

“6.1.1.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл;

6.1.2.эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Энх-Амгалан, С.Чинзориг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 18  
Бүгд: 40  
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналыг хуралдааны даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хамт тухайн” гэснийг “хуулийн этгээд” гэж, мөн хэсгийн “нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоно” гэснийг “нийлүүлж болно” гэж, 7.2.1, 7.2.2 дахь заалтын “сан бүхий энэ хуулийн 6.1.3-т заасан худалдах” гэснийг “сангийн” гэж, мөн заалтын “дүүргийн эмийн сангүй” гэснийг “сангийн хүрэлцээгүй” гэж, 7.5.1, 7.5.2, 7.5.3, 7.5.4 дэх заалтын “олгох, сунгахад” гэснийг “олгоход” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3.1-д,” гэснийг, 7.13 дахь хэсгийн “хууль эрх зүйн хүрээнд” гэснийг тус тус хасаж, 7.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүнээ” гэсний дараа “түүхий эдээ” гэж, 7.11 дэх хэсгийн “саналаар” гэсний дараа “хуралдааны шийдвэр” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.16 дахь хэсэг нэмэх:

“7.16.Энэ хуулийн 7.5.1, 7.5.3, 7.5.4, 19.1, 29.2.4-т заасан зохистой дадлын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн саналыг хуралдааны даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авсан” гэснийг “бүртгүүлсэн” гэж, 8.2.4 дэх заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж, мөн заалтын “худалдах” гэснийг “ханган нийлүүлэх” гэж тус тус өөрчилж, 8.1.6 дахь заалтын “улсын бүртгэл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 19  
Бүгд: 41  
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 18 цаг 47 минутаас хуралдааныг даргалав.*

**Л.Мөнхбаатар:** 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 9.4.6 дахь заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж, мөн заалтын “худалдах” гэснийг “ханган нийлүүлэх” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 21  
Бүгд: 41  
48.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19  
Татгалзсан: 20  
Бүгд: 39  
48.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 16  
Бүгд: 39  
59.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Горимын санал дэжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “эмнэлгийн” гэснийг “эрүүл мэндийн байгууллагын” гэж, 10.4 дэх хэсгийн “жоргүй олгох эмийг цахимаар болон утсаар авсан” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээс бусад эмийг цахим жор болон” гэж, 10.8.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 10.8.10 дахь заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “болон сумын эрүүл мэндийн төв” гэснийг, 10.8.1 дэх заалтын “улсын бүртгэлд бүртгэгдээгүй” гэснийг, 10.8.4 дэх заалтын “, үйлчлэх” гэснийг, 10.8.9 дэх заалтын “хаяг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 18

Бүгд: 38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “байгуулах,” гэсний дараа “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 11.1.7 дахь заалт нэмэх:

“11.1.7.эм, эмнэлгийн хэрэгслийн цувралын дугаар, стандарт код, тоо хэмжээг тухай бүр цахим санд оруулсан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 19

Бүгд: 38

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16

Бүгд: 38

57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Горимын санал дэжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 16  
Бүгд: 38  
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад энэ хуулийн 8-11 дүгээр зүйлд заасан үүрэг, шаардлага, Эрүүл мэндийн тухай хуулийн 19.17-д заасан нөхцөлийг хангасан эсэх талаарх дүгнэлтийг үндэслэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг үг хэлэв.

Дээрх саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “Эм, эмийн үйлчлэгч бодисыг бүртгэх” гэж, 15.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 15.2 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, мөн зүйлийн 15.2.2 дахь заалтын “зөвшөөрөл олгох” гэснийг “бүртгэл” гэж, 15.3 дахь хэсгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөл олгоход” гэснийг “Эм, эмийн үйлчлэгч бодисыг бүртгэхэд” гэж, 15.3.2 дахь заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 15.5 дахь хэсгийн, 15.5.4 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “эм, эмийн үйлчлэгч бодисын бүртгэлийг” гэж тус тус өөрчилж, 15.4 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 16  
Бүгд: 38  
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан” гэж, 16.9 дэх хэсгийн “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэж бүртгэсэн” гэж, 16.10 дахь хэсгийн “энэ хуулийн 16.9-д зааснаар” гэснийг “түргэвчилсэн байдлаар” гэж, 16.11, 16.12 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж тус тус өөрчилж, 16.11 дэх хэсгийн “импортын” гэсний өмнө “Энэ хуулийн 16.10-д зааснаас бусад” гэж нэмж, мөн зүйлийн 16.15 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 15  
Бүгд: 39  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авахад шаардагдах бүтээгдэхүүний” гэснийг “бүртгэлийн” гэж,

17.1.6 дахь заалтын “онцгой” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн ноцтой” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн гарчгийн, 18.1, 18.2 дахь хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, 18.1 дэх хэсгийн “Шинэ эм” гэснийг “Эм” гэж, 18.3 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, мөн хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан” гэж, 18.4 дэх хэсгийн “зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 18.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн” гэсний дараа “байгууллага, эсхүл гадаад улсын эрх бүхий” гэж, 18.3 дахь хэсгийн “баримт бичиг,” гэсний дараа “Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, эсхүл гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “лабораторийн зохистой дадлын стандарт хангасан” гэж, 19.2 дахь хэсгийн “лаборатори” гэсний дараа “итгэмжлэгдсэн байх бөгөөд” гэж, 19.4 дэх хэсгийн “Ерөнхий” гэсний өмнө “Дотоод болон гадаадын” гэж тус тус нэмж, 19.5 дахь хэсгийн “шинэ эм, уламжлалт” гэснийг “анхдагч” гэж өөрчилж, мөн зүйлийн 19.10 дахь хэсгийн “ эсхүл иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлын дагуу яаралтай шинжлэх дээж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, 20.12 дахь хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 20.9 дэх хэсгийн “вакцин,” гэсний дараа “биобэлдмэл” гэж, 20.12 дахь хэсгийн “тандалт” гэсний дараа “судалгаа” гэж тус тус нэмж, 20.11 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “үйлдвэрлэгч, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл



эзэмшигч” гэснийг “улсын төсвөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 18  
Бүгд: 39  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “дархлаажуулалтын дараах” гэснийг хасаж, 21.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 30.1-д заасан” гэснийг “Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн,” гэж, 21.4 дэх хэсгийн “нөлөөг нягтлан дүгнэлт гаргаж, эмийн гаж нөлөөний талаар” гэснийг “нөлөөний үнэлгээг холбогдох зөвлөлийн шийдвэрээр баталгаажуулан,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 17  
Бүгд: 39  
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн гарчгийн, 22.2, 22.8 дахь хэсгийн “Шинэ” гэснийг “Анхдагч” гэж, мөн зүйлийн 22.4.5 дахь заалтын “биошингэц” гэснийг “биохүрэхүй” гэж, 22.6 дахь хэсгийн “биошингэцийг” гэснийг “биохүрэхүйг” гэж, 22.7.4 дэх заалтын “үйлчлэлийг” гэснийг “үйлдлийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 17  
Бүгд: 39  
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 16  
Бүгд: 39  
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “хэвлэлээр” гэснийг “хэвлэл, албаны ёсны цахим хуудсаар” гэж өөрчилж, 26.5.5 дахь заалтын “чухал, цорын ганц, маш өндөр идэвхтэй,” гэснийг, мөн заалтын “хамгийн сайн,” гэснийг тус тус хасаж, 26.5.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.5.10.эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг өвчнийг оношлох, эмчлэх үйлдэлтэй гэж олон нийтийг төөрөгдөлд оруулсан байдлаар сурталчлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 16  
Бүгд: 39



59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.4.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.4.4 дэх заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.4.6 дахь заалт нэмэх:

“29.4.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид бага насны хүүхдийн эмийг олгохдоо онцгойлон анхаарч эмийн зохистой хэрэглээний талаарх мэдээлэл өгөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн гарчгийн “хэрэгсэл зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “хэрэгслийн бүртгэл” гэж, 33.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 33.2 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг энэ хуулийн 15.3.1, 15.3.7 дахь заалт болон үйлдвэрлэгч улсдаа зах зээлд гаргасныг харгалзан үзэж,” гэж, 33.6 дахь хэсгийн “лабораторийн” гэснийг “лаборатори, эсхүл төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн үндэсний итгэмжлэгдсэн лавлагаа лабораторийн” гэж, 33.7 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийн” гэснийг “улсын бүртгэлийн” гэж, 33.9 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, 33.9.4 дэх заалтын “маш бага” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-д заасан байгууллагад хэрэглэгдэх” гэж, 33.9.6 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авахад шаардагдах бүтээгдэхүүний” гэснийг “бүртгэлийн” гэж, 33.9.9 дэх заалтын “хэрэглэгдэхүүн, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж” гэснийг “хэрэгсэл” гэж тус тус өөрчилж, 33.4 дэх хэсгийг, 33.9.5 дахь заалтын “эмнэлзүйн” гэснийг тус тус хасаж, 33.5 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “өндөр, дунд эрсдэлтэй” гэж, 33.9.4 дэх заалтын “оношилгооны” гэсний дараа “өвөрмөц” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.9 дэх хэсэг нэмэх:

“33.9.Өндөр, дунд эрсдэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, загвар, эсхүл бүтээгдэхүүний дугаар тус бүрээр нь жагсаалтад оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “сөрөг нөлөө,” гэсний дараа “аюулгүй байдал,” гэж нэмж, 35.5 дахь хэсгийн “зах зээлд гаргах

зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19  
Татгалзсан: 20  
Бүгд: 39  
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 19  
Бүгд: 39  
51.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 16  
Бүгд: 39  
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “, эсхүл Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-д заасан байгууллага” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 17  
Бүгд: 39  
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.4 дэх заалтын “серийн” гэснийг ”цуврал, эсхүл бүтээгдэхүүний” гэж, 38.4 дэх хэсгийн “сав, баглаа боодол дээрх” гэснийг “гадна талд байрлах” гэж, 38.5.3 дахь заалтын “техникийн үзүүлэлт” гэснийг “загварын нэр” гэж, 38.8 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 38.4.5 дахь заалтын “, сар, өдөр” гэснийг, 38.5.4, 38.5.7, 38.5.8, 38.5.9, 38.5.10 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 38.6 дахь хэсэг нэмэх:

“38.6.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэрэглэгчийн гарын авлага монгол, эсхүл англи хэлээр байх бөгөөд дараах мэдээллийг агуулна:

38.6.1.бүтээгдэхүүний нэр;  
38.6.2.үйлдвэрлэгчийн нэр;  
38.6.3.загварын нэр;  
38.6.4.техникийн үзүүлэлт;

- 38.6.5.ашиглалтын заавар;
- 38.6.6.хадгалах болон тээвэрлэх нөхцөл;
- 38.6.7.ашиглалтын нөхцөл;
- 38.6.8.аюулгүй ажиллагаа;
- 38.6.9.суурилуулалт хийх зааварчилгаа;
- 38.6.10.засвар үйлчилгээ хийх зааварчилгаа;
- 38.6.11.холбоо барих үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага;
- 38.6.12.ариутгал, халдваргүйжүүлэлтийн нөхцөл;” гэсэн саналыг дэмжье

гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

Зөвшөөрсөн: 18  
Татгалзсан: 21  
Бүгд: 39  
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 19  
Бүгд: 39  
51.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 18  
Бүгд: 39  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “хэвлэлээр” гэснийг “хэвлэл, албан ёсны цахим хуудсаар” гэж, 39.5.4 дэх заалтын “чухал, цорын ганц, маш өндөр үйлчилгээтэй,” мөн заалтын “хамгийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 17  
Бүгд: 39  
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “бусад байгууллага” гэсний дараа “үндсэн, эсхүл гэрээт” гэж, 40.1.4 дэх заалтын “төхөөрөмжийн” гэсний дараа “хэрэглэгчийн гарын авлагад үндэслэн” гэж тус тус нэмж, 40.7 дахь хэсгийн “хэсгээс” гэснийг “хэсэгт заасан баталгаат хугацаанаас” гэж өөрчилж, 40.1.4 дэх заалтын

“эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” гэснийг, 40.2 дахь хэсгийн “болон лабораторийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 17  
Бүгд: 39  
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “, бүртгэлд өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг үг хэлэв.

Дээрх саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй эм,” гэснийг “бүртгэлгүй эм, өндөр, дунд эрсдэлтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 43.3.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл,” гэснийг хасаж, 43.8 дахь хэсгийн “байгууллагын” гэсний дараа “эмийн асуудал хариуцсан улсын байцаагч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 16  
Бүгд: 39  
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1.1, 44.1.2, 44.1.3 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 44.4.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрлийн гэрчилгээ” гэснийг “бүртгэлийн дугаар” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 44.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“44.7.Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд бүртгэлгүй эм, эмнэлгийн хэрэгслийг импортлоход Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага импортын мэдүүлэг олгоно:

44.7.1.гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн;

44.7.2.эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсэж орлуулан хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл байхгүйгээс эмнэлгийн тусламж, үйлчилгээнд доголдол үүссэн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 16  
Бүгд: 39  
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.3, 46.9, 46.10 дахь хэсгийн “тусламж, төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 46.10.1 дэх заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 46.10.6 дахь заалтын “эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэснийг “эмийг” гэж, 46.14.2 дахь заалтын “зах зээлд гаргах

зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж тус тус өөрчилж, 46.11 дэх хэсгийн “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасаж, мөн хэсгийн “40.10.6” гэсний дараа “46.10.7” гэж нэмж, 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зориулан эм, эмнэлгийн хэрэгслийг хандив, тусламж хүлээн авахдаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, гадаад, дотоодын хуулийн этгээдээс хандив, тусламж хүлээн авахдаа эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19  
Татгалзсан: 20  
Бүгд: 39  
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 16  
Бүгд: 39  
59.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.1.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох,” гэснийг “бүртгэх” гэж, 50.1.7 дахь заалтын “өөрчлөх” гэснийг “нэмэлт оруулах” гэж, 50.1.10 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “бүртгэл, үйлдвэрлэлийн зохистой дадал” гэж, 50.1.12 дахь заалтын “эм, зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 50.1.17 дахь заалтын “жигжиг хэрэгслийн” гэснийг “хэрэглэгдэхүүний” гэж, 50.2 дахь хэсгийн “Зах зээлд гарах зөвшөөрөлгүй” гэснийг “Бүртгэлгүй” гэж тус тус өөрчилж, 50.1.4, 50.1.6 дахь заалтын “өөрчлөх” гэснийг хасаж, 50.1.22 дахь заалтын “үйлдвэрлэхээс” гэсний дараа “хэрэглэх” гэж, 50.1.24 дэх заалтын “байгууллагаар” гэсний дараа “гэрээний үндсэн дээр” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, С.Чинзориг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 18  
Бүгд: 38  
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “дүрэм, гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргах” гэснийг, 51.4 дэх хэсгийн

“иргэний төлөөлөл, эрүүл мэндийн салбарын тэргүүлэх мэргэжилтнээс” гэснийг, 51.5 дахь хэсгийн “, магистраас дээш зэрэгтэй” гэснийг, 51.13 дахь хэсгийн “үндэсний” гэснийг, 51.14.4 дэх заалтын “үйлдвэрлэх” гэснийг, мөн зүйлийн 51.14.5 дахь заалтыг, 51.15.3 дахь заалтын “, эмнэлгийн хэрэгслийн нөхцөлт зөвшөөрөл олгох” гэснийг, 51.15.4 дэх заалтын “эмнэлзүйн” гэснийг, 51.16.3 дахь заалтыг, 51.18.1 дэх заалтын “, үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон” гэснийг, 51.18.3 дахь заалтын “бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө” гэснийг тус тус хасаж, 51.4 дэх хэсгийн “захиргааны байгууллага,” гэсний дараа “эрүүл мэндийн байгууллага,” гэж, мөн хэсгийн “сургуулийн” гэсний дараа “төлөөллөөс” гэж, 51.9 дэх хэсгийн “дарга,” гэсний дараа “нарийн бичгийн даргыг шууд,” гэж, 51.18 дахь хэсгийн “хэрэгслийн зөвлөл,” гэсний дараа “түүний салбар зөвлөлийн” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 51.14.3 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох” гэснийг “бүртгэх” гэж, 51.15.5 дахь заалтын “хөрөнгө оруулалтын асуудлаар шийдвэр” гэснийг “асуудлаар төлөвлөлтийн санал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 17  
Бүгд: 38

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 57 дугаар зүйлийн 57.1.3 дахь заалтын “зах зээлд гарах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй,” гэж, 57.1.5 дахь заалтын “итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтэд” гэснийг “үр дүнд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 18  
Бүгд: 38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

#### **“60 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

60.1.Энэ хуулийн 8.1.2, 15.3.2-т заасан стандартыг дотоодын уламжлалт эмийн үйлдвэр 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

60.2.Энэ хуулийн 16.14 дэх хэсэгт заасныг үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч дотоодын үйлдвэрлэгч 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ.

60.3.Энэ хуулийн 16.10 дахь хэсэгт заасан өнчин эмийн бүртгэлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хийнэ.

60.4.Энэ хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19  
Татгалзсан: 19  
Бүгд: 38

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 19 |
| Татгалзсан: | 19 |
| Бүгд:       | 38 |

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 20 |
| Татгалзсан: | 18 |
| Бүгд:       | 38 |

52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 19 |
| Татгалзсан: | 19 |
| Бүгд:       | 38 |

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 22 |
| Татгалзсан: | 17 |
| Бүгд:       | 39 |

56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 21 |
| Татгалзсан: | 17 |
| Бүгд:       | 38 |

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “, холбогдох баримт бичиг, түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт” гэснийг хасах гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.1.Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг сонгохдоо дараах зарчмын баримтална:

47.1.1.эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг, эсхүл эмийн зардалд өндөр хувь эзэлж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.2.тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай, тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.3.төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийг болон хөнгөвчлөх эмчилгээний эм.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Б.Пүрэвдорж, Ш.Адьяа, С.Чинзориг нар үг хэлэв.

*Уг асуудлыг 20 цаг 00 минутад түр хойшлуулав.*

***Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсох***

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /20:00/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 12 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 37 минут үргэлжилж, 72 гишүүнээс 62 гишүүн хүрэлцэн ирж, 86.1 хувийн ирцтэйгээр 20 цаг 01 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**  
2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 14 минут

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданишатар:** Амгаланг айлтгая. Айлтгамуй за. Хуралдааны ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 69 төсөл байна. 69 хуулийг эцэслэн батална.

2 дугаарт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

3 дугаарт “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн цалин тушаа албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

4.Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл

5.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /хэлэлцэх эсэх/

6 дугаарт Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

7 дугаарт Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

8 дугаарт Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

9 дүгээрт Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

10 дугаарт Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

11-д Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төсөл

12. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

13.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

14.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

15 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

16.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

17.Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг

18. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

19. Мал, амьтны эм тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу үг хэлэхээр саналаа ирүүлсэн гишүүдийг танилц танилцуулъя. Ховд аймгаас сонгогдсон 2 гишүүн байна. Эхлээд Сандагийн Бямбацогт гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллын өөрчлөлттэй холбогдуулж үг хэлнэ.

**С.Бямбацогт:** Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Энэ малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль сая бас хэлэгдэлгүй өнгөрчих шиг болох юм. Малчны тухай хуультайгаа хамт хэлэлцээд явчихвал, хурдан баталчихвал уг нь хэрэгтэй юм болов уу гэж бодож байгаа юм. Тэгээд Их Хурлын нэр бүхий гишүүд санаачилсан. Малчдын бас нэгдэж нийлэх, хамтарч хорших, ингээд хадлан тэжээлээ бэлддэг, хашаа хороогоо бэлддэг, худаг усаа гаргадаг, малаа эрүүлжүүлдэг, малынхаа түүхий эдийг бас боловсруулдаг анхан шатны боловсруулалт хийдэг, малынхаа түүхий эдийг бас үр өгөөжийг нь нэмэгдүүлэх энэ зорилгоор л энэ хуулийг бас батлах гээд Их Хурал хэлэлцэж байгаа. Энийг хурдан баталчихвал бас цаашидаа хэрэгтэй болов уу гэж бодож байгаа. Малчдын орлого нэмэгдэхэд. Монгол Улсын төрөөс бас малчдынхаа талаар бас тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа. Нийгмийн хамгааллын, нийгмийн халамжийн чанартай болчихоод байгаа. Одоо яг орлого нэмэгдүүлэх чиглэлд нь бас тодорхой болж чадахгүй байгаа. Өнөөдрийн байдлаар ноолуур зүүн аймгуудад 180 орчим мянгатай хамгийн өндөр гарсан. Баруун аймгууд руу 120 мянга орчим болж үнэ нь их бууж байна. Унаж байна. Үүнтэй холбоотойгоор

Засгийн газраас самнасан ноолуурыг, угаасан ноолуурыг хилээр чөлөөтэй гаргах тогтоолыг өчигдөр бас баталсан. Үндэсний үйлдвэрүүдээ дэмжээд уг нь угаасан ноолуур дотооддоо бас самнах эцсийн боловсруулалт хийх, нэмүү өртөг шингээх энэ бодлогыг дэмжиж байгаа боловч харамсалтай нь үндэсний үйлдвэрүүд маань малчдын гар дээр байгаа ноолуурыг бас харьцангуй өндөр үнээр авах тал дээр хойрго байгаад байна.

Тийм учраас бас чөлөөтэй өрсөлдөөн үүсгэж, ноолуурын үнийг бас өсгөх тал дээр бас Засгийн газар өчигдөр тогтоол гаргасан. Гэхдээ ийм байдлаар бас цаашидаа бас явахгүй байх. Тэгээд үндэсний үйлдвэрлэлүүдээ яаж дэмжих вэ. Энэ үндэсний үйлдвэрүүд маань бас энэ иргэдээ боддог, малчдаа боддог энэ тал дээр анхаармаар байгаа юм. Бид газар тариаланг дэмжээд гурилын үйлдвэрлэлээ дэмжээд тодорхой одоо гурил импортлохыг бас хязгаарласан. Квоттой болгосон, татвартай болгосон. Гэтэл гурилын үнэ тэнгэрт хаданд гарсан. Үүнийг бас зохицуулаад Улсын Их Хурлаас тогтоол баталсан. Өнөөдрийн байдлаар энэ тогтоолын үр дүн гарч байна. Гаалийн татваргүй болгосон, квотгүй болгосон. Урьд нь баруун аймгуудад 1 уут гурил 120 мянга хүрч байсан бол өнөөдөр баруун аймгуудад 1 уут гурил 60-65 мянга болж, үндсэндээ 2 дахин буурлаа.

Үүнтэй адилхан бид нар ноолуурын үнийг бас тодорхой хэмжээнд өсгөх, ноолуурын эрэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр түр зуурын арга хэмжээ авч байгаа. Цаашидаа бодлогын томоохон арга хэмжээ, тогтвортой малчдын орлогыг нэмэгдүүлэх малын гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуур, дайвар бүтээгдэхүүнийг бас үнэ цэнтэй болох асуудал бол ерөөсөө л энэ Үндэсний үйлдвэрүүд малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдийг л дэмжих. Энэ тал дээр Их Хурал илүү бас санаачилга гаргаж ажиллах хэрэгтэй байна. Бид бүхэн бас малчдын тэр яаж

малын гаралтай түүхий эд боловсруулдаг үйлдвэрүүдийг дэмжих вэ, хөнгөлөлттэй зээл өгөх. Урьд нь батлагдсан Үйлдвэр технологийн паркийн тухай хуулийг бас илүү бас бодитой хэрэгжүүлэх энэ талд нь бас тодорхой томоохон дэмжлэг үзүүлсэн бодлогыг яаралтай гаргавал цаашидаа малчдын орлого нэмэгдэнэ. Саалиа бэлдэхээр саваа бэлд гэж монголчууд ярьдаг. Малчдаа дэмжээд хоршоо, нөхөрлөл байгуулаад малын гаралтай түүхий эдээ анхан шатны боловсруулалт хийгээд ямар ч байсан түүхий эдээ бас анхан шатны боловсруулалт хийгээд малчдадаа бэлэн болгох нь. Тэгвэл сав нь болсон үйлдвэрүүдийг барьж байгуулах дээр бас Их Хурлаас, Засгийн газраас, төрөөс томоохон дэмжлэг үзүүлж, үйлдвэрүүдийг бариад байгуулчих юм бол тэр хаягдаад байгаа, үнэ цэнгүй болчихоод байгаа ноос, арьс шир, дайвар бүтээгдэхүүн үнэ цэнтэй болно. Энэ тал руу бас анхаарсан бодлогыг ойрын үед бас энэ Их Хурал хэлэлцээд баталчихвал саяын бас шинэ хоршоо хөдөлгөөнтэй адилхан бас нэг малчдад бас илүү бас үр өгөөжөө өгсөн, Монголын төр бас саваа ч бэлдсэн, саалиа ч бэлдсэн ийм арга хэмжээ болох болов уу. Тэгээд энэ тал дээр бас Их Хурлынхаа гишүүдийг илүү анхаарч ажиллахыг бас уриалж байна.

Тийм болохоор Малчин өрхийн нэгдсэн холбооны хууль, Малчны тухай хуулиа бас яаралтай батлаад араас нь бас үйлдвэрийнхээ асуудлыг ярьчихвал яасан юм бэ гэсэн саналтай байгаа.

**Г.Занданишатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний дуу хоолой болох ёстой. Тийм учраас хөдөө орон нутгаар ажилласан. Ард иргэдийнхээ үгийг дамжуулъя. Ховд аймгийн Зэрэг сумын Хөндлөн багийн иргэн Даньдрагчаа Амирлан Өмнөговийн орон нутгийн Тавантолгойн ордоос Өмнөговийн иргэд маш их үр ашиг хүртэж байна. Өмнөговь аймаг маш их хөгжиж байна. 1 сум дээр

10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт жил болгон ирдэг ийм сайхан зүйл бий болж байна. Гэтэл манай Ховдын Хөшөөт тийм юм алга. Тийм учраас Ховдын Хөшөөтийн уурхайн хувьцааг орон нутгийн иргэдэд өгөх замаар, орон нутагт бас тодорхой хувийг өгөх замаар Ховд аймгаа хөгжүүлээр байна гэж байна.

Ховд аймгийн Мөнххайрхан сумын өндөр настан Чоглом гуай бүсийн хөгжлийн төлөө олон гишүүд нэгдэж хамтарч ажилласны үр дүнд аймаг аймагт нь таарсан том том үйлдвэр бариад, үүний дагуу ажлын байр бий болгох ийм боломжийг нээж өгөх юм байна гэж ярьж байна.

Дуут сумыг Хөхбэлчир багийн аймгийн аварга малчин Шаравын Батсуурь сүүлийн 3, 4 сар сумын бараг бүх төрийн албан хаагчийг хот руу, аймаг руу семинар зөвлөгөөнд авч явлаа. Онгоцны зардал, үнэтэй буудал, тансаг ресторан, тор дүүрэн бэлэг авснаа л ярьж байна гэнэ. Тэгээд 1 намд санал өгөх тухай ярьж байна гэнэ. Тэгээд энэ ард нь ингээд төрийн алба ингээд унаж дуусаж байна гэдэг ийм зүйлийг ярьж байна.

Жаргалант сумын иргэн, Ховд Их Сургуулийн оюутны зөвлөлийн дарга Баянжаргал. Ипотекийн зээл 0,8%-тай, 0,6%-тай, 0,5 хувьтай өөр өөр байна. Энийг ижил болгох талаар ажиллаач гэдэг ийм хүсэлтийг тавьж байна.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэн Ганбаатар Улсын Их Хурлын гишүүний тангарагт хуулийн хариуцлага хүлээнэ гэдэг ийм 1 ерөнхий заалт яачхаад, тэгээд 1 ийм торгуулийн ял, янз янзын юм аваад байна. Тэрний оронд энэ тангарагтаа хуулийн дээд цээрлэл хүлээнэ гэдэг ийм юм оруулаач гэдэг ийм хүсэлтийг тавьж байна.

Мөн Рашаант сумын иргэн Т.Отгонцэцэг Энэ хоршооны тухай хуулиар Эрдэнэтийн малчин хүн

хоршоонд элсээд 5 га газар авах гэхээр Эрдэнэтэд газар байхгүй юм байна. Тэгээд хажуу талын Булган аймгийн 1 сум дээр очиж авах юм байна. Тэр нь тэр нь чөлөөтэй юм байна. Тэгээд тэнд очоод 5 га газар авна гэхээр нь тухайн сумын Засаг дарга нь шууд тэр газрыг нь гаргаж өгөхөд ийм хуультай болчихжээ. Тэгэхгүй бол хариуцлага хүлээнэ гэж байна. Тэгэхээр өөр аймгийн малчид ирээд нутаг дээр нь хашаалаад 5 га газар аваад суучих юм бол тэр бэлчээр бөөн дайн дажинд хүрэх ийм нөхцөл байдал руу орж байна гэж байна. Тэгээд ер нь энэ хоршооны хууль бол их тийм эргэлзээтэй хууль болж байна. Ер нь бол төр засаг зээл ав, илүү өрөнд ор гэдэг ийм төр засаг ерөөсөө байхгүй. Харин явал тэр махыг нь үнэтэй болгох вэ, явал тэр түүхий эдийг нь боловсруулж үнэтэй борлуулах вэ гэдэг ийм л төр засаг байх ёстой. Гэтэл энэ дээр тийм юм шийдэхгүй, зүгээр л зээл өгнө гээд дайраад байдаг. Түрүүчийнх нь зээл нь эрсдэлд орчихсон. Тэр зээлээ яаж хаах вэ ийм ийм зүйлүүд байгаад байна.

Тэгэхээр ер нь бол энэ хоршооны хуулийн дагуу тэр зээл авахаасаа илүү Ардчилсан намын бүлгээс өргөн барьсан тэр 1,2 их наядоор, 1,2 их наяд болохгүй юм л даа. Ойролцоогоор 250 мянган малчны 5 сая төгрөгийн зээл хаахаар 750 тэрбум төгрөг болох юм. Тэгээд 750 тэрбум төгрөг зарлагдаад шийдчих тэр юмыг чинь заавал 5 их наяд төгрөгийн зээл гаргаж шийднэ гэдэг улам их өрөнд оруулдаг, 1 малчинд 20-оос дээш дээд тал нь 50 сая төгрөгийн зээл олгоно гэж дайрдаг ийм төр засаг байж болохгүй. Тэгээд ч ер нь бол 10 малчин зээл авлаа гэхэд 6 нь хариуцлагатай ажлаа хийгээд, 1 нь тэр зээл аваад сайн санаа гаргаад хашаа, малын хашаа барьдаг, хадлан тэжээлийн талбай барьдаг тэгж байгаад 200 малтай хүн чинь тэр авсан зээлээ төлж чадахгүй. Бас 1 малчин нь юу байдаг юм онлайн покерт ороод, тэр покер тоглоод мөнгөө алдчихвал яах юм. 3 дахь малчин нь морь мал худалдаж аваад уралдаж явж байгаад, тэгээд зээлээ хэрэглэсэн юм байхгүй тансаглаад

дуусчихвал яах юм. 4 дэх малчин нь 10 малчныхаа махыг авч явж хот руу борлуулна гэж явж байгаад өмхийрүүлчихвэл яах юм. Ийм эрсдэлд 4 малчин орлоо гэхэд үлдсэн тэр 6 хариуцлагатай байсан малчин тэгээд тэр хүмүүсийн өмнөөс зээл төлөөд байж байх юм уу. Тэгэхээр ер нь бол ингээд нэгдэл коммун юу байдаг юм хоршоо гээд олон зүйлийг хамтрах тухай асуудал ярьж байсан. Ер нь бол уулын мухарт өөрсдийгөө эзэн гэж боддог тэр хүмүүс тэгж хоршоолоод, нэгдэлжээд амжилтад хүрээгүй гэдгээ л өнгөрсөн түүх бүгдээрээ л харуулж байгаа.

Тэгэхээр малчдаа бас энэ зээл авахдаа болгоомжтой байгаарай. Хажуу хавиргад хоршоонд элссэн хүмүүс чинь.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлж дууслаа.

Сандагийн Бямбацогт гишүүний хэлсэн Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль өнөөдрийн хэлэлцэх асуудлын жагсаалтад байгаа. Тэгэхдээ 13 цагаас Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хуралдана. Байнгын хорооны гишүүдэд зарлаж мэдэгдэж байна. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр шийдвэрлэсний дагуу Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо өчигдөр хуралдаагүй учраас өнөөдөр 1 цагаас хуралдаж, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Малчны эрх зүйн байдлын тухай хууль 2-г хэлэлцэнэ. Төсвийн байнгын хороо бас хуралдах билүү. Тэмүүлэн дарга.

Ингээд энэ Байнгын хороодын хурлаар сая Бямбацогт гишүүний хэлсэн хуулиуд хэлэлцэгдсэний дараа Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон байгаа.

Ноолууртай холбоотой асуудлын талаар Улсын Их Хурлын гишүүд болон



иргэдийн зүгээс олон санал хүсэлтүүд ирж байгаа. Зарим иргэд бол энэ тогтоолд өөрчлөлт оруулж, ноолуурыг, түүхий ноолуур гадагшаа экспортлох хугацааг сунгасан шийдвэрийг талархан хүлээж авч байна. Зарим нь бол ингээж зохиомлоор бас худалдан авалтыг сааруулж бас ийм үйл ажиллагаа явуулж байна гэж шүүмжилж байгаа иргэд ч байна. Ер нь бол үйлдвэрлэгчид бол орон нутгаас 140-153 мянган төгрөгөөр худалдаж авч байгаа гэсэн мэдээлэл ирүүлсэн. Энийг шалгаж үзэх шаардлагатай.

Мөн энэ арилжааны банкнуудаар дамжуулж олгосон ноолуурын зээлийн гаралт ямар байгаа юм. Ноолуурын зээлийн гаралт нэмэгдэж байж, түүхий эд бэлтгэх ноолуур худалдан авах үйл ажиллагаа эрчимжих ёстой. Энийг Монголбанк холбогдох арилжааны банкнуудад ноолуур бэлтгэлийн ажилд шаардлагатай санхүүжилтийг яаралтай гаргаж шийдвэрлэхийг үүрэг болгосон байгаа. Үйлдвэрлэлүүд бол эргэлтийн хөрөнгийн зээл буюу ноолуур худалдан авах зээлийн дутагдалтайгаас болоод ноолуур авахгүй ноолуурын үнэ хани унаж байна, худалдан авах ажиллагаа багасаж байна гэсэн шүүмжлэл өрнөж байгаа.

2 дугаарт Пүрэвдорж гишүүний хэлсэн асуудлуудтай холбогдуулаад энэ малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Малчдын эрх зүйн байдлын тухай хуультай холбогдуулж Адьшаа гишүүн бид 2 1 хууль санаачилсан байгаа. Гишүүд нэгдэж болно. Энэ ашигт малтмалын лиценз малчдын маш их анхаарлыг татаж байна гэж осая гишүүд ярилаа. Энэ орон нутгийн зөвшөөрлийг татгалзаад байхад нь ашигт малтмалын лиценз олгоод байдаг. Ийм учраас орон нутгийн хурлаар хэлэлцүүлдэг. Заавал саналыг нь үндэслэж байж, хэлэлцүүлж байж, орон нутгийн хянан шалгагч томилж байж, орон нутагт ашигт малтмалыг хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаа явуулдаг хуучин зохицуулалтыг сэргээх,

ер нь бас орон нутагтаа учраа олж зөвшилцөж, нийгэмд, орон нутагт үр ашигтай л бол энэ төслүүд хэрэгждэг байх ийм зарчимд нийцүүлсэн хуулийг бол санаачилсан байгааг бас мэдэгдэж байна.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн бас байгаа. Даваасүрэн гишүүн бас орж байгаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

**Одоо 1 дүгээрт хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 69 төсөл байгаа.**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

2 дугаарт Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

3 дугаарт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

4 дүгээрт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

5 дугаарт Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл,

6 дугаарт Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

7 дугаарт Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

8 дугаарт Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл,

9 дүгээрт Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы чуулганы баасан гаргийн үдээс өмнөх хуралдаанаар хуулийн төслүүдийг эцэслэн батлах бөгөөд хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар байвал өөр өдөр, цагт санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу Байнгын хороод хуулийн төслүүдийг эцэслэн батлах хувилбаруудыг бэлтгэж эцэслэн батлуулахаар бэлэн болгож тараасан байгаа.

Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулъя. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу нийт гишүүдийн олонхоор хуулийг эцэслэн батална. 39-өөс дээш гишүүн дэмжиж байж, хууль эцэслэн батлагдана.

Нэг. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Ингээд эхлээд бүртгэлийн санал хураалт явуулна. Анхны санал хураалт учраас. Цэдэвийн Сэргэлэн гишүүн, генерал суудалдаа сууя. Чинзориг сайд суудалдаа сууя. Бүртгэлийн санал хураалт Адъяа, Алтанхуяг, Баярсайхан, Булгантуяа, Бямбацогт, Ганибал.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын сонгуулийн 8 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент хаврын отгон чуулганаах сүүлийн сарын нэгдсэн хуралдаан

чуулгануудыг зохион байгуулж байна. Тэгээд энэ отгон чуулганууддаа Улсын Их Хурлын гишүүд бас эвтэй найртай, сахилга хариуцлагатай оролцож отоглох, сүүлийн тэмээний ачаа хүнд гэдэг. Энэ ажлууддаа бас идэвх санаачилгатай оролцож хуулиудаа баталж, Монгол хүний бэлгэдлээр бэлгээр бас эв найртай, санал санаачилгатай хурал чуулгандаа оролцохыг бас нийт гишүүдэд уриалж бас анхааруулж байна.

Энэ отгон сарын хурал. Хаврын отгон чуулганы отгон сарын хурал гэж. Бат-Эрдэнэ гишүүн суудалдаа. Энэ Бямбацогт гишүүн сая үг хэлээд байсан хааччихав. 40 болчихлоо.

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

#### **Хамт өргөн мэдүүлсэн:**

2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

3. Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжих хууль эцэслэн батлагдлаа.

4. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

7.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

8.Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

9.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжих хууль эцэслэн батлагдлаа.

11.Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Адьшаа гишүүн ээ, санал хураалтаа дуусгачихъя. Үгүй ээ, үгүй. Энэ нөгөө Улсын Их Хурлын хаврын отгон чуулганы отгон хуралдаанууд үргэлжилж байна. Одоо отгон хуралдаандаа гишүүд эв найртай, санал санаачилгатай, бүрэн дүүрэн сайхан оролцоод бариагаа сайн

хийх хэрэгтэй. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 43 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. Эвтэй байгаа юм байна. Ганбат гишүүн гэхдээ эсрэг санал өгчихсөн байна шүү.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт Баттөмөр гишүүн саналаа өгсөн үү. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

6.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Батлут гишүүн саналаа өгсөн үү. 43 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

7.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

8.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

9.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя 42 гишүүн дэмжих хууль эцэслэн батлагдлаа.

10.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

11.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

12.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

13.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, тогтоол батлагдлаа.

1.Улсын Их Хурлын тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

2.Энийг эхэлж хураах ёстой. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулсан.

3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

4.Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

6.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энх-Амгалан гишүүн. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.



**Хамт өргөн мэдүүлсэн:**

2.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5.Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Одонтуяа гишүүн таны хууль шүү дээ. Яагаад мартаад байна. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Одоо Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хаана байна. Сайд байхгүй бол хураахгүй. Энэ чухал хууль баталъя. Дашидондогийн

Ганбат гишүүн орж ирлээ. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Шинжлэх ухаан технологийн их хурал болж байгаа юм байна яг одоо. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

3.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Дээд эцэслэн баталъя гэсэн саналын боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5.Инновацын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

6.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

7.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Балжиннямын Баярсайхан гишүүн сайн байна уу. Өнөөдөр 1 цаг хоцорсон тухай асуудал биш. Сүүлийн сар, ойрын хэдэн сар чуулганд ерөөсөө ирээгүй учраас л асууж байгаа юм.

8.Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Пүрэвдорж гишүүн санал. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

9.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

11.Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

12. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя 46 гишүүн дэмжиж хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

ХҮН намын дарга Тогмидын Доржханд гишүүн сайн байна уу. Ингээд Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайдаа баталлаа. Өгсөн амлалт үүргээ яг таг биелүүлж, шинжлэх ухаанаа их сайн дэмжиж ажиллана, боловсролоо дэмжиж ажиллана гэдэгт итгээж байгаа шүү.

1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

### Хамт өргөн мэдүүлсэн:

2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 46 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

5.Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

6.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Болоогүй байна. Дөхөж байна. Одоо ерөөсөө 10 хэдэн хууль л байна. 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

7.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ ажлын хэсэг нь хаачсан юм. Соёлын бүтээлч үйлдвэрийн тухай хууль чинь дагасан олон хуультай шүү дээ. Ундрам гишүүн

ээ. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

8.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

9.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 46 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа. 48 гишүүн дэмжсэн байна.

11.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

12.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 49 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

13.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 50 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Сайн байна уу. Жамбын Батсуурь гишүүн ээ. Сайн явж ирэв үү та. Ойрд уулзаагүй юм байна.

14.Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя 49 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

15.Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 49 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

16.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя 50 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

17.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

18.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ яагаад удаад байдаг болчихсон юм бэ. 45 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

1.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Яагаад ингээж удаад байна. 49 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

1. Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 46 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа. Нийт одоо 69 хуулийн төслийг эцэслэн баталлаа. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

Ямар ч байсан дараагийн 126 гишүүнтэй Улсын Их Хурлын үйл ажиллагаагаа хэвийн явуулах Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиуд эцэслэн батлагдлаа.

Одоо Шинжлэх ухаан, технологийн тухай хууль өнөөдөр чуулганаа хийж байгаа энэ өдөр бас эцэслэн батлагдлаа. Ингээд нийт 69 хуулиуд батлагдлаа.

11.06 цаг.

Дараагийн асуудалд орно.

**“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Улсын Их

Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт санал гараагүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хороо “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг



анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасан байна. Үүнтэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Асуулт тасаллаа. Энэ гагцхилаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр хөдөөгүүр явж байхад иргэд бол маш их дургүйцэлтэй байгаа зүйл бол энэ авлига, хээл хахууль, хулгайтай тэмцэх талаар ерөөсөө тодорхой арга хэмжээ авахгүй байна. Энэ дээр л гол анхаарлаа хандуулаарай гэж байгаа. Тэгэхээр энэ нүүрсний хулгайн сонсгол болсон. Тэр нүүрсний хулгайн сонсгол дээр бол манай хөдөөгийн ард иргэд бол алинд нь хулгай болчихсон юм бэ гэдгийг бүрэн сайн тогтоож авч амжаагүй, чадаагүй. Тийм учраас энэ хулгай яаж явагдсан бэ гэдгийг бас би тодорхой хэлж өгөх нь зүйтэй гэж бодож байна.

Би 2021 оны 10 сарын 1-ний өдөр одоо боллоо гэдэг жагсаалыг талбай дээр зохион байгуулж байхад би хэлж байсан. 1 машин нүүрс жишээ нь Цагаан хадны талбайгаас Ганц модны боомт хүртэл 29 километр газарт 60 сая төгрөгөөр тээвэр хийж байна шүү, энийгээ болиоч ээ, одоо боллоо шүү дээ гэдэг зүйл хэлж байхад чимээгүй л байсан. Тэгээд дараа нь 3, 4 сарын дараанаас эхлээд л ер нь бол тэр тээвэр чинь 120 сая болчихсон байхгүй юу. Урьд нь 3 сая төгрөгөөр 29км газарт тээвэр хийдэг байсан чинь ковидын үед 120 сая төгрөг болгож байгаад л энэ хулгайгаа бүгдийг нь хийсэн байхгүй юу даа. Өдөрт 300 машин гарлаа гэхэд л 36 тэрбум төгрөг тэнд хулгайлагдаж байсан байхгүй юу даа. Тэгээд 360 сая төгрөгийн үнэтэй цоо шинэ давхар чиргүүлтэй хятад машиныг 360 сая төгрөгөөр худалдаж аваад банканд нь солярк дүүргээд банкных нь солярк дуусаагүй байж байхад 180км яваад нөгөө машиныхаа 360 сая төгрөгийг олж байлаа шүү дээ. Ийм луйврыг бүтэн 2 жилийн туршид хийсэн байхгүй юу даа. 2 жил 4 сарын туршид. Тэгээд энэ хулгайны асуудлаа ерөөсөө яриагүй.

Тэгээд өдөрт 500 машин гарлаа гэхэд л 60 тэрбум төгрөг л тэндээс хулгайлж байсан. Энэ их хулгайны асуудлаа ерөөсөө яриагүй. Яагаад гэвэл энд бүх эрх баригчид, бүх дарга мяндагтнууд, бүх хуулийнхан бүгдээрээ оролцоод эндээсээ хулгай хийсэн учраас өнөөдөр энэ асуудлаа ерөөсөө гаргаж ирж ярихгүй байгаад байгаа юм.

Тийм учраас ард иргэд бол 1 зүйлийг л хүсэж байгаа юм. Бидний боломжийг хулгайлсан энэ хулгайч нөхдүүддээ хариуцлага тооцоод, шорон оронд нь явуулаад тэр хулгайлсан мөнгийг минь олж ирээч ээ л гэж байгаа шүү дээ. Гэвч харамсалтай нь сонсголоор энэ асуудлаа шийдээгүй, цаашаа ямар ч арга хэмжээ аваагүй, сонсголын дагуу хариуцлага тооцогдсон хүн алга. Жишээ нь, тэр нүүрсний хулгай хийж гэмт бүлэглэл бий болгосон гэдэг Аюурсайхан гэдэг нөхөрт 3 жилийн ял өгч байгаа. Одоо 10 сар гаруй шалгагдчихсан. Тэр нь ял дотор орчихно. Тэгээд 3 жилийн ял өгнө гэдэг чинь 1,5 жилийн ял эдлээд л тэгээд л нөгөө хүн чинь суллагдчихна. Тэгээд энэ яаж байна гэхээр Аюурсайхан одоо ингээд баахан нүүрсний хулгай гээд баахан пижигнүүлчихсэн. Ард түмэн хариуцлага хүлээ гээд байна. Тун удахгүй Их Хурлын сонгууль болно. Орон нутгийн сонгууль намар болно. Миний хөгшин чи ингээд 11 сард гарчих л даа гэж хэлж байгааатай ялгаагүй л хариуцлага тооцож байна шүү дээ. Ингэж хариуцлага тооцох юм бол энэ ард түмний баялгаас хулгайлсан тэр хүмүүст яаж хариуцлага тооцох гэж байгаа юм. Ялын дээд хэмжээ нь 12 жил байгаа шүү дээ. Тэгээд өгөөд явуулсан бол энэ хүмүүс чинь хаширах байхгүй юу даа. Гэтэл одоо ийм юм байхгүй. Яагаад ингэж асуудалд хандаж байна гэхээр ерөөсөө эрх баригчид чинь бүгдээрээ энэ нүүрсний хулгай болон янз янзын хулгайнуудад бүгдээрээ холбогдчихсон. Өө чи миний хүнийг нүүрсний хулгай дээр шалгаж байгаа юм уу. Өө тэгвэл чиний хүн чинь төмөр замын хулгай, Хөгжлийн банк дээр холбогдчихсон шүү дээ гэхээр нөгөө 2 нөхөр хөшигний цаана орчихоод

хоёулаа нисчхээд л шүү хоёулаа чимээгүй байна. Ингээд л гараад ирж байна шүү дээ. Ингээж ийм байдлаар хариуцлага тооцох асуудал дээр урагшаа хөдлөхгүй байна. Тэгээд энэ асуудал дээр Авлигатай тэмцэх газар ямар юм.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Энэ чинь үйл ажиллагааны төлөвлөгөө шүү дээ. Хөтөлбөр хэлэлцэж байгаа. Сонгууль болох гэж байгааг ойлгож байна. Тэгэхдээ хэлэлцэх асуудалтай бас холбож яривал зүгээр байгаа юм. Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй дотоод хэргийн сайд хариулна. Энхбаяр гишүүнээ карт чинь уншигдаагүй байна. Баттөмөрийн Энхбаяр.

**Б.Энхбаяр:** Пүрэвдорж гишүүний ярьж байгаа зарчимтай санал нэг байгаа. Олон хүчин зүйл яригдаж байна. Засгийн газар, Улсын Их Хурал, хууль хяналтын байгууллагуудын зүгээс ялангуяа энэ Хөгжлийн банк, нүүрсний хулгай тойрсон асуудал дээр сонсгол хийж, хууль хяналтын байгууллагууд руу шилжүүлсэн. Нүүрсний сонсгол хийсний дараа 9700 хуудас материалыг шилжүүлсэн. Эхнээсээ бол шүүхээр бас ял шийтгэгдэж, ял сонсож байна. Энд шүүх хурлыг хаалттай хийснээс болоод тэгээд тэнд ял шийтгэл авсан хүмүүс гэм буруугүй ариун цагаан байсан юм шиг мэдээлэл түгээдэг. Эсвэл таны сая хэлж байгаагчлан 50 хувийнхаа хорих ялыг эдлээд гарчих ийм яриа өгүүлэл гаргасан байна лээ. Өөрөөр хэлбэл сая энэ нүүрсний сонсголд ял шийтгэгдсэн нөхдүүдээс ирэх онд гарчихна гээд ярьж байгаа зүйлүүд байгаа юм байна лээ. Харин Улсын Их Хурал сая миний бие өөрөө Хууль зүйн сайдаар томилогдсоны дараа авлига албан тушаалын гэмт хэргээр хорих ял шийтгэгдсэн этгээдийг магадлангаар суллахгүй ээ гэдэг хуулийг Улсын Их Хуралд өргөн бариад бид хамтдаа баталчихсан байгаа. Бид энийг баталчихсан. Одоо магадлангаар суллагдах асуудал байхгүй гэсэн үг. Тэр хорих ялаа дуустлаа эдэлнэ.

Ер нь шүүхтэй холбоотой асуудал дээр бол тэгээд ард түмэн харж байгаа даа. Би их олон юм яримааргүй байгаа юм. Монгол Улсын 560 шүүгчийн 75 хувь нь Элбэгдорж, Баттулга гэдэг хүмүүсийн томилсон шүүгч нар байгаа. Монгол Улсын шүүгчдийн талыг Элбэгдорж гэдэг хүн томилсон юм. Тэгээд одоо шүүх дээр энэ очиж байгаа хэргүүдийг гаргадаг, янз бүрийн хүмүүсийг сулладаг асуудал байна. Тэгээд ялангуяа Хууль зүйн сайд одоо энэ хэргийг ингээж шийдэх ёстой, тэгж шийдэх ёстой гэж мөрдөн шалгах ажиллагаа юм уу, шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж болохгүй. Үндсэн хуулийнхаа тангараг өргөсөн зарчимдаа үнэнч байгаад дуугүй байгаад байгаа юм. Ярьж болохгүй. Тэгэхдээ энийг чинь ард түмнээрээ хараад байгаа шүү дээ.

Одоо Улсын Их Хурлын дарга Занданишатар, манай бүлгийн дарга Тогтохсүрэн, хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар 3 санаачлаад энэ авлига, албан тушаалын гэмт хэргүүдийг бүгдийг нь нээлттэй шүүх хуралдаанаар хийнэ. Хаалттай хийхгүй гэдэг хуулийн төсөл санаачилж байгаа. Өчигдөр Засгийн газрын хуралдаанаар энэ хуулийн төслийг дэмжсэн. Тэгэхээр энэ хуулийг бас хурдан батлаад өгөөч ээ гэж би Их Хурлын гишүүдээсээ бас хүсэх гэж байгаа юм. Тэгвэл тэр шүүх хуралдаанууд дээр чинь юу яригдаад байгаа юм. Үнэхээр гэм буруутай юм уу, эсвэл хонгилдоод хүнийг хэлмэгдүүлэх гээд байна уу. Эсвэл үнэхээр гарцаагүй тэр хэрэг учрал нотлогдчихсон юм нь байгаад байна уу гэдэг тодорхой болно.

Би нүүрсний хэрэг дээрх шүүх хурал дуусчихсан гэж ойлгохгүй байгаа. Одоо ял шийтгэгдсэн хүмүүстэй холбоотой дахиад авлига, албан тушаалын асуудлууд шалгагдаж байгаа асуудлууд бас байгаа. Бид нарын 2017 онд баталсан хуулиар бол үйлдэл тус бүрд нь ял шийтгэх учраас хэрвээ энэ асуудлууд дахиад шүүх рүү очвол нэмэгдээд ял шийтгэлээ аваад явна л гэсэн үг. Тийм

учраас би хэрэг дуусчихсан биш, үргэлжилж байгаа гэж ойлгож байгаа.

**Г.Занданишатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн асууна.

**О.Цогтгэрэл:** Авлигатай холбоотой асуудал ард иргэдийн сүүлийн жилүүдийн асар их санаа зовоосон асуудал. Улс орон даяараа л энэ хэрэг хөдөллөө. Сая гишүүд бүгдээрээ л орон нутагт ажиллах шиг болсон. Сумын клуб бүхэнд очиход гарч байгаа асуудал авлигын л асуудал. Иргэдийн асууж байгаа асуултыг нь, тавьж байгаа саналыг нь, илэрхийлж байгаа байр суурийн гол нь ер нь яагаад энэ авлигатай тэмцээд байхад чинь авлига чинь өсөөд байдаг юм бэ 1 дүгээрт нь.

2 дугаарт нь яагаад авлигатай тэмцээд байгаа юм бол хариуцлага тооцдоггүй юм бэ.

3 дугаарт нь авлигатай үнэхээр тэмцээд байгаа юм бол яагаад хохирол барагддаггүй юм бэ. Яагаад хохирол барагддаггүй юм бэ. Мөнгөн хохирол гэдэг зүйл яагаад барагдахгүй байна гэдэг үндсэн 3 асуудлыг л иргэд асар их санаа зовж асууж байгаа. Яг л улс орон даяар ийм л байгаа байх. Миний явсан газраар л нэлэнхийдээ л ийм л зүйлүүдийг иргэд томилбол ярьж байна. Тэгэхээр энэ авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр гэж батлагдах гэж байна л даа. Яг энэ дээр холбоотой яг ярих юм бол сая нүүрсний хэрэг. Нүүрсний хэрэг чинь Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлөөс эхлээд бүгдийг нууцад авснаас болж асуудал тэр хулгайн асуудал эхэлсэн 1 дүгээрт.

2 дугаарт нь процессынхоо үед тэр сонсгол энэ тэр болж байхад гол гэрчүүд орж ирэхгүй бас нууц.

3 дугаарт нь шүүх хурал нь хаалттай. Шүүх хурал нь хаалттай. Тэгэхээр яг одоо бид нар үндсэндээ энэ авлигын эсрэг энэ төлөвлөгөө дээр одоо яг юу байна. Үүний эсрэг юу байна вэ. Сая

Энхбаяр сайд бас шүүх хурлыг нээлттэй явуулах тухай ярьж байна. Энэ бол би яг сая голчлон энийг ярих гэж байсан юм. Гол асуудал Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлөөс хаалттай гэрээ. Сонсгол хэлэлцүүлэг дээр гол гэрч байдаггүй, хаалттай. Шүүх хурал хаалттай. Тэгэхээр чинь яг үнэндээ бид нар авлигатайгаа тэмцэх чин эрмэлзэл, чин хүсэл манай төрд яг байгаа юм уу гэдэг. Яг үнэндээ иргэд яг ийм л зүйлийг ярьж байгаа юм. Тэгээд тэр шүүх хурлыг нээлттэй явуулах тухай бас хуулийн төслийн өөрчлөлтийг бид бүхэн бас АН-ын бүлэг дээр бэлдэж байсан юм. Тэгээд сая Энхбаяр сайдын ярьснаар бол Засгийн газраас ийм санал орж байгаа юм байна. Энийг тэгээд бид бүгд бүрэн дүүрэн дэмжиж ажиллах ёстой. Бүгдийг л нээлттэй, ил тод болгох энэ зарчмыг л баримтлахгүй юм бол яг одоо өнгөрсөн хугацаанд явж ирсэн энэ авлигын эсрэг тэмцэл бол үндсэндээ нүд хуурсан ийм тэмцэл болж өнгөрсөн гэдгийг л хэлэх байна. Тэгэхээр асуулт бол алга. Сая тэр хэлэх гэж байсан санал сая гарчих шиг боллоо.

**Г.Занданишатар:** Хэн хариулах вэ. Санал л хэлчихлээ. Тэгээд ер нь Улсын Их Хурлын гишүүд сая Пүрэвдорж гишүүн, Цогтгэрэл гишүүд нарт хэлэхэд нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар Улсын Их Хурлаас нүүрсний тээвэр ложистикийн зөрчил байна гэж Улсын Их Хурал 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Хяналт шалгалтын түр хороо байгуулсан. Тэгээд гол нь цөөнхийн төлөөллийг оруулж байгуулах дэгтэй. Цөөнхийн төлөөлөл маань бас идэвхтэй оролцоогүй ээ. Яг ний нуугүй хэлэхэд. Ингээд 2022 оны 6 дугаар сарын 10-нд байгуулаад, Гочоогийн Ганболд гишүүн, Адышаа гишүүн энэ дээр чинь бас оролцсон. Ингээд Гочоогийн Ганболд гишүүнээр ахалсан ажлын хэсэг байгуулж энэ оффтейк гэрээ, энэ нүүрсний статистик мэдээний зөрөөнүүдийг ил тод болгож анх асуудал эхэлсэн шүү. Жагсаал цуглаан 12 сарын 5-нд болсон. Тэрэнд Пүрэвдорж гишүүн

тэр бүх сонсголууд дээр өөрсдөө тэр үед оролцох бүрэн эрх нь байсан.

Ийм учраас бол харин ч энийг чинь Улсын Их Хурлын гишүүд энийг чинь ярьж энд тэр хүний өөрийн ялгалгүй дуудаж, сонсгол явагдсан. Тэр сонсголд Улсын Их Хурлын гишүүд бүгд орох эрхтэй байсан. Ийм учраас сонгууль болж байгааг ойлгож байна. Улс төржиж болохыг ойлгож байна. Гэхдээ бас үнэн бодит факт баримт дээр тулгуурлаж яривал зохино. Авлигатай тэмцэх газар зөвхөн 2023 онд 2 их наяд 794 тэрбум 936 сая төгрөгийн хөрөнгө хураасан. 2022 онд. 2023 онд 238 тэрбум байсан байх. 238 тэрбум 784 сая төгрөгийн хөрөнгийг нөхөн төлүүлж, улсын орлого болгосон. Энэ бол хөрөнгө хурааж холбогдох байгууллагууд одоо Эрдэнэт, Дархан гэх мэт ч холбогдох байгууллагуудад орлогыг нь оруулсан. Улсын төсөвт орсон нь энэ 2 ялгаатай. Гадаад дотоодод байгаа олон үл хөдлөх хөрөнгө оффшорт ч байна уу гадаадад байгаа хөрөнгүүдийг хурааж улсын төсөвт оруулсан ийм бодит эдийн засгийн үр дүн гаргасан бөгөөд шүүхийн процесс бол дуусаагүй байгаа.

Энэ шүүх хуралдаанаар шүүгч нотлох баримтыг яллах, цагаатгах талыг тэнцүү баримталж нотлох баримтыг үнэлээгүй бол Шүүхийн сахилгын хороонд гомдол гаргах эрх нь байгаа. Шүүхийн процесст бол Дээд шүүхийн хяналтын шатын дараа бол Шүүхийн сахилгын хороонд нээлттэй сонсголоор цугласан нотлох баримтуудыг үнэлсэн эсэх асуудлаар бол гомдол гаргаж, шүүгч яллах талыг баримтлаагүй байна гэсэн дүгнэлт, гомдол гаргаж болж. Тийм учраас шүүхийн процесс дуусаагүй байгаа. Нэгт хэлье.

2 дугаарт Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар бид санаачлаад, Хууль зүйн сайд Баттөмөрийн Энхбаяр сайд маань дэмжээд, шүүхийн ил тод байдлын хангасан шүүх процесс авлига, албан тушаалын гэмт хэрэг шийдэхдээ

олон түмний өмнө ил тод байж нотлох баримтыг яаж үнэлж байгаа юм бэ гэдэг асуудлыг ил тод харуулах, зөвхөн гэрчийн мэдүүлэг дээр биш нотлох баримтуудыг яаж үнэлж байгаа вэ гэдэг асуудлыг ил тод харуулж, ингээд энэ шүүх засаглалд итгэх ард иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, шүүхийн хариуцлагыг ч гэсэн дээшилүүлэхэд чиглэсэн ийм өөрчлөлтийг оруулаад өргөн бариад хэлэлцээд явж байгаа гэдгийг бас тайлбар өгөх нь зүйтэй гэж бодож байна. Ер нь бол манай Дашдондогийн Ганбат гишүүн бол энэ дээр дандаа дуугарч, харин идэвх санаачилгатай ажиллаж байсан гэдгийг бас онцлон тэмдэглэж хэлмээр байна. Байнга дуугардаг хүн. Ингээд Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

**Д.Ганбат:** Ер нь улс орон бол авлигад живж байна. Тэгээд энэ байдлаараа ингээд будраад яваад байхаар энэ чинь авлигад ингээд живчихсэн улс орон бол өөдөлдөггүй л дээ. Одоо ийм чухал асуудал ярьж байхад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр баталж байхад Авлигатай тэмцэх газрын дарга нь хаана байна. Дэд дарга нь хаана байна. Өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд хаана байна. Эрх барьж байгаа МАН-ын дарга хаана байна гэсэн би асуултыг тавимаар байх юм. Энэ Хууль зүйн сайд л шаварт унасан шарын эзэн гээд л ингээд л бүх юмны өмнө явж байдаг. Үүний төлөө бас ажиллаж л байна л даа. Хөгжлийн банкны сонсгол, нүүрсний сонсгол, Хөгжлийн банкны сонсгол анх удаагаа гэхэд амжилттай явагдсан. Мэдээж хэрэг Их Хурлын гишүүдийн хүчин зүйлс, Засгийн газрын оролцоо ч байгаа гэж бодож байна. Нүүрсний сонсголыг бол нэлээн хэлтэй амтай явж явж хийсэн. Тэгээд иргэд бол мэдэх эрх нь хангагдсан. Хаанаа, юу нь болохгүй байна гэдэг анх удаагаа болж байгаа сонсголууд учраас ойлголтуудыг авсан.

Ингээд гадна дотнын байгууллагын дүгнэлтээр бид нар чинь сүүлийн 8 жил авлигатай тэмцээд уг нь болж байсан



шүү дээ. 2012, 2013, 2014 онд гаднын байгууллагын дүгнэлтээр хараат бус “Трансперенси интернэйшнл” байгууллагын тэр индексээр бол бид нар чинь 72-т байсан байхгүй юу. Тэгээд одоо хэдэд байгаа билээ. Би андуураагүй бол 121 байгаа байх. Яагаад ийм байгаа юм бэ. Энийг одоо юу гэж бодож байгаа юм. Цаашидаа одоо энэ индекс сайжирч, ард түмний амьдрал өөдлөх юм уу. Тэгээд одоо удахгүй Улсын Их Хурлын сонгууль болох гэж байна. Мэдээж хэрэг хэн нэгэн хүн шүүхээр эцсийн шийдвэр гаргаагүй байхад хэн нэгнийг буруутай энэ тэр гэж ярьж болохгүй л дээ. Бид нар бол тэр хуулийг дагаж мөрдөөд, шүүхэд хүндэтгэлтэй хандаад ингэж явдаг л даа. Орчин үеийн иргэншсэн нийгэмд амьдарч байгаа ийм хүмүүс. Гэхдээ энэ намууд ингээд нэр дэвшилт нь явагдах гэж байна. Ер нь бол иргэд 1 л зүйлийг ярьж байна шүү дээ. Ялангуяа энэ 2 нам нэр цэвэр хүмүүсээ явуул. Шаардлага хангасан. Ер нь авлига, албан тушаалын хэрэгт орооцолдоогүй ийм хүн маш цөөхөн болчихсон байна. Тэгээд үүнтэй тэмцэж чадахгүй учраас эцсийн найдвар бол ард түмний сонголт дээр үлдээд байна л даа. Ард түмэн энэ асуудлыг шийдэж өгөх ийм цаг хугацаанд болчихсон байна.

Тэгэхээр энэ байгууллагын би бас хэлэх үгийг, энэ Засгийн газрын яагаад сүүлийн 8, 10 жил ийм амжилтгүй байсан, юу дутагдсан юм, ямар юм нь болохоо байсан юм, ямар дүгнэлт хийж байгаа гэдгийг нь бас нэг сонсчихмоор байна. Яагаад вэ гэдгийг би тэртээ тэргүй мэдэж байна. Гэхдээ олон түмний өмнө бас та нарын үгийг сонсмоор байна.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийг танилцуулна. Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Мягмарцэрэнгийн Даваатогтох Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Доржсүрэнгийн Дуламсүрэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг

хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар, Мөнхжаргалын Ганбагана Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн.

Бид нар бол “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-өө баталчихсан. 2023 оны хаврын чуулганаар баталчихсан. Одоо бол тэр хөтөлбөрөө хэрэгжүүлэх төлөвлөгөө, ажлын төлөвлөгөө баталж байгаа ийм л юм шүү дээ. Хэн хариулах вэ. 3 номер Мягмарцэрэнгийн Даваатогтох.

**М.Даваатогтох:** Гишүүний асуултад хариулъя. Энэ авлигын төсөөллийн индекс гэж индексийг “Трансперенси интернэйшнл” олон улсын байгууллагаас гаргадаг. Энийг тодотгож хэлэхэд энэ бол төсөөллийн индекс гэж өөрөө оноосон нэр нь ийм оноосон нэртэй. Энэ бол одоо яг туйлын үнэн бол биш. Төсөөллийн индекс гэж явдаг. Сая таны асуултад дурдагдлаа. Энэ өөрөө 100 хувь нь хамгийн цэвэр буюу авлигагүй. 0 хувь нь бол хамгийн их авлигажсан гэж дүгнэгддэг ийм үнэлгээний үзүүлэлт байдаг. 2012 онд бол Монгол улс 36 оноотой байсан байна. 2013 онд 38 оноотой байсан. Сүүлийн жилүүдийн оноог бол та мэдэж байна. 33 оноотой ингэж Монгол Улс үнэлэгдсэн байгаа. Авлигын төсөөллийн индекс гэдэг энэ үнэлгээ бол тухайн улс орны авлигын нөхцөл байдлыг ерөнхийд нь үнэлдэг ийм үнэлгээ. Энэ бол авлигатай тэмцэх агентлагийг юм уу, аль эсвэл нэг дан Засгийн газрыг юм уу, аль эсвэл аль нэг авлигатай тэмцэх чиг үүрэгтэй төрийн бус байгууллагыг үнэлдэггүй. Тухайн улсын иргэний оролцооноос авхуулаад, тэр хууль тогтоох байгууллага хүртэл бүх институцүүдийн нийлбэр байдлаар үнэлдэг. Дээр нь нөгөө авлигын эсрэг үндэсний, шударга ёсны тогтолцоог бас үнэлдэг ийм үзүүлэлт байгаа.

Монгол Улсын сүүлд унасан шалтгаануудын дотор бол энэ Төрийн өмчит компаниудын асуудал дурдагдсан.

Төрийн өмчит компаниудын засаглалыг ил тод болгох ёстой гэдэг ийм асуудал дурдагдсан. Дээр нь иргэдийг мэдэх эрхээр хангах энэ асуудлыг бас тусгагдсан ийм байгаа. Тэрнээс авлигатай тэмцэл хийж байгаа яг гэмт хэргийн тухай асуудал гэдэг юм уу, аль эсвэл манлайлалтай ажиллаж байгаа Улсын Их Хурал, Засгийн газрын тухай асуудал бол энэ сүүлийн үнэлгээнд бол дурдагдаагүй байгаа. Хариулж дууслаа.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу та. Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

**Д.Ганбат:** Их Хурлын гишүүн ард түмний төлөөлөлд бол мэдээж хэрэг хуулийг одоо ард түмний Засгийн газар хариуцах ёстой. Их Хурлын өмнө. Хариулт бол хангалтгүй байна. Хариулж чадах хүмүүс нь ч гэсэн алга байна. Тэгээд хамгийн гол зүйл бол итгэл, үнэмшил, зоригтой байх ёстой. Энд тэр итгэл, үнэмшил, хуулийн илд больё гэж байгаа ганц нэгхэн л сайд харагдаж байна. Бусад нь бол харагдахгүй байна. Тэгээд бид нар бол бид нар ч юу байх вэ дээ энэ МАН, Засгийн газар энэ олонх бол авлигад бол ялагдлаа. Ажилгүйдэлд бол ялал ялагдлаа иргэд эх орноосоо дайжиж байна. Муу засаг, муу бодлого явбал улс орноос иргэд нь ингээд дайждаг байхгүй юу. Ийм үзүүлэлт болж байна. Маши хариуцлагагүй ажиллаж байна шүү.

**Л.Мөнхбаатар:** Ганбат гишүүн үг хэллээ. Одоо Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа үг хэлье.

**Х.Булгантуяа:** Сая хэд хэдэн гишүүд бас хэлж байна. Олон сайхан хөтөлбөр батлагдаж байна. Олон сонсгол хийж байна. Тэгээд үр дүн нь ер нь хаана байгаа юм бэ. Олон хөтөлбөрүүд энэ бол 40 тэрбум төгрөгийн төсөвтэй хөтөлбөр батлах юм байна. Тэгэхээр тэрүүний өмнөх та бүгдийн хийсэн ажлын чинь үр дүн хаана байна гэдэг асуултыг л хүмүүс бид нараас

асуугаад байна л даа. Тэгэхээр бид нар л та бүгдээс асуух ёстой юм шиг байна.

I дүгээрт өмнө нь ийм авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт та бүхэн хэдэн хувьтай гэж үнэлсэн юм бэ. Манай төрийн байгууллагууд бол дандаа л өөрсдийгөө 70 хувьтай, 80 хувьтай, 90 хувьтай гэж үнэлдэг байх. Тэгэхээр та бүгдийн өмнөх хөтөлбөрийн чинь үнэлгээг хэн хийсэн юм бэ. Хэдэн хувьтай гэж гарсан юм бэ. Дээрээс нь нэмээд олон нийтийн зөвлөл гэж байх ёстой. Авлигатай тэмцэх олон нийтийн зөвлөл гээ. Яагаад тэр төлөөллөөс өнөөдөр бас ирээгүй юм бэ. Яагаад гэвэл энд яг олон нийтийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүд бол олон нийтийн төлөөлөл, иргэдийн төлөөлөл болоод ирээд сууж байна. Бид төрийн хариуцлагатай албан тушаалтнуудаас гадна уг нь байсан бол өнөөдөр бас их зүгээр байсан юм. Та бүгдийг хөндлөнгөөс харахад яаж ажиллавал зүгээр юм шиг байна гэж асуувал зүгээр байсан юм. Дээрээс нь нэмээд энэ авлигын гол шалтгаануудаа та бүхэн маань бас юу гэж хараад байгаа юм бэ. Гол авлига төр дээр л явж байгаа байх. Тэгэхээр төр дээрээс ахиад дээрээс нь нэмээд үндсэн шалтгаанууд нь юу байгаад байгаа юм. Процесс ихтэй байгаад байгаа. Зөвшөөрөл бичиг цаас шаардаад байгаа ийм юмнаас болоод байгаа юм уу. Яагаад байгаа юм. Та бүгд энэ дээр бас дүн шинжилгээ үнэлгээ хийсэн зүйлүүд байна уу. Дээрээс нь нэмээд энэ том хэргүүд ингээд явдгаараа яваад, үүний араас Авлигатай тэмцэх газар илрүүлээд л тэгээд л шүүхийн байгууллага руу шилжүүлээд л хаячхаад байгаа юм биш биз дээ. Нэгэнт хэрвээ эхлүүлсэн бол эцэс төгсгөл хүртэл нь явах ёстой юм биш үү. Нэгэнт л илрүүлээд л гаргаж ирсэн бол явах ёстой юм биш үү. Яагаад гэвэл та бүхэн үүнийг ард түмний өмнөөс бас хүлээж байгаа хариуцлагатан биз дээ. Тэгэхээр энд тэндээс гомдол санал хүлээж аваад л прокурор луу шүүх рүү шилжүүлсэн шүү дээ гээд ингээд хаячхаад байна гээд.

Нөгөөдөх нь тэр өөрөө бас хохирсон асуудлууд зөндөө их байна. Жишээлбэл манай Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээрээс бид нар авлагуудаасаа 51 хувийг нь шүүх рүү шилжүүлээд л тэгээд л таг алга болсон. Үүний араас бид нар өөрснөө хөөцөлдөөд хөөцөлдөөд барахгүй байна. Төрийн албан тушаалтнууд, дээрээс нь нэмээд авчхаад төрийн албан тушаалтнууд хүртэл үүн дээрээс бас оролцсон, олгосон, авсан зүйлүүд энэ тэр нийгмийн даатгалын сангаас авхуулаад бас энэ зүйлүүд байгаа. Тэгээд эд нарын араас хөөцөлдөж өгөхгүй юм уу. Яах вэ энэ том хэргүүдтэй харьцуулах юм бол дүн нь арай бага ч гэсэн дараа нь очих үр дүн нь уг нь бид нарт хэрэгтэй байгаа юм. Энэ сангаас бид нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, жижиг дунд бизнес эрхлэгчдэд, хөгшин настай хүмүүст хөдөлмөр эрхлэхийг дэмжиж бид нар үүнээс зээл олгодог юм. Тэгээд ингээд том том хэргүүдийн ч үр дүн гарахгүй, жижиг жижиг хэргүүдийн ч үр дүн гарахгүй юм. Нийгмийн даатгалын сангийн авлага гэж байхад одоо бид нар хаана хэнд зарах нь тодорхойгүй баахан үл хөдлөх хөрөнгө хүлээж авсан. Эрх хүлээн авагчаас. Одоо тэгээд үүнийгээ яах вэ.

Дээрээс нь нэмээд энэ танай төлөвлөгөөг харж байхад би бас өмнө нь бас ярьж байсан. Энэ хахууль өгсөн, зуучилсан хүнийг хэрвээ нотлох баримтаа олон нийтэд үүнийгээ мэдээлэх юм бол эрүүгийн хариуцлагыг нь хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно гээд. Энэ бол их чухал гэж би боддог. Энэ бол жинхэнэ шүгэл үлээлт. Би авлига өгөхөөс өөр аргагүй болсон. Ажлаа, бизнесээ явуулахын тулд намайг ингээж дарамталсан. Хэрвээ би өгсөн. Тэгэхдээ би энэ талаараа мэдээлж байн гэвэл тэр хүнийг адилхан 1,6 жил хориод байх юм бол ямар амьтан мэдээлэл өгөх вэ дээ. Авлигын төлөө. Дээрээс нь нэмээд аягүй бол албан тушаалтан нь л ялна шүү дээ. Тэр шүүх хурал дээр, тэр цагдаа дээр очоод.

Дээрээс нь нэмээд энэ авлига, албан тушаалын хэргийг мэдээллээ гэхэд тухайн хүний өмгөөлөл хуулийн асуудлыг хэн хариуцдаг юм бэ.

**Л.Мөнхбаатар:** Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг бол Улсын Их Хурал батлан гаргасан. Жилийн өмнө батлан гаргасан. Үүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө нь өнөөдөр Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа юм. Ер нь бол Авлигын эсрэг хуульд ингээд заачихсан учраас өнөөдөр хэлэлцэж байгаа боловч, цаашид бол Хууль зүй, дотоод хэргийн яам, Энхбаяр сайд, Авлигатай тэмцэх газрынхан 1 зүйл дээр бас анхаарал хандуулмаар байгаа юм. Энэ хөтөлбөр гэдэг бол бодлогын баримт бичиг. Бодлогын баримт бичгийг бол Их Хурал батлах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Хийх ажлын төлөвлөгөө гэдэг маань яам, агентлаг, байгууллагуудын хийх ажлын төлөвлөгөөг Их Хурал батална гэдэг чинь бол өөрөө хэт жижиг зохицуулалт руу орчхож байгаа юм л даа. Яагаад гэвэл баталсан төлөвлөгөөнд маань гэнэтхэн нэг шинэлэг санаа гарч ирээд гэдэг юм уу, туршилага оруулж ирээд тэрийг нэмж оруулья гэхээр Их Хурлаар дахиж оруулах нь байна шүү дээ. Эцэс төгсгөлгүй олон өөрчлөлтүүд ордог ийм байх. Тэгэхэд цаашидаа болбол ерөөсөө авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг Их Хурал батлах нь зүйтэй. Төлөвлөгөөг нь Засгийн газар батлах нь зүйтэй. Их Хурал, түүний харьяа байгууллагууд хэрвээ энэ асуудлаар ажиллах төлөвлөгөө байх юм бол түүнийг Их Хурлын дарга баталдаг ч юм уу иймэрхүү зохион байгуулалттай цаашаа явах нь зүйтэй.

2 дугаарт өнөөдөр их олон гишүүд үг хэлэхээр нэр өгчихсөн байна. Нийтдээ 24 асуудал хэлэлцэнэ. 24 асуудал хэлэлцэнэ гэдэг маань өнөөдөр их олон асуудалтай байгаад байгаа шүү. Тийм учраас энэ төлөвлөгөө дээрээсээ та бүгд маань бас яг зарчмын шинжтэй асуух зүйлүүдээ тодорхой асуугаад, санал байгаа бол тэрийгээ хэлээд явах нь

зүйтэй байх гэсэн ийм бодолтой байна. Байгууллагуудын, яам, агентлагийн л хийх ажлын төлөвлөгөө шүү дээ. Асуултад нь хэн хариулах юм. Дуламсүрэн дарга хариульъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

2 дугаарт 1 ийм зүйл байгаа шүү. Авлигатай тэмцэх газрынхан маань авлигын чиглэлээр хэргүүд илрүүлж байгаа нь сайн байна. Гэхдээ үүнийгээ ингээд шүүхээр эцэслэтэл нь явах ёстой гэж тийм чиг үүрэг бол байхгүй. Тус тусын чиг үүрэгтэй. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан процессынхоо дагуу тухайн хэргийг илрүүлээд, прокурорт шилжүүлснээр энэ байгууллагын үүрэг дуусна. Прокурор шүүхэд шилжүүлэх үүрэгтэй. Шүүх тэр процессоо процессынхоо дагуу шийдвэрлэдэг ийм тус тусдаа үүрэгтэй байгаа шүү. Түүнээс биш Авлигатай тэмцэх газар шүүхийн эцсийн шийдвэр гартал нь ажиллах ёстой гэсэн эрх зүйн ойлголт байхгүй гэдгийг бас давхар хэлье. Дуламсүрэн дарга асуултад хариульъя.

**Д.Дуламсүрэн:** Булгантуяа гишүүний асуултад хариульъя. Өмнөх “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” 2017-2023 он хүртэл хэрэгжээд ингээд дууссан байгаа. 6 жилийн хугацаанд. Тухайн үеийн энэ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг бол Засгийн газар баталж байсан. Энэ удаа бол Улсын Их Хурал батлахаар өнөөдөр төлөвлөгөөний төсөл орж ирсэн байгаа. Манай энэ өнгөрсөн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт ямар байсан бэ гэдгийг бид 2 түвшинд бол дүгнүүлсэн байгаа.

1 дүгээрт нь бол Засгийн газрын 206 дугаар тогтоолоор баталсан энэ хяналт шинжилгээ, үнэлгээ, мониторинг хийх аргачлалын дагуу хяналт шинжилгээ, мониторинг хийлгээд дараагаар нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу мөн Засгийн газрын тогтоолоор баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр

дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу бас үнэлүүлсэн байгаа. Эхний мониторингийн ажлыг хөндлөнгийн 3 шинжээч гүйцэтгэсэн. Дараагийн энд тулгуурласан хэрэгжилтийн үр дагаврыг бол зөвлөх ажиллаж гаргаж ирсэн байгаа. Хөндлөнгийн үнэлгээ. Энэ хөндлөнгийн үнэлгээгээр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт 75,8 гэсэн хувьтай гарсан байгаа. Энэ хөтөлбөрт хэрэгжихгүй үлдсэн заалтууд ер нь бол яагаад ингээд 75,8 хувьтай хэрэгжив яагаад 100 хувьтай хэрэгжээгүй вэ гэдэг ийм асуултыг бол бид шинжээчид, экспертүүдээс асуусан байгаа. Тухайн хариулт нь бол улс төрийн хүрээний авлигатай тэмцэх хүсэл зориг бол хангалтгүй гэж үнэлэгдсэн байгаа. Яагаад гэхээр өнгөрсөн хөтөлбөрийн хүрээнд бол Улс төрийн намын тухай буюу улс төрийн намын санхүүжилт, сонгуулийн санхүүжилттэй холбоотой асуудлыг бол шийдвэрлэнэ, ил тод, нээлттэй болгоно гэсэн заалт арга хэмжээ бол хэрэгжээгүй дүгнэгдсэн байгаа. Мөн Шүгэл үлээгчийг хамгаалах тухай эрх зүйн орчныг бүрдүүлж, холбогдох арга хэмжээг авч иргэдийг төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх, нийтийн ашиг сонирхлын төлөө дуу хоолойгоо хүргэх ийм боломжоор хангах нөхцөл бол хангагдаагүй. Мөн Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлах, Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг батлах гэсэн ийм яг нөгөө олон нийтийн дуу хоолойг хүргэхтэй холбоотой асуудлууд бол бүрэн хэрэгжиж чадаагүй гэсэн ийм дүгнэлтийг бол өгсөн байгаа.

Шалтгааны хувьд бол манай байгууллагаас төрийн энэ байгууллагын шударга байдлын үнэлгээ гэсэн судалгааг хийдэг. Энэ судалгаагаар бол иргэдийн хувьд, экспертүүдийн хувьд, мөн төрд ажиллаж байгаа хүмүүсээс авсан ийм судалгаан дээр үндэслэдэг бас баримтын нотолгоонд суурилдаг судалгаагаар бол хамгийн түгээмэл шалтгаан юу вэ гэдгийг бол тодруулсан байгаа. Өнгөрсөн



2023 оны судалгааны дүнгээр бол одоогийн нийгэм төрийн тогтолцоо буруу байгаа учраас авлига бол түгээмэл байна гэж үзсэн байгаа. Мөн төрийн үйлчилгээнд удаан цаг хугацаа бас авч байна. Төрийн албан хаагчид хүнд сурталтай байдаг гэсэн ийм асуудал бол гарч байгаа. Тийм учраас одоогийн байгаа хууль, дүрэм журмын хэрэгжилт бол хангалттай биш, мөн хариуцлага бол төдийлөн тооцохгүй байна гэсэн ийм хариултыг түгээмэл өгсөн байгаа юм л даа. Тэгэхээр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т бол өнгөрсөн хөтөлбөрт ч гэсэн энэ хүнд суртал чирэгдлийг арилгах чиглэлээр хугацааг хожих чиглэлээр бол энэ ил тод нээлттэй байдлыг хангах И-платформ хөгжүүлсэн байгаа шүү дээ. Э-Монголиа. Энэ бол манай үндэсний хөтөлбөрийг бас зохих түвшинд хэрэгжилтийг оноог нь ахиулахад бол их дэмжлэг болсон гэдгийг бас энд хэлмээр байна. Одоогийн.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах юм уу. Болж байгаа юу. Даваатогтох дарга нэмж хариулъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

**М.Даваатогтох:** Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Энэ эцсийг хүртэл явдаггүй гээд би процедурын юмыг нэмээд тайлбарлачихъя. Авлигатай тэмцэх газар иргэд, аж ахуйн нэгжээс гомдол, мэдээлэл, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээж аваад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа эхлүүлдэг. Үүний дараа гэмт хэрэг үйлдэгдсэн гэж нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэж тогтоогдвол яллагдагчаар татах саналыг прокурорт хүргүүлээд, яллагдагчаар татсаны дараа бол шүүхэд шилжүүлэх саналаа прокурорын байгууллагад шилжүүлдэг. Энэ явцаа мөрдөгч гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөлийг тогтоомогц тухайн шалтгаан нөхцөлийг арилгахаар эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэл бичдэг юм. Ийм ийм үндэслэл, ийм ийм шалтгаан нөхцөлийн улмаас авлигын гэмт хэрэг

үйлдэгдсэн байна. Үүнийгээ арилга гэсэн ийм мэдэгдлийг хүргүүлдэг. Энэ нь өөрөө заавал биелэгдэх шинжтэй ийм эрх зүйн баримт бичиг байдаг. Хүлээн авсан албан тушаалтан энэ авлигын шалтгаан нөхцөлийг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Одоо Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор үг хэлье.

**Д.Өнөрболор:** 2030 он хүртэл бид нар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-өө бол баталсан байж байгаа. Өнөөдөр 290 төсөл хөтөлбөр бүхий энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө орж ирж байна. Тэгэхээр би хэд хэдэн тоон дээр суурилоод бас та хэдээс хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна. Манай улсын энэ авлигын төсөөллийн индексээр 182 орноос 12-д орж 5 байраар ухарсан байна. Хахуулын эрсдэлийн байдлаар 98 дугаар байрт орж 2 байраар ухарсан гэсэн бас нэлээн тааруу үзүүлэлттэй байна. Тэгээд ардчилсан орнуудын энэ авлигын төсөөллийн индексийн оноо 73 байдаг юм байна. Тэгээд энэ гажуудсан ардчилалтай улсуудынх нь 48. Гэтэл ардчилсан биш орнуудынх нь 33 байдаг юм байна. Тэгээд манайх бол одоо энэ оноо авсан байдлаараа бол 33 байгаад байгаа байхгүй юу. Тэгээд үүн дээр ер нь та бүгд маань ямар нэгэн дүн шинжилгээ хийсэн зүйл байна уу. Авлигыг бууруулах ер нь энэ ямар бодитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Ер нь 4, 5 жилийн дараа ямар үр дүнд хүрнэ гэсэн төсөөллийг та нар харж байна. Өнгөрсөн хугацаанд энэ авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг энэ байгууллага бүр баталдаг байгаа. Тэгээд бодит байдал дээр энэ хэрэгжилт нь бол миний ойлгосноор яам, агентлагийнх нь бол 50 хувьтай байгаа юм байна. Орон нутагт бол 60 хувьтай гарсан юм байна гэж ойлгож байна. Тэгэхээр энэ яг юуг хэлж байна гэхээр дээд байгууллагууд, яам, агентлагууд ер нь авлигын эсрэг ер нь хойрго ажиллаж байна уу гэсэн ийм сэтгэгдэл төрж байна л даа.

Нөгөөтээгүүр авлигын индексийн нэг гол хэмжүүр нь бол хуулийг дээдлэх ёсны индекс байгаа. Гэтэл манай улс бол хууль дээдлэх түвшин бол 0,5 хувийн оноотой, 50 хувьтай яваа юм байна. Тэгэхээр энэ хууль дээдлэх ёс бол энэ хувь хүний ёс зүй, ёс суртахуунтай иүүд холбоотой асуудал. Мэдлэг боловсролыг бол энэ академик түвшинээс авахаасаа гадна ер нь бол ард иргэдийнхээ төлөө сэтгэл зүрхтэй, ёс зүйтэй ийм хүн байж ажиллах ёстой. Хуулийг дээдлэх, мөн авлигыг бууруулах гол асуудал бол танай байгууллагад бас байж байгаа. Соён гэгээрүүлэх ийм бүтэц, үйл ажиллагаа ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ тал дээр ямар арга хэмжээнүүд авч байна.

Нөгөө талаар энэ төрд итгэх итгэлийг бий болгож энэ улс орныг хөгжилд хөтлөх ёс зүйтэй, хариуцлагатай хүмүүсийг томилох тал дээр ер нь та нар яг ямар ажлуудыг хийж төлөвлөж байна. Авлигын эсрэг Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа олон арга хэмжээнүүд байгаа. Улсын Их Хурлын болон Засгийн газраас ч гэсэн зохион байгуулсан сонсголудаар ноцтой олон асуудлуудыг бас илрүүлж, асуудлуудыг гаргаж тавьсан. Тэгээд өнөөдөр яг ямар үр дүнд хүрчхээд байгаа юм бэ. Ер нь иргэд бол яг энэ хариуцлага тал дээрээ бол маш их хүлээлттэй нэхэж байгаа гэдгийг бол та бүгд бүгдээрээ ойлгож байгаа байх. Энэ хохирлын асуудал дараагийн асуудал. Сая хохирол барагдуулах асуудлыг бол 2022 онд 238 тэрбум төгрөг би буруу сонсоогүй бол. 2023 онд бол 2 их наяд төгрөгийн хохирол барагдуулсан юм байна гэж ойлгосон. Тэгээд энэ хохирлын төлбөр яг хаана улсын төсөв дээр ч байдаг юм уу. Эсвэл хаана орлого болж бичигдэж, бүртгэлжээд байна. Энэ яг ямар зүйлд цаашидаа зарцуулагдахаар төлөвлөгддөг ч юм уу эсвэл ямар хэлбэрээр энэ орлогодоо бүртгээд байгаа ийм асуудлууд байна. Яагаад гэхээр би бас Энхбаяр сайдыг байж байгаа дээр өмнө нь ч гэсэн хэлж байсан юм. Энэ хүүхэд хамгааллын асуудал дээр үнэхээр л

тэгээд мөнгө дутагдаад энэ төсөв дээр мөнгө тавихад тавихад хэцүү байгаа бол ядаж энэ авлигын эсрэг тэмцсэн, үйл ажиллагаанаасаа үүссэн, бий болгосон хохирлыг барагдуулсан мөнгө төлбөрөөсөө хүүхэд хамгааллын асуудал дээр зарцуулаач ээ гэдэг асуудлыг бас тавьж байсан юм л даа. Тэгэхээр энэ яг хаана нь бүртгэгдээд, хаана орлого болж орж ирээд байна.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Даваатогтох дарга хариулчихъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

**М.Даваатогтох:** Гишүүний асуултад хариулъя. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр маань 2023-2030 оны хооронд буюу 8 жилийн хугацаанд үндэсний хэмжээнд хэрэгжих ийм хөтөлбөр байгаа. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, дээр нь Авлигатай тэмцэх газрын бүтцэд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж байгуулахаар ингэж Улсын Их Хурал шийдвэрлэж өгсөн. Үүний дагуу Авлигатай тэмцэх газарт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулсан. Мөн Авлигатай тэмцэх газрын санаачилга Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Үндэсний хороо байгуулсан. Үндэсний хороог бол Амарбаясгалан сайд ахалдаг. Бүх Төрийн нарийн бичгийн дарга нар энэ үндэсний хорооны гишүүдээр ажиллаж байгаа. Энэ бол бас урьд өмнө бол манайд байгаагүй юм байна лээ. Ийм шинэ бүтэц бий болгож ажиллах гэж байгаа нь өөрөө энэ удаагийн Үндэсний хөтөлбөрийг бас амьдралд бодитой хэрэгжүүлье гэсэн энэ иргэд олон нийтийн хүлээлтэд бас бодит ажил хэрэгч ийм үр дүнгээр хариулт барих ийм төсөөлөлтэй, төлөвлөгөөтэй ингээд ажиллаж байгаа.

Энэ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т бол хамрагдаагүй ийм нэгж

байхгүй юм байна лээ. Бүх хэмжээнд хүрч бас энэ 8 жилийн хугацаанд ажиллаад үнэхээр энэ Монгол Улсын хөгжил, цэцэглэлтэд саад учруулж байгаа, чөдөр тушаа болж байгаа энэ үзэгдэлтэй бол ингээд бас эрчимтэй тэмцье гэж үзэж байгаа. Сая таны хэлж байгаа тэр төрд итгэх итгэлийг яаж дээшлүүлэх юм бэ гээд. Энэ дээр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2 дугаар зорилго дээрээ бүхэл нэг зорилго байгаа юм. Энэ зорилго дээр иргэдийн итгэлийг хүлээсэн нийтийн албыг бэхжүүлнэ гээд. Энэ дээр тухайн албан тушаалтныг томилохоос авхуулаад л бүх харилцааг зохицуулсан байгаа. Анх томилогдох гээд орж ирэх үед ямар байдлаар тэр ХОМ-ийг нь үзэх юм. Тухайн албан тушаалтны чадвар, дээр нь нэмээд төрийн албан хаагчийн чадвар, ёс зүйн асуудлыг давхар үзэхээр байгаад байгаа юм. Энэ өөрөө төрийн албан хаагчийн шалгалт өөрөө цогц чадамж гэж юманд шилжихээр энэ хөтөлбөрт бол тусгагдсан байгаа. Одоо бол ерөнхий шалгалт, тусгай шалгалт гээд авчихдаг. Ур чадварын шалгалт авдаггүй. Энэ ур чадварын шалгалтыг жишигээр үндэсний хөтөлбөрт тусгасан байгаа.

Хохирол хаана, яаж бүртгэгдэж явдаг юм бэ гээд. Авлигатай тэмцэх газрын удирдлагын зүгээс энэ авлигын гэмт хэргийн улмаас хулгайлагдсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал дээр ажлынхаа тэргүүлэх чиглэлийг болгож ажилла гэсэн ийм чиглэлийг бид бүхэнд өгсөн. Тэгээд үүний дагуу ажиллаад ингээд 2,3 их наяд төгрөгийг 2022 онд барагдуулсан. Энэ бол бас урьд өмнө байгаагүй ийм өндөр үзүүлэлт байгаа. Энэ хохирлыг Авлигын эсрэг хуулиараа гэхээс илүү ЭХХШТХ-аар зохицуулагдсан харилцаа байдаг. Өөрөөр хэлбэл иргэн мөнгөө алдчихсан, заллуулчихсан бол тэр иргэний мөнгийг хуулийн байгууллага тухайн иргэнд л барагдуулдаг шүү дээ. Яг тэрэнтэй адилхан авлигын гэмт хэргийн улмаас хулгайлагдсан хэргийн хохирогч хэн байна вэ гэдгийг мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоодог.

Прокурор, шүүх тогтоох эрх нь бас бий. Ингээд хохирогчийг тогтоосны дараа процессын ажиллагаа хийгдээд, хөрөнгө буцаах, хөрөнгө нөхөн төлүүлэх ийм боломж үүссэн тохиолдолд тухайн хүнд өгч байгаа. Бодитой жишээгээр танилцуулахад бол Хөгжлийн банканд банкны хэрэг гэж бас нэлээн тухайн үедээ шуугиантай ийм хэрэг болсон. Монгол даяараа мэдэж байгаа. Энэ хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад бол 860 орчим тэрбум төгрөгийг Хөгжлийн банканд барагдуулсан. Сангийн яаманд биш, Монгол Улсын Хөгжлийн банканд энэ зээлийн эргэн төлөлтүүд хийгдсэн. Энэ яагаад хохирол гэж яриад байгаа юм бэ гэхээр зэрэг энгийн зээл төлбөрийн харилцаагаар явчихсан бол энэ хохирол биш шүү дээ.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууна.

**Г.Ганболд:** Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гээд зузаан ном байна. Энэ дотор харах юм бол дийлэнх нь зүгээр байгууллагын төлөвлөгөөнд тусгаад явчихаар юм байна. Парламентаас ийм детальный жишжигхэн төлөвлөгөө батална гэж бол байхгүй. Үнэхээр та нар энэ авлигатай тэмцэх, манай авлигын индекс үнэхээр 122, 121 рүү ортлоо буурсан юм бол үндсэн 5 шалтгаанаа гарга. Парламентаас болоод тэр Шүгэл үлээгчийн ч гэдэг юм уу, парламент ийм ийм хууль батал гэдэг юмнуудаа л гарга. Тэгээд байна шүү дээ дотор нь компанийн засаглал дээр яг тодорхой юмнуудаа яг парламент юу хийх юм гэдэг юмнуудаа гаргахгүй бол хэт танай энэ байгууллагын төлөвлөгөө шиг юм болчихоод байна шүү дээ. Яг нарийндаа бол тэгээд энэ агуулгаар нь та манай индексийг хойш нь татаад байгаа яг 5 шалтгааныг 1, 2, 3, 4, 5 гээд хэлээч. Тэр лүүгээ чиглэж нэг жаахан төлөвлөгөөгөө жаахан жишжигхэн болгож явахгүй бол нэг хэт одоо байгууллагын төлөвлөгөө шиг юм болчихоод яваад байна.

2-т нь ер нь хөдөө явж байхад энэ иргэд үр дүн асар их нэхэж байна. Тэгээд баахан сонсголууд болдог Хөгжлийн банкны нүүрсний эмийн сонсголуудаар араасаа ингээд баахан сонсгол явж байна. Энэний үр дүнг асар их нэхэж байна. Одоо авлигын гэмт хэргээр хэчнээн хүн ял шийтгэл ноогдсон юм хэдэн хүнд эрүүгийн хэрэг одоо үүсчхээд байгаа юм. Тэрний хүрээнд хэдий хэмжээний хөрөнгө мөнгө ер нь яг хураагдсан юм бэ гэдэг нь их чухал байна шүү дээ. Ямархуу хэмжээний юм хураагдчихаад байгаа юм. Одоо тэр авлигын гэмт хэргээр шийдэгдсэн хүмүүсээс хэдэн төгрөгийн хөрөнгө зоорийг нь хураасан юм. Зарим хүмүүс чинь тийм хууль санаачилна гээд яваад байх юм. Тийм юм байхгүй учраас тийм юм санаачлах гээд яваад байгаа юм уу гэдгийг нь хэлж өгмөөр байна.

3 дугаарт нь байна шүү дээ. Одоо жишээлэх юм бол нэг ийм юм боллоо. Ер нь нийгэм заавал Их Хурал сонсгол хийсний дараа араас нь энэ хууль хүчний байгууллагууд заавал явах ёстой юм уу. Энэ ногоон автобусны хэрэг чинь тов тодорхой ганцхан гэрээ дээр Их Хурлын сонсголыг хийж байж араас нь явах гээд байгаа юм уу. Урьдчилаад нийгмийг заавал бухимдуулж, сонсгол хийж, хэн нэгнийг чичлүүлэхгүйгээр энэ хуулийн байгууллагууд ажлаа хийгээд шуурхай арга хэмжээ авчхаж болохгүй байгаа юм уу. Заавал парламент дээр нь сонсгол хийж байж, дуулиан шуугиан болгож байж араас нь хөөцөлдөх гээд байгаа юм уу. Үгүй ээ, ганцхан гэрээ дээр юун уддаг юм. Тэгээд энэ Авлигатай тэмцэх газрын урьдчилсан мэдүүлэг гэдэг юмнууд чинь ер нь хэр бодитой байгаа юм. Сая эмийн сонсгол дээр Эрүүл мэндийн яаманд ажиллаж байгаа хүмүүсийн бараг 67 хувь нь эмийн компаниуд, эмийн бизнес, эмийн сангуудтай хамааралтай гээд сонсгол дээр Чинбүрэн гишүүн хэлж байна шүү дээ. Тайлан дээрээ. Тэр хүмүүсийг томилогдоход нь танай байгууллагаас тэр хамаарлыг нь гаргаж болдоггүй юм уу. Тэгээд орж ирсэн хойно

нь баахан дуулиан шуугиан болгоод яваад байхын хэрэг бас яг юу байгаа юм бэ.

Дараагийн асуудал нь энэ ёс зүйг л хуульчлах л юм яриад байх юм. Та чинь одоо юу гэнэ ээ. Томилогдохоор нь ёс зүйг хардаг болно гэсэн үү, үгүй юу. Юуг нь харах юм. Ёс зүйг яг хувь хүний ёс зүйг яаж дүгнэх вэ та нар. Тэгээд хамгийн гол юм бол энэ дээр та нарын эхний бүхэл бүтэн бүлэг бол ерөөсөө сонгогчдын саналыг худалдан авах зорилго агуулсан баахан юмнууд биччихсэн байна. Үгүй ээ, та нар яагаад инээгээд суугаад байгаа юм бэ. Би эсвэл буруу юм асуугаад байгаа юм уу. Сонгогчдын саналыг худалдан авах зорилгоор энэ чинь тойрог тойрог дээрээ очоод баахан хүмүүс худлаа үнэн яриад бараг л малчдын тэтгэврийг тэглэх хуулийн төсөл өргөн барьсан чинь Их Хурлын дарга авахгүй байна гээд худлаа яриад яваад байна шүү дээ. Энийг шалгасан юм байна уу. Тэр хүн үнэхээр тийм амлалт өгөөд худлаа ярьсан байвал Сонгуулийн хууль зөрчих үү.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ. 3 Номер. Даваатогтох дарга. Мягмарцэрэнгийн Даваатогтох дарга хариулъя.

**М.Даваатогтох:** Гишүүний асуултад хариулъя. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө 295 ийм арга хэмжээг тусгасан байгаа. Үүний 37,5 хувь нь хууль тогтоомжийн асуудал. Улсын Их Хурлын өөрөө баталсан үндэсний хөтөлбөр. Бид бол хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг оруулж ирж танилцуулж байгаа. Ер нь хөтөлбөрийн 37,5 хувь нь хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэсэн ийм байгаад байгаа юм. Энэ үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилго нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ийм суурь нөхцөлийг бүрдүүлэх үндсэн зорилготой. Алсын хараа 2050-ыг хэрэгжүүлэх энэ урт хугацааны бодлогоо хэрэгжүүлэх эхний 10 жилд нь үндэсний хөтөлбөр маань давхцаж байгаа. Энэ 37,5 хувь дээр эрх зүйн шинэтгэлүүдээ



хийнэ гээд Улсын Их Хурал сая та асуулаа Улсын Их Хурал юу хийх юм бэ гээд. Улсын Их Хурал бол энэ ажил дээр хариуцахаар, Хууль зүйн яам хариуцахаар Улсын Их Хуралд танилцуулахаар ингээж тусгагдсан байгаа.

Танд зарим нэг мэдээлэл, таны мэдээллүүд буруу байх шиг байна. Энэ сонсголын дараа хуулийн байгууллага ажиллаад байгаа юм гэж танд ийм мэдээлэл байх шиг байна. Ногоон автобусны хэрэг удаж байгаа гээд. Ногоон автобусны хэрэг одоо шүүхийн шатанд хянагдаж байгаа. Авлигатай тэмцэх газар бол ажлаа дуусгасан. Хохирол мөнгө барагдах нөхцөлийг бүрдүүлсэн. Одоо энэ ногоон автобусны хэрэг бол шүүх дээр хянан хэлэлцэгдэнэ. Сонсголоос өмнө энэ хэрэг нээгдчихсэн, мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байсан. Нүүрсний хэргүүд мөн адилхан. Нүүрсний дараа, сонсголын дараа эхэлсэн юм байхгүй. Нүүрсний сонсголын өмнө энэ хэргүүд тодорхой тооны хэргүүд явж байсан. Нүүрсний тухай гэхэд нийт тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар хамтраад 84 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Ийм байгаа.

Урьдчилсан мэдүүлэг хянах асуудал дээр тэр хүний эмийн зөвлөлийг та сая дурдаж байна. Хянаагүй юм уу та бүхэн гээд. Энэ дээр нэг ийм юм байгаа юм. Хүний эмийн зөвлөл өөрөө албан тушаалаараа томилогддог юм байна лээ. Хүний эмийн зөвлөлд тийм албан тушаалтны асуудал томилогддог учраас тэр үед бол Авлигатай тэмцэх газар хянах боломжгүй. Өөр албан тушаалаар томилогдчихоод дараа нь Хүний эмийн зөвлөлд албан тушаалаараа орчихсон ийм бас нөхцөл байдлууд байгаа юм байна лээ.

Тэгээд Ёс зүйн тухай хууль Улсын Их Хурал баталсан байгаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсан. Энийг бол бас энэ хөтөлбөрт илүү чамбайруулаад ингээд хэрэгжилтэд нь анхаараад тал талаасаа ТАЗ-тэйгөө

хамтраад явахаар төлөвлөөд явж байгаа юм. Хариулж дууслаа.

**Г.Занданшатар:** Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууна.

**Г.Ганболд:** яах вэ зарим нэг юман дээр хариулт авлаа. Ер нь Энхбаяр сайд аа, хөдөө явж байхад энэ хөдөөгийн иргэд бол энэ сонсголчуудын үр дүнг асар их нэхээд байгаа юм. Тэгэхээр энэ үр дүнгүүдийн талаар нэгдсэн мэдээлэл өгч, хэдий хэмжээний хүмүүс дээр ер нь ял шийтгэл ноогдуулсан юм, ямар хэмжээний хөрөнгө зорийг хурааж авсан юм гэдэг юмнуудыг бас нэлээн тодорхой мэдээллүүдийг иргэдэд өгөх нь зайлшгүй шаардлага байна. Тэгэхгүй бол огт тийм юм байхгүй юм шиг, зарим хүмүүс ингээд хөрөнгийг нь хурааж авдаг хуулийн төсөл өргөн барина энэ тэр гээд яваад байгаа зүйлүүд байна л даа. Тэгээд бид нар нөгөө мэдээллээ өгөхгүй байгаатай холбоотой ийм ойлголт бол нэлээн байгаад байх шиг байна. Тэгээд энэ дээр бас та ойрын үед анхаарч, энэ асуудлуудыг нийгэмд нэг мөр тодорхой ойлголтуудыг өгөхгүй бол хүсэлт шаардлага.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулна.

**Б.Энхбаяр:** Мэдээж мэдээлэх асуудал ганц миний үүрэг бас биш л дээ. Бүх гишүүдийн үүрэг. Ганболд гишүүн ч гэсэн түр хорооны даргаар ажиллаж байсан, гишүүнээр ажиллаж байсан. Аль алиных нь л үүрэг байгаа. Хууль хяналтын байгууллагууд дээр яах вэ гол асуудал бол ингээд бариад хорьчхооч гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр та бид 2 чинь хүн барьж хорьдог хүн биш. Хүн шалгадаг хүн биш. Алх тогшоод шүүхийн өмнөөс хүнд ял шийтгэдэг бас хүн биш. Энийг хэдэн жил өг, энийг ялла гээд ингэхээр бас болохгүй байгаад байгаа байхгүй юу. Хөрөнгө хураахтай холбоотой асуудал бол одоо хуулиараа угаасаа хураадаг. Гэмт хэргийн улмаас олсон орлого, хууль бус зүйлийг угаасаа

Эрүүгийн хуулиараа хураадаг байхгүй юу. Тэгэхээр энэ бол мөрдөх алба, прокурорын байгууллага, шүүхийн тухай тухай хэрэг дээрээ хуулиа яаж хэрэглэж байна вэ гэдэг ийм.

**Г.Занданшатар:** Тэр мэдээллийг нь бэлтгээд, ямар үр дүн гаргасан гэдгийг, хэдэн хүн шалгаж байгаа юм, хэчнээн төгрөгийн хөрөнгө хураах шүүхийн процесс явж байгаа гэдгийг нь мэдэгдчихвэл болно гэж байгаа юм. Тогмидын Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгэхээр энэ Авлигатай тэмцэх газрын ажлын бараг 50%-ийг нь бас ХҮН нам хийж байгаа гэж үзэж байгаа шүү. Яагаад вэ гэхээр Хөгжлийн банкны нээлттэй хэлэлцүүлэг, сонсголыг бол бид нар анх удаа хийсэн. 2 ч удаа ажлын хэсэг гарсан байдаг юм байна лээ. Тэгээд харамсалтай нь энийгээ мэдээлээгүй. Тэгвэл энэ нээлттэй сонсголыг хийе гээд анх тэр шахаад, санаачлаад, бас Ардчилсан намтай бас яриад сүүлд бас Ардын намын бүлэгтэй яриад ингээд сонсголоо бол хийсэн, амжилттай хийсэн, сайн хийсэн. Одоо яг тухайн үед хийсэн Баттөмөрийн Энхбаяр гишүүн бол бас энэ дээр бол идэвх зүтгэл бол гаргаж ирсэн сайн жишиг тогтоосон. 3 7 хоног бид 2 бас сууж байгаад санхүүгийнх нь асуудлыг гаргаж ирж байгаад яг л нэг хүнийг хэлмэгдүүлэхгүйгээр тэгэхдээ санхүү банк нь хуулийн чиглэл нь юу байдаг юм бэ гэж байгаад иргэдэд бодитой мэдээллээр өгсөн нь бол үнэн. Монголын түүхэнд анх удаагаа 80 яллагдагчтай хэрэг анх удаагаа олон нийтийн өмнө гарч ирсэн нь үнэн. Монголын түүхэнд анх удаа Ерөнхий сайд байсан хүмүүсээсээ эхлээд сайд байсан хүмүүс, Улсын Их Хурлын гишүүд, эрх мэдэлтэй нөхдүүд бүгдээрээ ирсэн. Түүн дээр нэмэгдээд бид нарын бас хүндэлж хүлээн зөвшөөрдөг бизнесийн нөхдүүд ч гэсэн ирсэн. Тэгээд бүгдээрээ иргэд мэдээлэлтэй болсон. Ямар мэдээлэлтэй гэхээр 2 их наядын хулгай бодитой байсан юм байна. Тэгээд ард тал нь энийг идэж уучихсан юм байна. Зүгээр

ингээд өөрийнхөө нөлөөгөөр тараахаас гадна өөрийнхөө тойрог руу тараачихсан юм байна. Өндөр хүүтэй мөнгөөр зогсоол хүртэл барьчихсан юм байна. Хэтэрхий их улс төржсөн байна. Тэгээд төлбөрийг нь төсвөөс гаргахаар ингээд бүх схемээ хийсэн байна. Ийм хулгай байж болохгүй гээд. Үүн дээр би бас 2 сэтгүүлчийг бол нэр дурдаж хэлмээр байгаа юм. Та нарын ажлыг бас сайн хийсэн шүү. Тэр сэтгүүлч Өнөрцэцэг, Лодойсамбуу гээд. Нийгэмд бас шүгэл үлээсэн. Олон нийтийн анхаарлыг хандуулсан. Тэгэхээр энэ ажлыг бол хамтдаа хийсэн. Гагцхүү асуудал нь хариуцлага яаж тооцсон юм бэ гэхээр ердөө 4, 5 дунд шатын хөгжлийн банкны захирлууд л хариуцлага тооцсон. Эрх мэдэлтнүүд нь бүгдээрээ цагаадсан байдаг. Одоо тэгвэл цаашаагаа яах юм бэ гэдэг асуудал байгаа.

2 дахь нь нүүрсний хулгай. Их хэмжээний нүүрсний хулгай бол гарсан. Монгол Улсын Ерөнхий сайд нь бол эдийн засагтайгаа тэмцэх хулгай байна гээд. Тэр нь бол 41 их наяд байсан. 2022 ны дүнгээр. Бид гарч ирээд 40 их наяд юм байна гээд тооцоо гаргаж ирсэн. Тэгээд иргэд бол талбай дүүргэсэн. Үр дүнд нь асар том ийм хулгай гарч ирсэн. Парламент дээр шүгэл үлээсэн шүү. Парламент өөрөө энийг шүгэл үлээсэн. Засгийн газар ч бас араас нь ингээд ажилласан. Харамсалтай нь оффтейк гэрээ ил боллоо гэсний дараа инээж байсан эрх мэдэлтэй нөхдүүд гадагшаа гараад зугтаасан байдаг. Ерөнхийлөгч байсан хүмүүсээс авхуулаад л маргааш нь гараад л зугтаасан. Гэрээнд гарын үсэг зурсан нөхдүүд захиалагч нь гадагшаа гараад л зугтаасан. Удаанжаргал гэдэг нөхдүүдээс эхлүүлээд зугтаагаа биз дээ. Хариуцлага хүлээсэн үү. Хүлээгээгүй. Ганц Ганхуяг гэдэг захирал нь л тэнд хариуцлага хүлээж байгаа болохоос яг гарын үсэг зурсан нөхдүүд нь хүлээгээгүй. Ингээд цаашаагаа явж байна.

Одоо өнөөдөр ногоон автобус. ХҮН намын Улаанбаатар хот, Нийслэлийн бүлгээс энэ асуудлыг гаргаж тавьсан.

Энэ чинь хуучин автобус байна шүү дээ гээд. Тэгээд нууцалчихсан байна шүү дээ гээд. Тэгээд энэ асуудлыг ингэж гаргаж ирж тавьсан. Одоо ирэх 7 хоногт сонсгол хийх гэж байна. Одоо ирээд юу хүлээж байна гэхээр хариуцлага хүлээгээд байна. Хариуцлага.

Асуулт. Бид нар цаашаага яаж хариуцлага тооцох юм бэ. Хууль шүүхийн байгууллага руу бид нар нөлөөлөх боломжгүй гээд ингээд хаачхаж байгаа юм. Уг нь тогтолцоогоо өөрчилж гэх юм бол бид нар дахиад парламент хуралдаж байгаад шийдэх ёстой байх. Авлигатай тэмцэх газрын зүгээс энэ дээр яг яаж хариуцлага тооцох юм бэ гэдэг дээр та нарт хариулт байвал өгмөөр байна. Тэгээд эцэст нь ер нь хулгайн үүр чинь төрийн өмчийн компаниуд дээр л байгаа шүү дээ. Хөгжлийн банк чинь төрийн өмч байсан. Эрдэнэс Тавантолгой төрийн өмч байсан. Ингээд цаашаага ингээд Эрдэнэт ч гэсэн төрийн өмч ингээд явж байгаа. Үүн дээр та нар яаж яг тодорхой арга хэмжээ авч ажиллах юм бэ.

**Г.Занданишатар:** Мягмарцэрэнгийн Даваатогтох 3 номер хариулъя.

**М.Даваатогтох:** Авлигатай тэмцэх газраас энэ хөгжлийн банкны хэрэг дээр цагдаагийн байгууллагатай хамтарч мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Бид бол мөрдөн шалгах ажиллагааны явцад нийт 94 хүн, хуулийн этгээдийг яллагдагчаар татаж прокурорын байгууллагад шилжүүлсэн. Мөрдөн шалгах ажиллагааны явцад ер нь хохирол нөхөн төлүүлэх буюу төрд учирсан хохирлыг барагдуулах чиглэлд онцгой анхаарч ажилласан. Үүний үр дүнд бол ингээд 860 орчим тэрбум төгрөг мөрдөн шалгах ажиллагааны явцад барагдсан. Ийм байгаа.

Мөн Авлигатай тэмцэх газрын өөрийн эрх үүргийн чиг үүргийн хүрээ хязгаар байгаа. Бид бол гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн аваад, мөрдөн шалгах ажиллагаа

эхлүүлж байгаа. Мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтаа үнэлээд, прокурорт танилцуулаад, яллагдагчаар татах эсэх асуудлаа шийдүүлээд ингээд хэрэв нотлогдвол шүүхэд шилжүүлдэг. Нүүрсний хулгайн хэрэг дээр мөн адил процесс бол адилхан. Гомдол, мэдээллээ хүлээж авлаа. 5 хоногийн дотор цааш нь хэрэг сунгах уу үгүй юу гэдгээ даргадаа танилцуулна. Дарга 14 хоног хүртэл сунгах эрхийг өгнө. Нийт 19 хоногийн хугацаанд шалгаад, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх эсэх асуудлыг бол мөрдөгч шийдвэрлэдэг ийм хуулийн хугацаатай. Үүний дараа бол мөрдөн байцаалтын хэрэг дээр тухай бүрд нь сунгуулаад ингээд л мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа юм. Мөрдөн шалгах ажиллагаа дуусаад сая таны асуусан Хөгжлийн банкны хэрэг, Нүүрсний хулгай, Ногоон автобусны хэрэг гээд энэ хэргүүд дээр бол түрүүний ногоон автобусны асуудлыг бол Ганболд гишүүний асуулт дээр хариулсан. Мөрдөн шалгах ажиллагаа дуусгачихсан. Одоо энэ хэргийн шүүх хурал энэ сарын 20-ны өдөр шүүх дээр зарлагдсан байгаа юм байна лээ. Тэгэхээр Авлигатай тэмцэх газар бол энэ хэрэг дээр бол мөрдөн шалгах ажиллагаагаа өөрийнхөө хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээд ингээд шилжүүлчихсэн. Нүүрсний хулгайн гэх тодотголтой энэ хэрэг бол тухайн үедээ бас нийгэмд нэлээн шуугиантай ингэж ажилласан. Нийт 84 хэрэгт цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллагатай хамтарч мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. 9 хэрэг нь шүүхээр шийдвэрлэгдсэн байгаа юм байна лээ. 9 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн. Шүүхэд шилжүүлэх саналтай 13 хэрэг шилжүүлсэн. Одоо тэгээд 4 хэрэг прокурорын байгууллага дээр хянагдаж байна гэсэн үг. Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэргийн шинжгүй үндэслэл тогтоогдсон 15 хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлсэн. Прокурорын байгууллага дээр хааж шийдвэрлэгдсэн. 10 хэргийг нэгтгэсэн хуульд заасан үндэслэлийн дагуу нэг этгээд хэд хэдэн хэрэгт

шалгагдсан бол ч гэдэг юм уу энэ хуульд заасан үндэслэлийнхээ дагуу 10 хэргийг бол нэгтгэсэн байна. Одоо нийт нүүрсний гэх тодотголтой 46 хэрэгт Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

**Г.Занданишатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн. Доржханд гишүүн 1 минут тодруулъя.

**Т.Доржханд:** Тэгэхээр асуух зүйл байгаа нь юу гэхээр тэр гадагшийгаа зугтаасан нөхдүүдийг та нар яаж авчрах юм бэ гэдэг дээр товчхон хариулт өгмөөр байна.

2 дугаарт бол ХҮН нам өнөөдөр парламентад суудалтай улс төрийн хүчин өмнө нь энэ худал хулгайд ерөөсөө огт оролцож байгаагүй. Ийм болохоороо энэ хэргүүдийг чинь энэ дээр шүгэл үлээгээд, ил болгож байгаа юм. Хамтарч ажиллаж байгаа. Авлига, хулгайн асуудал дээр улс төржиж болохгүй. Хамтарч явахаас өөр арга байхгүй юм. Ийм болохоор өмнөх тэр шийдвэр гаргасан эрх мэдэлтэй нөхдүүдтэй хариуцлага тооцох ажлыг Авлигатай тэмцэх газар хийх хэрэгтэй.

2 дугаарт бүх авлига чинь төрийн өмчийн компаниуд дээр яваад байгаа. Тийм юм бол та нар төлөвлөгөөндөө төрийн өмчийн компаниудын удирдлага бол мэргэжлийн байх ёстой, хөндлөнгийн байх ёстой, хэн нэгэн эрх мэдэлтэй, хэн нэгэн ялсан намын томилгоо бай байж болохгүй гэдэг ийм зүйл заалтыг л оруулж өгөх хэрэгтэй. Энэ бол хамгийн бодитой эх үүсвэртэй нь тэмцэж байгаа ийм хэлбэр юм. Үүн дээрээ анхаарч.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Үг хэллээ. Одоо Бадарчийн Жаргалмаа гишүүн.

**Б.Жаргалмаа:** Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Үг хэлж байгаа гишүүн болгон л Монгол Улсын Их Хурлаас үүргээ гүйцэтгэсэн түр хороод ажиллаж, хариуцлага тооцох этгээдийг

олж илрүүлсэн, олон нийтийн дунд мэдээллийг ил тод нээлттэй болгосон, нотлох баримтыг шинжлэн судалсан гээд ингээд л нэхээд байна л даа. Олон нийт ч гэсэн яг биднээс ийм л зүйлийг хүсэж байгаа. Сая Авлигатай тэмцэх газрын мэргэжилтэн, дарга хэлж байна л даа. Өөрөөр хэлэх юм бол бид Авлигатай тэмцэх газрын үүргийн хүрээнд түр хорооны дүгнэлтийг үндэслээд хууль хүчний байгууллага руу шилжүүлэх ийм үүрэгтэй гээд. Их Хурал нь ч тэр, түр хороо нь ч тэр яг адилхан л ийм үүрэгтэй олон нийтэд мэдээллийг өгөөд л байж байна л даа. Тэр саяын Ганболд гишүүний тэр үнэхээр хууль зүйн хүрээнд шүүх цагдаа нь яг ямар хариуцлага тооцож байгаа юм бэ гэдгийг олон нийтэд бас мэдээлэх зайлшгүй шаардлагатай байх. 2007 онд Авлигатай тэмцэх газар байгуулагдаж байсан. 2007 оны 10 сард Авлигатай тэмцэх газрын дарга Дангаасүрэн гэдэг хүн харийн нутагт бусдын гарт амь эрсдэж байсан гээд л ингээд түүх ярих юм бол Авлигатай тэмцэх газар маань бас 17, 18 жил болчихжээ. Анх энэ газрыг байгуулагдаж байхад олон нийтэд авлига гэдэг зүйлийг ойлгуулах, мэдээлэх, иргэд олон нийт өөрсдөө хяналт тавих тэр боломжийг нь нээж өгөх бүхий л боломжийг төр засаг нь хууль, эрх зүйн хүрээнд хангаж өгсөн гэж би ойлгодог. Өөрөөр хэлэх юм бол олон нийт би авлига өгч болохгүй, авч болохгүй гэдгээрээ соён гэгээрч байсан. Анх бараг л соён гэгээрэл гэдэг үгийг авлигатай тэмцэх газрынхан маш өргөн хүрээнд хэрэглэж, олон нийт ч гэсэн энэ талаар бас ажилладаг байсан. Яг өнөөдөр Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх тэр үйл ажиллагаа тасалдчихсан юм болов уу гэж би өөрөө хардаг юм. Тэгэхээр энэ ажил дээрээ төлөвлөгөөндөө яг юу тусгасан юм бэ гэдэг зүйлийг тодруулъя.

Сая бас мэргэжилтэн хэлж байна л даа. Үнэхээр эмийн түр хороо бид юу хэлж байсан бэ гэвэл яагаад нөлөө бүхий этгээд юм байна гэдэг ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгээ өгчхөөд байхад энэ албан тушаалд томилчихсон юм бэ гэдэг



зүйлийг асууж байсан. Бид мэдээлээд л өнгөрчихдөг. Дахиад л Их Хурал нь ч мэдээлээд л өнгөрчихдөг, Авлигатай тэмцэх газар нь ч мэдээлээд л өнгөрчихдөг баймааргүй байгаа юм. Тэгэхээр энэ дээр ер нь Авлигатай тэмцэх газар хууль, эрх зүйн хүрээнд ямар арга хэмжээ авах, түүнийг албан тушаалд томилохгүй байх тэр эрх нь та нарт байдаг биз дээ. Яагаад энэ ажил хийгдэхгүйгээр нөлөө бүхий этгээд ашиг сонирхолтой хүмүүсийг энэ төрийн албанд томилоод байдаг юм бэ гэдэг дээр би нэг зүйлийг тодруулъя гэж бодож байна.

Нөгөөтээгүүр Монгол Улсын хувьд 2018 онд 37, 2019 онд 35, 2020, 2021 онд 35 оноотой авлигын индексээрээ. Өнгөрсөн онд 33 оноо болж буурсан бол улс орнуудын эрэмбийн тухайд 180 улсаас 116-д нь Монгол Улс бичигдээд, 121 болж 5 байраар ухарчээ гэж. Яг юу дутагдаад бид нарын энэ авлигатай тэмцэх үйл ажиллагаа ингээд индексээрээ ухраад буураад байгаа юм. Юуг хийж чадахгүй байгаа юм. Олон нийтийн дэмжлэг нь байхгүй байгаа юм уу. Танай нөгөө соён гэгээрүүлэх, олон нийтийг хамруулах тэр нөлөөллийн үйл ажиллагаа чинь гээгдчихээд байгаа юм уу. Яагаад энэ ажил хийгдэхгүй байгаа юм бэ гэдэг зүйлийг тодруулмаар байна. Авлигатай тэмцэх газар Олон нийтийн зөвлөлтэй хажуудаа. Өөрөөр хэлэх юм бол хөндлөнгийн иргэн энд хяналтаа тавь гээд Олон нийтийн зөвлөлийг ажиллуулж байгаа. Энэ Олон нийтийн зөвлөл чинь өнөөдөр ажиллаж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр та бүхэн бас тайлбар хэлээч. Тэр улсууд чинь бас л төсвийн мөнгөөр, татварын мөнгөөр цалин аваад ажиллаж байгаа. Үр дүн байна уу, үгүй юу. Үр дүнгүй бол олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа хийж чадахгүй бол олон нийтийн өмнөөс хяналтаа тавьж чадахгүй бол энэ Олон нийтийн зөвлөлийг байлгах шаардлага байна уу, үгүй юу гэдэг зүйлийг асуух гэсэн юм. Яг Олон нийтийн зөвлөлөө чадавхжуулах, эргээд нийгэмд хүрсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг тэр

хяналт тавьдаг процессоо улам бүүр нэмэгдүүлэх боломжийг нь төлөвлөгөөндөө яаж тусгасан юм бэ гэдэг зүйлийг тодруулъя. Энэ хэдэн асуултад хариулт аваадахъя.

**Г.Занданшатар:** 3 номер Даваатогтох хариулъя.

**М.Даваатогтох:** Гишүүний асуултад хариулъя. Энэ авлигын төсөөллийн индексээр Монгол Улс 2023 онд 33 оноо авсан байгаа. Энэ авлигын төсөөллийн индекс гэдэг өөрөө бас ийм оноосон нэртэй. Энэ ийм шүү 100 бол хамгийн цэвэр 0 бол хамгийн муу гэсэн ийм үзүүлэлт байдаг. Авлигын төсөөллийн индексийн онооны өмнө тэмдэглэгээ байдаг. 3 янзын тэмдэглэгээ байдаг. Ногоон дугуй дээр дээшийгээ сум заасан, нэг бол улаан дугуй дээр доошийгоо сум заасан, үгүй бол саарал дугуй дээр тэнцүүгийн тэмдэгтэй. Монгол Улс 2022 онд 33 оноотой үнэлэгдсэн. 116 дугаар байранд. 2023 онд мөн адил 33 оноотой 121 дүгээр байранд үнэлэгдсэн. Монгол Улсын 2023 оны 33 онооны өмнөх дугуй дээр тэнцүүгийн тэмдэг байгаа. Өөрөөр хэлбэл энэ 33 оноотой орнууд давхцаж үнэлэгдээд 121 гэдэг тоо руу орчхоод байгаа юм. Тэрнээс Монгол Улс бол 16-аас 121 рүү унасан үзүүлэлт бол биш гэдэг ийм тайлбарыг хэлье.

Авлигатай тэмцэх газрын дэргэд Олон нийтийн зөвлөл ажилладаг. Авлигын эсрэг хуулиар зохицуулагдсан ийм харилцаа. Олон нийтийн зөвлөлийг Монгол Улсын Ерөнхийлөгч тус зөвлөлийн гишүүдийг 4 жилийн хугацаатай Ерөнхийлөгчийн зарлигаар томилогддог ийм субъектүүд. Энэ хүмүүс өөрсдөө энэ гишүүд дундаасаа даргаа томилдог ийм нэгж байгаа. Авлигатай тэмцэх газарт бол юу байхгүй. Шууд удирдагдахгүй Авлигатай тэмцэх газраас цалин авдаггүй, урамшуулал гэдэг ийм мөнгөн урамшуулал бол авдаг юм байна лээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөнд бол соён

гэгээрүүлэх чиглэлийн олон ажлууд тусгагдсан байгаа. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 9 дүгээр зорилго бүхэлдээ олон нийтийн оролцоонд тулгуурласан соён гэгээрүүлэх ажиллагааг цогц байдлаар зохион байгуулна гэсэн ийм бүтэн зорилго байгаа. Энэ дээр бол хүүхдээс авхуулаад ер нь бага наснаас нь авхуулаад энэ соён гэгээрүүлэх ажлыг явууля гэдэг ийм том бодлогын шийдвэрүүдийг бол Улсын Их Хурал гаргасан. Энэ олон улсад бол жишиг болчихсон байдаг юм байна лээ. Монгол Улсад хараахан зарим зүйл нь бол эхлээгүй байгаа. Бид хэд энэ ажил хүлээж авснаас хойш сургуулийн өмнөх боловсролоос авхуулаад бүх шатны сургалтын байгууллагад ер нь энэ авлига, авлига гэхээсээ илүү хүүхдүүдэд бол шударга ёсны хариуцлага гэдэг ийм хичээлийн хөтөлбөрийг эхлүүлээд туршилтын хөтөлбөр нь өнгөрсөн 7 хоногт дууслаа. Дээр нь энэ хүүхдүүдэд сошиал орчинд нөлөөлж байгаа сөрөг үзэгдлүүдийг багасгая гээд энэ дээр тодорхой зорилгууд орсон байгаа. Дээр нь ер нь хүүхдүүдээр дамжуулаад Монгол Улсад авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажилд үндэсний дүр бүтээнэ гээд энэ Япон, Сингапур, гаднын улс орнуудад бол ерөөсөө тогтчихсон ийм байдаг юм байна лээ. Монгол Улс бас яг энэ чиглэлд явна гээд ингээд соён гэгээрүүлэх ажлыг явж байгаа.

Мөн иргэдийн оролцоонд тулгуурлая гэдэг дээр бид нэлээд төлөвлөгөөндөө бол тусгасан байгаа. Хөтөлбөр маань ч өөрөө ингэж батлагдсан. Иргэд төр, төрийн бус байгууллагуудын оролцоонд тулгуурлаад Төрийн бус байгууллага, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудаа бэхжүүлээд, энэ бэхжигдсэн төрийн бус байгууллагатайгаа хамтраад соён гэгээрүүлэх ажлаа бас шинэ шатад гаргана гэсэн ийм төлөвлөгөө тусгагдсан байгаа.

**Г.Занданишатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Сая энэ ХҮН намын дарга тэр Хөгжлийн банкны асуудлыг бид үлээсэн гэж байна. Үгүй юм аа. Энэ энийг анх Их Хурлын дарга Занданишатар энэ Хяналт шалгалтын хууль гараагүй, сонсгол хийх эрх зүйн орчин бүрдээгүй байх үед надаар ахлуулаад Даваасүрэн гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Чинзориг, Пүрэвдорж гишүүн нар оролцуулсан Хөгжлийн банкны анхны сонсголыг хийж, 3,2 их наяд төгрөгийн найдваргүй зээл байна. Үүнээс 1,7 их наяд нь бол хугацаа хэтэрчихсэн явж байна гэж. Энийг анх нийгэмд гаргаж тавьсан хүмүүс нь бид нар шүү. Үнэн юм бол үнэнээрээ байх хэрэгтэй. Тэгээд энийг бол би өөрийнхөө бланк дээр яг тэр үед бол хяналт шалгалтын хууль батлагдсан өөрийнхөө бланк дээр 27 хүний гарын үсэгтэй энэ сонсгол хийх ажлын хэсгийг байгууля гээд би өөрөө санаачилж хийсэн юм шүү. Тэгээд намайг ахалж ажилла гэсэн. Би өөрөө яах вэ хуулийн чиглэлийн хүмүүс нь ахлах нь зүйтэй гээд би татгалзаад, тэгээд Сүхбаатар, Сүхбаатарын дараа Энхбаяр сайд энэ тэр ингээд яасан түүхтэй шүү. Үнэн юм бол үнэнээрээ байх хэрэгтэй.

Ингээд энэ төлөвлөгөө ярьж байна л даа. Тэгээд бид нар бол үндэсний хөтөлбөрийг бол баталчихсан. Төлөвлөгөөнд бол орох ёстой асуудлууд бол бүрэн орсон байна гэж ингэж үзэж байгаа юм. Тэгээд ер нь бол энэ зах зээлийн нийгэмд шилжсэн үеэс эхлээд л авлига эхэлсэн. Өмч хувьчлал гээд л. Тэрнээс хойш бүх л зүйлүүд яг аваад үзэхээр зэрэг л ерөөсөө энэ авлигалын категорид багтдаг байхгүй юу. Тэгэхээр энэ маань ингэж явсаар явсаар байгаад өнөөдөр юу болсон гэхээр Монгол Улс энэ авлигын сүүдэр тусаагүй салбар гэж өнөөдөр байхгүй болчихсон. Тийм учраас бол энэ дээр бол Авлигатай тэмцэх газрыг бол авлигыг бүрэн устга гэж найдаад суух нь бол тун гэнэн хэрэг болно. Бүх нийтээрээ авлигыг үл тэвчих уур амьсгалыг бий болж байж энэ Авлига гэдэг юм буурна. Дэлхийд бол авлигалгүй улс гэж бараг байхгүй. Дани гэдэг улс 90 оноо авч 1 дүгээр байр эзэлсэн байгаа.

Хуучин социалист орнуудаас Латви гэдэг улс 12 дугаар байранд явж байна. Ийм л үр дүнтэй байгаа юм.

Тэгээд манай Авлигатай тэмцэх газрын хийж байгаа ажлыг бол бид бас үнэлэх ёстой 2022 онд энэ чинь 5 их наяд төгрөгийн хохирол учруулснаас 2,4 их наяд төгрөгийн төлүүлсэн байгаа шүү дээ. 2023 онд чинь 845 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 238 тэрбумыг нь бас оруулсан байгаа. Ингээд үзэхээр 238 тэрбум төгрөг гэдэг чинь өнгөрсөн жилийн төсвийн тэнцэл чинь бол 700-аад тэрбум төгрөгийн ашигтай байгаа шүү дээ. Үүний 3-ны 1-ийг нь энэ байгууллага оруулчихсан байгаа байхгүй юу. Тийм учраас эдний ажлыг бол бид нар бас үнэлэх ёстой гэж ингэж үзэж байна. Манай авлигатай тэмцэх ажлын сая үзүүлэлтээр бол 5 байр ухарчихсан 121-д орсон байгаа юм. Хахуулийн тэр эрсдэлийн матриц гэдэг үзүүлэлт бас 2 байраар ухарчихсан байгаа юм. Хууль дээдлэх ёсны тэр индекс дээр бас тийм дорвитой өөрчлөлт гараагүй байгаа юм. Инновацын индекс бол бас буурсан байгаа юм. Тэгэхээр бид чинь бол авлигыг илрүүлээд, тэр нөхөн төлүүлээд бодит эдийн засгийн тэр үзүүлэлтүүд нь гараад байна шүү дээ. Яагаад ингэж ухраад байдаг юм. Ер нь энийг яаж үнэлдэг юм бэ. Та бүгд оролцдог юм уу. Хийсэн ажлынхаа дүнг гаргаж өгдөг юм уу. Хаана энийг ингэж дүгнэдэг юм бэ. Тэр дүгнэсэн үзүүлэлтүүдийг нь та нар үзэх барих ийм боломж байдаг юм уу. Энийг л би асуух гэж байгаа юм. Энд хариулт өгөөч.

**Г.Занданишатар:** Дуламсүрэн комиссар хариулна. Доржсүрэнгийн Дуламсүрэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар.

**Д.Дуламсүрэн:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр авлигын төсөөллийн индексийг ерөнхийдөө жаахан буруу ойлгоод байдаг л даа. Энэ тусдаа нэг ийм судалгаа хийгээд тэр судалгааны дүн гардаг юм

шиг мэт. Гэтэл энэ бол ямар нэг байдлаар ийм тусдаа судалгаа, үнэлгээ бол явагддаггүй. Өмнө нь хийгдчихсэн судалгаанууд 13 эх сурвалжийн судалгаа дээр суурилж интеграцлаад тэгээд ийм дүн гаргадаг ийм судалгаа байгаа юм л даа. Тэгээд Монгол Улсын хувьд бол ер нь энэ судалгааны эх сурвалжийн хувьд бол 13-аас эхлээд сүүлдээ бол 9 гэсэн ийм эх сурвалжийн үнэлгээнд очиж суурилж байгаа. Энэ түрүүний сая Баттөмөр гишүүний ярьж байгаа энэ үзүүлэлтүүдийн гаргасан судалгаа, дээрээс нь экспортуудын судалгаа энэ тэр бас нөлөөлж байгаа юм л даа. Тэгэхээр энэ эх сурвалжуудын мэдээлэл бол өөр өөр байгаа юм л даа. Дэлхийн банкны улс орны бодлого институцийн үнэлгээ ямар байгаа юм бэ гэдгийг авч үздэг. Дэлхийн эдийн засгийн форумын үзэл бодлын судалгаа, глобал инсайт байгууллагын улс орнуудын эрсдэлийн түвшин, Бертисман сангийн шилжилтийн индекс, Ай Эм Ди дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл, үзэл бодлын судалгаа, Дэлхийн эрх зүйн төсөл буюу түрүүний хууль дээдлэх ёсны индекс, эрсдэлийн үнэлгээ ардчиллын олон талт байдлын төсөл, эдийн засгийн мэдээллийн нэгж улс орнуудын эрсдэлийн үнэлгээ гэсэн ийм үнэлгээнд Монгол Улс яаж үнэлэгдсэн юм бэ гэдэг энэ дүн мэдээ маань нэгтгэгдээд, тэгээд авлигын төсөөллийн индекс гэсэн ийм судалгаа болж гарч ирдэг юм байгаа юм. Тэгэхээр авлигын төсөөллийн индексийн судалгаагаар ер нь улс орнуудын дундаж бол түрүүн бас нэрлэж байсан. Ер нь 43 оноотой л явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ түвшинд авч үзэх юм бол төсөөллийн индексийн 43-аас доош үнэлгээтэй гарсан улс орнуудад бол тодорхой зөвлөмжүүдийг өгөхдөө нийтлэг байдлаар ер нь ямар шалтгаан нөхцөл байгаа юм бэ гэдгийг нь тодруулсан байдаг. Энэ дээр түрүүний нэрлэсэн гишүүдийн асуултад хариулахад дурдагдаж байсан нөхцөл байдлууд гарч ирж байгаа юм л даа. Тухайлах юм бол Монгол Улсын хувьд бол энэ иргэдийн мэдэх эрхийг хангахтай холбоотой, ил тод байдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой,

мэдээллээр хангах ийм нөхцөл боломж бол муу байна гэдэгтэй холбоод Шүгэл үлээгчийг хамгаалах статусыг бий болгохтой холбоотой асуудлуудыг хөндсөн байх жишээний.

Мөн түрүүн дурдагдсан энэ өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалттай холбоотой, ил тод нээлттэй байдалтай холбоотой асуудлуудыг бол дурддаг. Мөн улс төрийн институцийн хүсэл зоригийн илэрхийлэл ямар байсан юм. Батлагдаж байгаа хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа нөхцөл байдал гээд энэ бүгд маань яг нэгтгэгдээд яагаад гэвэл судалгааны үзүүлэлтүүд эх сурвалжийн нэрээс л үзэхэд бол ер нь эдийн засаг голлосон эдийн засгийн өсөлтийг хэрхэн нэмэгдүүлсэн бэ гэдэг дээр их фокусладаг гэдгийг бас энд хэлмээр байна. Ялангуяа нэг хүнд ноогдож байгаа ДНБ-ий хэмжээ ямар байгаа юм бэ гэдгээр бас тооцож үзэх шаардлага бол цаана нь харагдаж байдаг юм байна лээ. Ялангуяа энд авлигын төсөөллийн индексээр хамгийн өндөр оноотой авлигагүй гэж улс оронд бараг нэрлэгдэх дөхөж байгаа улс орнуудын хувьд бол ДНБ-ий өсөлт нэг хүнд ноогдож байгаа тоо бол маш өндөр байгаа. Ийм учраас авлигын төсөөллийн индексийг нэмэгдүүлэхийн тулд түрүүний дурдсан эх сурвалжуудад гарч байгаа асуултууд, түүний нөхцөл байдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой чиглэлд бол илүү анхаарах шаардлагатай гэдэг нь.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

**Б.Баттөмөр:** Авлигын эсрэг энэ парламент бол бас бодитой ажлууд хийсэн. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулсан. Авлигатай тэмцэх хуульд өөрчлөлт оруулсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулсан. Үүний үр дүн бол энэ 2024, 2025 оноос гарах байх. Тэгэхээр энэ хууль маань тэгээд дээрээс нь Авлигад тэмцэх үндэсний хөтөлбөрийн хөтөлбөр тэрийг хэрэгжүүлэх одоо ажлын

төлөвлөгөөнүүд бодит ажил болсноор бол Монголд авлигын индекс буурна гэсэн ийм хүлээлт бол байгаа. Хамгийн гол нь бол юу гэхээр эдийн засаг бол өсөж байгаа. Тэгэхдээ улам их өсөх боломж байгаа. Яагаад гэхээр авлига бол эдийн засгийг боомилдог. Дээрээс нь хамгийн аюултай нь бол юу гэхээр эдийн засгийн бүтэлгүйтлийг бас бий болгодог авлига. Тийм учраас хөгжихийн тулд Авлигатай тэмцэх ёстой. Авлигын эсрэг.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд явуулъя Асуулт хариултын цаг дууссан. Асуулт явсан. Гишүүд чуулганы танхимд цуглая. Асуулт хариултын цаг дууссан. Үг хэлэх гишүүн байна уу. Дэмжсэн, дэмжээгүй. Алга байна. Санал хураалт явуулна.

“Байнгын хороо авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасан. Горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энх-Амгалан сайд чуулган, их хурал нь амжилттай явж байна уу. Завсарлачихсан уу. Санал хураалт явуулна. Байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Чинбүрэн гишүүн суудалдаа суугаарай. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 24 гишүүн дэмжиж, 65,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэгдсэн хуралдаанд оролцогдсон гишүүдийн олонх нь Байнгын хорооноос гаргасан горимын саналыг дэмжсэн тул “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, тогтоолын төсөл



батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

12.34 цаг

Дараагийн асуудалд орно.

**“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Авлигатай тэмцэх газраас 2024 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг үндэслэн Хууль зүйн байнгын хорооны Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасныг баримтлан “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Энэ ингээд хоцорчихсон бусад байгууллагуудын цалин нэмсэн. Энэ чинь Улсын Их Хурлаас тогтоодог болчихоор энэ Улсын Их Хурлын дэргэдэх байгууллага хоцорчхоод байгаа юм. Бусад байгууллагууд ч гэсэн яаралтай нэг оруулж байна уу, үгүй юу. Нөгөө статистик аудит энэ тэр чинь бүгд 4 сарын 1-ээс бусад бүх байгууллагууд цалингаа нэмчихсэн. Төсөв дээр тавиад өгчихсөн тэгээд нөгөө Их Хурал тогтоодог учраас ингээд хоцорчхоод байгаа юм.

Одоо Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. 24 гишүүн дэмжиж, 55,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

12.36 цаг.

Дараагийн асуудалд орно.

**Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд

Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын иргэд олноор зорчдог гадаад улстай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсаас Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын 1959 оны конвенцод нэгдэн орох тухай хүсэлтийг Европын Зөвлөлийн Сайд нарын хороонд гаргаж тус хороо нь орлогч сайд нарын 2019 оны 63 дугаар хурлаар хэлэлцэн дэмжээд, урилга ирүүлсэн болно.

Монгол Улс гадаадын 24 улстай байгуулсан 39, 2 талт гэрээний үндсэн дээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэмт этгээд ялтан шилжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн байна.

Үүнд, ихэнх нь Зүүн Европ болон Азийн улсууд багтаж байна. Харин баруун Европын ихэнх улстай олон улсын конвенцуудад заасан тодорхой төрлийн гэмт хэргээс бусад гэмт хэргийн асуудлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх асуудлаар харилцах боломжгүй байна.

“Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Европын конвенцод Европын зөвлөлийн 48 гишүүн улс Европын зөвлөлийн гишүүн бус 5 улс нэгдэн орсон бөгөөд тус конвенцын гишүүн улсын тоонд Монгол Улсын иргэд, суралцах ажиллах бизнес болон аяллын зорилгоор олноор зорчдог, оршин суудаг Англи, Герман, Бельги, Рили, Ирланд, Швед зэрэг улсууд багтаж байна.

Энэхүү конвенцод нэгдэн орсноор манай улсын хуулийн байгууллагууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой зарим ажиллагааг, тухайлбал, нотлох баримт албажуулж авах мөрдөн

шалгах ажиллагаанд холбогдох этгээдийг байлцуулах гэмт хэргийн улмаас олдсон эд зүйл, хэрэгслийг хураан авах зэрэг тодорхой төрлийн ажиллагааг конвенцын гишүүн улсуудын нутаг дэвсгэрт гүйцэтгүүлж туслалцаа авах боломжтой болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу энэхүү конвенц нь заавал соёрхон батлах олон улсын гэрээ бөгөөд 10 дугаар зүйлийн 10.4 дэх заалтад заасны дагуу түүнд гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон улсын олон талт гэрээ тул Засгийн газрын хуралдаанаар тус конвенцод нэгдэн орох саналыг хэлэлцүүлэхдээ түүнийг Соёрхон батлах тухай хуулийн төсөл хуулийн төслийн үзэл баримтлалын хамт хэлэлцүүлсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлд Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг танилцуулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулга, санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасныг үндэслэн зөвшилцөх хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн ““Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай” Европын

конвенцыг соёрхон батлах тухай” хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Дээрх хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлсэн болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх төслийг дэмжиж, соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

““Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Европын конвенцыг соёрхон батлах тухай” хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн алга байна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нэргүйн Мягмар хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Сүхээгийн Сүхболд Гадаад харилцаа яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал, Чойжанцангийн Нарантуяа Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ,

гадаад хамтын ажиллагааны газрын дарга. Протоколд энэ хүмүүс тэмдэглэгдэж үлдэж байгаа. Одоо Байнгын хорооны саналаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэнээр хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцно гэж заасан. 39 гишүүнээр эцэслэн батлагдана.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг гишүүдийн ирц шаардлагатай үед Улсын Их Хурлын дарга зарлан хуралдуулж, санал хураалт явуулж болно гэсэн заалтын дагуу маргааш өглөө санал хураалт явуулахаар хойшлуулчихъя.

Улсын Их Хурлын чуулганы хурлын дэгийн тухай хуулиар 5 дахь өдрийн 10 цагаас хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна гэсэн дэгтэй. Тэр хуулийн дэгийн дагуу.

12.43 цаг.

Дараагийн асуудалд орно.

“Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна. Сайд байхгүй учраас хойшлууллаа.

**Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тул хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажсанцангийн Сарангэрэл танилцуулна. Энэ хуулийг бол орон нутагт иргэд сонгогчидтой уулзаж байхад гишүүд бас их дэмжиж асууж байна лээ шүү. Одоо шуурхай болгож ажлын хэсэг сайн ажилласан байх гэж найдаж байна. Ажлын хэсгийн дарга танилцуулна.

**Д.Сарангэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхболд, Адышаа, Баделхан, Батжаргал, Баттөмөр, Бат-Эрдэнэ, Баярсайхан, Бейсен, Дамдинням, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Одонтуяа, Пүрэвдорж, Учрал, Цэрэнпунцаг нараас 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1. Ахмад настны зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин зэрэг халдварт бус өвчин нь нас баралтын нэг шалтгаан болж байгаа нь буруу хооллолттой холбоотой байх магадлал өндөр бөгөөд зөв хооллох дадал зуршил нь эрүүл мэндээ сайжруулж, амьдралын чанарыг дээшлүүлэх чухал ач холбогдолтой тул ахмад настанд үзүүлэх үйлчилгээ хэсэгт зөв хооллолт гэж нэмэхээр;

2. Ганцаардал, ганцаардлаас үүссэн мэдрэмж нь сэтгэл санааг тогтворгүй болгож, амьдралын идэвх буурах, нойргүйдэх, оюуны чадамж буурах, амьдрах итгэлээ алдах, сэтгэл гутралд орох зэрэг сэтгэл зүйн ноцтой асуудалд хүргэдэг бөгөөд цаашилаад эрт нас барах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Иймд ахмад настанд үзүүлэх үйлчилгээг зохион байгуулах хэсэгт ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж зохион байгуулах талаар зохицуулалтыг өөрчлөн найруулахаар;

3. Эрүүл мэндийн тухай хуульд эрүүл мэндийн үйлчилгээг магадлан итгэмжлэл авснаас гадна тусгай зөвшөөрөлтэй эрүүл мэндийн байгууллага үзүүлэх эрхтэй байхаар зохицуулсан учраас тус хуульд нийцүүлж өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ болон ахмад настанд үзүүлэх сэргээн засах үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй магадлан итгэмжлэл авсан эрүүл мэндийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр;

4. Сүүлийн үед ахмад үе залуу үеийн харилцаа холбоо хамтын ажиллагаа улам хөндийрч энэ нь нийгмийн тулгамдсан асуудлын нэг болж байгаа бөгөөд ахмад болон залуу үеийг холбох, тулгарч байгаа асуудлыг хамтдаа даван туулах нийгмийн хэрэгцээ шаардлага бий болоод байна. Үүнтэй холбоотойгоор бүх шатны Засаг дарга нар, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд жил бүрийн ахмадын өдрийн хүрээнд 10 дугаар сарын эхний 7 хоногийн турш



ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг туршилагыг нь залуу үед хүргэх зэрэг арга хэмжээг зохион байгуулахаар;

5.Хөл, гар, шүдний протез, сонсох арга, эрхтний ортепедын хэрэгсэл, тэргэнцэр, нэн шаардлагатай тусгай хэрэгсэл худалдан авсан зардлын үнийн хөнгөлөлтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас бус Нийгмийн халамжийн сангаас олгохоор өөрчилж, хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаахаар;

6.Хуулийн төсөлд их, дээд сургуульд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, сувилагчийн мэргэжлээр суралцаж байгаа оюутны ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээний байгууллагад хийсэн сайн дурын ажлыг сургалтын хөтөлбөрийн дагуу хийх дадлагын ажлын цагт тооцож болно гэсэн нь эрүүл мэндийн болон боловсролын салбарын мэргэжлийн дадлага хийх үйл ажиллагаатай зөрчилдөж байгаа тул хасахаар;

7.Хуулийн төсөлд ахмадын байгууллагатай холбогдох зарим заалтаар нэг байгууллагад давуу эрх олгохоор байгаа нь Ахмад настны тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа тул хасахаар;

8.Хуулийн төслийн төрийн албатай холбогдох зохицуулалт нь Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зарчимтай зөрчилдөж байгаа тул хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаахаар тус тус тусгалаа.

Ажлын хэсгээс Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 24 санал, найруулгын шинжтэй 1 санал болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 17 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг хуулийн төсөлд ахмадын сангийн санхүүжилтийг улсын төсөвт тусгах тооцоолол, сангийн харьяаллын болон тэтгэвэр өвлөгдөх зохицуулалтыг дагасан хуульд нийцүүлсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Чинзориг хуулийн төсөлд ахмад настан, боловсролын байгууллагад ажиллах, насан туршийн боловсрол олгох чиглэлээр ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг хөдөлмөрийн болон боловсрол хариуцсан Засгийн газрын гишүүд хамтран хэрэгжүүлэхийг онцолсон шалтгаан болон тэдгээрийн цалин хөлс, урамшууллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа хуулийн төсөлд ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгэх зохицуулалтыг хэрхэн тусгасан болон ахмад насанд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлсэн эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын болон

албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданишатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Учрал гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хүрэлбаатарын Булгантуяа хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нэргүйн Энхбат Ю Зи Сан хуулийн фирмийн зөвлөх хуульч, Юрагийн Отгонбилэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын шинэчлэлтийг зохицуулах газрын шинжээч гэсэн ажлын хэсэг байна.

Чинбатын Ундрэм гишүүн асуулт асууна.

**Ч.Ундрэм:** Ахмад настны тухай хуулийг бол ер нь дэмжиж байна. Нэлээн хүлээлттэй хууль гэж би бодож байгаа. Тэгээд энэ хууль дээр ажлын хэсгээс асуух нэг асуулт нь ахмадын асрамжийн төв гэж бас байгаа. Энэ гадаад улс орнуудад бас ийм хувийн хөрөнгө оруулалттай ахмадууд нэг дороо цуглаад, зарим нь тэндээ бүр 1 дэхээс 5 дахь хүртэл байдаг ч юм уу, зарим нь бүрмөсөн тэндээ амьдраад, тэгээд нийгмийн харилцаанд ороод, хажуугаар нь эмчилгээ, сувилгаа, асаргаа нь ингээд явж байдаг ийм хувийн секторыг хөгжүүлэх тал дээр та хэд ажлын хэсэг

дээр ярьж энэ хуульд оруулж тусгасан юм байгаа юу гээд 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт энэ ахмад настнууд хөдөлмөрийн гэрээгээр ажиллах нөхцөлийг нь бол энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор оруулж ирж байгаад миний хувьд маш их баяртай байгаа юм. Гэхдээ бас хажуугаар нь Хөдөлмөрийн хуулийнхаа дагуу тэр хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын асуудал, тэгээд бас хэтэрхий бага дүнгээр ажиллуулчих вий гэхээс бас санаа зовж байгаа юм. Бас боломжийн цалин олгодог гэх мэтчилэн ахмадуудынхаа эрхийг хамгаалах асуудлыг бас нэлээн сайн анхаарах тийм нөхцөлүүд бүрдсэн үү, үгүй юу. Тэрийг бүрэн оруулж өгч чадсан уу гэдэг асуудал.

3 дугаарт бид нар энэ нийгмийн даатгалын багц хуулийг батлахдаа тэтгэвэр өвлөгддөг болгосон маш том түүхэн ийм өөрчлөлтийг хийж чадсан. Гэхдээ манай улсын дундаж наслалттай холбоотойгоор бас тэтгэвэрээ урт хугацаагаар авч чадахгүй байгаа хүмүүс байгаа шүү дээ. Тэгэхээр 20 хувь нь л өвлөгдөж байгаа. Үлдсэн 80 хувь нь ядаж энэ ахмадууд руу бусад ахмадууд руу чиглэсэн үйл ажиллагааны сан руу хуримтлагддаг ч юм уу тийм санхүүгийн зохицуулалт байж болох уу гэсэн ийм 3 асуулт асуумаар байна.

**Г.Занданишатар:** Ажлын хэсэг дээр 2 хүн хоцорч ирсэн байна. Будрагчаагийн Баярболд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц зохицуулалтын газрын дарга, Болдын Ундрал Хөдөлмөр нийгмийн хагмааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн ажлын хэсгийн ахлагч асуултад хариулна.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Ундрэм гишүүн маань Ахмад настны тухай

хуульд оруулсан гол зүйл, заалтуудыг хөндөж асууж байна. Ер нь бол өнөөдрийн байдлаар 300 ахмад л Батсүмбэрийн улсын харьяаллын асрамжийн газар асруулж байгаа. Хэрэгцээ бол маш өндөр байгаа. Тийм учраас зөвхөн улсын гэхгүйгээр хувийн салбар мөн энэ ахмад настны асрах энэ үйлчилгээнд бас хөрөнгө оруулалт хийх, хамтран ажиллах, үүнийхээ хүрээнд бас дэмжлэг авах ийм заалтуудыг оруулж өгсөн нь энэ хуулийн төслийн бол их том давуу тал байгаа. Яг ямар заалтаар хэрхэн яаж орсныг манай Отгонбилэг бол нэмээд хариулчихна байх.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулахаар энэ хуулийн төсөлд орсон. Түүнээс гадна Ундрэм гишүүн ээ, хэрвээ тухайн иргэн 65 нас хүрээгүй байхад нь хүчээр тэтгэвэрт гаргах асуудлыг энэ хуулиар бүрэн хориглож өгч байгаа нь өөрийн энэ хуулийн бас давуу тал болж байгаа. Тэгээд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ахмадууд маань тухайн байгууллагатай гэрээ хийгээд, цалингаа цагаар авах уу, өдрөөр авах уу, хоногоор авах уу, сараар авах уу гэдгээ шийдэх тэр шийдэл нь хуулиар мөн нээлттэй заагаад өгсөн байгаа.

Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой тэтгэвэр өвлөгдөх асуудлыг бол энэ хуулиар бид нар ер нь зохицуулалтад хүрээгүй. Энэ бол Тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар явж байгаа. Тэгэхдээ гишүүн асуусан учраас би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан энэ тэтгэвэр өвлөхтэй холбоотой асуудлыг Ундрэм гишүүнд бас тодруулаад хэлээд өгөх нь зүйтэй гэж бодож байна. Тэгээд Мөнхбаатар дарга аа 2 дугаар микрофонд үг өгөөд, дараа нь 3 дугаар микрофонд үг өгөөд Ундрэм гишүүний асуултыг гүйцэд хариулах боломжтой гэж бодож байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн ахлагч хариулсан. Нэмэлтээр мэдээлэл өгье. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулъя.

**Ю.Отгонбилэг:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны шинжээч Отгонбилэг гишүүний асуултад хариулъя. Хувийн хэвшлийг асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр бол хуулийн төслийн 7 дугаар зүйл дээр 4, 5 үйлчилгээг нэмсэн. Ялангуяа бол яг нөгөө ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ гэдгийг нэмсэн байгаа. Энэ дээр бол ахмад настныг олон төрлөөр зөвхөн байнгын асаргаа биш бас богино хугацаагаар асрах, түр асрах гэсэн энэ асуудлуудыг тусгаад төслийн 13 дугаар зүйл дээр энэ санхүүжилтийг нь тодорхой болгосон. Нийгмийн халамжийн сангаас ахмад настны чиглэлээр зарцуулж байгаа нийт хөрөнгийн 10-аас доошгүй хувийг халамж асрамжийн үйлчилгээнд зарцуулна гээд тодорхой заагаад өгчихсөн байгаа. Тэгэхээр санхүүжилт тодорхой болж байгаа. Тэгээд энэ үйлчилгээ үзүүлэх журмыг болохоор эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн сайдууд бол хамтран батлаад, тэгээд аймаг, дүүрэг нь бол гэрээ хийгээд явахаар зохицуулалтуудыг хийсэн. Мөн хувийн асрамжийн газруудыг дэмжих бас заалтуудыг дагалдах хуулиуд дээр тусгаж өгсөн байгаа юм.

Ахмад настныг ажиллуулахтай холбоотой асуудал дээр болохоор одоо бол ахмад настан бол ер нь мэдлэг туршилагатай хамгийн өндөр түвшний зөвлөх ажилтнууд байдаг. Тийм учраас заавал бүтэн цагаар биш тодорхой богино хугацаагаар ажиллаад, цалин хөлсийг нь бол зах зээлийн ханшаар нь бас тодорхой өндөр түвшинд өгөх асуудал нь болохоор ажил олгогч, ажилтан 2 хөдөлмөрийн гэрээгээр зохицуулах боломжтой байгаа. Хөдөлмөрийн хуулийн 104 дүгээр заалтын дагуу энэ заалтуудыг бол мөн тусгаж эшилж оруулсан байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Хариулт хангалттай юу. Нэмж хариулах уу. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье. Ундрал дарга хариулчихъя.



**Б.Ундрал:** Гишүүний асуултад хариулъя. Хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр бол нийгмийн даатгалын багц хууль дээр 7 сарын 1-нд бол бид нар өөрчлөлт оруулсан байгаа. Яг энэ нэмэлт, өөрчлөлт дээр бол өвлөх асуудлыг оруулаагүй явж байгаа. Хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр болохоор.

**Л.Мөнхбаатар:** Дараагийн гишүүн асуултаа асууя. Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тэр лобби бүлэг буюу санаачлагч 14 гишүүний нэг нь бол бас би байгаа. Тэгээд ахмадуудын өмнө тулгарч байгаа олон асуудлуудыг яг эрх зүйн хувьд нь санхүүжилтийн хувьд нь зохицуулах маш тодорхой нарийвчлан зохицуулах заалтуудыг оруулж өгснөөрөө энэ хууль маань их өндөр ач холбогдолтой байгаа. Ахмадуудтай уулзаж байх жишээлбэл хөдөлмөр эрхлэх дээр гэхэд эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүйгээс насаараа ялгаварлагдах юм уу эсвэл хөдөлмөрөө бодитоор үнэлүүлж чадахгүй байх гэх мэт олон асуудлууд тулгарч байсан бол бид энэ хууль дээр энэ зохицуулалтуудыг бол маш нарийвчлан хийж өгч байгаа. Одоо хагас цагаар юм уу, бүтэн цагаар юм уу, 7 хоногоор ажиллах бол тэр хүний хөдөлмөрийг хэрхэн яаж үнэлэх вэ, тэр хүн өөрөө нийгмийн даатгалын шимтгэл төлөх сонирхолгүй байгаа бол ажил олгогч тэрний 8,5 хувиа төлөхгүй байх ч гэдэг юм уу яг энэ зохицуулалтуудыг бол маш нарийн тусгаж өгснөөрөө тэр хүн ажлын байр дээр очоод хөдөлмөр эрхлэх бол асуудал тулгарахгүй байх энэ зохицуулалтуудыг маш сайн тусгаж өгсөн байгаа юм. Одоо бид нар очоод л ахмадуудтайгаа уулзаж байхад жишээ нь хороон дээр ахмадуудын маань үйл ажиллагаа явуулах ямар ч санхүүгийн зардал байхгүй учраас дүүргээсээ ч юм уу, хаа нэгтэйгээс дэмжлэг авах гээд л хөөрхий маш хэцүү байдаг. Тийм учраас

бид нар энэ дүүрэг болгон дээр ахмадын сан байна гэсэн. Гэхдээ Ахмадын сан маань өөрөө яг хороо дээрээ байрлавал илүү их ач холбогдолтой юм. Яагаад гэвэл энэ өөрөө яг бодит амьдрал дээрээ нийлэх асуудал гээд ахмадууд маань ярьж байсан. Тэгээд бид бас ажлын хэсэг дээр энэ санг хороо дээр нь байршуулчихвал ямар вэ гэхэд яах вэ Засгийн газрын тухай асуудал хариуцсан сайдын багцад нь ороод, тэгээд дүүрэг нь өөрөө тэр хороо руугаа энэ зохицуулалт явчих, хяналтыг нь тавьчих ийм зохицуулалт орж ирж байгаа гэж байгаа. Гэхдээ бид нар энийг хэлэлцүүлгийн явцад санг нь уг нь яг тэр тодорхой санхүүжилтүүд нь угаасаа 3-аас доошгүй хувь нь гээд заагаад өгчихсөн юм чинь тэрийг нь хороо дээр нь байршуулаад ахмадын сан дээр, тэгээд хяналтыг нь харин дүүрэг нь өөрөө хөдөлмөр халамжийн хэлтэс нь ч юм уу хяналтаа тавиад явчихдаг энэ бололцоонууд уг нь их чухал байгаа. Тэгээд хэлэлцүүлгийн явцад гишүүд маань энийг бас оруулж өгвөл зүгээр байгаа юм. Яагаад гэвэл энэ өөрөө ахмадуудаас гарч байгаа ийм санал байгаа юм.

Нөгөө талаасаа ахмадууд бас ингээд байгаа юм. Ипотекийн зээлд ахмадууд хамрагдах ямар ч боломж байхгүй байна. Энийг хязгаарлачихсан. Тэгэхээр бас 1 өрөө байр ч гэдэг юм уу ахмадын орон сууц энэ тэр орох бол ипотекийн зээлд хамрагдах, тэр нь өөрөө хуримтлалын сангаараа дамжуулаад ч юм уу баталгаа болчихдог. Эсвэл өөрсдөө мөнгө төгрөг боломж байгаад байхад ахмад хүмүүсийг ипотекийн зээлд хамруулах бололцоо байхгүй байгаа. Санхүүжилтээр ингээд тусгачихсан байгаа гээд арилжааны банк дээр маш хэцүү байгаад байна гэдэг саналууд бас уулзалтын үеэр гарч байсан. Тэгэхээр бид нар бас энэ мэтийн зохицуулалтуудыг хуримтлалын сантайгаа юм уу эсвэл нийгмийн даатгалын шимтгэл энэ тэртэйгээ уяад бас зохицуулалт хийх бололцоо олох хэрэгтэй юм байна лээ. Тэгээд энэ дээр би зүгээр та бүхнээсээ 1 асуултад хариулт авчихъя. Тэгээд

ипотекийн зээлийг ахмад настнуудад олгох. Одоо сая тэр нөгөө хуримтлалын санг 1,2 их наядыг гаргаад 2 сая төгрөгөөс доош орлоготой иргэдээ эхний ээлжид хамруулна. Ингэснээрээ чинээлэг дундаж давхарга буюу дундаж давхаргаа бэхжүүлэх бодлого Засгийн газар барьж байгааг Ерөнхий сайд хэлсэн. Энийг жишээ нь иргэд маш таатай хүлээж авч байгаа. Тэгэхээр энэ ипотекийн зээлийг бас ахмадууддаа хамруулах бололцоо ер нь ямар хуулийн зохицуулалтаар хийх бололцоотой вэ. Энэ дээр нэг хариулт авчихъя. Бусад зүйл дээр энэ хууль дээр үнэхээр ахмадуудын маань өмнө тулгарч байгаа асуудлуудыг цогцоор нь шийдэх ийм нэмэлт, өөрчлөлтүүд орж ирсэн байгаа гэдгийг би бас хэлчихье. Тэгээд саяын асуултдаа хариулт авчихъя. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Даваажанцангийн Сарангэрэл хариулъя.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа манай Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, манай Оюунчимэг гишүүн Ахмад настны хуулийн төсөл дээр бол нэлээн идэвхтэй ажилласан. Саяын шинэлэг зүйлүүд орсныг бол өөрөө бас ажлын хэсэгт ажилласны хувьд бол хэлж байна. Тэгэхээр Засгийн газраас гаргасан нэг томоохон энэ шийдвэр гэвэл 1,2 их наяд төгрөгийн хүрээнд 10 мянган өрхийг ипотекийн зээлд хамруулан орон сууцжуулах ийм нийгмийн хүсэн хүлээлтэй байгаа, эрэлтэд тулгуурласан ийм шийдвэрийг бол гаргасан байгаа. Тэгэхээр ахмад настнуудын хувьд бол ихэнхдээ ипотекийн зээлд хамрагдахаасаа илүүтэй түрээсийн орон сууцын асуудлыг бол хэрэгжүүлээд ингээд явж байгаа. Яг энэ 10 мянган иргэнийг орон сууцжуулах хүрээнд ахмадыг хэрхэн хамруулах энэ журам нь бол Засгийн газрын түвшинд гарахаар асуудал бас тодорхой болох байх гэж бодож байна. Энэ хуулийн хүрээнд бол бид нар ипотекийн зээлд ахмад настан хамрагдаж, орон сууцжуулах асуудлыг

бол хуулийн хүрээнд бол оруулаагүй байгаа.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах уу. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье. Нэр албан тушаалаа хэлээд асуултад хариулъя.

**А.Хишигбаяр:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хишигбаяр. Ахмад настны орон сууцтай холбоотой, ипотекийн зээлтэй холбоотой асуудал бол Баригал, хот байгуулалтын яам дээр орон сууцжуулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Яамнуудаас санал аваад явж байгаа. Энэ хүрээнд ахмад настны түрээсийн орон сууцад хамруулах гэдэг илүү зорилтот бүлэг рүү хэрхэн яаж орон сууцжуулах вэ, залуучуудыг хэрхэн яаж орон сууцжуулах вэ гэсэн бүхий л асуудлыг хамруулсан ийм хуулийн төсөл боловсруулаад яамнуудаас санал аваад явж байгаа. Тэгээд энэ дээр бол ахмад настны орон сууцжуулах асуудлыг бол нарийн тусгаад энэ хуулиараа бол зохицуулаад явна гэж харагдаж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал асуултаа асууя.

**Н.Учрал:** Ахмад настны энэ хуулийн төслийг бас Энхболд дарга санаачлаад, би бас санаачлагчийнх нь 1. Тэгэхээр Ахмад настны хууль бол энэ удаа орж ирж байгаа энэ концепцыг иргэд маань ойлгохдоо энийг бол халамжийн хууль гэж ойлгож огт болохгүй гэж бас хэлмээр байгаа юм. Тэгээд ахмад настанд төр нь өөрөө үйлчилгээ үзүүлнэ гэдэг бол энэ халамж ерөөсөө огт биш. Тэр хүн ухамсарт амьдралаа төр улсынхаа төлөө зориулаад, сар болгон нийгмийн даатгалын шимтгэл төлөөд, хөдөлмөрийн чадвараа алдсан үедээ төрөөсөө өрөө л одоо авч байна гэсэн үг шүү дээ ер нь бол. Тэгэхээр төр

ахмадууддаа хандах хандлагаа өөрчлөхгүй бол энэ зүгээр нэг ийм халамжийн тогтолцоо яваад байна гэдэг хандлагаар хандаж бол бид ерөөсөө болохгүй. Тийм ч учраас анх тэр тэтгэврийн хуулиудыг хэлэлцэж байхад ч гэсэн энэ сар болгон төлж байгаа шимтгэлийнхээ үр шимийг тэтгэвэрт гарахдаа хүртдэг тогтолцоо бол огт халамж биш. Энэ бол хөдөлмөрлөсөн хөлснийхөө үр шимийг эргээд хүртэж байгаа л хэлбэр. Тийм учраас энэ ахмад настны хууль дээр бол төрөөс үзүүлж байгаа үйлчилгээнүүдийгээ ингэж тухайлан зааж бас өгч энэ хуулийн төсөл боловсруулагдсан.

Тэгэхээр сая жишээ нь нэг ийм өөрсдөө хөгширөхгүй юм шиг бодож ханддаг нэг ийм дарга нартай бас болчихоод байна л даа. Тэгээд 1 өглөө сэргэхэд ахмадууд нийтийн тээврээр 7 хоногт 4 явна энэ тэр гээд ийм журам гаргачихдаг. Тэд ахмадууд чинь тэгээд өдөрт хэд л явав гэж дээ энэ автобусаар. Хэдэн жил ч явав гэж дээ. Тэгээд энийг нь хатуу хуульчилж өгөхгүй бол зүгээр нэг ийм орон нутгийн чанартай дарга нар гэнэт гарч ирээд 7 хоног та нар 3 л явна шүү. 4 явбал төлбөрөө төлөөрэй энэ тэр гэдэг чинь байж болохгүй шүү дээ. Тийм учраас энийг хатуу хуульчилж өгөх ёстой. Үгүй ээ, энэ ахмадууддаа төр нь насаар нь зүтгүүлчхээд автобусаар нэг үнэ төлбөргүй явуулчхаж бас болно шүү дээ. Тэгээд уулзалт хийхэд дандаа ийм энгийн асуудлуудыг ярьж байгаа байхгүй юу. Бид нар эрч хүчтэй үедээ бид нар энэ улс эх орныхоо төлөө зүтгэчихсэн байхад, эргээд хэдхэн жил ядаж яагаад бид нарыг автобусаар үнэгүй явуулж болдоггүй юм бэ гэдэг зүйлийг ахмадууд хэлдэг. Тэгэхээр ажлын хэсэг бол бас хариуцлагатай хэлэх ёстой. Энэ ажлын хэсэг ажилласан үеэрээ яг энэ заалтуудыг бас хамгаалж авч гарсан уу. Үүнийг хуульд яг тусгасан уу гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь бид төр өөрөө тэр ахмадууддаа тэтгэвэрт гарсных нь дараа үйлчилгээ үзүүлэхээсээ гадна

хувийн хэвшил ч гэсэн ахмадуудын төлөө ажиллах тэр хөшүүргийг бий болгож өгөх ёстой. Сая гишүүд ярьж байна. Жишээ нь Ундрам гишүүний асуулттай би бас дүйцүүлээд хэлэхэд жишээ нь Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль бол ирэх 7 хоногт хэлэлцэнэ. Хот, тосгоны эрх зүйн байдлын ажлын хэсэг дээр бид тодорхой санал гаргасан. Үнэхээр алслагдсан хот, сум, суурин газар үнэхээр тэр ахмадын өргөө байхгүй, ахмадын тэр халамжийн төвүүд байхгүй, ахмадын чөлөөт цагаа өнгөрүүлэх төв байхгүй байгаа хот, сум, суурин газар хэрвээ ахмадад зориулсан үйлчилгээг нэвтрүүлэх юм бол хувийн хэвшлийг бид нар бүх төрлийн татвараас 5 жил хойшлуулах ёстой. Тэгж байж тэр хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд тэр хот, сум, суурин газар ч гэдэг юм уу, ахмадад хандсан үйлчилгээ, чөлөөт цагаа өнгөрүүлэх төв, ахмадын өргөө байгуулахад хувийн хэвшлийг дэмжиж хөшүүрэг хийхгүй бол төр 100 хувь асуудлыг шийднэ гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр хувийн хэвшил бол зүгээр л тодорхой бодлогоор дэмжих юм бол бид нар бизнесийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулъя л гэж байгаа юм. Тийм учраас Хот, тосгоны хууль дээр энэ заалтыг бол ирэх 7 хоногт оруулж ирээд баталчихвал бас энэ 20 минутын хот концепцын хувьд бол энэ бас уялдана гэдэг ийм бодолтой байгаа.

**Л.Мөнхбаатар:** Асуулт юм уу. Үг хэлчхэв үү. Ажлын хэсгээс нэмж хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье. Отгонбилэг шинжээч.

**Ю.Отгонбилэг:** Учрал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яах вэ, бид нар бас хамт энэ ажлын хэсгээр ажиллаад нийтийн тээврийн газрынхны саналыг бас хэлэлцүүлэг дээр нэлээн авч тусгасан байгаа. Тэгээд энэ хуулийн 8.1.5-д болохоор ахмад настан орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих энэ асуудлыг тусгасныг илүү тодорхой болгож. Яагаад гэвэл сүүлийн жилүүдэд хөдөө орон нутгаас хотод түр хугацаагаар юм

уу, тодорхой хугацаагаар амьдарч байгаа ахмад настнууд нийтийн тээврээр зорчиход тэр хүний явсан зорилчилтынх нь мөнгийг хэн төлөх вэ гэдэг асуудал дээр бас маргаан гараад, тэгээд энэ нь шийдэгдэхгүй байгууллага хооронд мөнгөн төлбөр гараад байсан учраас нийслэлд орон нутгийн ахмад настан явах юм бол тэр ахмад настны төлбөрийг нийслэлээс хариуцна гэдгийг нь энд хуульчлаад өгчхөж байгаа. Дээрээс нь үнэ төлбөргүй зорчих гэдгийг нь бас тодорхой 8.1.5-д тодорхой тусгачихсан. Ийм учраас бол энэ нийтийн тээврийн асуудлыг бол ямар ч асуудалгүйгээр зохицуулах боломжтой болж байгаа юм.

Дараагийн асуудал болохоор тэр хувийн хэвшлийг дэмжих асуудал дээр энэ хуулийн төсөл дээр ААНОАТ-ын тухай хуульд Учрал гишүүн, бусад гишүүдийн саналыг бас тусгаад нийгмийн халамж, асрамжийн байгууллагатай гэрээ хийсэн аж ахуйн нэгж, байгууллагуудыг гэрээлсэн үнийн дүнгээр нь татвараас чөлөөлөх гэсэн заалт тусгасан байгаа. Мөн үйл ажиллагаа явуулж байгаа барилга байшингийнх нь тогтмол зардал ус, дулаан, цахилгаан ч юм уу тэр зардлыг нь орон нутгийн төсвөөс хариуцах, дээрээс нь гэрээлсэн үнийн дүнгээр нь улсаас тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх гэсэн заалтуудыг бол хуулийн төслийн 7 дугаар зүйл, 13 дугаар зүйлүүдэд нарийвчлан тусгасан юм.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах уу. Ажлын хэсгийн ахлагч Даваажанцангийн Сарангэрэл нэмж хариулъя.

**Д.Сарангэрэл:** Манай ажлын хэсэгт ажилласан Отгонбилэг маань ер нь тодорхой хариулчихлаа. Би зүгээр нэг ойлголтыг 1 мөр өгөхөд энэ хуулийг гарсны дараа бол ахмадуудын дунд яригдаад байгаа нэг асуудал бас шууд шийдэгдэх юм. Хөдөө, орон нутгаас Улаанбаатарт хүрч ирээд нийтийн тээврээр үйлчлүүлж байгаа ахмад настан харьяалал нь хөдөөгийнх учраас Улаанбаатарт нийтийн тээврээр

үйлчлүүлж байгаа чинь хамаарахгүй, мөнгөө төл гэдэг ийм асуудал яригдаад ахмадуудыгаа гомдоож байсан юм байна лээ. Одоогийн энэ хуулиар ахмад настан хаана явж байгаагаасаа, харьяаллаасаа үл хамааран нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих ойлголтыг энэ хуулиараа нэг мөр болгож өгч байгаа.

**Л.Мөнхбаатар:** Их тодорхой хариуллаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. 14 цагаас санал хураана.

13.11 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Одоо нэг асуудал байгаа. Манайхан сууж байгаарай.

**Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд Энхбаяр танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Төрийн тусгай хамгаалалтын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 1995 онд баталсан Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар Төрийн тусгай хамгаалалт, түүнийг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг анх удаа хуульчлан тогтоосноос хойш өнөөдрийг хүртэл хугацаанд улс орны эдийн засаг, нийгмийн эрх зүйн харилцаа, гадаад бодлогод ихээхэн дэвшил хөгжил өөрчлөлтүүд гарсан тул энэхүү хуулийг



шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлага үүслээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаагаар дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

Төрийн тусгай хамгаалалтын зорилгыг хэт ерөнхий тогтоож өгснөөс болж төрийн тусгай хамгаалалтаас ялгамжтай байдал тодорхой бус, хуулиар төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан иргэний шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүйгээс холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байна.

Объектыг төрийн тусгай хамгаалалтад авах шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүйгээс төрийн тусгай хамгаалалтад байгаа объектын хүрээ хэт өргөжиж, хамгаалалтын иж бүрэн байх зарчим алдагдсан байна. Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх арга хэлбэрийг хуулиар хатуу тогтоож өгсөн нь хамгаалалтын арга тактикийг өөрчлөх, олон нийт болон хамгаалуулагч нараас тавьж буй шаардлагад нийцүүлж уян хатан байх боломжийг хязгаарлаж байна.

Төрийн тусгай хамгаалалтын бүс, дэглэм тогтоох үйл ажиллагаа нь хуулиар тодорхой бус байна. Төрийн тусгай хамгаалалтын хуулиар тогтоосон төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг бусад хуулиар өргөжүүлэн тогтоодог хуулийн гажуудал бий болжээ.

Төрийн тусгай хамгаалалтын албан хаагчид тавих шаардлага, эрх зүйн байдал, эрх зүй, нийгмийн баталгаатай холбоотой зохицуулалт нь төрийн албаны болон бусад тусгай чиг үүргийн салбарын эрх зүйн шинэчлэлээс хоцорч, эрх зүйн байдал нь хийдэлтэй, эрх зүй нийгмийн баталгаа нь сул болжээ. Төрийн тусгай хамгаалалтад албадлага хэрэглэх үндэслэл журмыг хүний эрхийг хангах, хүндэтгэх зарчимд нийцүүлэх

шаардлага үүссэн. Иймд хуулийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийг арилгах, төрийн тусгай хамгаалалтын зорилго, хамрах хүрээг Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн оновчтой тогтоож, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтыг эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, алба хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, эрх зүйн баталгааг бүрдүүлэх чиглэлээр уг хуулийн төслийг шинэчлэн боловсрууллаа.

Төрийн тусгай хамгаалалтын хуулийн тухай шинэчилсэн найруулгын төсөл нь 7 бүлэг, 60 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд хуулийн зүйл, заалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хэл найруулга хийх, ойлгомжтой, тодорхой болох шинжтэй өөрчлөлтүүдийг хийсэн болно.

Хуулийн төсөлд бүх яамдын болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын саналыг авч, холбогдох саналуудыг тусгасан.

Эрхэм гишүүд ээ,

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Энхбаяр сайдад баярлалаа. Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Х.Баделхан:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.1.3-д үндэсний аюулгүй байдлаа хангах тухай тухайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно гэж, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 7.3.1-д хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг, гүйцэтгэх чадвар, чадавхыг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ гэж тус тус заасныг үндэслэн Засгийн газраас төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт хийх нийгмийн хөгжил, олон улсын харилцаа, хамтын ажиллагааны өөрчлөлттэй уялдуулан шинэчлэх үүднээс Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын төрийн орны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Баделхан гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, бригадын генерал Лхамсүрэнгийн Алтангэрэл, Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга, хурандаа Долгорсүрэнгийн Тэмүүлэн, Төрийн тусгай хамгаалалтын газрын Захиргаа, удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Хурцын Ууганбат, Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, хошууч Эрдэнэдашийн Ариунаа, Төрийн тусгай хамгаалалтын газрын Санхүүгийн



хэлтсийн дарга, хошууч Чойжамцын Бат-Очир нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна. Үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Байнгын хорооны саналаар санал хураалт явагдана. 14 цагаас явагдана. 13 цаг болсон тул цайны завсарлага. Чуулганы нэгдсэн хуралдаан 14 цагаас үргэлжилнэ.

13.19 цаг.

### ЗАВСАРЛАГА

**Г.Занданишатар:** Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын хаврын чуулганы 5 дугаар сарын 16-ны өдрийн үдээс хойших хуралдаан нээснийг мэдэгдье.

Одоо Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 42 санал байгаа. Энийгээ хойшлуулчихсан юм уу. Ахмад настны тухай хуулийг хойшлуулчихсан байгаа.

**Одоо Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлж хэлэлцэнэ.**

Гишүүд асуулт асууж, хариулт авч дуусчихсан байгаа.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглана. Цуглаагүй гишүүдийг нэрийг зарлан дуудна.

Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр гишүүн хаачсан. Пүрэвдорж гишүүн, Одонтуяа, Ганбат 2 гишүүн байсан. Дуудчих. Туваан, Батсуурь 2 ч гэсэн орж ирсэн юм сан. Гол нь энэ Чинзориг сайд хаачсан бэ. Б.Энх-Амгалан гишүүн яасан Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн. Санал хураалт явуулъя. Чойжоо гишүүн хаашаа алга болчихдог юм бэ. Хаваржин байсангүй, тэгээд л хааяа нэг ирэхээр алга болчих юм. Гишүүд суудалдаа сууя. Санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүн суудалдаа суучих. Санал хураалт явуулъя. Нямаагийн Энхболд гишүүн суудалдаа. Санал хураалт явуулъя. Нэр дурдсан хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа суугаарай. Нямаагийн Энхболд гишүүн суудалдаа суу. Санал хураалт. Батлут суудалдаа суу. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн нийт өмнө нь би дурдсан 12 хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Чинзориг гишүүн картаа битгий сугалаад бай. Санал хураалт. Төгтохсүрэн дарга энэ суудлын хуваарьт өөрчлөлт оруулаад Сарангэрэл гишүүн, Чинзориг сайд 2-ыг хамт суулгая.

Энэ миний санал эсрэг гарсан байна. Ийм учраас санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Энэ чинь бүртгэлийн санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Бямбацогт гишүүн санал хураалт карт чинь хийчихсэн байна уу. Баттөмөр гишүүн картаа уншуулаагүй байна. Картаа уншуулъя. Хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон тул Байнгын хорооны саналаар санал хураалтыг дахиж явуулъя. Гишүүд анхааралтай. Болорчулуун гишүүн. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, 56,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо Б.Энх-Амгалан гишүүнийг ирэх 7 хоногт шуурхай хэлэлцээд, ажлын хэсэгт туслаад, энэ хуулийг бас шуурхай ирэх 7 хоногт батлах зорилт тавьж ажиллах хэрэгтэй.

14.37 цаг.

Дараагийн асуудалд орно.

**Ахмад настны тухай хуулийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 32 санал байгаа.**

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.1.11 дэх заалтын “дасгал хөдөлгөөн,” гэсний өмнө “зөв хооллолт,” гэж нэмж, тус заалтын “эрүүл мэнд, нийгмийн оролцоог” гэснийг “эрүүл мэндийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл, Бадарчийн Жаргалмаа, Цэндийн Сандаг-Очир /цаашид “ажлын хэсэг” гэнэ/. Энэ хуулийг бол ахмадууд иргэдтэй уулзаж байхад ахмадууд иуурхай бас ажил хэрэгч баталж өгөхийг бас их хүсэж байгаа. Хуучин Ахмад настны хууль бол бас хэрэгжилт муутай, хоорондоо зөрчилтэй, асуудал ихтэй байсныг засаж өгөөрэй, баталж өгөөрэй гэж их ярьж байгаа. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт 57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.9<sup>1</sup>, 7.2.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.2.9<sup>1</sup> дэх заалтын дугаарыг 7.2.13 дахь заалт болгох:

“7.2.13.ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах, соёл, урлаг, спорт, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, сурч хөгжихөд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах;

7.2.11.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, өрх, сум, тосгоны эмч, эмнэлгийн мэргэжилтэн байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний эрүүл мэнд, ачааллыг

үнэлэн ахмад настныг энэ хуулийн 4.1.9-д заасан үйлчилгээнд хамруулах, эсхүл гэр бүлийн бусад гишүүдийн асрамжид шилжүүлэх талаар санал гаргах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ 7.2.13, 7.2.11 гэж дараалал нь буруу байна уу, дараалал дээр алдчихав уу. Санал хураалт 53,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.12, 7.2.13 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Дээр нь 7.2.13 гээд хэлчихсэн. Энэ дугаар алдчихсан юм уу. Энийгээ эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай. Тэгэхгүй бол 7.2.13 гэхээд тэгээд доор нь хасаад хаячих болчихоод байна шүү дээ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Юу гэнэ ээ, Пүрэвдорж гишүүн ээ. Пүрэвдорж гишүүн намайг Ахмадын хууль санаачилдаг их ээлтэй гишүүн гэж хэлж өгөөч ээ гэж байна. Энийг жич дараа нь санал хураалтын төгсгөлд бас шалгаж байгаад хэлнэ ээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.8.Энэ хуулийн 7.6-д заасан “Ахмадын өргөө” болон бусад төв төрийн болон орон нутгийн өмчит барилга, байгууламжид байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа бол барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвөөс хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Төв төрийн гээд байгаа юм. Энэ төв гэдэг илүү л юм шиг. Бусад төв гэж байхгүй л дээ. Энийг гүйцээж боловсруулъя. Тэгэх үү. Тэгэхгүй бол дараа нь хөдлөх хөрөнгийн ашиглалт гээд тэгчих юм бол үл хөдлөх хөрөнгө биш, хөдлөх хөрөнгө гэдэг чинь ингээд машин техник бүгд орно шүү дээ. Үл хөдлөх хөрөнгийн ашиглалтыг хэлж байгаа юм уу. Хөдлөх хөрөнгийн

ашиглалт юм уу. Тэгээд цэг, таслал чинь бас утга агуулгыг нь зөрүү болгочихдог. Энийг гүйцээн боловсруулчих чиглэл өглөө.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.1.4, 9.1.5, 9.1.6 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.13 дахь хэсэг болгох:

“9.13.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран дараах чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ:

9.13.1.хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран ахмад настныг боловсролын байгууллагад ажиллуулах;

9.13.2.хөдөлмөрийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран ахмад настныг эрүүл мэндийн байгууллагад ажиллуулах;

9.13.3.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран эрхлэх асуудлын хүрээнд ахмад настныг ажиллуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхдээ энэ эрхлэх асуудлын хүрээнд ахмад настныг шууд ажиллуулах гэж байгаа байхгүй юу. Энэ чинь дээдэх агуулга нь арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна гэж байгаа шүү дээ. Тийм ээ. Ахмад настныг ажиллуулах асуудлаар ажлын төлөвлөгөө боловсруулах гэсэн агуулгаар бичихгүй бол 2 гишүүн хамтраад л шууд ахмад настныг ажиллуулах юм шиг ийм ойлгомжгүй тэгж уншигдаад байна. Тэгээд энийг анхаараарай. Эцсийн хэлэлцүүлэг дээр найруулгын хувьд.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.1.7 дахь заалтыг доор

дурдсанаар өөрчлөн найруулж, 9.1.4 дэх заалт болгох:

“9.1.4.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд ажилласан ахмад настны цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасны дагуу тооцон гэрээний дагуу олгох.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал уначихлаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Би сая кноп дээрээ дараад, дараад болсонгүй. Энэ түрүүлээд дарчих шиг боллоо. Түрүүлээд дарахаар эсрэг гарчихдаг юм аа. Тэгээд энэ санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулж өгнө үү.

**Г.Занданшатар:** Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. Сарангэрэл гишүүн суугаарай. Санал хураалт унах гээд байна шүү. Санал хураалт. Пүрэвдорж гишүүний горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг хүчингүйд тооцон, санал хураалтыг дахиж явуулъя. 54,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгээд энэ Хөдөлмөрийн тухай хуулийн 104 гэхээр бодвол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулна л гэж, цагаар, өдрөөр гэдгээр нь явж байгаа юм уу.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.9.Ахмад настан хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллах бол Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасны дагуу тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Даатгалын хуулийн тэр 7.6-г нь эшилчихсэн юм байна. Силк хийгээд

татчих. 55,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.11 дэх хэсгийн “өөрөө хүсэлт гаргаагүй” гэсний өмнө “65 насанд хүрээгүй бөгөөд” гэж нэмж, 9.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.11, 9.12 дахь хэсгийн дугаарыг 9.10, 9.11 дэх хэсэг болгох:

“9.12.Аж ахуйн нэгж, байгууллага Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.4-т заасны дагуу ахмад настныг ажлын байраар хангана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхдээ ер нь бас зарим ажлыг бол ахмадууд илүү хийгээд байгаа шүү. Хүний хуучин, дээлийн шинэ гэдэг шиг. Ахмадууд бол одоо ерөөсөө одоо ингээд л Их Хуралд ч гэсэн харж байхад хурал чуулгандаа яс сууж байгаа нь, ажил хэрэгч байгаа нь.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9.10 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт Тогтохоо дарга аа, санал хураалт. 54,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 11.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.4.ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршилагыг залуу үед хүргэх зэрэг арга хэмжээг ахмадын өдрийн хүрээнд бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд 10 дугаар сарын 01-ээс 07-ны өдрүүдэд зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Одоо энэ Пүрэвдорж гишүүнийг магтаад, Чинзориг сайдыг загнамаар байдаг. 54,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.



11.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.6, 13.7, 13.9, 13.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13.5, 13.6, 13.8, 13.9 дэх хэсэг болгох:

“13.5.Нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг нийгмийн хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлнэ.

13.6.Энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зориулан зарцуулах нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна.

13.8.Энэ хуулийн 9.13-д заасан арга хэмжээний зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, боловсрол, эрүүл мэндийн болон холбогдох асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

13.9.Энэ хуулийн 7.1, 8.1.1, 8.1.2, 10.1.2, 10.2-т заасан үйлчилгээг цахимжуулах, давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитоор олгох зорилгоор ахмад настны Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглаж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ хуулийн эрх баригч чинь хэн юм. Тамгын газраас. Нямбаяр чи Монгол хэлний найруулга зүйдээ анхаарахгүй бол хүн ойлгоход аягүй хэцүү. Хууль энгийн ойлгомжтой болох ёстой. Ахмад настны Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн заасан мэдээллийг ашиглаж болно. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1-д заасан ахмад настны мэдээллийг ашиглаж болно гээд энэ өгүүлбэрийн байрлал зүй энэ тэрээ зөв хийхгүй бол энэ чинь ойлгомжгүй болоод найруулга дээр анхаараарай Нямбаяр.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.5, 13.10 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 22 гишүүн. Ануужин гишүүн.

**П.Ануужин:** Сая төхөөрөмж ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

**Г.Занданшатар:** Төхөөрөмж ч ун нь ажиллаад л байгаа л даа. Тэгээд хүчингүй болгох санал хураалт явуулъя. Ануужин гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Чинзориг сайд, хөөе Чинзориг гишүүн суудалдаа сууя. Та санал үймүүлээд байна. Саналаа өг. 52,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Сая чинь хүчингүй болгох санал хураасан. Санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14.9 дэх хэсгийн “ахмадын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал” гэснийг “Ахмадын сан”-ийн үйл ажиллагааны тайлан” гэж, “харьяалагдах дээд байгууллагадаа тайлагнаж, хамт олондоо мэдээлнэ.” гэснийг “байгууллагын нийт ажилтны хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14.10, 14.11 дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.5 дахь хэсгийн “үзүүлэх” гэснийг “үзүүлж” гэж, “ахмадын мэдээллийн санг бүрдүүлэн, баяжуулж, дүгнэлт гаргана” гэснийг “хяналт тавина” гэж, 15.8 дахь хэсгийн “15.2, 15.4, 15.7-д заасан гэрээ, хэрэгжүүлэх төсөл” гэснийг “15.2, 15.3-

т заасан гэрээ, төсөл” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “дэмжлэг үзүүлэх, оролцох, хяналт тавих, хөдөлмөр эрхлэлтэд” гэснийг хасаж, 15.5, 15.8, 15.9 дэх хэсгийн дугаарыг 15.4, 15.6, 15.7 дахь хэсэг болгох:

“15.7.Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага 50 ба түүнээс дээш ахмад настантай бол ахмадуудтайгаа харилцах үндсэн чиг үүрэгт зөвлөх болон туслах үүрэгтэйгээр ахмад настныг төлөөлсөн нэг хүнийг гэрээгээр ажиллуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгээд хуульд бол ингээд ажиллуулна гэвэл зүгээр гэрээгээр ажиллуулна гээд л шууд заачих ёстой юм байгаа юм. Болно гэхээр сайн дурын шинж чанартай болоод тэртээ тэргүй хувийн хэвшил ч байна уу аль байгууллагад ажиллуулж болох нь нээлттэй. Хуулиар хориглоогүй бол гэж болох юмыг болно гэдэг заалтууд бол их л бүрхэгдүүлж байгаа. Энийг эцсийн хэлэлцүүлэгт анхаараарай.

16.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.4, 15.7 дахь хэсгийг тус тус хасах Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 16.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 2 дугаар зүйлийн “болон ахмад настны өмчлөлийн байр, орон сууц, газар, бусад эд хөрөнгө, тэтгэвэр, мөнгөн хөрөнгийг нь түүний зөвшөөрөлгүйгээр болон айлган сүрдүүлэх, дарамт, шахалт үзүүлэн хүч хэрэглэн авч ашиглах зэргээр” гэснийг “ахмад настны тэтгэвэр, тэтгэмж, Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд заасан хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан,” гэж өөрчилж, “7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7.2.5 заалтын “үйл ажиллагааг” гэсний өмнө

“болон ахмад настны сайн дурын” гэж” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ бол сайн заалт байна.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ тэгэхдээ иргэний хуулийн 84 гэхээр өөрөө өмчилж байгаа, эзэмшиж байгаа орон сууцыг хэлж байгаа юм л даа. Түрээсэлж байгааг хэлэхгүй байгаа юм.

19.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Энэ хуулийн 4.1.7-4.1.9, 4.1.11, 7.1-д заасан үйл ажиллагааны журмыг дараах байдлаар баталж, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ.

7.3.1.энэ хуулийн 4.1.7-4.1.9, 4.1.11-д заасан үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ үзүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлэх;

7.3.2.энэ хуулийн 7.1.6, 7.1.12-т заасан үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн, эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

7.3.3.энэ хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага 7.3.1-д заасан сонгон шалгаруулах журмын дагуу гэрээний үндсэн дээр иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.



20.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг үзүүлэх зорилгоор нутгийн захиргааны байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага аймаг, дүүрэг, сум, тосгон, хороонд “Ахмадын өргөө”, сэргээн засах, идэвхтэй насжилтыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулах төвийг байгуулан ажиллуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 56,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Нямбаяраа аа, энэ тосгон гэдгийн ард таслал байхгүй шүү. Тосгон, хороонд гэж байгаа юм уу. Тосгон гэж байвал тэгвэл хот тосгон хороонд гэж орно. Одоо бүгд хот тосгоны хуулиар хот болж байгаа шүү дээ. Аймгийн төвүүд.

Жаргалмаа гишүүний яриад байсан нөгөө хувийн хэвшил, Ундрам гишүүн яриад байсан тэр хувийн хэвшил нөгөө Хятад энэ тэрд ахмадын үйлчилгээ үзүүлдэг төвүүд байдаг шүү дээ тээ. Тоглодог, нааддаг тийм юмнуудыг байгуулахыг энд нээж байгаа юм байна лээ. Нээлттэй болгож байна гэсэн үг шүү дээ. Энэ дээр харин дэмжлэг, урамшуулал. Тэгээд тэр Насан туршийн боловсролын төв гэж нэг юм байгаа юм байгаа юм л даа. Тэр энэ тэр байвал зүгээр. Санал хураалт явуулъя. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 8.1.1 дэх заалтын “Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох” гэснийг “нийгмийн халамжийн сангаас олгох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22. Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 15.1, 15.2 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,8 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 5 дугаар зүйлээс “13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “7.1-д заасан үйлчилгээ”” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн “тус тус” гэсний өмнө “, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “7.1-д заасан үйлчилгээ” гэснийг “7.1.1-7.1.5, 7.1.7-7.1.11-д заасан үйлчилгээг нийгмийн халамжийн сан болон орон нутгийн төсвөөс” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 4 дүгээр зүйлийн “үйлчилгээ, дэмжлэг хүндэтгэлийн хэмжээ” гэснийг “Хоёрдугаар бүлэгт заасан ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хүндэтгэлийн хэмжээ” гэж, “дэмжлэгийн хэмжээ” гэснийг “8, 10-12 дугаар зүйлд заасан ахмад настанд үзүүлэх дэмжлэгийн хэмжээ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Хэний төхөөрөмж ажилласангүй вэ. Балжиннямын Баярсайхан гишүүн.

**Б.Баярсайхан:** Дарга аа, төхөөрөмж ажилласангүй ээ. Санал хураалтыг хүчингүй болгож дахин явуулж өгнө үү.

**Г.Занданшатар:** Таныг орж ирэхээс өмнө төхөөрөмж ажиллахгүй гэж байхгүй л дээ гээд нөгөө төхөөрөмжийн байгууллага нь гомдол гаргаад өгчихсөн юм. Тэгээд өөр саналаар систем ажиллаж болохгүй байна гээд.

Баярсайхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүнээ суудалдаа суу. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ яамныхан их залуужсан учраас хуулийн найруулга нь бас их тийм залуужсан юм шиг байна. Хүчингүй болгох санал хураалт дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя. Санал

хураалт. 62,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

### **Найруулгын санал**

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.9 дэх заалтын “иргэн” гэсний өмнө “төрийн байгууллага” гэж нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.8 дахь заалтын “цогцоор” гэснийг “цогц үйлчилгээ” гэж, 4.1.9 дэх заалтын “өдрөөр, түр, урт хугацаанд байрлуулан асрах, байнга асрах төрөлжсөн асрамжийн, асралт гэр бүлээр асруулах, гэрээр асрах зэрэг бусад шаардлагатай үйлчилгээг” гэснийг “ахмад настныг төрөлжсөн асрамжийн, гэрээр, асралт гэр бүлээр, өдрөөр, түр, урт хугацаагаар, байнга асрах үйлчилгээг” гэж, 4.1.11 дэх заалтын “онол, арга зүй, мэргэшлийн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх” гэснийг “мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 7.2.14 дэх заалтын “зарим” гэснийг “шаардлагатай” гэж, 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 13.8 дахь хэсгийн “зээлийн зардлыг оруулахгүйгээр” гэснийг “зээлийн хэмжээг тооцохгүйгээр” гэж, 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.3 дахь хэсгийн “хэсэгчлэн болон бүрэн” гэснийг “хэсэгчлэн, эсхүл бүрэн” гэж, 2 дугаар зүйлийн “төсвийн байгууллага, тухайн жилийн төсвийн зардалдаа тусган” гэснийг “төсвийн байгууллага, тухайн жилийн төсөвт тусган” гэж, 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 8.1.6 дахь заалтын “үнэ төлбөргүй зорчих” гэснийг “ахмад настны нийтийн тээврээр зорчсон” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.9 дэх заалтын “төрийн бус” гэсний өмнөх “төрийн болон” гэснийг, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын “орох бөгөөд үнэлгээг хийхдээ ахмад настанд чирэгдэлгүй байхыг анхааран” гэснийг, 2

дугаар зүйлийн “хөнгөлөлтийн” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Одоо яг талдаа л орж байна шүү. Талаас өнгөрсөн байна. Сууцгааж байгаарай.

Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. 5 дугаар сарын 12-нд Улсын Их Хурлын гишүүн Жавхлан Лувсангийн Болд, Мэндбаярын Энхмандах нарын дунд хүү болон эхээс мэндэлжээ. Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланд болон төрүүлсэн ээж Мэндбаярын Энхмандахад төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээд ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

**Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 19.12 дахь хэсгийн “хэмжээ,” гэсний өмнө “хэлбэр,” гэж нэмж, 19.14 дэх хэсгийн “19.11-д заасны дагуу ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулж байгаа” гэснийг “9.1.1-д заасан үйлчилгээг ахмад настанд үзүүлж байгаа” гэж, “хувийн хэвшил, төрийн бус байгууллагад” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагад” гэж, “заасан нормативын дагуу” гэснийг “заасны дагуу” гэж, “тооцох бөгөөд” гэснийг “тооцох” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ дээр 19.11 гээд бичигдчихсэн юм байна 9.1 гэж ойлгох юм уу тэ 9.1.1 Үгүй ээ энэ 19.19.12 гэж явж байгаа шүү дээ тэгээд 19.14 дэх хэсгийн 19.11 гэхээр ингээж ташираараа алдана гэж баймааргүй юм. Тэгээд гэснийг 19.1.1-д заасан үйлчилгээг гэж байгаа юм. Тэрийг 9.1.1 гэж унших ёстой юм уу. Энэ дээр бол ингээд биччихсэн юм байна. Нямбаяр энэ найруулга дээрээ. Энийгээ гүйцээж анхаараарай.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 19.15 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

### **Найруулгын санал**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 19.11. дэх хэсгийг “хувийн хэвшил, төрийн бус байгууллагад” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллагад” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 15.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.16.нийгмийн халамжийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний үйл ажиллагааны зардал;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энхболд дарга аа, түрүүний хууль дээр 9.1.1 гэсэн заалт байхгүй байна шүү. 19.1.1 л гэж байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 15.1.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.17.асрамж, халамжийн байгууллага үйл ажиллагаагаа явуулах байрыг шинээр барих, тохижуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх зорилгоор үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, хандив.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Одоо Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.**

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарчмын талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 16.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.8."Ахмадын сан" байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 76.1.19 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**5.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтаа явуулъя.**

Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**6. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.**

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 16.1<sup>1</sup> дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.21 дэх хэсэг болгох:

“16.21. Энэ хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-д заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын дэргэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Эмнэлэг хяналтын комисс ажиллуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,4 хувийн саналаар нийт санал дэмжигдсэн.

2 Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16.1<sup>2</sup> хэсгийн “дүрэм” гэснийг, “ажиллах журам” гэж, “16.1<sup>2</sup>” дугаарыг, “16.22.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 27 гишүүн дэмжиж 61,4 хувийн санал дэмжигдлээ.

**7. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.**

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “1.2<sup>1</sup>” дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3. дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3. тэтгэвэр, тэтгэмж, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл

хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.**

Нэг төслийн 1 дүгээр зүйлийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.3<sup>1</sup> дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 4.5 дахь заалт болгох гэснээ 4.4 гэгчхсэн юм. Энэ юу гэсэн үг юм Нямбаяр аа. 4.5 дахь заалт болгох гэснээ 4.4 гэдэг нь. Тэгвэл энэ 4.5 биш 4.4 дэх заалт болгох гэж найруулна шүү дээ. Яагаад ийм их алдаатай юм хийж байна аа. Ийм хууль ингэж орж ирж байгаагүй ер нь.

“4.4. Ахмад настны тэтгэвэр, тэтгэмжээ ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тийм учраас Хүмүүнлэгийн боловсролын хууль батлах хэрэгтэй байгаа юм. Энэ Аубакир гишүүн хаачсан бэ. Энэ Аубакир гишүүн энэ хуулийг явуулахгүй бол одоо өөр гишүүнд өгөх хэрэгтэй. Хүмүүнлэгийн боловсролын хуулийг ер нь 2 жил дарж хэвтлээ. 57,8 хувийн саналаар санал дэмжигдсэн.

9. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төслийн 2 дугаар зүйлийн 35.2.6 дахь заалтын “түр байрлуулах, түр хоноглох зэрэг газар байрлаж байсан” гэснийг, “түр байрлуулах газарт байсан,” гэж, “бөгөөд” гэснийг



“тохиолдолд” гэж, “садан” гэснийг, “садангийн хүн” гэж тус тус өөрчилж, тус заалтын “тэнэмэл амьдралтай” гэснийг, “иргэн нас барсан” гэсний өмнөх “ганц бие” гэснийг, “түүний” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 35.2.7 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Наад саналаа өг өө. Эмэгтэй хүмүүсийн хооронд эр хүн яс хаях муухай байдаг юм. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хамт Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

15.25 цаг.

Дараагийн хуульд орно. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцчихсэн.

**Дараагийнх нь Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн

Баттөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Мөнхбаатар:** Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр танилцуулна.

**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлаас 2021 оны 1 сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар системд нөлөө бүхий банкнуудыг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн зохион байгуулах шаардлагыг тогтоосон бөгөөд үүний дагуу Хаан Банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт, Хас, Төрийн банкнуудаас анх удаагаа хувьцаагаа олон нийтэд санал болгон хөрөнгийн зах зээл дээр амжилттай гаргасан.

Системд нөлөө бүхий 5 банк 2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 6 дугаар сарын хугацаанд нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-11,4 хувьтай тэнцэх хувьцааг олон нийтэд санал болгосон бөгөөд анхдагч зах зээлийн захиалга нь анхны саналаас 17,2-204,6 хувиар илүү биелж, банкнуудаас хувьцаагаа олон нийтэд санал болгох үйл ажиллагаа бүгд амжилттай хэрэгжсэн. Эхний үр дүнд эдгээр 5 банк Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 6,5 хувьтай тэнцэх хэмжээний 446,8 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг харьцангуй богино хугацаанд татаж төвлөрүүлсэн.

Монголын банкнуудын хувь эзэмшлийг бууруулахад дотоодын хөрөнгийн захын төлбөрийн хөрвөх чадвар ханасан гэж олон улсын байгууллагуудаас дүгнэсэн бөгөөд нийт арилжааны банкнуудын хувьцаа эзэмшлийг 9 дүгээр сарын 30-ны байдлаар авч үзвэл цөөн тооны томоохон хувьцаа эзэмшигчид суурилсан бүтэцтэй, хувьцааны төвлөрөл өндөртэй бөгөөд хамгийн их өндөр хувьцаа эзэмшиж байгаа 3 хувьцаа эзэмшигч нь

тухайн банкныхаа хувь нийлүүлсэн хөрөнгийн дийлэнхийг эзэмшиж байна.

Банкны системд нөлөө бүхий банкнуудаас Хас банкаас бусад банкны томоохон хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл 85-аас дээш хувийн төвлөрөлтэй байгаа бол бусад банкнуудын хувьд 76.6-100 хүртэл төвлөрөлтэй байна. Уг төвлөрлийг хуульд заасан 20 хүртэл хувиар бууруулахад банкны салбарын хэмжээнд нийт 1,8-2,1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Банкны хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний дотор 20 хувь болгож бууруулах хүрээнд банкнууд болон Монгол банкны зүгээс санаачилга гарган ажиллаж байгаа хэдий ч банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах үйл явц нь гадаад, дотоод олон хүчин зүйлээс хамаарч ихэнх банкнуудын хувьд цаг хугацаандаа биелэх боломж хязгаарлагдмал байгааг дараах нөхцөл байдал харуулж байна.

Банкнуудын нийт хувьцаагаа санал болгох замаар хөрөнгийн зах зээлээс ихээхэн хэмжээний эх үүсвэр татаад удаагүй байгаа өнөөгийн нөхцөлд их хэмжээний хувьцааг богино хугацаанд харьцангуй өндөр үнэлгээтэйгээр худалдан борлуулах шаардлага үүсэж байгаа нь цаашид банкнуудын хувьцааны нийт эрэлт нийлүүлэлтээсээ бага болсноор банкнуудын хувьцааны ханшид сөрөг нөлөө үзүүлж, компанийн зах зээлийн үнэлгээ буурах, улмаар банкнууд болон хувьцаа эзэмшигчдэд томоохон бэрхшээл хүндрэлтэй тулгарч болжгүй байна. Банкнууд олон улсын хөрөнгийн зах зээл дээр хувьцаагаа гаргах үйл ажиллагаа нь ихээхэн цаг хугацаа шаардагдаж байгаа.

Монгол Улсын прокурорын байгууллагаас зарим банкнуудын нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг шилжих хөдөлгөөний тодорхой хугацаагаар хязгаарласан нь эдгээр банкнуудын хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд санхүүгийн

салбарын тогтвортой байдлыг хангах, банкны салбарын нийт хувьцаа эзэмшигчдийн өмчилж байгаа хувьцааны үнэ цэнийг хадгалах, банкны эзэмшлийн хувийн эзэмшлийн төвлөрлийг бууруулах зохицуулалтыг банкны салбарт амжилттай хэрэгжүүлэх зорилгын хүрээнд хөрөнгө оруулагч болон хувьцаа эзэмшигчид боломжит хугацаа өгөх шаардлага үүсээд байгаа.

Олон улсын валютын сангаас 2023 оны 10 дугаар сард олон нийтэд танилцуулсан Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлын тайланд Монгол Улс банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал гэдгийг онцлон тэмдэглэсэн.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон банкны салбарыг чадавхжуулах, дунд хугацааны хөтөлбөр Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 онд хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, зээлийн хүүг бууруулах стратеги зэрэг богино, дунд хугацааны бодлогын баримт бичгийг судлан банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх олон улсын мэргэжлийн байгууллагын саналыг харгалзсан.

Хадгаламжийн даатгалын корпорац болон Монголын банкны холбоо, банкуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгээс боловсруулсан бөгөөд хуульд заасан дагуу төслийн талаар олон нийтээс санал авах зорилгоор Монгол банкны цахим хуудас нээлттэй байршуулсан боловч тодорхой саналууд ирээгүй. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь банкнуудын нийт хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулж, шинэ хөрөнгө оруулагчаар дамжуулан банкны



зохистой засаглалыг сайжруулах, шат дараалсан хяналтын хэрэгжилтийг хангуулах, банкны төвлөрлийн эрсдэлийг бууруулах, хязгаарлалтыг мөрдүүлэх, өөрийн хөрөнгийн бүтэц, чанарыг сайжруулах, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, банк болон олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох, мөн банкны салбарын тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой гэж үзэж байна. Хуулийн төслийг хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье. Баярлалаа анхаарал тавьсанд.

**Г.Занданишатар:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Дашдондогийн Ганбат гишүүн, Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Өө уучлаарай. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

**М.Оюунчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 19-ний, 5 дугаар сарын 15-ны өдрүүдийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, банкны салбарын нийт хувьцаа эзэмшигчийн өмчилж байгаа хувьцааны үнэ цэнийг хадгалах, банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах зохицуулалтыг амжилттай хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хөрөнгө оруулагчид

болон хувьцаа эзэмшигчдэд боломжит хугацаа олгох шаардлагын үүднээс Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийн талаар болон Монгол банкнаас хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авсан арга хэмжээ нь хангалтгүй байгаа талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданишатар:** Хууль санаачлагч болон байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Тасаллаа. Цогтгэрэл гишүүн байсан. Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Түрүүн байсан. Ганибалын Амартүвшин гишүүн.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Банкны тухай хуулийг 2021 оны 1 сард нэмэлт,

өөрчлөлт ийг баталсан. Тэрнээс хойш хангалттай хугацаа уг нь өнгөрсөн байна л даа. Тэгэхээр яг энэ дээр бол Монголбанкны удирдлагууд яг арилжааны банкнуудтай яаж ажилласан юм. Ямар шаардлага хүргүүлсэн юм. Ямар арга хэмжээ авсан юм бэ. Өөрөөр хэлбэл 1 сарын 1-нд хэрэгжих ёстой хууль нь хэрэгжихгүй банкнууд нь хуулиа зөрчөөд явж байхад энэ хооронд Монголбанк ямар ямар арга хэмжээ авсан юм. Удирдлагуудтай нь уулзаж ярьсан юм уу. Тэр банкнууд нь яг энэ эзэмшлийнхээ төлбөрийг бууруулах тал дээр ямар нэгэн төлөвлөгөө гаргаж өгсөн юм уу. Танилцуулсан юм уу. Энэ дээр 1 дүгээрт асууя.

2 дугаарт одоо энэ санал болгож байгаа өөрчлөлтөөр бас л хэдүүлээ хэдэн жилийн 2, 3 жилийн дараа дахиад л ийм байдалд орох вий дээ. Өнгөрсөн 2, 3 жилийн хугацаанд юу ч өөрчлөгдөөгүй. Боломжгүй байна, ийм хэмжээний хөрөнгө босох ямар ч боломж алга гэж ярьж байсан энэ яриа чинь үргэлжлүүлээд л явах юм биш үү. Өөрөөр хэлбэл та нар яаж хугацаагаар нь шахах юм. Гол нь энэ Баттөмөр гишүүний оруулж ирсэн хуулийн төсөл дээр яг энэ шат дараалалтай бас нэг ийм хугацаануудыг тавимаар байгаа байхгүй юу. Энэ 2024 оны эцэст ийм арга хэмжээ авсан байна. 2025 онд ийм арга хэмжээ аваад, биелүүлсэн байх ёстой гэсэн ийм шаардлагууд тавимаар байна л даа. Тэгэхлээр энэ дээр ямар бодолтой байгаа юм Монголбанкны удирдлагууд.

3 дугаарт бодлогын хүү 11 хувь болсон. Өөрөөр хэлбэл системээр хүүгийн хэмжээ буурч байна гэсэн үг. Инфляцын хэмжээ 7-оос доошоо орсон гэсэн үг. Гэтэл зээлийн хүү бол өндөр хэвээрээ. Арилжааны зээл, Засгийн газрын ямар нэгэн хөнгөлөлтгүй зээлүүд бол бүгд 20-оос дээш хувьтай байна. Энэ дээр Монгол банк яг ямар арга хэмжээ авах юм. Энэ аж ахуйн нэгжүүд, иргэд чинь цалингийн зээлийнхээ зүгээр хүүг төлөөд л хугацаа нь дуусахаар дахиад л шинээр зээл аваад л өмнө нь авсан зээлээ дахин

санхүүжүүлээд л явж байна шүү дээ. Зээлээс зээлээр амьдарч байна. Тэгэхээр энэ дээр Монголбанкныхан маш тодорхой хариулт өгмөөр байна. Ер нь бол өмнө ч гэсэн би хэлж байсан. Банк, санхүүтэй холбоотой асуудал ярих болгонд энэ арилжааны банкнуудыг илүү тэр 10 их наяд Монголбанкны үнэт цаас дээр байгаа мөнгөө илүү арилжааны зээл, бодит эдийн засгийн санхүүжилт тал руугаа оруулаач. Энэ дээр Монголбанк бодлогоороо дэмжээч. Тэр барьцаа хөрөнгийнх нь шаардлагаа бууруулаач. Энэ барьцаа хөрөнгө, зээлийн ангиллын журам чинь хатуу хэвээрээ л байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт өгнө үү.

**Г.Занданишатар:** Хэн хариулах вэ.3 Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван.

**Г.Энхтайван:** Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Монголбанкнаас дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6.1, 6.2 дахь хэсэгт заасан арга хэмжээ буюу дараах арга хэмжээ авч ажиллахыг бол хуулиар зохицуулж, өөрөөр хэлбэл Банкны тухай хуулийн 48 дугаар зүйл буюу урьдчилан сэргийлэх арга хэмжээ, 49 дүгээр зүйл буюу нөхцөлт удирдлага, мөн 36.1-д заасан шаардлагыг хангаагүй хэсэгт хамаарах хувьцаанд хамаарах хэсгийг өөрийн хөрөнгөөс хасаж тооцох арга хэмжээг банканд авч хэрэгжүүлэх тухай хуулийн зохицуулалттай байгаад байгаа.

Тэгээд яг энэ банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах төлөвлөгөөг энэ системийн нөлөө бүхий банкнууд болон бусад банкнууд бүгдээрээ Төв банканд бол ирүүлсэн. Тухайн банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах төлөвлөгөөг Төв банкнаас улирал тутамд хянаж, банкнуудад бол үүрэг болгож, төлөвлөгөөний биелэлтэд улирал болгон үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан байгаа. Арилжааны банкнууд болон Төв банкны

зүгээс энэ хуулийн 36.1-ийг авч хэрэгжүүлэх талаар тус бүрдээ бол идэвх чармайлттай ажилласан. Жишээлэх юм бол олон улсын томоохон форум болон хөрөнгө оруулагчдын уулзалтад бол удаа дараа Монголбанкны Ерөнхийлөгч болон арилжааны банкны удирдлагууд бол оролцож, үйл ажиллагаагаа танилцуулсан байгаа. Ерөнхийдөө бол олон улсын зах зээл болон бусад дэлхий нийтийг хамарсан бусад хүндрэлтэй асуудлуудаас хамаараад олон улсын зах зээл дээр байгаа хөрөнгө оруулалт татахад бол бас харьцангуй хүндрэлтэй байгаад байгаа. Ер нь бол банк тус бүр бол өөр өөрсдийн хүрээнд бол харьцангуй бас боломжийн хэмжээнд ажилласан. Гэхдээ олон улсын хөрөнгө оруулалтын байгууллагуудаас тавьж байгаа асуудал нь бол манай энэ арилжааны банкнуудын үйл ажиллагаанд эхний ээлжид илүү хамтран ажиллах журмаар буюу хөрөнгө байршуулах, дотоод санхүүжилт өгөх хэлбэрээр ажиллаад, тэгээд тодорхой хугацааг хараад, түүнийхээ дараа тэрийгээ буцаагаад санхүүжилт буюу equity financing хэлбэрээр хувьцаанд хөрвүүлэх чиглэлээр бол хамтарч ажиллах тухай саналыг бол арилжааны банкнуудад илэрхийлээд явж байгаа. Тэгэхээр хугацааны хувьд бол бид бүхэн бас арилжааны банкнуудыг бол үйл ажиллагаагаа сурталчлаагүй гэж үзэхэд бол бас хүндрэлтэй байгаад байгаа.

Гишүүний 2 дахь асуудал энэ 2026 оны 12 сарын 31 гэхэд энэ асуудал ингээд хэвээрээ байх юм уу гэж санаа зовж байна. Мэдээж бол ийм эрсдэл бол байгаа. Энэ бол олон улсын зах зээл болон бусад хөрөнгө оруулагчдын үзүүлж байгаа тэр маркет сентиментээс хамаараад бол 3 жилийн хугацаанд мэдээж энэ 2,5 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг татаж оруулна гэдэг бол бас хүндрэлтэй. Мэдээж төв банк болон арилжааны банк, Монголын банкны холбоо болон бусад холбогдох байгууллагууд бол энэ дээр идэвх

санаачилгатай ажиллаад дараа.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гүйцээж хариулах уу. 3 номер гүйцээгээд тодорхой хариу хэлье.

**Г.Энхтайван:** 2026 оны 12 сарын 31 гэхэд бол энэ хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах талаар бол төлөвлөгөө гаргаад ажиллана. Тэр бодлогын хүүтэй холбоотой асуудал дээр бол өнгөрсөн 7 хоногт Төв банкны Мөнгөний бодлогын хороо хуралдаад бодлогын хүүг бол 12 хувиас буулгаж 11 хувьд хүргэсэн байгаа. Инфляцын хэмжээ бол 6,4 хувьтай байгаа. Нэгэнт инфляцын хэмжээ Төв банкны зорилтот түвшинд ойртсон учраас бодлогын хүүг бол шат дараатай бууруулж явж байгаа. Зээлийн хүү бол мэдээж бодлогын хүүтэй уялдаатай байдаг. Зээлийн хүү бол энэ оны эхний 3 сарын байдлаар бол дунджаар 16,1 хувьтай байгаа. Мэдээж зээлийн хүү нь өөрөө энэ төв банкнаас тавьсан энэ бодлогын хүү болон бусад зах зээлийн нөхцөл байдалтай шууд уялдаатай учраас бол төв банк энэ дээр бол зээлийн хүүг шат дараатай бууруулах хүрээнд бодлогын хүү дээр цаг тухайд нь бодлогын тохируулгуудыг хийгээд явна.

**Г.Занданшатар:** Амартүвшин гишүүн тодруулж асууя.

**Г.Амартүвшин:** Ер нь энэ эзэмшлийн төвлөрлийг бууруулахад зөвхөн шинэ хөрөнгө татахаас гадна энэ чинь бас өөр хэлбэрээр явж болно шүү дээ. Банкнууд хоорондоо нийлж болно. Өөрөөр хэлбэл 2 банкны эзэд хоорондоо хувьцаагаа солилцоод, нөгөө 90 юм уу 100 хувь байсан хэмжээ чинь тодорхой хэмжээгээр үнэлгээнээс хамаараад буурах боломж байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ тал дээр Монголбанк бас энэ банкны эзэдтэй яриа хөөрөө өрнүүлсэн үү. Энэ тал дээр бас санал бодлоо солилцсон уу. Ялангуяа дундаж хэмжээний банкнуудад энэ илүү тохиромжтой байхгүй юу. Одоо 4 системийн банкнаас бусад банкнуудад. Тэр бол бүгдээрээ л дундаж

хэмжээний банкнууд. Энэ банкнуудын эзэд нь бас хоорондоо тохироод банкнуудаа нийлүүлээд арай томорсон хэмжээний банк болоод тэгснээрээ бас 20 хувийн эзэмшлийн хязгаартаа хүрэх бүрэн боломж байгаа шүү дээ. Энэ талаар нэг тодруулж өгөөч.

**Г.Занданишатар:** 3 номер. Энхтайван дэд ерөнхийлөгч хариулна.

**Г.Энхтайван:** Яг энэ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд бол арилжааны банкнуудын хувьд нэгдэх асуудал бол хуулиараа нээлттэй байгаа. Төв банкны зүгээс Монголын банкны холбоотой хамтраад хэд хэдэн удаагийн бол уулзалт, семинаруудыг бол зохион байгуулсан. Энэ хүрээнд бол арилжааны банкны удирдлагууд болон түүний хувьцаа эзэмшигч нарыг бол хооронд нь банкны үйл ажиллагаагаа нэгтгэх, арилжааны банкнуудыг бол нэгдэж илүү томоохон хэмжээний арилжааны банк үүсгэх чиглэлээр бол хамтран ажиллах хүрээнд бол төв банкнаас бол уриалга гаргаад банкны хувьцаа эзэмшигч нарыг бол хооронд нь бол уулзуулаад явдаг. Яг одоогийн байдлаар бол мэдэгдэж байгаа хоорондоо нэгдэхээр хүсэл сонирхлоо илэрхийлсэн болон яриа хэлэлцээрийн түвшинд явж байгаа тийм хэлэлцээ бол алга байна.

**Г.Занданишатар:** Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Оруулж ирж байгаа тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд би 4 тодорхой асуулт асууя.

1 дүгээрт манай Баттөмөр нарын гишүүд бол энэ Банкны тухай хуулийг Их Хурал дээр хэлэлцүүлсэн. Их Хурал их чухал шийдвэр гарсан. Энэ банкны монополийг задлах, ялангуяа хувьцаа эзэмшигч нийтэд хувьцааг нь эзэмшүүлэх, дээрээс нь энэ банкны гол хувьцаа эзэмшигч байгаа шүү дээ. Тэрний монопол байдлыг задлахтай холбоотой ийм шийдвэр гарсан. Энэ ямархуу үр дүнтэй байна. Яагаад өнөөдөр цаг

хугацааг нь сунгахаар ингэж оруулж ирж байгаа юм бэ. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч гэж.

Дараагийнх нь юм бол энэ банкны зээлийн хүү буурахгүй байна. Энэ зээлийн дарамт гэдэг бол маш хүнд байна. Оюутны, цалингийн, тэтгэврийн, малчны гээд л өчнөөн олон зээлтэй. Засгийн газар, Их Хурлаас авч хэрэгжүүлж байгаа энэ бодлогын хүрээнд бол эдийн засагт эерэг өөрчлөлтүүд гарсан. Өсөлт гарсан. Бас боломж байгаа учраас Засгийн газрын хэрэгжүүлж байгаа энэ төслийн хөтөлбөрийн хүрээнд л одоо тө зээлийн хүүгийн татаасыг өгч ингэж явж байна шүү дээ. Тэгээд энэ дээр нэг зүйл хэлээч. Ялангуяа энэ тэтгэврийн ахмадуудад бол их хүндрэлтэй байх юм л даа. Хөдөө, орон нутагт уулзаад иргэдтэй уулзахад гарч байгаа асуудал бол энэ дээр л байгаад байна. Тэгээд ийм зүйлийг нэг хариулт өгөөч.

Гуравдугаарх нь бол энэ Засгийн газар, Монголбанк энэ арилжааны банкнууд энэ өвлийн цас зудын нөхцөл байдал, ялангуяа гамшигт нэрвэгдсэн иргэдийнхээ, малчдынхаа асуудлыг шийдэх тал дээр хамтарч ажиллаад тодорхой зөвшилцөл шийдэлд хүрсэн байхад энэ яагаад ажил хэрэг болдоггүй юм бэ. Хөдөө, орон нутагт сум дээр яваад очно. Тэр сумын тооцооны төвүүд бол яах вэ, тэр арилжааны банк ч ашгаа бодож байгаа юм болохоор ингээд малчдыг нэгэнт дээд талд ийм шийдвэр гараад албажиж ирээгүй байхад л ерөөсөө л яараад л, шавдуулаад л, зээлийг нь төлүүлээд л, тэгээд л хугацааг нь сунгахгүй маш их хүндрэл чирэгдэл байна. Өнөөдөр ч энэ асуудал бол цэгцдээ ороогүй байна. Харьцангуй Төрийн банк бол асуудал харьцангуй бага байна. Гэтэл Хаан банк чинь сум болгонд юутай байна шүү дээ. Тооцооны төвүүдтэй. Энд бол хүндрэл чирэгдэл байна. Энийг нэг талд нь яаралтай гаргаач. Энэ дээр онцгой анхаарал тавихгүй бол Их Хурлын зүгээс ч гэсэн энэ дээр их анхаарах хэрэгтэй байна. Ийм нэг зүйлийг би асуух гээд, хэлэх гээд байна.



4 дүгээрт бол энэ банкны тухай хууль орж ирэхдээ энэ гадаадын өрсөлдөөнийг хангах чиглэлээр гадаадын банк оруулах тухай асуудал гарсан. Энэ хаана юун дээр гацаад байна. Ингээж өрсөлдөөнийг хангаж байж бодит хүү буурах, эх үүсвэр хангалттай байх, цаашилах юм бол томоохон хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх ийм нэг нээлттэй бодлогоо бодитой ажил болгомоор байна шүү дээ. Ийм зүйлүүд дээр нэг тодорхой хариулт өгөөч. Баярлалаа.

**Г.Занданишатар:** 3 номер.  
Энхтайван дэд ерөнхийлөгч.

**Г.Энхтайван:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. 2021 оны 1 дүгээр сард Банкны тухай хууль батлагдаад, үүнийг дагаад бол дагаж мөрдөх журмын тухай хууль бол гарсан байгаад байгаа. Энэ хуулийн дагуу бол мэдээж арилжааны банкны хувьцаа эзэмшигчийн төвлөрлийг 20 хувьд хязгаарласан тийм зохицуулалт орсон байгаа. Яг энэ өнгөрсөн хууль батлагдсанаас хойших хугацаанд бол мэдээж дэлхий нийтийг хамарсан цар тахал болон манай хойд хөршийн болон Европт үүсээд байгаа энэ дайн байлдаан, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдалтай холбоотойгоор бол олон улсын санхүүгийн зах зээлийн төлөв бол бас харьцангуй сайнгүй байлаа. Мэдээж энэ өнгөрсөн хугацаанд бол төв банкны зүгээс бол энэ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд арилжааны банкнууд, системийн нөлөө бүхий 5 банкиг олон нийтийн болгох, түүний хүрээнд системийн нөлөө бүхий 5 банканд активын чанарын үнэлгээг хийж, түүний дараа олон нийтийн болж нийтдээ 478 тэрбум төгрөгийг бол олон нийтээс татан төвлөрүүлсэн. Гэх мэтчилэн бол шат дараатай үйл ажиллагааг бол явуулсан. 20 хувийн хязгаарлалтыг хангах хүрээнд мэдээж энэ бол тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт манай улсад шинээр орж ирэх шаардлагатай байгаад байгаа. Одоогийн байдлаар Төв

банкны бол тооцсоноор бол 2,5 их наяд төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт бол шаардлагатай байгаад байгаа. Тэгээд гадаад дотоод хүчин зүйл, нөхцөл байдлаа үнэлсний үндсэн дээрээс бол энэ 2,5 тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт бол бас яг энэ хуулийн хэрэгжих хугацаанд бол орж ирж амжсангүй. Тийм учраас бол энэ арилжааны банкнуудыг бол системийн нөлөө бүхий банкнуудыг гадаад зах зээл дээр ажиллах, нэмэлтээр хөрөнгө оруулалт татах, нэг хувьцаа эзэмшигчийн төвлөрлийг бууруулах, үйл ажиллагаагаа илүү олон улсын зах зээл дээр үр дүнтэй явуулах боломжийг олгох үүднээс бол энэ хуулийн сунгалтын асуудлыг бол Баттөмөр гишүүний санаачилсан энэ асуудлыг бол Төв банк бол дэмжээд байгаа.

Зээлийн хүүтэй холбоотой асуудал бол мэдээж зээлийн хүү бол өөрөө зах зээл дээр энэ оны 3 дугаар сарын төгсгөлийн байдлаар 16,2 хувьтай байна. Засгийн газрын татаастай хөтөлбөрүүд бол явж байгаа. Тэгэхээр зээлийн хүү бууруулах чиглэлээр бол төв банк бол Улсын Их Хурлаас зээлийн хүү бууруулах стратегийг баталсан. Энэ хүрээнд бол үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд явж байгаа.

Нийт бол зээлийн хүүгийн зардлын 60 гаруй хувь нь бол зөвхөн эх үүсвэрийн зардал байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр бол мэдээж өнгөрсөн жилүүдэд үүссэн энэ хүндрэл инфляц болон энэ нийлүүлэлтийн хүндрэлтэй асуудлуудаас болоод төв банк бол бодлогын хүүгээ бол бас нэлээн өндөр түвшинд барьж, мөнгөний бодлогын төлөвийг бол чангаруулсан. Энэ хүрээнд бодлогын хүү бас оргил түвшиндээ 13% дээр хүрсэн. Одоо бол бас шат дараалаад буугаад явж байна. Ер нь бол цаашидаа эдийн засаг инфляц ингээд Төв банкны зорилтот түвшинд байгаад байх.../минут дуусае/



**Г.Занданишатар:** Товч тодорхой хариул Энхтайван. 3. Малчдын зээл, зээлийн хүүгийн асуудал.

**Г.Энхтайван:** Энэ оны хавраас үүссэн энэ өвөлжилтийн хүндрэлтэй байдалтай холбоотой малчны зээлийн ангиллыг бол төв банкнаас бол энэ оны 3 дугаар сард хуралдсан Мөнгөний бодлогын хорооны хурлаар бол хойшлуулсан байгаа. Арилжааны банк дээр малчид өөрсдөө хүсэлтээ гаргаад, зээлийн эргэн төлөлтөө бол хойшлуулах нь бол нээлттэй байгаа. Хүсэлт гаргах ёстой байгаа. Арилжааны банк дээр очиж зээлийн гэрээ гэдэг маань өөрөө малчин, банк 2 хоорондоо хамт байгуулсан гэрээний үндсэн дээрээс явагдаж байгаа учраас гэрээнд оролцогч малчин өөрөө банк дээр очиж зээлээ хойшлуулъя гэдэг хүсэлтээ гаргах ёстой байгаа.

Тэр гадаадын банктэй холбоотой асуудал дээр бол Төв банкнаас удаа дараа бол гадаад орны банк, санхүүгийн байгууллагуудад Монгол Улсад ажиллах боломжийн талаар нээлттэй танилцуулга, хэлэлцүүлгийг удаа дараа зохион байгуулаад явж байгаа. Ер нь бол гадаад улсын санхүүгийн байгууллага Монгол Улсад орох нь бол дан ганц хууль, эрх зүйн орчноос үл хамааран гадаад, дотоод нөхцөл байдал, олон улсын санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүд гэх мэтчилэн маш олон шалтгааны улмаас энэ асуудал бол хүлээгдэж байгаа.

Төв банкны зүгээс бол энэ дээр шат дараалсан арга хэмжээг бол аваад явж байгаа. Гадаадын банкиг оруулах тал дээр.

**Г.Занданишатар:** Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна. 1 минут.

**Б.Бат-Эрдэнэ:** Та нар ингээд өрөөнд суугаад байхаар чинь бодит ажил амьдрал дээр чинь хэрэгжихгүй байна шүү дээ. Та нар яг одоо хөдөө энэ өвлийн гамшигт нэрвэгдчихээд байна шүү дээ. Байгалийн гамшигт үзэгдэлд

нэрвэгдчихээд байгаа иргэдийнхээ хохирлыг барагдуулах дээр та нар санаачилгатай ажиллах хэрэгтэй байна шүү дээ. Та бол эндээс ингээд хүсэлт гаргах ёстой, хэвийн явж байгаа гэж. Бодит байдал дээр хэвийн явахгүй байна шүү дээ. Зүгээр цаана чинь тэр ажил хариуцаж байгаа, та нартай шууд ажил төрлийн холбоотой арилжааны банкнуудын чинь суман дээр ажиллаж байгаа тооцооны төвүүд чинь энийг чинь хаагаад сууж байна шүү дээ. Тэгээд энийг цэгц журамд нь оруулах чиглэлээр та нар хаана юу байгаа юм. Та ингэж дургүйлхэж, хандлагаа та илэрхийлж болохгүй. Энэ 3 номер дээр сууж байгаа тэр нүдний шилтэй нөхөр юу хариуцдаг вэ. Ингээд эд нар ажил албан тушаалд авахаараа зүгээр бүр нэг арслан барс шиг болчихдог. Тийм байж болохгүй шүү дээ. Тэр орон нутагт чинь энэ ажил чинь явахгүй байна. Явахгүй байгаа юмыг нь би хэлж байна.

**Г.Занданишатар:** Энийг анхаарч ажиллах хэрэгтэй. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах гэдэг үзэл санаатай нэлээн чухал ийм хуулийн төсөл, хуулийн заалт хэрэгжихгүй хагас жил болчихлоо л доо. Тэгэхээр үүний цаана олон олон зүйл байгаа байх. Тэгэхдээ ер нь энэ сүүлийн үед Монголын банкнууд дээр үүсээд байгаа нөхцөл байдал, өнөөгийн эрх баригчдын төрийн оролцоо 2 нийлээд нэг ийм сонин байдал руу л очиж байна. Банкны салбарын ашигтай ажиллагаа гэдэг зүйл асар ихэсчихсэн. Мэдээж ашигтай ажиллаж байвал сайн. Тэгэхдээ үүний нөгөө талд төрөөс асар их төсөл хөтөлбөр зарладаг. Үүний бүх хүүгийн зөрүү, татаас, бүх зүйлийг төрөөс өгдөг. Одоо сүүлдээ батлан даалтын сангаас бүх эрсдэлийг төр даана гэгчихсэн үүний цаана ингээд эрүүл бусаар банкны салбарын үйл ажиллагаа ашиг гэдэг зүйл ингээд эрүүл бусаар их наядаар тоологдох ашгууд ингээд олдог. Гэтэл энэ нь эрүүл зах зээлээрээ явж байгаа бол

хамаа алга. Гэтэл нөгөө талд нь одоо шинээр зарлагдаж байгаа хөтөлбөр, хуучин энэ тэдэн их наядын, эдэн их наядын гэдэг хөтөлбөр чинь бүгд банкаар гардаг. Банкаар гарсны цаана төрөөс бүх эрсдэл даатгалыг өгдөг. Бүх хүү, зөрүүгийн татаасыг өгдөг. Тэгээд бодлогын хүү өндөр. Энэ банкнууд чинь үндсэндээ эрүүл бус ашигтаар сүүлийн үед ингээд тоглоод байна шүү дээ. Гэтэл үүний нөгөө талд тэгээд төвлөрлийг бууруулах гэдэг 20 хувийн асуудал орж ирэхээр энэ хууль нь хэрэгждэггүй хагас жилийн. Тэгэхээр ер нь ингээд хууль хэрэгжихгүй яваад байхаар яг яадаг ёстой юм бол. Энийг тэр ажлын хэсгийнхэн бас хариулмаар байна. Энэ чинь одоо үндсэндээ 2023 оны 12 дугаар сарын 31-ээр хэрэгжих ёстой хуулийн заалт өнөөдөр яг хэрэгжихгүй явж байдаг. Одоо яг энэ дээр ямар асуудал яригдах ёстой юм.

Тэгээд ач холбогдлыг нь яривал Монгол Улсад олон хувь эзэмшигчтэй, гадаадын хувь эзэмшигчтэй 1 банк байна. Хас банк, ОУСК, Европын хөгжлийн банк бүгдээрээ 20 дотор хувийн хувь эзэмчихсэн асар эрүүл засаглалтай банк тэнд ингээд эрүүл саруул ажлаа хийгээд явж байгаа харагддаг юм. Энэ сайн жишиг байхад энэ сайн жишиг рүү нь Монгол банк шахаад энэ хуулийн хэрэгжилт рүү чинь явах ёстой юм биш үү.

Нөгөө талд нь ингээд нэг ийм эрүүл бус жинхэнээсээ бас ахиц дэвшилтэй ажиллаж байсан банкны салбар чинь сүүлийн үед хамгийн эрүүл бус салбар болж хувирлаа. Төрийн бүх төсөл, хөтөлбөр дамждаг. Бүх барьцаа баталгаагүйгээр бүх зүйлийг төр хариуцдаг. Хүү зөрүү, татаасыг нь бүгдийг нь өгдөг. Тэгэхээр энэ дээр одоо тэгээд ямар асуудал. Тэр хууль, хууль хэрэгжихгүй болохоор яадаг дээр хариулт өгөөч.

Төгсгөлд нь энэ Төрийн банк чинь бас системийн банк. Төрийн банкийг өөрийг нь хувь эзэмшлийг нь задлах

асуудал, хувьчлах асуудал чинь харин төр манлайлаад энэ асуудлаа бид нар шийдэх ёстой биш үү. Төрийн банкны хувьчлал гэдэг зүйл лав л одоо намайг гишүүн болж байхад л жил бүхэл мөрийн хөтөлбөрт орж байсан. Одоо бүр сураг алдарлаа. Тэгээд төрийн оролцоо чинь бүр энэ банкны салбараас эхлээд ийм өндөр байхлаар чинь нөгөө нэг авлига, хээл хахууль олон олон зүйлүүд чинь үүний цаана далдлагдаад, тэгээд л одоо яг саяын хуулийн төвлөрөл дээр ингээд тайлбар.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 3 номер. Энхтайван дэд ерөнхийлөгч хариулъя.

**Г.Энхтайван:** Банкны энэ дагаж мөрдөх тухай хуулийн 6.1, 6.2-т заасан арга хэмжээг бол одоо авч ажиллахыг бол хуулиар зохицуулсан байгаа. Тэгээд Банкны тухай хуулийн 48 буюу урьдчилан сэргийлэх арга хэмжээ, 49 буюу нөхцөлт удирдлага, 36.1-д заасан шаардлагыг хангаагүй хэсэгт хамаарах хувьцаа, хувьцаанд хамаарах хэсгийг өөрийн хөрөнгөөс хасаж тооцох арга хэмжээг бол банканд авч хэрэгжүүлнэ. Мөн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хурлын саналын эрхийг түдгэлзүүлнэ. Хязгаарлалт хангаагүй хэсэгт ноогдол ашиг олгохгүй гэсэн хуулийн зохицуулалтууд бол байгаа юм. Энэ хуулийг албадан хэрэгжүүлсэн тохиолдолд. Мэдээж бол арилжааны банкнуудаас бол хувьцааны төвлөрлийг бууруулах арга хэмжээний хүрээнд бол өөр өөрсдийн хийсэн ажлыг төлөвлөгөөний дагуу Төв банканд бол ирүүлээд байгаад байгаа. Хэрвээ ингээд энэ 36.1-ийг сунгахгүй тохиолдолд бол нэлээн олон гадаад, дотоод эрсдэлүүд бол үүсэж болзошгүй байгаад байгаа. Зөвхөн хэлэхэд бол Хаан банк, Худалдаа хөгжлийн банкнаас бусад 7 банк нь Монгол банкнаас хуульд заасан 20 хувиас хэтэрсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшлийг өөрийн хөрөнгөөс хасаж тооцоход бол хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээнд бол хүрэхээ больж байгаа. Энэ бол тодорхой хэмжээнд бараг 18-80 орчим тэрбум

төгрөгөөр дутагдах ийм асуудал бол үүсэж байгаа.

Мөн төвлөрлийн эрсдэлийг бол Хаан , М банкнаас бусад бүх банкнууд бол зөрчиж байгаа. Мөн дийлэнх банкнууд хувьцаа эзэмшигчдийн хурлаа бол хуралдуулах боломжгүй болж ирж байгаа. Тэгэхээр бол мэдээж энэ гадаад дотоод нөхцөл байдлаас хамаараад 2,5 их наяд төгрөгөөр хэмжигдэх хэмжээний хөрөнгө оруулалтыг бол татаж оруулахад хүндрэлтэй байгаад байгаа учраас энэ арилжааны банкнуудын зохистой үйл ажиллагаагаа явуулах, хэвийн үйл ажиллагаагаа явуулах, засаглалын хямралд өртүүлэхгүй байх үүднээс бол энэ хуулийн хэрэгжилтийг сунгах хугацааг бол төв банкны зүгээс ийм тайлбарыг ажлын хэсэгт бол гаргаж өгсөн байгаад байгаа.

Бас дараагийн 1 асуудал бол хэрвээ энэ хуулийн 36.1-ийг сунгахгүй тохиолдолд их хэмжээний бол хөрөнгө банкны зах зээлийн салбараас бол гадагшлах зохицуулалттай байгаа буюу манай арилжааны банкнууд гадаад зах зээл дээрээс бусдын өмнө үүрэг хүлээгээд гэрээний дагуу бол их хэмжээний хөрөнгийг татан төвлөрүүлчихсэн байгаад байгаа. Үүнийг жишээлбэл банкны салбар дахь 4 их наяд төгрөгийн гадаад эх үүсвэр гадаад банкны системээр бас бол гадагшлах буюу системээс гараад явах эрсдэлтэй байгаа. Бид бүхэн бол энийг банкны систем дээр ковинант гэж нэрлээд байгаа. Тэгэхээр ГХО-д олон улсын байгууллагуудын энэ хөрөнгө оруулалт хийх боломжийг бий болгох эх үүсвэр олгохдоо тавьдаг тэгээд үндсэн шалгууруудыг хангахад бол энэ хуулийн 36.1-ийг бол хангах зайлиггүй шаардлагатай байгаа. Ер нь бол гишүүний тавьж байгаа асуудалтай санал нэг байгаа. Ер нь бол арилжааны.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Дашидондогийн Ганбат гишүүн. Дараа нь санал хураалттай гишүүд чуулганы танхимд цуглая.

**Д.Ганбат:** Яах вэ, энэ асуудлыг хэлэлцээд ингээд шийдэх нь зөв байх. Гэхдээ угаасаа л үгүй ээ, тэгээд яахаараа ийм юм болдог юм бэ. Угаасаа л наадах чинь биелэгдэх боломжгүй шүү дээ. Ийм л хууль шүү дээ. Ахиад 2026 он хүртэл сунгаад ч биелэгдэхгүй. Тэгээд энэ коммунистууд, социалистууд эдийн засаг удирдаад л, Монгол банк яг өөрийнхөө хийх ёстой ажлаа хийхгүй, банкнуудыгаа хамгаалж чадахгүй явсаар байгаад ийм байдалд хүргэж байгаа шүү дээ. Та нарын чадал чадвар байж байгаа байдал чинь энэ үү. 20 хувь дээр юу гэж гаднын хөрөнгө оруулалт орж ирэх юм бэ. Юу гэж олон нийтийн хяналт тавигдаж чадах юм бэ. Энэ чинь 34 хувиас доош олон нийтийн хяналтад байлаа ч тэр чинь явахгүй шүү дээ. Хамгийн багадаа 51, 34 байж байж наадах чинь цаашаа явна. Дахиад 2026 онд энэ юмаа яриад л сууж л байна. Тэгээд ийм юм мэдсээр хэнд ч ойлгомжтой баймаар ийм юмыг та нар ингээд явуулаад байдаг. Тэгээд хүлээгээд байдаг. Тэгээд ярьж байгаа юм, хэлж байгаа юм чинь тэр социалистууд, коммунистууд юу ярьдаг. Энэ улс орныг удирдахаараа ямар болгодог гэдгийг чинь дөнгөж илрэл нь энэ.

Бас хэлчихье. Гамшиг боллоо. Олон жил энэ малчид 2 оронтой тоотой 20, 30 хувийн хүүтэй зээлээр энэ банкнуудыг тэтгэж байлаа. Одоо тэгээд хариугаа үзүүл л дээ. Эрсдэлийн сан гээд байдаг шүү дээ. Тэр эрсдэлийн сангаасаа, энэ газар нутгийг нь булааж аваад байгаа уур уурхайн компаниудаасаа нийгмийн хариуцлагын хүрээнд малчдынхаа зээлийг нааш цааш нь болгочхож болдоггүй юм уу. Ийм ажил төрлөө хийхийн оронд хэзээ ч бүтэхгүй ийм юмаар хөөцөлдөөд одоо хар л даа. Зээлийн хүү дан орон тоо байна. 9 хувьтай байна гэж 2020 онд амлалтаа аваад л явсан. Одоо 4 жил өнгөрлөө. Танай бодлогын хүү чинь өчигдөр 11 хувь болов уу. Тэгэхээр яаж зээлийн хүү дан орон тоо тоонд орох юм. Тэгээд Монголын ард түмнийг ядуу байлгах ийм бодлогыг та нар санаатай ч

юм уу, санамсаргүй ч юм уу тэрний хавсарга болж яваад байх юм. Ийм л байдалтай байна л даа. Одоо тэгээд энэ малчид маань чинээлэг дундаж давхаргад байсан байхгүй юу. Энэ 300-аад мянган айл. Одоо ядуурлын түвшинд оччихсон. Энэ чинь Монгол банкнаас болон энэ Монгол Ардын намын Засгийн газрын буруу явуулж байгаа бодлогын үр дүн шүү дээ. Одоо ингээд сонгууль болохоор бүгд санасан сэрсэн юм шиг хайр зарлаад, нөгөө улс орныг улам л дампууруулах, малчдыг бүр модоо барих ийм юм руу л явуулаад байна шүү дээ. Тэрийг хязгаарлах барих талаар Монгол банк яаж ажилладаг юм. 2026 онд та нар ийм юм яриад сууж байна. Тэгэхээр энэ хуулиа бол өөрчиллөө. Тэр хөрөнгө оруулалт татах гэж байгаа юм бол 34 хувь болго л доо адгийн наад зах нь. Тэр хяналтаа тавих ийм юм мэддэггүй юм уу. Мэдээд ингээд байдаг юм уу. Хэн та нарт ийм юм зааж өгөөд байдаг юм бэ. Энэ хуулийг хэн оруулж ирээд батлуул гэсэн юм. Хэн ингээд сунга гэсэн юм. Энэ нэг юмыг нэг сонсчихмоор байх юм. Одоо энэ бол эхлэл шүү. Цаашаа энэ байдлаар үргэлжилбэл энэ банкнууд чинь өөрсдөө дампуурна шүү. Тэгээд араас нь.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. 3 номер. Энхтайван асуултад хариулъя. Монгол банкны дэд ерөнхийлөгч.

**Г.Энхтайван:** Ганбат гишүүний тавьж байгаа асуултад хариулъя. Гишүүний ярьж байгаатай ерөнхийдөө бол санал нэг байна. Мэдээж энэ 20 хувь гэдэг асуудал бол гадаадын хөрөнгө оруулалт оруулж ирэхэд бол бас тийм одоо юу гэдэг юм хөрөнгө оруулагчдыг уриалан дуудсан тийм хуулийн хувь хэмжээ бол биш байгаад байгаа. Мэдээж бол гадаадын хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгө оруулж байгаа субъектийн тогтвортой байдалд улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас илүүтэйгээр бас тухайн хөрөнгө оруулж байгаа өөрийн тэр тухайн банкандаа тавих хяналт, өөрийн саналын эрхтэй холбоотой

асуудлуудаа бол мэдээж харгалзаж үздэг. Тэгэхээр мэдээж энэ дээр бол таны тавьж байгаа болгоомжлолтой санал нэг байгаа. Гэхдээ энэ дээр бол хувь эзэмшигчдийн төвлөрлийг бууруулахтай холбоотой энэ асуудлыг бол олон улсын байгууллагууд, ОУВС болон холбогдох гадаад улсын манай улстай хамтран ажилладаг олон улсын байгууллагуудын зүгээс энэ зөвлөмжийг бол тухай бүрд нь өгч явж байсан. Мэдээж хөрөнгө оруулагчдыг илүү оруулж ирэх, олон хөрөнгө оруулагчтай байх, олон нийтийн болгох, банкны засаглалыг илүү тунгалаг болгох, засаглалыг илүү дараа дараагийн түвшинд гаргахад энэ хууль бол чухал шаардлагатай гэж үзээд 2021 онд бол Улсын Их Хурлаар баталсан байгаа. 2026 оны 12 сарын 31 хүртэл төв банк, арилжааны банк, МБХ хамтраад энэ дээр бол хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бүхий л шат дараалсан арга хэмжээнүүдийг бол цаг тухайд нь авч ажиллана.

**Г.Занданишатар:** Одоо санал хураалт явуулна. Дашидондогийн Ганбат гишүүн тодруулж асуусны дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулган танхимд цуглая.

**Д.Ганбат:** Монголбанк тэрний төлөөлөл нь орж ирчихсэн байгаа. Ингээд юм асуух боломж олдсон дээр нь. Одоо ипотекийн зээл гэж байна. Ардчилсан нам 4 жил засаглаад олонх байхдаа бол 100-аад мянган айл орон сууцад оруулсан. Ипотекийн зээлийг санаачлаад. Монгол банк ч энд оролцоод явсан. Одоо Монголбанк үе шаттай үүнээс гарах ёстой. Тэр нь хаана байна. Одоо ипотекийн зээл гэхэд хэчнээн айл оруулж чадав энэ 8 жилд.

Нөгөө талаар бол зах зээл дээр хүү чинь 3, 6, 8, 10, 12 гээд олон янзын хүү байна. Ийм байж болдог юм уу. Энд зах зээл энэ тэр гэж байна уу. Яг алинаар нь явах юм. Тэрийгээ тодорхой болгочих. Хэн нь 3 хувийг аваад, хэн нь 6 хувийн зээлтэй байгаад, хэн нь арилжааны зээл аваад ингэж явах ёстой юм. Энэ чинь бас



л нэг улс орныг дампууруулах.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хариултын дараа санал хураалт явуулна. 3 номер. Энхтайван дэд ерөнхийлөгч.

**Г.Энхтайван:** Ипотекийн зээлийн хөтөлбөр 2013 оноос хойш Төв банк оролцоод бол хэрэгжүүлээд явж байгаа. Гишүүн яг хэдэн өрх хамрагдсан бэ гэж асууж байх шиг байна. Байгаа мэдээллээр бол 2021 онд 7 мянга орчим өрх, 2022 онд бол 10 мянга, 2023 онд 8600 өрх бол одоогийн байдлаар хамрагдаад явж байна. Ипотекийн зээлийн хөтөлбөр бол зээлийн эргэн төлөлтөөрөө санхүүжээд явж байгаа. Төв банкны зүгээр энэ хөтөлбөрөөс хэзээ гарах юм бэ гэж байна. Өнгөрсөн оны 10 дугаар сард баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд 2023 онд энэхүү хөтөлбөрийг эргэн төлөлтөөр нь санхүүжүүлээд явах талаар бол Улсын Их Хурлын тогтоол гарсан байгаа. Тэгэхээр энэ оны үндсэн чиглэл хэрэгжээд явж байгаа. Үүний дараа бол 2024 оноос эхлээд Төв банк энэхүү ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол Засгийн газар шилжүүлж өгнө. Одоогоор бол төв банк энэ дээр ямар нэгэн төсвийн шинж чанартай санхүүжилт хийж мөнгө нийлүүлэхгүй байгаа. Зөвхөн эргэн төлөлтөөрөө санхүүжээд явж байгаа.

Хөтөлбөрийн хувьд бол мэдээж урьд нь бол анх 8 хувийн хүүтэй хөтөлбөр бол гарсан. Дараа нь бол 6 хувийн хүүтэй болж өөрчлөгдсөн. 8 хувийн хөтөлбөрөөр зээл авсан иргэдийн хүүг 6 хувь руу шилжүүлэхэд тодорхой хэмжээний санхүүжилт шаардлагатай байгаад байгаа. Энэ санхүүжилтийг шийдэх эх үүсвэр нь бэлэн байх юм бол энэ 8 хувьтай иргэд 6 хувь руу шилжихэд нээлттэй байгаа.

3 хувийн зээлийн хувьд бол мэдээж төвлөрлийг сааруулах, орон нутгийн хөгжлийг дэмжих хүрээнд бол орон нутагт зээл авч байгаа тохиолдолд бол тодорхой хувийг нь бол төсвийн

татаастайгаар буюу хүүгийн дэмжлэгтэйгээр бол 3 хувийн зээлийн хөтөлбөр бол хэрэгжээд явж байгаа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Сарангэрэл гишүүн суудалдаа асуугаарай. Санал хураалт явуулна Гишүүдэд бас нэг мэдээлэл энэ даширамд сонсгоё.

Өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон сууцжуулалтыг дэмжих тухай хуулийг өргөн мэдүүлсэн. Ирэх 7 хоногт хэлэлцэхээр төлөвлөж байна.

Ипотекийн зээлийг Үндэсний баялгийн сангийн эх үүсвэрээр дэмжиж 500 тэрбум төгрөгийг эх үүсвэрт үндэсний баялгийн сангаас гаргаснаар I өдрийн дотор ипотекийн зээлийн олголт 48 хувиар нэмэгдсэн гэж Ерөнхий сайд өнөөдөр хуулийн төсөл өргөн мэдүүлэхдээ хэлж байсан. Одоо цөөхөн өдрийн дотор бол 48 хувиар ипотекийн зээлийн олголт нэмэгдэж, ипотекийн зээлийн эх үүсвэр нэмэгдэж, нөгөө талаасаа Үндэсний баялгийн сангийн хөрөнгө ч гэсэн төрийн сангийн дансанд хүү өгөөжгүй байришиж байсан бол нөгөө талдаа бас эргэлтэд орж байгаа хэрэг. Нөгөө талдаа хямд эх үүсвэрээр ипотекийн зээлийг санхүүжүүлж, Үндэсний баялгийн сангийн хууль хэрэгжиж, орон сууцжуулалтыг дэмжих ийм том бодлогод бас их дэвшил гарлаа. Энд бас Монголбанк энийг сайн зохион байгуулсан байна.

Харин тэр малчдын зээлийг хугацааг нь сунгах харилцаа чинь их сайн ойлголт өгөхгүй бол орон нутаг, аймаг, сумын банкнуудын салбарууддаа бас тодорхой чиглэлүүд өгөхгүй бол олон өөр ойлголттой, тохиролцоо, гэрээний хэрэгжилт хангалтгүй, тэгээд их хэл ам гарч байгаа тухай Бат-Эрдэнэ гишүүн, орон нутгаас сонгогдсон гишүүд яриад байгаа. Энийг бас онцгой анхаарч арилжааны банкнуудтайгаа уулзалт хийж идэвхжүүлэх, тэр дотроо шинэ хоршоо гээд 5 их наядын зээлийн



хөтөлбөр зарлачихсан. Тэгээд энэ маань бас ингээд маш их хүлээлт үүсгэхээд, тэгээд яг олголт дээрээ очоод нөгөө арилжааны банкнууд, зээлийн батлан даалтын сан хүнд суртал чирэгдэл нь дийлдэхгүй бол хүлээлтэд хүрэхгүй их эрсдэл дагуулна. Ийм учраас энэ зээлийн схемүүдээ яг мэргэжлийнх нь хувьд та нар зөвлөж зөв гаргаж зохион байгуулалтын хувьд их зөв хийж ажилламаар байгаа юм. Тэр малчдын зээлийн асуудал ч гэсэн урьдчилаад баахан зарлаад хаячихдаг. Энийгээ иргэд хүсэлтээ гаргаад, 2 тал гэрээний үндсэн дээр гэрээндээ өөрчлөлт оруулах байдаг юм уу, зээлийн хугацаа сунгах зохицуулалтуудаа бас харилцагчидтайгаа банкнууд тулж ажиллах хэрэгтэй шүү дээ. Эцсийн эцэст тэр чинь банкнуудын өөрсдийнх нь л харилцагч нар.

Санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа сууя. Энэ хөдөө аж ахуйн байнгын хорооныхон яасан. Хуралдаж дууссан биз дээ. Цаадуулаа дуудаадхаач. Орж ирж санал хураачаад гар гэж хэл. Батжаргал, Ганболд, дандаа Байнгын хорооныхон байна. Санал хураалт явуулъя. Дараагийн асуудал руу орж болж байна л даа. Бүртгэлийн санал хураалт явуулна. Энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хуралдаж байгаа учраас давхцаад байгаа юм байна. Байнгын хороо хуралдаж дуустал дараагийн асуудал руу орж байж болж байна. Оюунчимэг гишүүн ороод ирлээ. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ бол бүртгэлийн санал хураалт шүү. Үдээс хойших бүртгэлийн санал хураалт. Энэ бүртгэлийн санал хураалт.

Одоо Байнгын хорооны саналаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 21 гишүүн дэмжиж хуулийн төслийг

хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

16.15 цаг.

Дараагийн асуудал орно. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Байж байгаарай. Дараагийн асуудал гадаа аль ажлын хэсэг нь бэлэн байна. Цэргийнх байна. Бас Эдийн засаг, хөгжлийн яамны төлөвлөгөө өөрсдөө байхгүй болохоор хойшлогдоод байх юм. Ингээд орж ирэхгүй. Цэргийнхнийгээ оруулах уу. Цэргийнхэн бүгдээрээ байна гэж байна. Олонхын саналаар цэргийнхийг явуулахаар тохирох уу. Эм хаа байсан хол байна.

**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна.

**Б.Жаргалмаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гаргаагүй бөгөөд төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Анужингаас Төсвийн тухай хуульд төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэрийг гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байхаар заасан тул хуулийн хэрэгжих хугацааг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх талаар зарчмын зөрүүтэй 1 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсан баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Цэндийн Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Ганц асуулт асууя. Албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан цэргийн албан хаагч нарт гэр бүлд нь 80м2-аас доошгүй талбайтай орон сууцыг 1 удаа олгоно гэж заалт орж ирж байна. Энэ хэрэгжиж эхлэхээсээ хойш уу. Өмнө нь алба үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан цэргийн алба хаагч нарт хамаарах уу. Зүгээр хөдөө, орон нутаг ард иргэдтэй уулзахаар яг албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан хүмүүс, ар гэрийнхэн нь их л гомдолтой байдаг юм байна лээ. Тэгээд яг одоо Батлан хамгаалах яам дээр олон хүсэлт юмнууд өгсөн. Одоо тэрнээс хойш дарга сайд нар нь солигдчихсон ингээд асуудлыг авч хэлэлцдэггүй, ар гэр нь үнэхээр хүнд байн, амьдрал ахуйгаа залгуулдаг байсан ганц хүн маань ингэчихсэн гээд ингээд гомдол, саналууд их байдаг. Энэ хуулиар хууль хэрэгжсэнээс хойших хүмүүст хамаарах уу. Өмнөх амь насаа алдсан хүмүүс яг нотлох баримтын хэмжээнд яг алба үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан хүмүүст хамаарах уу л гэдэг тодорхой нэг асуулт асууя. Энэ дээр хариулт өгөөч.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Протоколд тэмдэглэн үлдэнэ. Рагчаагийн Батрагчаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх, Дашицэдэнгийн Баасандамба Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, Бригадын генерал, Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Хошууч генерал, Хожгорын Лхагвасүрэн Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хошууч генерал, Хилийн цэргийн командлагч, Гомбожавын Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал,

Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга Мижиддоржийн Санжаадорж.

Рагчаагийн Батрагчаа зөвлөх хариулна. 3 номер.

**Р.Батрагчаа:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хууль хэрэгжсэн буюу хүчин төгөлдөр болсон цагаас эхлээд энэ заалт нь хэрэгжиж эхэлнэ. Энэ хуулийг бол буцааж хэрэглэхгүй гэсэн үг ээ. Хэрэгжсэн цагаасаа эхэлж үйлчилнэ гэсэн үг.

**Г.Занданшатар:** Хууль зүйн техник гээд хууль буцааж хэрэглэхгүй. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Энэ Чинзориг сайд орж ирье. Гаднаас Чинзориг сайдыг дууд. Санал хураалт явуулна.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол

### **Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал**

Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужин.

Яах юм энэ чинь төслөөрөө хэднээс гэж байгаа билээ. Санал хураалт явуулъя. Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

**Д.Ганбат:** Энэ саналыг гаргасан гишүүдэд бас талархал илэрхийлж байна. Би дэмжиж байна. Ялангуяа мөрдөс зүүгээд, цэргийн алба хаагаад, эх орныхоо төлөө зүтгээд, тангараг өргөөд

явж байгаа манай цэргийн албан хаагчид маань төр засгаас бол онцгой анхаарах ёстой. Үеийн үед нэг ярьдаг хэлдэг зүйл нь эдийн засаг хүнд байна. Жоохон хүлээж бай, тэгж байгаад болох байх гээд. Тэгээд өөрсдөө ч юм ярьдаггүй хүмүүс хүлээгээд л ингээд явдаг. Олон аавын хүүхдүүд, ээж охидууд ингэж явж байгаа. Тэгээд нас нь тодорхой хэмжээний үртэй бүтээлтэй байдаг ид залуу насаа эх орондоо зориулаад ингээд дуусдаг. Эцсийн эцэст сүүлд нь тэгээд 1 хэдэн заставаар, эсвэл цэргийн ангиудаар явсан, хүүхдүүд нь олон сургууль дамжсан, ирээд орох оронгүй болчихсон ийм хүмүүс байдаг. Бүр бүгдийг нь орон сууцаар хангамаар байгаа юм. Энэ уул уурхайн баялгаас орж ирж байгаа энэ бүх мөнгө, авлига, хээл хахуульд явж байгаа алтан мөнгөн гулдмай болоод гэрт нь хэвтэж байгаа энэ юмтай харьцуулахад яг зориулах, зарцуулах ёстой зүйл нь энэ юм байгаа юм.

Би өөрөө байлдагчаас ахмад хүртэл хугацаат болон эр цэргийн албыг хааж байсны хувьд зөв зүйтэй санал байгаа юм. Тэгээд харамсалтай юм нь бүр арга ядаад ар гэр нь амь үрэгдсэний дараа нь ч болтугай орон сууцаар хангая гэсэн ийм зүйл оруулж ирсэн байна. Уг нь бол амьд сэрүүнд нь бүгдэд нь л орон сууц өгчихмөөр байгаа юм. Ингээд одоо дэмжиж байна.

Тэгээд манай цэргийн албан хаагчид энэ Улсын Их Хурлыг, энэ Улсын Их Хурлын гишүүдийг, бас эх орноо дэмжиж сайн ажиллах, өнөөдөр уучлаарай бид нарын байгаа авч чадаж байгаа боломж нь энэ юм гэдгийг сайхан ойлгуулж өгөөрэй гэж хэлье.

**Г.Занданшатар:** Дэмжсэн үг хэллээ. Санал хураалт явуулна. Унишиж танилцуулсан саналын томъёоллыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ санал дэмжигдсэнгүй. Тэгэхдээ энэ юу шүү дээ. Энэ санал дэмжигдээгүй ч гэсэн хууль ердийн журмаар хүчин төгөлдөр болно. Хориг тавих хугацаа хууль хүчин

төгөлдөр болох хугацаа өнгөрөөд Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болдог. Төрийн мэдээлэл сэтгүүлд гараад 10 хоногийн дараа. Тэгэхээр одоо батлагдлаа гэхэд багцаагаар 6 сарын 1. Төрийн мэдээлэл сэтгүүл дээр хэвлэгдлээ. Ингээд л цаад талын хугацаа 7 сарын 1 гээд л хэрэгжиж эхэлчихсэн байна гэсэн үг. Тийм учраас тэгэхдээ 4 дүгээр зүйл дээрээ нөгөө он сар өдөргүй тавьчихсан байгаа учраас тэр зүйл хасагдах ёстой болно л доо. Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлье.

**Б.Баттөмөр:** Би энэ саналыг дэмжиж байгаа юм. Тэгээд сая дэмжсэн кнопоо дарж амжсангүй. Уучлаарай. Одоо саналыг дахиж хурааж өгнө үү.

**Г.Занданшатар:** Баттөмөр гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулья. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Ингээд горимын санал дэмжигдсэн учраас Баттөмөрийн гишүүний гаргасан горимын санал дэмжигдэж, өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас одоо жинхэнэ санал хураалт. Байнгын хорооны гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дэлгэцээ битгий солиорой. Тэр дэмжээгүй гишүүд ... яагаад дэлгэц солиод байна энийг сайн гарга. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд ишлэжүүлж байна.

16.28 цаг.

**Одоо дараагийн асуудалд орно.**  
**“Монгол Улсын хөгжлийн 2025 оны**

**төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Ч.Хүрэлбаатар:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд эдийн засгийн өсөлтийн өгөөжийг өрх бүрд хүргэх гэсэн зорилгын хүрээнд эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого, эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого, шинжлэх ухаан, дэвшилтэт технологид тулгуурласан засаглалын бодлого, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого, Ногоон хөгжлийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлого Улаанбаатар хотын бүсчлэл 20 минутын хотын бодлого, Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гэсэн бодлогын 8 тэргүүлэх чиглэл, 224 төсөл, арга хэмжээнд нийтдээ 11,8 их наяд төгрөгийг санхүүжүүлэхээр тусгалаа.

Үүнээс, Улсын төсвийн хөрөнгөөр 3,9 их наяд төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 0,2 их наяд төгрөг, гадаадын зээлээр 1,8 их наяд төгрөг, гадаадын тусламжаар 0,2 их наяд



төгрөг, төр, хувийн хэвшлийн түншилэлээр 2,6 их наяд төгрөг, хувийн хөрөнгө оруулалтаар 1,4 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээр 1,7 их наяд төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөв.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэхийг ишийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна.

**М.Оюунчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэрэг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан боловсруулж, эдийн засгийн өсөлтийн өгөөжийг өрх бүрд хүргэх гэсэн зорилтын хүрээнд бодлогын 8 тэргүүлэх чиглэл бүхий 224 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Тогтоолын төслийг D-parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байна. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хөгжлийн

төлөвлөгөөний төсөлд хот, суурин газруудыг дахин төлөвлөх асуудал, гадаргын усыг хуримтлуулах, хог хаягдлыг дахин боловсруулахад чиглэсэн арга хэмжээг тусгасан эсэх, Төрийн өмчит компаниудын үр өгөөж болон гадаад улс дахь дипломат төлөөлөгчийн газрын албан тушаалтнууд хөрөнгө оруулалт татах чиглэлд үйл ажиллагаа явуулдаг эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлын чанар биелэлтийн талаар, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцын хорооллуудыг засан сайжруулах арга хэмжээ, түүнд шаардагдах санхүүжилтийг төлөвлөгөөний төсөлд тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Төсөл хөтөлбөрүүдийг арга хэмжээ, улсын төсвийн хөрөнгө, гадаадын хөрөнгө оруулалт, хувийн хэвилээс тус бүр ямар хувь хэмжээгээр санхүүжүүлэх, Оюу толгойн ордын нөөц болон үр өгөөж нүүрсний үнийн өсөлтийн талаар төлөвлөгөөний төслийн холбогдох заалтад ААНОАТ-ыг бууруулахаар тусгасан зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал хөгжлийн төлөвлөгөөний төсөлд шинэ хоршоо хөдөлгөөний талаар тусгасан эсэх, хөдөө, орон нутагт урьдчилан сэргийлэх вакцины тарилга очихгүй байгаа талаар, 2023 оны хөгжлийн төлөв төлөвлөгөөний биелэлт болон өмнөх төлөвлөгөөний биелэлтийг анхаарахгүйгээр дараагийн төлөвлөгөөг баталж байгаа нь оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин сэргээгдэх эрчим хүчний үнийг бууруулахад чиглэсэн ажил хийгдэх эсэх, говийн бүсэд усны нөөц хангамжийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан ямар арга хэмжээ авах болон цаашид Хөх морь төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Байгаль орчин, аялал жуулчлалын яам Орчны бохирдлыг бууруулах төслүүдээ эрчимжүүлэх, Эко



нойл төслийн хүрээнд тус яамны гүйцэтгэсэн үйл ажиллагаа хангалтгүй байгаа талаар болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин говийн бүсэд усны хангамжийг сайжруулах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагаа хангалтгүй байгаа тул энэ талаар идэвх санаачилгатай ажиллах нь зүйтэй гэсэн саналыг тус тус гаргасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданишатар:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Цэндийн Сандаг-Очир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Сайд нар асуухгүй шүү дээ. Засгийн газрын ажлын төлөвлөгөө. Нанзадын Наранбаатар Улсын Их Хурлын гишүүн асуулт асууна.

**Н.Наранбаатар:** Энэ 2025 оны төлөвлөгөөнд Хөх морь төслийг хэрэгжүүлэх асуудал байгаа юм уу. Ямар ажил хийгдэх юм энэ чиглэлээр. Говь руу ус татах Орхон онги, Хэрлэн, Тоонот гэсэн 2 төсөл байгаа шүү дээ. Шинэ

сэргэлтийн бодлогын 94 том төсөл, арга хэмжээ, говьд хэрэгжих 25, түүний нэг том төсөл нь бол усных шүү дээ. Тэгээд энэ чиглэлээр ямар ажил хийгдсэн юм. Ерөөсөө нүдэнд харагдсан ажил байхгүй байгаад байгаа. Тэгээд 2025 онд ямар ажил хийгдэх юм. Ямар төсвийн хөрөнгө тавигдсан юм. Цаашидаа говийн бүсэд энэ уул уурхай, түүнийг дагасан үйлдвэр, боловсруулах болон баяжуулах үйлдвэр бүгдээрээ усгүйгээр явахгүй шүү дээ. Тийм учраас энэ дээрээ яаж анхаарч байгаа юм. Цаашаа юу хийх гэж байгаа юм. Төсөл ямар хэмжээнд хэрэгжиж байгаа юм гэдэг дээр тодорхой хариулт өгөөч.

**Г.Занданишатар:** Ажлын хэсгийг танилцуулъя. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Борхүүгийн Дэлгэрсайхан, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Сангийн сайд Болдын Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Зам, тээвэр хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг байсан. Хаачив дуудаарай. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ханджавын Батжаргал, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Чимэдцэрэнгийн Цэвэгдорж, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Нансалын Тавинбэх, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Даваасамбуугийн Эрдэнэбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Сангийн яамны Төсвийн

бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Батчулууны Мөнгөнсүх, тус яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Галбадрахын Төгөлдөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлогын, төлөвлөлтийн газрын дарга Амарсайханы Хишигбаяр, Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Жигмэдсамбуугийн Отгонбат, Батлан хамгаалах яамны Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Чулуунборын Гандирваа, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл байна уу. Байгаль орчны яамнаас хэн байгаа юм. Байгаль орчны яамнаас хүн байвал саяын асуултад хариулна. Усны асуудал асуусан.

Наранбаатар гишүүн ээ, энэ яамныхыг нь дуудаад, дараа нь таны хариултыг өгүүлчих үү. Цаашаа явахгүй бол. Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

**Б.Баттөмөр:** Бид нар энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль гэж баталж, би санаачлагчийн нэг юм байгаа. Тэгээд энэ хөгжлийн яамыг байгуулсан. Ингээд хөгжлийн бодлогоо оруулж ирж байгаа. Тэгээд энэ дээр бол тухайн тухайн жилдээ шаардлагатай тэр хөгжлийнхөө асуудлыг төлөвлөөд оруулж ирж байгаа юм. Энэ жилийнх бол 8 тэргүүлэх чиглэлтэй, 224 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж орж ирж байгаа юм байна. 11,8 их наяд төгрөг, 3,7 их наяд төгрөгийн төсвөөс хэрэгжүүлнэ. Үлдэж байгаа 8 их наядыг төр, хувийн хэвшил, гаднын зээл тусламж гээд л явах юм байна л даа. Энэ жил чинь манай дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 74 их наяд төгрөг байгаа. Ирэх жил 82, 83 болох юм болов уу даа. Ингээд бодохоор ДНБ-ийхээ 4 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг л хөрөнгө оруулалтад оруулах нь л дээ.

Тэгэхээр эндээс юу харагдаж байна гэхээр бид чинь энэ ажил хийгээд, олсныгоо идээд зарцуулчхаж л байна л даа. Бүтээн байгуулалтад бол юм алга. Юм хийх болохоороо гаднын зээл тусламж ийм л болсон байна. Тэгээд энэ дээр санхүүжилтийн 70 хувь нь бол эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах 12,7 хувь нь өрхийн үйлдвэрлэл өрхийг дэмжих, тэгээд яг өрхийг дэмжих дээр нь аваад үзэхээр 50 мянган ажлын байр бий болгох гэж байгаа юм уу. 50 мянга хүргэнэ гэсэн нэг ийм юм байж байгаа юм. Тэгээд өөр нэг их олигтой юм алга. Яг яаж эдийн засгийн өсөлтийг өрхөд хүргэх вэ. Ямар бодитой ажлууд хийгдэх вэ. Энэ 50 мянган ажлын байрыг бий болгох чинь хүмүүс цалингаа голоод ажил хийхгүй байгаа шүү дээ. Хөдөлмөрийн үнэлэмж нь бол маш бага. Тийм учраас энд 6 сар хийж олдог мөнгийг Солонгост 1 сард олж байгаа юм. Тийм учраас энэ үнэлэмжийг дээшлүүлэх чиглэлээр юу хийх вэ. Энэ чинь аливаа нийгмийн гол хөдөлгөгч хүч нь дундаж давхарга байдаг шүү дээ. Дундаж давхаргыг нэмэгдүүлэхэд юу хийх вэ. Энэ чинь юу гэхээр зэрэг хөгжилтэй л холбоотой асуудал шүү дээ. ДНБ-ий 60, 70 хувь нь бол өрхийн орлого, худалдан авалт эзэлдэг шүү дээ. Дундаж давхарга чинь энийгээ түүчээлж явдаг. Энэ дээр нэг хариулт өгөөч гэж.

Манай улс бол 1 улс, 1 бүтээгдэхүүнээс хамааралтай эдийн засаг. Нүүрснээс хамааралтай. Өнгөрсөн жилд 9 тэрбум долларын нүүрс гадаадад гаргасан. Хятадын хойд бүсүүдийн одоо эрчим хүчний станцуудын эрчим хүчний нүүрсний хэрэглээ манай эрчим хүчний нүүрсний эрэлтийг бол нэмэгдүүлж байгаа. Бугатын гангын үйлдвэр манай коксжих нүүрсний эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлж байгаа юм. Тэгэхээр 1 улсаас 1 бүтээгдэхүүнээс хэт хамааралтай байгаа энэ эрсдэл 2025 оны хөгжлийн эрсдэлийг юу гэж харж байгаа вэ та нар. Яг одоо энэ чигээрээ явна гэж үзэж байгаа юу. Ямар байгаа вэ. Энэ олон улсын байгууллагууд урд хөршийн эдийн засгийн төлөв байдлыг бол бас тийм

сайнаар үнэлэхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр та нар энэ дээр ямар эрсдэлүүд байна гэж харж байгаа вэ гэсэн ийм зүйлийг хэлж байгаа юм. Тэгээд маш их олон арга хэмжээг хэрэгжүүлэх юм байна. Энэ бол зүйтэй. Хамгийн гол нь юу гэхээр зэрэг манай хийж байгаа, төлөвлөж байгаа хөтөлбөр төсөл, арга хэмжээнүүд дандаа амь сүнсгүй байгаад байгаа юм. Яагаад амь сүнсгүй байна гэхээр эдийн засгаараа баталгаажихгүй байгаад байгаа байхгүй юу. Эх үүсвэр нь байхгүй. Тийм учраас энэ их олон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд эдийн засгийн баталгаа хэрэгтэй гэдэг утгаар асууж байгаа юм.

Хамгийн сүүлчийн асуудал бол 4 тэрбум долларын долларын гадаадын хөрөнгө оруулалт орно гэж. Тэгээд ямар ямар төслүүд дээр энийг төлөвлөж байгаа вэ. Оюу толгой дээр байна уу. Өөр ямар ямар төслүүд байна. Тэр Хармагтай, Асгат тэр том том төслүүдээ хөдөлгөх үү. Ямар төслүүд дээр энэ 4 тэрбум долларын хөрөнгө оруулалт оруулж ирнэ гэж тооцож байгаа вэ. Ийм асуултуудад хариулт авъя.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулна. Чимэдийн Хүрэлбаатар сайд.

**Ч.Хүрэлбаатар:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Эхнийх нь дундаж давхаргыг яаж бий болгох вэ, яаж хадгалах вэ гээд. Ингэхээр өнгөрсөн хугацааны тэр туршилага, үр дүнг харахад бол үндсэндээ макро эдийн засгийн тогтворгүй байдал бол олон дундаж давхаргыг бол алга болгож байсан. Инфляц өндөр, хани тогтворгүй ийм болохоор ерөөсөө л дундаж давхарга алга болдог. Нөгөө олсон орлого нь инфляцад идэгддэг. Олсон хэд нь гадаад валютаар аваад үзэхээр алга болчихдог. Мөнгө биш болчихдог. Ийм зүйл учраас ерөөсөө 1 дүгээрт нь бид нар энэ макро эдийн засгийг тогтворжуулахгүйгээр дундаж давхаргыг бий болгоно гэдэг зүйл байхгүй. Өөрөөр хэлбэл макро эдийн

засгийн тогтворжилт гэдэг бол өөрөө дундаж давхаргыг бий болгох суурь гол нөхцөл юм гэдгийг Эдийн засаг, хөгжлийн яам бол үзэж байгаа. Ийм учраас юуны өмнө энэ валютын хани хэлбэлзээд байдгийг алга болгохын тулд Монгол Улс 10 тэрбум долларын нөөцтэй болох ёстой.

2 дугаарт нь инфляц байгаа. Инфляцыг ерөөсөө Эдийн засаг, хөгжлийн яам бол 3 хувиас хэтрүүлэхгүй байлгах ёстой гэдэг ийм зарчмын байр суурь дээр хатуу байгаа. Яагаад вэ гэхээр 3 хувьтай байж байж энэ зээлийн хүү 1 оронтой тоо руу буух боломжтой. Хани тогтвортой байж байж энэ зээлийн хүү 1 оронтой тоо руу орох боломжтой болно. Ийм учраас инфляцыг 3 хувь байлгаад, валютын нөөцөө 10 тэрбум доллар болгоод, тэгээд жил бүрийн эдийн засгийн өсөлтийг 6-7 орчим хувь дээр тогтмол бариад 10 жилээр хөгжөөд явах юм бол үндсэндээ манайд дундаж давхарга бол нийтдээ бий болно гэж үзэж байгаа.

Үүний дараагийн зүйл бол бид нар энэ хөрөнгө оруулалтыг сайн татах ёстой. Олон мянган залуучууд гадаадад очоод янз бүрийн үйлдвэрт ажилладаг. Монголчууд очиж тэр ажиллаж байгаа тэр үйлдвэрүүд нь тэндээ биш, тэр үйлдвэрүүд нь Монголд ороод ирэх юм бол Монголчууд өөрийн гэсэн нутагтаа өндөр цалинтай ажиллаад байх ийм боломжтой. Тэгэхээр Монголчууд очиж ажиллаад байдаг үйлдвэрүүдийг нь Монголд ажилладаг болох тэр нөхцөлийг бол бид нар хийж өгөх ёстой. Хавчиж, хөөж гадуурхах биш, дэмжиж тэтгэж байж хөрөнгө оруулалтууд орж ирнэ. Тэгвэл Монголчууд маань өөрийнхөө нутаг дэвсгэртээ өндөр цалинтай ажиллах ийм боломж нь бүрдэнэ. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтыг дэмжихгүй байна гэдэг бол үндсэндээ бид нар Монголчуудаа гадагшаа дүрвэх зайлсхийж ажиллах ийм олон эрсдэлүүдийг бий болгоод байгаа гэдгийг би бол энд хэлмээр байна. Гол нөхцөлөө Эдийн засаг, хөгжлийн яам бол ингэж



харж байгаа. Тогтвортой байлгах, хөрөнгө оруулалтыг дэмжих нь дундаж давхаргыг бий болгох гол хүчин зүйлс.

Дээр нь 200 гаруй мянган малчин өрхийг бүгдийг нь дундаж амьдралтай болгох ёстой малчин өрхийг. Тэгэхээр МАА-н гаралтай түүхий эдийг бид нар үнэтэй олох ёстой. Зээл өгөх биш, хөдөлмөрлөөд олдог бүтээгдэхүүнүүдийг нь бид нар үнэтэй болгоод өгчих юм бол тэр МАА-н салбарт ажиллаж байгаа 200 мянган малчин чинь өөрөө бүгдээрээ дундаж давхарга болчих юм. Тэр ноолуур нь өндөр үнэтэй зарагдах ёстой. Мах нь өндөр үнэтэй зарагдах ёстой. Арьс, шир нь өндөр үнэтэй зарагдах ёстой. Ноос нь өндөр үнэтэй зарагдах ёстой. Тийм учраас бид нар ОХУ-тай худалдааны хэлэлцээр хийж байна. Дууссан. Удахгүй баталгаажих ажилдаа орох байх. Мөн үүнтэй адилхан Хятадтай худалдааны хэлэлцээр хийж гэдэг саналаа өгчихсөн байна. Солонгостой бол Чөлөөт худалдааны хэлэлцээрийн ажлыг Эдийн засаг, хөгжлийн яам бол хийгээд явж байна. Энэ нь бол өөрөө эргээд дундаж давхаргыг бий болгоно гэж үзэж байгаа. Дараагийн .../минут дуусав/

**Г.Занданшатар:** Чимэдийн Хүрэлбаатар сайд гүйцээж хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Дараагийн асуулт бол энэ Хятадын эдийн засгийг эрсдэлтэй гэж үзэж байна. Тэгэхэд ямар эрсдэл байгаа вэ гэдэг ийм асуудал байна. Одоо бол Монголын нүүрс Хятад руу гарахдаа бол татвартай гарч байгаа. Татвар төлж гардаг. Хятадын талдаа татвар төлдөг. Эрчим хүчний нүүрс дээрээс 6 хувийн татвар авч байна. Коксжих нүүрснээс 3 хувийн татвар авч байна. Орос, Монголын нүүрс дээр Хятадууд татвар авч байгаа. Тэгсэн мөртөө Австралид Индонезийн нүүрс Хятадын зах зээл рүү ямар нэгэн татваргүй орж байгаа. Энэ нь юутай холбоотой вэ гэхээр нөгөө чөлөөт худалдааны хэлэлцээр манайх байхгүй. Австрали, Индонез бол чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулчихсан

учраас ингээд явж байгаа. Тийм учраас юуны өмнө бид нар энэ чөлөөт худалдааны хэлэлцээрийг БНХАУ-тай бол байгуулах нь манай улсын эдийн засагт, эрх ашигт бол нийцэж байгаа гэдгийг би 1 дүгээрт нь бол хэлье. Ерөнхийдөө 2024 оны эдийн засгийн нөхцөл байдлыг бид нар Эдийн засаг, хөгжлийн яам бол 2023 оныхоос нэг их дутаад байхгүйгээр үзэж байгаа.

Ганцхан ХАА-н салбар бол уналт өндөр байна. Бусад салбарууд дээрээ дандаа өсөлттэй гарч байгаа. Өнгөрсөн оны хувьд аваад үзэх юм бол өдийд 19 сая тонн нүүрс экспортолж байдаг бол эхний 4 сард Монгол Улс 24 сая тонн нүүрс экспортолчихсон байна. 450 мянган зэсийн баяжмал экспортолдог байсан бол одоо 500 мянган тонн зэсийн баяжмал экспортолчихсон байна. Зэсийн үнэ тун дажгүй байна. Газрын тос ч гэсэн өнгөрсөн жилтэй харьцуулах юм бол илүү явж байна. Илүү хэмжээгээр экспортолж байна. Эдийн засгийн үзүүлэлтүүд бол дажгүй, гадаад худалдааны статистикууд бол дажгүй байгаа. Тэгэхээр бид нар ерөнхийдөө 2024 оны Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал 2023 оныхоос илүү байна гэдэгт бол итгэлтэй байгаа гэдгийг бол хэлье.

2024 онд Монгол Улс гадагшаа төлөх 1 долларын ч бондын төлбөр байхгүй. 2025 онд Монгол Улс гадагшаа төлөх 1 долларын ч бас бондын төлбөр байхгүй. Гадаад Засгийн газрын өрийн хэмжээ ДНБ-ий 39 хувь болж, өөрөөр хэлбэл 40-өөс доошоо хувь руу орж сүүлийн 12 жил байгаагүй үзүүлэлт бол гарчихсан байна. Эдийн засаг дээр. Ийм учраас эдийн засгийн нөхцөл байдал бол ковидоос хойш 1 жил 7 сарын дотор тогтворжсон өсөлтийн байдалдаа орсон. Ийм байгаа гэдгийг л би хэлмээр байна. Хамгийн гол нь улс төрийн тогтвортой байдал өөрөө өөрсдөө л зооохон олигтойхон байчих юм бол Монгол Улс бол хөгжих бүрэн бололцоо нь бол байна гэж үзэж байгаа юм. Эрсдэлийг гаднаас биш бид нар өөрөө

өөрсдөөсөө л хайх нь зөв болов уу гэж бодож байна. Баярлалаа.

4 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг бол бид нар ялангуяа бүхий л салбарт орж ирнэ гэж тооцож байгаа. Бүхий л салбарт. Ялангуяа уламжлалт уул уурхайн салбар, ураны салбар, зэс, нүүрсний салбарт бол орж ирэх байх гэсэн ийм тооцоо байна. Хамгийн гол нь бид нарын хувьд бол боловсруулах үйлдвэрлэл, ХАА-н салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээнүүдийг банкны салбарт хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэхийг бол Эдийн засаг, хөгжлийн яам үнэхээр голлож анхаарч байна. Банк, санхүүгийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт бол хамгийн чухал амин хөрөнгө оруулалт болоод байна гэдгийг би бол хэлье. 4 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг бол Монгол Улсын эдийн засгийн цар хэмжээтэйгээ харьцуулаад үзэх юм бол татчих хэмжээ. Ер нь жил болгон 4 тэрбумаас доошгүй хэмжээний хөрөнгө оруулалтыг татаж байж Монгол Улс бол бусад орнуудын түвшинд хөгжинө гэж үзэж байгаа.

**Г.Занданишатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Энэ 2025 оны төлөвлөлтийг хийхдээ бас яг улс орны өмнө ялангуяа томоохон хотууд болон орон нутагт тулгарч байгаа асуудлыг бас зөв төсөвлөж, тэгээд тэрний хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр орж ирсэн нь бол сайшаалтай байна. Сая бол Эдийн засаг, хөгжлийн сайдын ярьж байгаагаар бас мэдээж гадаад дотоод прогнозыг харахад эдийн засгийн үзүүлэлтүүд 2026, 2027 онд нэлээд таатай байх ийм таамгууд харагдаж байна л даа. Жишээлбэл гадаад худалдаанаас л гэхэд 7 орчим тэрбум ам.доллар-ын ашигтай байх ийм төлөвлөлт харагдаж байна гээд энэ дээр дурдагдсан байна. Тэгээд үүнтэй уялдаад ямар ч байсан санхүүжилтийн ийм таатай орчнуудыг бүрдүүлэх нь өөрөө том төсөл хөтөлбөрүүд хэрэгжих гол үндэс болно.

Тэгээд өнөөдөр Ерөнхий сайд тэр үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барьсан байна. Тэгээд энэ Үндэсний орон сууцжуулалтын тухай хууль хэрвээ хэрэгжиж чадвал 30 мянган айл өрх орон сууцтай болох бүрэн боломж хангагдана гэж үзэж байгаа юм байна. Энэ бол үнэхээр сайн. Хэрвээ энэ ингээд хэрэгжээд явчихвал. Тэгэхээр энэ 30 мянган айл орон сууцад хамрагдана гэдгийг хэдий хэмжээний хугацааны түвшинд ярьж байгаа юм бол. Энд Барилга, хот байгуулалтын сайд нь сууж байна. Энэ өөрөө нөгөө нэг хуримтлалын сангийн ипотекийн зээлийг 3 хувь болгох хуримтлалын сангийн хүрээнд 1,2 их наяд санхүүжилт суулгасан. Энэ хэмжээ нь жишээлбэл 2025, 2026, 2027 онд энэ 30 мянгын хэд нь орон сууцад орох бололцоо бүрдэх юм. Энэ яг хаана байхаар Улаанбаатар хотод хэд нь байх юм. Орон нутагт хэд байх вэ гэсэн ийм тооцоо судалгаанууд яг энэ төлөвлөлт дотроо яаж орж байгаа вэ. Ер нь энэ утаа, хөрсний бохирдлын талаар би бол маш их ярьдаг. Ярихаас ч гадна бас бодит үйлдлээрээ Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүддээ бол харуулж байгаа л даа. Тэгэхээр өнөөдрийн байдлаар жишээ нь хэсэгчилсэн инженерийн дэд төвийн хүрээнд манай Чингэлтэй дүүрэгт 200-аад айл өрх хаашаандаа орон сууцтай, нүүрс түлэхгүй, нүхэн жорлон гэдгийг мартаад, үнэхээр амьдрал нь эрс өөрчлөгдсөн. Яг энэ шиг 4 мянгаад айлыг бид бол бас яндан, нүхэн жорлонгоос бол салгасан. Гэхдээ энэ бол хангалтгүй. Маш олон хүсэлтүүд байна. Үүнээс гадна энэ 40 мянгат, 50 мянгат, Бага тойргийн орон сууцууд бүр насжилтаар нь аваад үзвэл ашиглалтын шаардлага хангахгүй гээд гарчихсан. Тэгэхээр энэ орон сууцуудыг нураахгүйгээр яг өнөөгийн энэ хотын өнгө төрх дээр нь засварлах, өөрчлөх, шинэчлэх ажил үүний хүрээнд явагдах уу. Өнөөдөр энд оршин сууж байгаа айл өрхүүд бүгд ярьж байна л даа. Нөгөө социализмын үед баригдсан ямар ч гарааш энэ тэр байхгүй. Тэгээд нөгөө байшингууд нь одоо бүр агааржуулагч, дэд бүтцийн түвшний асуудлууд, тэр



лифт нь бараг ажиллахаа байчихсан. Энд бол маш олон мянган улс орны хөгжлийн төлөө явж байсан сэхээтнүүд, бүтээн байгуулагч нар, олон мянган хүмүүс маань байж байна. Ахмадууд их байна. Залуучууд олноороо амьдарч байна. Тэгээд энэ байруудыг бас засах, засварлах, шинэчлэх энэ төлөвлөлт, энэ үндэсний орон сууцжуулах тухай хуулийн төслийн хүрээнд энэ 30 мянган айлын хүрээнд орох болов уу. Тэгээд энэ асуулт дээр би бас тодорхой хариулт авчхаад, тодотгоё гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданишатар:** Хэн хариулах вэ. Барилга, хот байгуулалтын сайд Даваасүрэн хариулна.

**Ц.Даваасүрэн:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь бид нар доод тал нь 7 мянган айл, тэгээд л 15 мянган айлын орон сууц бол ингэж жилдээ ипотекийн зээлээр барьж ирсэн байгаа юм. Одоо жил бүрийн статистикийг ингээд харах юм бол. Тэгэхээр энэ жил бол ипотекийн зээлийн эх үүсвэр 2 дахин өсөж байгаа. Тэгэхээр энэ жилийн санхүүгийн эх үүсвэрээр бол 14-15 мянган айлын орон сууц бол барьчих ийм бололцоо бол бүрдэнэ гэж ингэж тооцож байгаа. Хуримтлалын санд 570 тэрбум төгрөг хуримтлагдахаар байгаа. Төрийн өмчийн компаниудын ноогдол ашгаас. Ингээд одоо банк дээр байгаа 500 тэрбумтайгаа 1 их наяд гаруй тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдэж байгаа. Тэгэхээр энэ 30 мянган айлын орон сууцны хувьд энэ жил гэхэд бол тал хувь нь бол ингээд төлөгдөөд зээлийн гэрээнүүд хийгдээд ипотекийн зээлээр бол эхэлнэ. Ирэх жил гэхэд бас энэ хэмжээний доод тал нь 10 гаруй мянган айлын орон сууц. Тэгэхээр 30 мянган айлын орон сууц гэдэг бол 2 жилийн хугацаанд ерөнхийдөө хийчих санхүүгийн эх үүсвэр бол байгаа гэсэн үг. Гол хүндрэлтэй байсан юм бол валютын нөөц. Яагаад гэвэл барилгын салбарын импортын хэрэглээ бол 70 хувь байдаг учраас валютын ханшид нөлөөлчих ийм эрсдэл байдаг байсан бол харьцангуй валютын нөөц нэмэгдсэн байгаа учраас

иймэрхүү дарамт бол гарахгүй байх гэж ингэж бодож байна. Тийм учраас одоогийн байгаа санхүүгийн чадавх ер нь манай компаниудын чадавх бол 30 мянган айлын орон сууцыг бол 2 жилийн дотор барих бүрэн бололцоотой болсон байна.

40, 50 мянгатын айлуудын хувьд бол бид нар бас саяхан өнгөрсөн хавар шалгалт хийж үзсэн мэргэжлийн хяналтын байгууллагаас. 1 дүгээр давхруудад бол нэлээн хүндрэлтэй нөхцөл байдал бол үүссэн байгаа. Зарим газар бол 1 дүгээр давхрыг заал болгосон байгаа. Энэ туйлуун байшинд бол нурж орж ирэх, дээд талын айлууд цөмрөх ийм эрсдэл бол бий болсон байна гэсэн үг. Тийм учраас бид нар орон нутгийн байгууллагууд, онцгой байдлын газар гэх мэт байгууллагууд руу бол энэ чиглэлээр анхаарч ажиллаач гэсэн ийм зүйлүүдийг бол хэлсэн байгаа.

Нийслэл хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөлт бол явж байна. Хийгдэж дуусаагүй байна. Энэ хүрээнд бол энэ хотын төвийн район 40, 50 мянгатын айлуудын орон сууцны хэлбэрийг авч үлдэх үү, аль эсвэл дахин төлөвлөлтөд оруулах уу гэсэн ийм зүйлүүд бол яригдаад явж байгаа. Зүгээр одоогоор яг эцэслэчихсэн юм бол алга байна.

**Г.Занданишатар:** Оюунчимэг гишүүн тодруулж асууя. 1 минут.

**М.Оюунчимэг:** Тэгэхээр ер нь ойрын хугацаанд ч гэсэн бас энэ том Үндэсний орон сууцжуулах тухай хууль батлагдаад гарсны дараа энэ орон сууцжуулах хөдөлгөөний хүрээнд 40, 50 мянгатын хуучин байруудад үнэхээр анхаарал хандуулахгүй бол газар хөдлөлт болбол олон хүний амь настай холбоотой асуудал гарах эрсдэл үүсчихсэн байгааг бас анхаарах ёстой болчихсон байгаа гэдгийг нэгд хэлье.

2-т нь ер нь эрчим хүч өөрөө энэ эдийн засаг, нийгмийн тэргүүлэх гол тулгуур хүч нь байгаа. Сая ОХУ-д 2

станц нь гэмтэхэд л улс орон даяараа Монгол Улсад тогийн хязгаарлалт явагдаад л, тог тасарч байна шүү дээ. Тэгэхээр энэ төлөвлөлт дотор 2025, 2026, 2027 онд эрчим хүчээрээ хангах дэд станцуудыг бий болгох энэ тал дээр цахилгааны асуудал дээр ямар төлөвлөлт орж ирж уялдаж байгаа вэ энэ орон сууцжуулах хөтөлбөртэйгөө. Яагаад гэвэл энэ олон мянган айл орон сууцад орно гэдэг чинь өөрөө дахиад эрчим хүч тог цахилгааны асуудал бол хамгийн тулгуур асуудал болно. Тэгэхээр үүний төлөвлөлт дээр хэдий хэмжээний хөрөнгө мөнгө яаж хийх нөгөө станцаа барих вэ гээд энэ асуудал дээр хариулт авъя.

**Г.Занданишатар:** Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга. 4 номер.

**Н.Тавинбэх:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын хэмжээнд эдийн засгийн өсөлттэй холбоотой эрчим хүчний хэрэглээг өмнөх жилүүдээс илүү өсөлттэй байгаа. Энэ өсөлтийг бас эрчим хүчний салбар бэлэн байж чадаагүйтэй холбоотой хангаж чадахгүй байгаа ийм хүндрэлтэй нөхцөл байдал энэ цаг үед үүссэнийг хэлье. Энэ талаар мэдээлэл их олон удаа өгсөн.

2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд Улаанбаатар хот болоод Улаанбаатар хотын ялангуяа дулааны өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах, одоо байгаа хэрэглээг найдвартай болгох чиглэлээр улсын хэмжээнд өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах, одоо байгаа хэрэглээг найдвартай болгох үүднээс томоохон төсөл, арга хэмжээнүүдийг хийгдэж байсан болон төслүүдийг үргэлжлүүлэх, шинэ арга хэмжээг эхлүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан байгаа. Бөөрөлжүүтийн ДЦС 300мвт-аар, Багануурын.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Тавинбэх дарга гүйцээгээд хариулъя. Энэ тодруулгад

чинь шинэ асуулт асуучаад байна л даа Оюунчимэг гишүүн. 4 дүгээр микрофон.

**Н.Тавинбэх:** Багануурын ДЦС, Тавантолгой ДЦС-уудыг үргэлжлүүлэн ажлыг нь хийж, эрчим хүчний хэрэглээг хангах, цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хувьд бол бид нар газ болон хатуу түлшээр ажилладаг тархмал эх үүсвэрүүдийг барьж ашиглалтад оруулж өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахаар 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданишатар:** Болчихсон уу. Танай сайд хаачсан. Ер нь эрчим хүчний салбар бас эрчимжүүлэхгүй бол одоо манайх нийт эрчим хүчнийхээ 75 хувийг дотооддоо үйлдвэрлэж, 25 хувийг нь импортоор авч байна шүү дээ. Тийм ээ. Хэрэглээ 244мвт-аар нэмэгдчихээд байхад та нар нөгөө цахилгаан станц барих ажил таг. 2024 оны жилийн төлөвлөгөөнд туссан тэр баахан цахилгаан станцууд барих ажлууд таг. Ногоон хөгжлийг дэмжинэ, сэргээгдэх эрчим хүчийг дэмжинэ гэсэн ажлууд байхгүй. Тэгээд энэ жил ахиад л юу гэж оруулсан юм.

Дараагийн асуулт Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** 2025 оны хөгжлийн төлөвлөгөө нь жилийн хөгжлийн төлөвлөгөөнд энэ эрчим хүчний салбарт хэрэглэгчид борлуулах цахилгааны тарифыг нэмэгдүүлнэ, дулааны тарифыг нэмэгдүүлнэ гэж орж иржээ. Энэ чинь ер нь ирэх жилээ хүлээхгүйгээр энэ өвөл ер нь Улаанбаатарчууд, нийслэлчүүд ер нь эрчим хүч, дулаан яаж өвөлжих юм бэ. Яаж урсгал их засвараа хийх юм бэ. Мааш эмзэг байна шүү дээ. Тэгэхээр ер нь ирэх жилийг хүлээлгэхгүйгээр энэ өвлийн асуудал яригдаж байна. Тийм учраас энэ үнэ тарифыг заавал ирэх жил биш энэ жилд нь багтааж шийдэх асуудлыг ярихгүй юм уу. Энэ эрчим хүчний үнэ

тарифын либералчлалын асуудлыг ярихгүй юм уу. Энэ асуудлаар 2, 3 жил яриад, ерөөсөө ямар ч үр дүн гарсангүй ээ. Өнөөдөр энэ станцууд чинь бие биеэ татаад унагалаа шүү дээ. Өр, авлагын асуудал хэтрээд бүр алийгаа алдлаа шүү дээ. Тийм учраас цаашидаа энэ үнэ тарифыг нэмэгдүүлэх, өр авлагыг бууруулах асуудал, найдвартай эх үүсвэртэй байхгүй бол цаашидаа энэ өвөл хүртэл өвлийн бэлтгэл ажлыг хангах асуудал чинь төсөв санхүүгийн асуудлаас болоод, үнэ тарифын асуудлаас болоод юу ч хийгдэхгүй өнөөдөр хүлээгдэж байна. Энэ дээр ямар бодлого барьж байна вэ гэдгийг нэгд асууя.

2-т Багануурын цахилгаан станц гээд энэ 4 жилийн энэ төлөвлөгөөнд ингэж орж ирлээ. Нэг ч ажил хийгдсэнгүй. Яг үнэнийг хэлэхэд 2017 онд эхэлсэн Багануурын цахилгаан станц яг эхэлсэн шигээ эрчимтэй хийгдсэн бол өдийд дуусаад ашиглалтад ороод дор хаяж 400мвт-аар эрчим хүчний хэрэглээ бий болох байсан. Харамсалтай нь тухайн үеийн Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Ажлын албаны дарга Гансүх гэдэг тэргүүтэй хүмүүс Багануурт очиж энэ станцын ажлыг зогсоож байсан. Яагаад гэхээр энэ станцын төсөл бол Монгол Улсад ашиггүй өндөр үнэтэй гэдэг үндэслэлээр. Баахан улс төр хийж явсан нөхдүүд нь эхнээсээ өнөөдөр шоронд ороод явж байгаа. Тийм учраас энэ Багануурын цахилгаан станцын ер нь хийгдэх юм уу, хийгдэхгүй юм уу. Ямар шатандаа яваа юм. 4 жил ингээд төлөвлөгөөнд ороод туслаа. 1 ч ажил хийгдсэнгүй. Энэ юун дээр гацаад байгаа юм. Манай улсын талаас хүлээж байгаа үүрэг юмнууд нь бол одоо асуудал байхгүй. Цаад талаасаа асуудал байгаа гэж ойлгоод байгаа. Энэ тал дээр ямар мэдээлэл байна. Хэрвээ энэ цахилгаан станцын асуудал хийгдэж чадахгүй бол Багануурын уурхайг тэтгэж байгаа Багануурын дулааны станцын асуудлаа ярьж, өргөтгөлийн асуудал засварын асуудлыг хийхгүй бол Багануурын уурхайг тэтгэдэг Багануурын дулааны станц нь өөрөө

асуудалд орж, өвөлжилтийн бэлтгэл ажил хүндрэхээр байгаа юм. Тийм учраас би юу хэлэх гээд байна вэ гэвэл энэ төлөвлөгөөнд Багануурын дулааны станцын 8 зуухны 4 зуухыг өргөтгөх асуудлыг тусгаж өгөөч ээ Эрчим хүчний сайд аа. Тэгэхгүй бол тэр нөгөө бухын доодхыг харж үнэг турж үхнэ гэдэг шиг Багануурын цахилгаан станцын асуудал мөдгүй болсоор байгаад, энийг ярьсаар байгаад 10 хэдэн жил Багануурын одоо ажиллаж байгаа дулааны станц нь мөлхөхөд хүрээд байгаа юм. Тийм учраас энэ төлөвлөгөөнд нь Багануурын дулааны станцын өргөтгөлийн асуудлыг оруулж өгөөч ээ гэж 2-т хэлэх гэсэн юм.

3-д энэ шүүхийн асуудал дээр нэг ойлголтын зөрүүтэй асуудал байна. Багахангай дүүргийн шүүхийг шинээр барина гэж энэ Налайхынхыг бариад, Багануур дүүргийн шүүх юм шүү. Багануур дүүргийн шүүх. Налайх, Багахангай 2 чинь тойргийн 1 шүүх учраас тэрийг нь засаад, Багахангай гэдгийнх нь оронд Багануур гэж бичээрэй гэдгийг хэлье. Энэ 2 асуултдаа хариулт авъя.

**Г.Занданшатар:** Нансалын Тавинбэх. 4 номер.

**Н.Тавинбэх:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрчим хүчний чиглэлээр хэрэгжүүлэх, тэр дотроо эх үүсвэртэй холбоотой ажлууд хэвийн хийгдэж байгаа гэдгийг би хэлье. Би асуулт нэлээн хурц тавигдсан учраас би тодорхой тоо хэлье гэж бодож байна. Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 35мвт-аар өргөтгөх ажил ашиглалтад орж, өнөөдөр оргил ачааллыг давахад эрчим хүчний салбарт хэрэглэгчдэд эрчим хүч нийлүүлж байна. Дарханы ДЦС-ын хүчин чадлыг 35мвт-аар нэмэгдүүлэх ажил амжилттай хэрэгжиж дууссан. ДЦС 4-ийн хүчин чадлыг 89мвт-аар өргөтгөх ажил амжилттай дуусаж, ашиглалтад орсон. Дорнодын ДЦС-ын хүчин чадлыг 50мвт-аар өргөтгөх ажил энэ 6 сарын 6-нд ашиглалтад орно. Ажил бүрэн

дууссан. Туршилт нийлүүлсэн. Системд эрчим хүч нийлүүлж эхэлсэн. Засгийн газар өөрөө сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд 5-ыг барихаар төлөвлөсөн. Тэр дандаа баруун аймгуудад байгаа. Энэ ажил бүгд дууссан. Ашиглалтад орсон. 45мвт-ын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглалтад орсон байгаа. Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг би энд оруулаагүй. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын ажил эхэлсэн. Ганцхан одоо зээлийн тусгайлсан хэлэлцээр өнөөдрийг хүртэл албажиж дуусаагүй байна. Энэ бол Монголын талтай хамаагүй. Хятадын талын өндөр, их хэмжээний зээл олгохтой холбоотой дотоодын процесс үргэлжилж байгаа гэдгийг хэлье. Тэгэхдээ энэ зээл удахгүй албажин. Барилга угсралтын ажил эхэлчихсэн явж байгаа. Ялангуяа дэд бүтцийн ажил үндсэндээ одоо дуусаж байна. Ялангуяа боомт руу хүрэх зам гүүр гээд. Амгалангийн дулааны станцыг 100мвт-аар өргөтгөх ажил хийгдсэн. Хийж дууссан. Ашиглалтад орсон. Бид дэлхийд нэлээн том чадалд орох 200мвт-ын багтаамжтай батарейн цэнэгт хураагуурыг Улаанбаатар хотод ашиглалтад оруулж, системд эрчим хүч нийлүүлж эхлээд байна. Горимын тохируулгыг хийж эхлээд байна. Өөрөөр хэлбэл бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгачихсан арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлснээр Монгол Улсын эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадал өнөөдрийн байдлаар 395 орчим мегаваттаар нэмэгдээд байгаа гэдгийг хэлье.

Бас биднээс болон гадаад хүчин зүйлээс хамаарч удааширч байгаа төслүүд байгаа. Тухайлбал Тавантолгой ДЦС-ын төсөл бол нүүрсний технологитой эх үүсвэрт санхүүжилт хийхгүй байгаатай холбоотойгоор бол удааширч байгаа. Энэ үнэн. Гэхдээ бид боломжтой арга хэмжээнүүдийг авч байна.

Багануурын дулааны станцын хувьд бол удаан үргэлжилж байгаа нь үнэн.

Гэхдээ одоо хөрөнгө оруулагч нар энэ гэрээний үүргээ биелүүлэхээр ажиллаж байгаа гэдгийг бол албан ёсоор хэлж байгаа. Өнөөдрийг хүртэл гэрээ цуцлах, гэрээний үүргээ биелүүлэхгүй байх талаар албан ёсоор мэдэгдээгүй. Багануурын дулааны станцын хувьд дулааны эрчим хүчээр Багануун дүүргийг хангахаар бид тохирч гэрээнд тусгасан. Энэ тохирсноор бол бид бас Багануурын дулааны станцын хөрөнгө оруулагчийн өмнө дулааны хэрэглээг тогтвортой байлгах ийм үүрэг хүлээж байгаа. Тийм учраас бид Багануур дүүрэгт дулааны станц барих асуудлыг бол 2025 оны хөгжлийн хөтөлбөрт тусгаагүй. Багануур дүүрэгт 700мвт-ын ДЦС баригдаж, баригдах асуудал эцэслэх хүртэл бол энэ асуудлыг шийдэх боломжгүй байгаа. Гаднын хөрөнгө оруулагчдаа бид үүрэг хүлээсэн гэж ингэж ойлгож болно.

2 дугаарт бид нар Хятадын Засгийн газраас нүүрсний технологид хөрөнгө оруулалт хийхгүй, бас барилга угсралтын ажилд оролцохгүй. Төрийн бодлого гарсантай холбоотойгоор энэ шийдвэрээс өмнө хэрэгжиж байсан санхүүжилт Хятадын дотоодын зах зээл дээрээс босгох боломжтой цорын ганц төсөл бол Багануурын дулааны станц байгаа. Тийм учраас бид нар энэ төслийг хэрэгжүүлэх ажил болгохын төлөө бол бүх боломжтой арга хэмжээг авч байгаа гэдгийг хэлье.

Хэрвээ одоо албан ёсоор Багануурын ДЦС-ын төсөл 1 талдаа хэрэгжих, эс хэрэгжих нь шийдвэр гарвал энэтэй холбоотойгоор Багануурт одоо байгаа дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх ажлыг бол дахиж шинэ хувилбараа ярих боломжтой гэдгийг би танд хэлье.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Нансалын Тавинбэх сайд гүйцээж хариулъя. Төрийн нарийн бичгийн дарга. 4 номер.

**Н.Тавинбэх:** Салбарын үнэ тариф, хууль, эрх зүйн хувьд бол хараат бусаар



эрчим хүчний зохицуулах хороо нэмэгдүүлэх, өөрчлөх асуудлыг шийддэг. Бид эрчим хүчний зохицуулах хороонд үнэ тариф алдагдалтай байгаа, өртгөөсөө доогуур үнээр борлуулж байгаа асуудлыг шийдвэрлэх хүсэлтээ бол тавьчихсан. Эрчим хүчний зохицуулах хороо удахгүй шийдээ гаргах байх гэж ингэж харж байна. Өртгөөс нь доогуур үнээр борлуулж байгаатай холбоотой салбар их хэмжээний алдагдал хүлээж байгаа нь бодитой үнэн. Энэ олон хүндрэлүүдийг бий болгож байгаа хөрөнгө оруулалтыг татахгүй байх. Тэр битгий хэл одоо бид өнөөдөр урсгал зардлаа тавьж чадахгүй хэмжээнд бэлэн мөнгөний урсгалын дутагдалд орж байгаа нь үнэн. Ойрын үед Эрчим хүчний зохицуулах хороо хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргаж энэ асуудлыг эцэслэн шийдэх байх гэдэгт найдаж байна.

Эрчим хүчний салбарын хүндрэлтэй байдлаас болоод уурхайнууд бас хүндрэлтэй байдалд орж байгаа нь үнэн. Гэхдээ бид өнгөрсөн жилд уурхайнуудаас худалдаж авдаг нүүрсний үнийг бас боломжийн хэмжээнд нэмэгдүүлсэн байгаа гэдгийг би хэлье. Энэ жилийн хувьд бол бид нар бэлэн мөнгөний санхүүгийн хүндрэлтэй байдал, тэр дотроо бэлэн мөнгөний дутагдалд орсноос болоод засварын ажил удааширалтай явж байгаа нь үнэн. Гэхдээ бид боломжтой хэмжээнд бас 2024-2025 оны өвлийн их ачааллыг давах бэлтгэл ажиллагаа хангаж байгаа. Огт зогсчихсон зүйл байхгүй гэдгийг хэлье. Боллоо.

**Г.Занданишатар:** Чимэдийн Хүрэлбаатар сайд гүйцээж хариулна. Хариултын дараа тодруулж асууна Сандаг-Очир гишүүн ээ.

**Ч.Хүрэлбаатар:** Би Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Үнэхээр эрчим хүчний салбар дээр бид нар либералчлалын бодлого явуулахгүй бол үнэхээр бүтэхгүй. Одоо саяын Эрдэнэтийн станц гэж байна. Дарханы

станц гэж байна. Тэр томоохон батарей хуримтлалуудыг хийсэн гэж байна. Энэ чинь Даваасүрэн сайдын үед бүгд хийгдсэн. Одоо бидэнд энэ салбарт хөрөнгө оруулалт хийлгэхийн тулд бид нар энэ салбарыг либералчлахгүй бол болохгүй. Яг одоо байгаа энэ үнийн тарифын тогтолцоо, одоо байж байгаа хандлага энэ бүхэн бол өөрчлөгдөж байж энэ салбар өөр болно. Үнэндээ энэ 2024 онд бид нар бага таслаасай л гэж хүсэж байгаа юм. Бага таслаасай гэж. Энэ жил өчнөөн айлын цахилгааныг хэлж барихгүйгээр таслаад, өчнөөн хохирлууд зөндөө олон газрууд хохирол үүсчихсэн байж байгаа. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам бол 2022 оны 9 дүгээр сараас эхлээд эрчим хүчний салбараа либералчил, энд хөрөнгө оруулалтаа тат гэдэг ийм зөвлөгөөг бол өгч ирсэн. Тэгэхээр цаашидаа энэ Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг тогтвортой 6 хувиар өсгөхийн тулд бид нарт яах аргагүй эрчим хүчний салбар хэрэгтэй. Эрчим хүчний салбар бол ийм нийгмийн чиг баримжаатай байх юм бол энд улс орныхоо эдийн засгийн хөгжлийг бол бүгдийг нь хойш нь татаад суухаар байна. Тийм учраас энэ салбарыг бид нар зах зээлийнх нь ажилладаг тэр горим руу хийж зоригтойнхон ажил хийхгүй бол бага үнэ тарифтай байлгадаг. Тэгээд баахан хомсдолтой. Хомсдолтой учраас энд нөгөө төмөр замын тариф бага байж байгаад баахан авлигачид төрдөг шиг ийм нөхцөл байдал үүсгээд яваад байгаа юм. Тийм учраас энэ Сандаг-Очир гишүүний хэлж байгаа энэ санал бол энэ дотор үндсэндээ бол жилийн төлөвлөгөө дотроо бол байгаа. Эрчим хүчний салбарыг либералчлахгүйгээр, шинэ нүдээр харахгүйгээр энэ салбарыг бид нар бол хөгжүүлэх боломжгүй. Дээр нь Монгол Улсынхаа эдийн засгийн өсөлтийг хангах 6 хувийн өсөлтийг хангаж явах эрчим хүчний ханган нийлүүлэлт бол хийгдэхгүй. Зүгээр энгийн хэвийн бизнесийн үйл ажиллагаа явуулахад ч төвөгтэй болж эхэлж байгаа учраас одоо энэ салбар дээрээ энэ либералчлалыг маш сайн хийх шаардлагатай байгаа юм. Элдэв бусын



шалтаг хэлээд, урьд өмнө нь хийсэн ажлуудыг хамж шимж ярих биш, яг энэ салбар дээр бид нар ийм юм богинохон хугацаанд хийнэ гэдэг юмаа маш тодорхой гаргаж ирж явахгүй л бол болохгүй. Тийм учраас гол шийдлээ бид нар энэ салбарыг нь либералчлаад л гэж харж байгаа юм. Тэгэхгүй бол бухын доодхыг харж үнэг турж үхнэ гэгчээр энэ улс орноороо асуудал хүндрэх ийм асуудал руу явж эхэлж байна.

**Г.Занданишатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Сая хариултаас Багануурын дулааны станцыг бол Багануурын цахилгаан станцын ажил хэрэгжтэл шинэчлэл хийгдэхгүй юм байна гэж. Багануурын цахилгаан станц чинь бол дулаангүй шүү дээ. Цахилгаан гаргана. Зүгээр ТЭЗҮ-д нь дулааны гаргалгаа хийж байгаа. Тийм учраас Багануурын дулааны станцын одоогийн өргөтгөл хүссэн хүсээгүй энэ төсөл явсан яваагүй хэрэгжих ёстой. Өргөтгөл хийгдэх ёстой. Тийм учраас давхар явахгүй бол Багануурын цахилгааны станцын ажил чинь одоо тодорхойгүй байна. Хийгдээд эхэллээ гэж бодоход хэдэн жил болох вэ. Тэр хүртэл хугацаанд Багануурын уурхайг чинь Багануур дүүргийг чинь тэжээж байгаа дулааны станц нь өөрөө мөлхчих гээд байгаа юм. Тийм учраас энэ станцын өргөтгөлийн асуудлыг хамтад нь авч явж одоогоос засаж сэлбэх хөрөнгө оруулалтын юмнуудыг нь шийдэж байхгүй бол тэрний дараа энэ асуудлыг ярина гэдэг асуудал бол байж болохгүй шүү. Тэгээд энэ дээр би бүр зориуд хэлж байна. Өвлийн эд ачаалал эхлэхээр санасан сэдсэн юм шиг гэв гэнэтхэн асуудал яригддаг. Тийм учраас жилийн төлөвлөгөөнд.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Санал хэллээ. Хариулт Тавинбэх Төрийн нарийн бичгийн дарга санал хэлсэн учраас хариулах шаардлагагүй. Ер нь эрчим хүчний салбар улаан гэрэл асчхаад байгаа шүү. Энийгээ та нар ярьдаг юм уу.

Шийддэг юм уу. Саяын таны ярьсан асуудлууд энэ Шадар сайд Хүрэлбаатарын хэлсэнчлэн бүгд Даваасүрэн сайдын үед хийгдсэн ажлууд. Дорнодынх. Хамгийн сүүлд 2020 онд эхэлсэн. Дархан, Эрдэнэтийнх бүгд 2016-2020 онд хөөцөлдсөөр байгаад эхэлсэн ажлууд. Одоо дулааны эрчим хүчний түгээлт, хангамжийн сүлжээ чинь 18-20 хувийн алдагдалтай. Эрчим хүчний хэрэглээ 244мвт-аар нэмэгдчихсэн. Одоо ингээд цахилгаанаа хязгаарладаг ийм эрчим хүчний нөөцтэй эрчим хүчтэй улс гэж байгаа мөртөө өнгөрсөн 4 жил юу ч хөдөлсөнгүй шүү. Тавантолгойн цахилгаан станц байхгүй. Багануурын цахилгаан станц байхгүй. Тийм учраас энэ бол энэ жилийн төлөвлөгөөнд нээрээ энэ улаан гэрэл асчхаад байгаа учраас энэ зүгээр нэг тоглоомын асуудал биш. Эрчим хүчний салбарын либералчлал, аж ахуйн нэгж, байгууллагуудын үнэ тарифыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн. Нөгөө талдаа бас тэр уурхайнууд станцуудынхаа ч үйл ажиллагааг либералчилж, олон нийтийн хяналтад оруулахгүйгээр байна шүү дээ. Тэнд чинь маш үр ашиггүй тогтолцоо байдаг юм байна лээ шүү. Тэр цахилгаан станцууд хүн амьтан шалгагдаад Авлигатай тэмцэх газрын мэдээлэл тэр Багануур чинь ямар болчихсон. Одоо энэ дээр дорвитой өөрчлөлт хийхийг энэ төлөвлөгөөнд тусгах шаардлагатай гэдгийг л энэ гишүүд яриад байгаа юм.

Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

**Ш.Адьшаа:** Энэ 2025 онд гадаадын зээлээр санхүүжүүлэх бас хэдэн их наядын ийм төсөл хөтөлбөр байгаа юм байна л даа. Үүний эх үүсвэр хаанаас авах юм бэ. Тэгээд энэ өрийн тааз гээд нэг юм яригдаад байдаг. Тэр өрийн тааз чинь энд хамаарагдах уу. Энэ талаар нэг санал авъя. 200 гаруй төсөл хөтөлбөр хөгжлийн бодлоготой хэрэгжих юм байна. Энэ баруун бүс нутагт ямар одоо төсөл хөтөлбөрүүд хаанаас санхүүжилтээр шийдэгдэх вэ гэдэг асуулт байна. Энэ сэргээгдэх эрчим хүчний үнэ тариф гээд нэг энэ дэлхийд

байхгүй л нэг тийм тарифыг лоббидоод хийчихсэн байдаг юм уу. Ийм тариф байгаа шүү дээ. Энийгээ хэзээ бууруулах юм бэ. Энийгээ яг зөв голдиролд хэзээ оруулах юм бэ. Хэдэн жил энийг ярьсан. Энийг тийм боломж байна уу, байхгүй юу. Байхгүй бол өнөөдөр ингээд төсвөөс татвар төлөгчдөөс тэр дарамтыг авч ирээд ингээд сэргээгдэх эрчим хүч гэж нэрийн доор ингэдэг энэ янз бүрийн энэ төсөл санхүүжүүлдэг, тэр үнэ тариф санхүүжүүлдэг энэ тогтолцооноос бид ухарч болохгүй юу.

Дараа нь нэг асуудал байна. Энэ Оюутолгойн асуудал байна. Энэ Оюутолгойн асуудлаар Оюутолгойд Монгол Улсын эрх ашгийг хамгаалах Улсын Их Хурлын түр хороо байгуулагдаад, тогтоол гаргасан байгаа. Улсын Их Хурлын тогтоол. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх талаар Засгийн газар энэ 2 жилийн хугацаанд ерөөсөө дуугарсангүй. Ямар учраас энийг хэрэгжүүлэх боломж бүрдэхгүй байна. Хэрэгжүүлэхийг яагаад хүсэхгүй байна. Энэ талаар нэг хариулт авмаар байна.

**Г.Занданишатар:** Хэн хариулах вэ. Оюутолгой гэсэн биз дээ. Эрчим хүчний яам Нансалын Тавинбэх. 4 номер.

**Н.Тавинбэх:** Адьяаа гишүүний асуултад хариулъя. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс худалдаж авах эрчим хүчний үнийг хуучин хуулиар бол хатуу тогтоож өгсөн байсан. Нарны эх үүсвэрээс 15-18 цент, салхины эх үүсвэрээс 9-9,5 цент. Одоо хуульд өөрчлөлт орсон. 2019 онд. Энэ хуулийн өөрчлөлтөөр бол одоо сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчийг бол аукцион дээр сонгон шалгаруулахаар хуульчилсан. Энэ аукционыг сонгон шалгаруулахаар бид нар бэлтгэл ажил бүрэн хангасан. Ганцхан хүндрэл байна. Хуучин хуулийн хүрээнд маш олон хөрөнгө оруулагчтай хатуу гэрээ байгуулчихсан учраас бид нар бас одоо шинээр хөрөнгө оруулагчийг аукционоор сонгон шалгаруулах тийм орон зай багатай байна. Тэгэхээр бид нар

одоо хуучин гэрээ хийсэн хөрөнгө оруулагч нартай учраа олохоор ажиллаж байна. Харамсалтай нь олигтой үр дүн гарахгүй байна. Яг таны хэлдэг бид нар энэ хэлцлийн явцад бол үнээ буулгах, нийлүүлэх эрчим хүчний хэмжээг хэрэглээнээс хамааруулан диспетчерийн зохицуулалттайгаар системд нийлүүлэх ийм л шаардлагыг тавьж байгаа. Бас хүлээж аваад гэрээгээ шинэчлэн байгуулаад барилга угсралтын ажлаа эхлэх гэж байгаа хөрөнгө оруулагч нар байна. Огт одоо хуучин хатуу гэрээгээ бариад буулт ойлголтод хүрэхгүйгээр одоо байр сууриа хатуу хадгалж байгаа ийм хөрөнгө оруулагч нар байна. Цаашидаа бол бид нар энэ цаг үед болбол анх гэрээ хийж байгаагаас технологи болоод тоног төхөөрөмжийн үнэ хямдарсан учраас үнээ буулга гэдэг хатуу шаардлага тавьж байгаа. Энэ дээр яамны байр суурь маш тодорхой болсон. Шийдвэр гарчихсан. Тухайлбал бид нар нарны станцаас бол 12 центээр дээд тал нь худалдаж авахаар, хүчин чадлынхаа 20 хувьтай тэнцэх хэмжээний батареин цэнэгт хураагууртай байх ийм шаардлагыг тавьчихсан байж байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданишатар:** Дамбын Батлут гишүүн дараа нь санал хураалттай гишүүд чуулганы танхим цуглая.

**Д.Батлут:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Асуултууд бас давхцаж байна. Би эрчим хүчний салбараас...

**Г.Занданишатар:** Батлут гишүүн байж байгаарай. Чимэдийн Хүрэлбаатар сайд бусад асуултад хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** Адьяаа гишүүний асуултад хариулъя. Гадаадын зээл тусламжаар нийтдээ хэчнээн төгрөгийн санхүүжилтээр хийх вэ, ямар төслүүд байгаа вэ гэдэг зүйл асуусан. Тэгэхээр энэ бол бид нар ирэх жилийн 2025 онд хийгдэх ажлуудын тухай ярьж байгаа. Тэгээд нийтдээ 1,8 их наяд төгрөгийн гадаадын зээлээр төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ гэж байгаа. Энэ 1,8 их

наяд төгрөгийн төсөл бол бүгдээрээ нөгөө зээл нь батлагдчихсан төслүүд. Одоо тухайлбал Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг бид нар хараахан зээлийн гэрээ нь батлагдаагүй гэсэн ч Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц тэнд явна гэх жишээтэй. Эсвэл нөгөө бусад төслөөр хэрэгжиж байгаа авто замууд байж байна. Азийн хөгжлийн банкны Улаангом хот чиглэлийн зам байна. Улиастай-Алтай чиглэлийн авто зам байна. Энэ Дарханы замын төгсгөл байдаг ч юм уу гэх мэтийн ийм зүйлүүдийг бүгдийг нь тооцоод 1,8 их наяд төгрөгийн төсөл хөтөлбөрүүд хэрэгжинэ гэдэг ийм тооцоо бол хийж гаргаж танилцуулсан байгаа.

Оюутолгойн асуудлыг Хууль зүйн яамныхан хариулчих уу. Оюутолгойн хэлэлцээр хэн хийж байгаа билээ. Би Солонгоо дэд сайдыг хийж яваад байгаа гэж бодож байна. Энийг нь мэдээллийг гүйцэд авч байгаад танд өгье.

**Г.Занданишатар:** Адьшаа гишүүн яриад байгаа шүү. Дараа мэдээллийг чинь өгнө шүү. Дамбын Батлут гишүүн.

**Д.Батлут:** Өдрийн мэнд хүргэе. Асуултууд давхцаж байна. Эрчим хүчний салбараас асуулт байна. Эрчим хүчний салбарын үнэ ханштай холбоотой асуудлыг бас чөлөөлж өгөх нь хамгийн зөв шийдэл байгаа. Би Сандаг-Очир гишүүнтэй бол санал нэг байгаа. Тэгэхдээ бас дотоод дахь боломжуудаа бид нар бас гаргаж ирж энд бий болчихсон ургацагуудаасаа салмаар байгаа юм. Би одоо 3 дахь удаагаа энэ асуудлыг бас асууж байгаа. Эрчим хүчний салбарт 3 хувийг нь эрчим хүчний нийлүүлэлт хийчхээд бэлэн мөнгөнийх нь 27 орчим хувийг аваад явчхаж байгаа б, 7 том сэргээгдэх эрчим хүчний аж ахуйн нэгж байна. Жилдээ 60, 70 тэрбум төгрөгийн ашигтай ажилладаг. Тэгтэл манай төвийн эрчим хүчний систем нь үндсэндээ энэ жил гэхэд 204 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах тийм төсөөлөлтэй болчихсон. Дулааны цахилгаан станцууд нь тарифаа

нэмэгдүүлж чадахгүй болоод цалингаа нэмэгдүүлж чаддаггүй, технологио шинэчилж чаддаггүй. Ингээд бид цаашидаа яах юм. Сөхрөх юм уу. Энэ сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалт хийгээд явж байгаа аж ахуйн нэгжүүдтэйгээ гэрээний асуудлыг эцэслэн шийдэх боломж байхгүй байгаа юм уу. Яагаад вэ. Тэр үед ямар хүмүүс байгуулаад, ямар зүйл заалт орчхоод ингээд гэрээгээ цуцалж чадахаа байчхаад байгаа юм бэ. Тэр хүмүүсийнх нь асуудлыг хууль хяналтын байгууллагад өгч болдоггүй юм уу. Шалгаж болдоггүй юм уу. Олон нийтийн анхаарлын төвд оруулж болохгүй байгаа юм уу. Энэ тал дээр нэг хариулт өгөөч ээ. Яг тодорхой хариулт өгмөөр байна.

2 дугаарт нь бид эрчим хүчний хараат байгаа. Олон станцуудыг өргөтгөх, УЦС барих, хямд өртөтэй станцуудыг барих асуудлууд яригдаад л байгаа. Энэ Эгийн голын УЦС-аа бид яах юм бэ. Олон жил яригдлаа. Бүр тэдний чинь ажлын алба нь Хөгжлийн банкнаас санхүүжүүлээд явж байгаа юм байна лээ шүү дээ. Эд нар ер нь ямар ахицтай явж байгаа юм. Энэ хөгжлийн төлөвлөгөөнд орохгүй юм уу гэдэг тал дээр хариулт өгөөч.

3 дугаарт нь сая орон нутагт иргэдтэй уулзаж явахад эрүүл мэндийн салбар тэр тусмаа сумдын эмнэлгийн эмч нар нэг зовлон ярьж байна. Бид нар урьд нь бол шийдэл гаргаад сумдын эмнэлгийн 4 төрлийн тусламж, үйлчилгээг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд оруулчихсан. Эрүүл мэндийн салбарынхаа ажилчдын цалингийн дээд хэмжээг аваад хаячихсан ингээд яваад байдаг. Овоо санхүүжилт авдаг. Одоо гүйцэтгэлийнхээ санхүүжилтээр 15-60 сая төгрөг олж байна гэж байгаа юм сардаа. Мөнгө нь байгаад байдаг цалингаа нэмж чаддаггүй, ур чадварынхаа нэмэгдлийг авч чадахаа байчихсан. Тэгсэн мөртөө тэр сумдад нь эмч нар хүний нөөц нь тогтохоо байчхаад ийм л зөрчилдөөнтэй нөхцөл байдлууд үүсчихлээ. Үүсчихсэн

байна. Энийг бид ирээдүйд яах юм бэ. Энэ Эрүүл мэндийн яам, Сангийн яам яг юу гэж үзэж байгаа юм энэ дээр. Тэгээд цалингаа нэмэгдүүлье, ур чадварын нэмэгдэл олгоё гэнгүүт аудитын байгууллагууд нь акт тавьчихдаг гэх юм. Үгүй ээ, тэр дүрэм журмыг нь гаргаж өгөөд, асуудлыг нь шийдчихвэл шийдчихмээр байх юм Эрүүл мэндийн яам, Сангийн яамныхан. Энэ дээр надад яагаад болдоггүй юм бэ гэдэг талаар хариулт өгөөч.

Бид бол энэ эрүүл мэндийн салбарынхны цалин мөнгийг нэмэгдүүлэх, цаашилаад нийгмийн баталгааг нь хангах тал дээр нэлээн дорвитой алхам хийсэн гэж харж байгаа. 2021 онд ажил хаясных нь дараахан бид нар очиж уулзаж байгаад, эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсэг гаргасан. Түүнээс гаргасан үр дүнгүүд бол саяын миний хэлдэг шүү дээ. Гүйцэтгэлийн санхүүжилтэд оруулах, 4 төрлийн тусламж, үйлчилгээг нь бүрэн гүйцэтгэлийн санхүүжилтэд оруулсан асуудал шүү дээ. Энэ яагаад үр дүн, өгөөжөө өгөхгүй байгаа юм бэ. Аудитын байгууллага яг юун дээрээ юу гэж үзэж байгаа юм бэ гээд энэ төрийн байгууллагын уялдаа холбоо үнэхээр алдагдсан байна. Нэг нь болно гэдэг, нөгөөдөх нь болохгүй гэдэг. Акт тавьдаг. Яг тэр дунд чинь төрийн албан хаагчид.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Нансалын Тавинбэх Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

**Н.Тавинбэх:** Би Батлут гишүүний асуултад хариулъя. Тодорхой цаг хугацаа, мөнгөн дүн, тоо асуусан учраас би тодорхой хариулъя. Хуулийн орчинд 2007-2017 оны хооронд Монгол Улсын хэмжээнд 38 аж ахуйн нэгжид 1560 орчим мегаваттын хүчин чадалтай нар салхины хувьсах эх үүсвэр барих зөвшөөрлийг өгсөн байдаг юм. Энэ эх үүсвэрүүдээс худалдаж авах үнэ бол тухайн үед хүчин төгөлдөр байсан

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дагуу л зохицуулсан. Тэр бол үнэтэй үнэ. Ер нь одоо энэ үнээр эрчим хүч худалдаж авах нь хүндрэл учруулж байгаа 2 шалтгаан байгаа.

1 дүгээрт мэдээжийн хэрэг америк доллароор төлбөр хийхээрээ гэрээ хийчихсэн. Долларынхоо ханишийг, валютынхаа ханишийг бид нар макро түвшиндээ барьж чадаагүйтэй холбоотой эрчим хүчний салбар төлбөр хийх үед валютын ханшаас болж их хэмжээний ачаалал өгч байна.

2 дугаарт бид нар удаан хугацаанд цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглэгчийн үнийг тогтвортой өртгөөс нь доогуур барьсантай холбоотой л ийм 2 хүндрэл гарч байгаа юм. Бид нар энд ажилласан. Энэ 38 аж ахуйн нэгжээс 9 нь бол ашиглалтад орж, өнөөдөр үйлдвэрлэл явуулж, бүтээгдэхүүн эрчим хүчний салбарт нийлүүлж байна. 6 аж ахуйн нэгж бол өнөөдөр лиценз нь хүчин төгөлдөр маргаантай явж байна. Бусад аж ахуйн нэгжийн лицензийг бол хүчингүй болгосон байгаа. Цаг хугацаандаа барилга угсралтын ажлаа эхлээгүй, хөрөнгө оруулалтаа хийгээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй гэдэг шалтгаанаар. Гэхдээ бас нэлээд хэдэн аж ахуйн нэгж шүүхээр явж байна. Ер нь гэрээг бол ний нуугүй хэлэхэд би өмнө нь чуулган дээр бас хатуу хэлж байсан. Нэг талыг барьсан, маш хатуу, хохиролтой ийм гэрээ хийсэн нь бол үнэн. Тэгэхдээ би энд нэг зүйлийг бас онцолж хэлмээр байна. Ер нь бол Монгол Улс цаг агаарын өөрчлөлттэй холбоотой ногоон цэвэр технологид шилжих нь бол гарцаагүй үнэн, бодитой зүйл. Гэхдээ энийг алдаа мадаггүй хийх ёстой.

2 дугаарт нь Монгол улсын хувьд одоо хүйтэн, хүйтний улирал удаан үргэлжилдэг онцлогтой учраас эрчим хүчний хангамжид өндөр шаардлага тавигддаг. Энэ шилжилтийг хийхдээ бид нар бусдаас илүү хянамгай, шинжлэх ухаан, технологийн дагуу хийх ёстой л гэдэг ийм байр суурьтай байгаа. Бид нар



одоо хүчин төгөлдөр байгаа түрүүний б аж ахуйн нэгжтэй бол хэлцэл хийж байгаа. Би түрүүн хэлсэн. Үнийг буулгах, технологийн хувьд хэрэглээнээс хамаарч үйлдвэрлэлээ өөрчилдөг диспетчерийн зохицуулалтад орж ажилладаг ийм л шаардлага тавьж байгаа. Ойлголцоод үнээ буулгаад технологийн хувьд диспетчерийн зохицуулалтад орох боломжоо бүрдүүлээд явж байгаа аж ахуйн нэгж байна. Энэ нь цөөхөн. Дийлэнх нь бол хуучин нэг талыг барьсан гэрээгээ бариад ингээд маргалдаад явж байгаа.

Таны түрүүний хэлдэг үнэн. Нийт үйлдвэрлэж байгаа эрчим хүчний 9 орчим хувийг үйлдвэрлээд, орлогын 24 орчим хувийг авч байгаа нь бол түрүүний бодитой үнэн байгаа гэдгийг хэлье.

Эгийн голын цахилгаан станцын хувьд бол бид нар Эгийн гол бол Сэлэнгэ мөрөнд цутгаж, Сэлэнгэ мөрөн бол ОХУ руу гардаг. Тийм учраас ОХУ-аас Эгийн гол дээр одоо усны барилга байгууламж барьсантай холбоотойгоор ОХУ-аар урсдаг Сэлэнгэ мөрөн болоод Байгаль нуурт сөрөг нөлөөлөлтэй эсэхийг л тодруулж магадалж өг л гэж байгаа юм. Энэ бол зүй ёсны шаардлага гэж ингэж үзэж байгаа. Энэ ажлыг бид хийгээгүй явснаас болж үл ойлголцол үүссэн. Одоо энэ ажил хийгдэж эхэлсэн. Бид хамгийн түрүүчийн үнэлгээгээ хийгээд Дэлхийн өвийн хорооны Юнескоийн өвийн хороонд хүргүүлсэн. Дүгнэлт гарсан. Оросууд ахиад энэ үнэлгээг хамтарч хийе гэдэг ийм шаардлага тавьсан. Энэ ажил хийгдэж байгаа. Энэ ажил хийгдээд нөлөөлөлтэй гэж гарвал бид нар нөлөөллийг хэрхэн арилгах вэ, нөлөөлөлгүй гэж ажиллавал би Оросын талаас манай төслийг дэмжсэн нааштай хариу гарна гэдэгт эргэлзэхгүй байна. ОХУ-ын тавьж байгаа шаардлагыг би одоо зүй ёсны шаардлага гэдгийг дахин хэлье. Олон улсын гэрээ, конвенц хамтын ажиллагааны дагуу тавигдаж байгаа шаардлага. Харамсалтай нь бид нар энд хүндэтгэлгүй хандсан, хийх ёстой зүйлээ

хийгээгүйгээс болж энэ төсөл удааширч байгаа нь үнэн.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байгаль орчин, аялал жуулчлалын яам нэг юм хариулна. Би энэ эрчим хүчтэй холбоотой нэг асуулт асуугаадахъя. Бас нэгтээ Тавинбэх сайд байгаа дээр. Идэшийн Батхүү Төрийн нарийн бичгийн дарга аа, 2014 оны улсын хөгжлийн төлөвлөгөөнд Монгол Улс байна шүү дээ. Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ гээд заачихсан. Ингээд Монгол Улсын Засгийн газар шийдвэр гаргаад, Байдрагийн УЦС-ын ТЭЗҮ-ийг улсын төсвийн хөрөнгөөр ТЭЗҮ-г нь хийчихсэн. Тэгээд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлээд, Засгийн газрын хуралдаанаас Унгарын талд тавиад, Унгарын талаас хүүгүй зээлээр энэ Байдрагийн УЦС-ыг барьж өгөх ингээд тохиролцчихсон. Хүүгүй зээлээр. Тийм ээ. Тэгээд энэ бол Засгийн газрын хуралдаан, Ерөнхий сайдын гаргасан шийдвэр. Та яагаад Ерөнхий сайд, Засгийн газрын гаргасан шийдвэрийн эсрэг энийг дэмжихгүй, энэ хэлэлцээр явуулахыг дэмжихгүй гэж бичиг явуулаад гацаагаад байгаа юм бэ. Та Ерөнхий сайд Засгийн газрын хуралдаанаас илүү эрхтэй болчихсон юм уу. 5 номер. Наад асуултдаа та хариулаадах даа. Тэгээд 2025 оны жилийн төлөвлөгөөнд ч оруулдаггүй. Ямар санаа байдаг юм. Монгол Улсын эрчим хүч ямар хүнд байдалд орчхоод байгааг бид нар өнөөдөр яриад байна шүү дээ. Тэгээд хүүгүй зээлээр ингээд УЦС хямд хүүтэй эх үүсвэрээр барьж байгуулж өгье гэхээр энийг яагаад та ингэж эсэргүүцэж дэмждэг юм. Монгол Улсын эсрэг ийм бодлого явуулж байгаа юм. Дэмжихгүй гэж яагаад ийм санал өгч байгаа юм. Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Ер нь ямар нэгэн зүйлийг бол Эдийн засаг, хөгжлийн яам эсэргүүцсэн барьсан зүйл бол байхгүй



гэдгийг юуны өмнө эхлээд хэлчихье. Ер нь бид нар жоохон бодлогынхоо юман дээр жоохон тооцоотой, судалгаатай дотроо яриад ингэж байгаад хийхгүй бол нэг унтаад л сэргэхэд нэг юм ороод ирээд байхаар чинь аягүй төвөгтэй шүү дээ. Ядахдаа тэрүүн дээрээ ТЭЗҮ хийчихсэн. Ямар тооцоо гарах юм. Үр ашиг нь ямар байх юм. Ийм зүйлийгээ хийхээд, дараа нь зээлийн юмаа ярихгүй бол ийм мэдээлэлгүйгээр гэв гэнэт энд тэндээс зээлийн юмнууд орж ирэхээр чинь төвөгтэй байгаа шүү дээ. Тэгэхээр уг нь энийгээ өгөөд, бас судалж үзээд, тэгээд түүнийхээ үндсэн дээрээ энэ асуудлуудыг оруулбал зөв гэдэг л ийм байр суурийг бол Эдийн засаг, хөгжлийн яам бол байнга барьж байгаа. Аль ч улсаас, ямар ч тохиолдолд зээл авахдаа бид нар ингэж хандаж явахгүй бол болохгүй байгаа л гэдгийг би хэлэх гэж байгаа юм. Түүнээс биш ямар нэгэн зүйлийг эсэргүүцэж барьсан юм байхгүй. Уг нь жилийн төлөвлөгөөндөө суулгаад, судалгаагаа хийгээд, тэгээд тэр нь энэ бол үнэхээр зөв байна. Монгол Улсынхаа эдийн засагтаа хэрэгтэй юм гэдэг ийм зүйлийг дэмжиж явахгүй бол болохгүй шүү л гэдгийг би дахин хэлмээр байна. Ийм л учиртай юм. Өөр янз бүрийн санаа оноо байхгүй ээ.

**Г.Занданишатар:** 2021 оны улсын төсөвт суугаад ТЭЗҮ-ийнх нь төсөв суугаад, ТЭЗҮ нь хийгдээд, үр ашигтай гэсэн тооцоо судалгаа нь батлагдаад, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдээд, Засгийн газрын хуралдаанаар Унгарын талд Гадаад харилцааны яам, Сангийн яамнаас тавиад 2 талд дэмжээд, ингээд энэ чинь бүр социализмын үед Тайширын УЦС, Байдрагийн УЦС 2 ТЭЗҮ урьдчилсан ТЭЗҮ хийгдээд, үр ашигтай гэж тооцоо гараад Тайширынх нь баригдчихсан. Одоо энэ нь үргэлжлээд явъя гэж бараг 20 жил ярьсан л асуудал байгаа юм. Одоо Даваасүрэн сайд хариултдаа та. Урьдчилсан ТЭЗҮ-г Цэрэнпилийн Даваасүрэн сайдын үед шийдэгдсэн тийм ээ. Үр ашигтай гээд тооцоог нь хийгээд

2020 оны Засгийн газрын үед шийдвэр нь гарчихсан асуудал.

Батлут гишүүний 2 асуултад, дараа нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Цогтгэрэл ирчихсэн байна. Хариулна шүү. Эрүүл мэндийн яамнаас хэн байна. Чинзориг сайд. Пүрэвдорж суудалдаа суу. Наана чинь Чинзориг сайд асуултад хариулах гэж байна. Та таглаад зогсоод байна. Батлут гишүүний асуултад хариул. Чинзориг сайд битгий маазраад байгаарай. Хүмүүсийн асуулт сонсооч. Пүрэвдорж та 2 дандаа ингэж хурал үймүүлж байна. Тэр эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилт хөдөө орон нутагт хэрэгжихгүй байна. Эрдэнэт хотод хэрэгжихгүй байна. Сумдад. Гүйцэтгэлийн санхүүжилт чинь тэгэхдээ сумдад хүндрэлтэй байгаа шүү дээ. Төв суурин газартаа. Батлут гишүүн тодруулж асууя. 1 минут.

**Д.Батлут:** Сая сайд сонсоогүй байх л даа. Гаднаас орж ирсэн үү, үгүй юу. Би сая иргэдтэй уулзаж явсан. Сумдын эмнэлгийн эмч нар асуудал тавьж байгаа. 2021 онд эрүүл мэндийн салбарынхан ажил хаялт хийгээд, эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсэг гарч, тэгээд тэр сумдын эмнэлгийн 4 төрлийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлийн санхүүжилтэд оруулсан. Үүний үр дүн бол гарсан байна. Тэгэхдээ ажилтан, албан хаагчдынхаа цалинг нэмэгдүүлэх, ур чадварыг нь нэмэгдүүлэх асуудлыг нь ур чадварын нэмэгдэл өгөх асуудал нь шийдэгдэхгүй байгаад байгаа юм. Тэр аудитынхаа акт тавьдаг. Цалингаа нэмэгдүүлэхээр, ур чадварын нэмэгдэл олгохоор. Сангийн яам. Эрүүл мэндийн яам тодорхой зохицуулалтын журмыг нь гаргаж өгөхгүй байгаа гэсэн асуудал яригдаж байгаа юм. Энийг яаж шийдэх юм бэ. Хүний хөгжилтэй холбоотой асуудлыг бид нар чухалчилж үзээд тавиад байдаг. Тэгэхдээ 1 талдаа нийгмийн эрүүл мэнд хөрөнгө оруулалтын асуудлаа шийдчихээд, нөгөө талдаа

эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа хүмүүсийнхээ асуудлыг шийдэхгүй байгаа чинь учир дутагдалтай байна л гэж.

**Г.Занданишатар:** Содномын Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** Батлут гишүүний асуултад хариулъя. Яах вэ манай дээр Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийн аргаар санхүүждэг болоод бол 3 жил болж байна. Гэхдээ энд бол бас үр дүнтэй ч юм бол байна, бас болохгүй ч байгаа юмнууд бол байгаа. Бид нар бол олон янзын тохируулга хийж үзэж байна. Өнгөрсөн жил бид нар газар зүйн коэффициент гэж хийж өгсөн. Энэ жил бүсийн коэффициент гэж цоо шинэ зохицуулалт бол хийж өгсөн. 1 иргэнээр тооцох санхүүжилтийг авдаг учраас хүн ам цөөтэй сумуудад бол бас жаахан хүнд байгаа нь бас үнэн Батлут гишүүн ээ. Тийм учраас бол бид нар энэ жил энэ бүсийн коэффициент хийж өгч, хүн ам цөөтэй, төвөөсөө бас алслагдсан ийм газруудад бол коэффициент бол хийж өгч байгаа.

2 дахь асуудал дээр энэ тогтолцооны бас өөрчлөлт хиймээр юм байна лээ. Бүх нэгдсэн эмнэлгүүд, төрөлжсөн эмнэлгүүдээ бид нар лавлагаа шатны эмнэлэг болгочихсон. Бүгдээрэнд нь нэг ижил размын малгай өмсгөчихсөн гээд л би тэгээд байгаа юм. Нэг хэсэгт нь энэ малгай нь томдоод байдаг, нэг хэсэгт нь багадаад байгаа юмнууд бол байгаа. Бүгдийг нь лавлагаа шатны эмнэлэг болгочихлоор бас үйлчилгээний асар их давхцал бий болчихсон асуудлууд бол байна. Тийм учраас өнгөрсөн жил бид нар зохицуулалт хийгээд орон нутгийн нэгдсэн эмнэлгүүд өөрсдийнхөө хийж чаддаг тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа бол өндөр тарифаар, орон нутгийн нэгдсэн эмнэлгүүдийн хийж чаддаг үйлчилгээг төрөлжсөн эмнэлгүүд хийж байгаа бол тэдэнд олгож байгаа тарифыг нь арай багасгаж, бага тарифаар өгч бас нэлээн тийм тохируулга бол хийж байгаа. Одоо манай

дээр таны яриад байгаа үнэн. Тэр ур чадварын нэмэгдэл гээд нэг журам гаргаж өгөх ёстой гээд. Одоо бол ур чадварын нэмэгдэл гэж энэ журам цэцгэлж өгөхгүй бол эмнэлэг болгон өөрсдөө зарим нь төрөлжсөн эмнэлгүүнд нь үнэ цэний урамшуулал, нэмэгдэл, зарим нь бүр хариуцлагын нэмэгдэл эд нар гээд олон янзын нэмэгдлүүдийг эмнэлгүүд өөрсдөө бас ингээд өгч байгаа. Энэ дээр нь бол бас тэр Аудит бас акт тавьдаг юм бий. Тэгээд Сангийн яамтай бид ярьж байгаад ур чадварын нэмэгдлийн журам Сангийн сайдтай хамтарч батлахаар ажиллаж байгаа. Удахгүй энийг нь одоо бас батлаад өгнө.

2 дугаарт тэр урамшууллын асуудлыг ч гэсэн бас нэгдсэн байдлаар бас бид нар журамлаж өгье гэж байгаа. Урамшууллын асуудлыг ч гэсэн бас журамлаж өгөхгүй бол өөр өөрсдөө эмнэлгүүд урамшуулал бас бий болгочихсон олон янзын ийм асуудлууд байгаа. Энэ урамшууллын журам, ур чадварын нэмэгдлийн журам гэсэн ийм 2 асуудлыг бид нар ойрын хугацаанд шийдэж өгнө.

**Г.Занданишатар:** Тэгээд төлөвлөгөө хэлэлцэх үедээ Байнгын хороод дээр бас хэлэлцэнэ шүү дээ. Энийгээ яриарай. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Цогтгэрэл. 4 номер. Нанзадын Наранбаатар гишүүний асуультыг ойлгочихсон. Хариултаа бэлдчихсэн байгаа тээ. Тэрийг хариул. Болдын Жавхлан Сангийн сайд нэмж хариулна. Болдын Жавхлан сайд карт чинь уншигдаагүй байна.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Батлут гишүүний асуултад зүгээр нэмж мэдээлэл өгье. Чинзориг сайд ер нь бараг хэлчихлээ. Зүгээр энэ дээр ганц яг Эрүүл мэндийн даатгалын сангийн асуудал биш болчихоод байгаа юм. Уг нь энэ гүйцэтгэлээр нь санхүүжүүлээд тарифаар нь ингээд санхүүжүүлээд явуулчихдаг. Тэгээд очсон хойноо энэ аудитынхантай учраа олох асуудал болчихоод байгаа байхгүй юу. Та бол яг

ингээж хэлээд байгаа байхгүй юу. Яг ингээд нөгөө урд талын тогтоочихсон байгаа цалин юмнуудаар нь өгчхөөд, цаана нь юм үлдээд байгаа, хэмнэгдээд байгаа. Тэрийг нь ингээд татаж авч явчхаад, тэрийг нь уг нь нийгмийн асуудлыг нь шийдээд нэмэлтээр цалин дээр нь урамшуулал болгоод тавьчихъя гэхээр ингээд боломж олгохгүй хураагаад аваад явчхаж байна гээд. Энийг ингээд хөдөө орон нутгаар явахаар анхан шатан дээрээ энийг яриад байгаа байхгүй юу. Акт тавьчхаад наадах чинь болохгүй ээ. Энийг нэмж өгч болохгүй, буцааж авна гээд ингэжхээд байгаа байхгүй юу. Тэгээд одоо энэ гүйцэтгэлээр явж байгаа бүх байгууллагууд дээр ингээд байгаа юм. Сумын сургууль, эрүүл мэндийн төв. Бүгд дээр нь адилхан. Өрхийн эмнэлэг дээр адилхан ингээд байгаа байхгүй юу. Одоо ингээд бүх асуудлуудаа тавьж байгаад одоо яг аудитынхантай бид нар хэлэлцээр хийж байгаа. Салбар салбар дээр нь өнгөрсөн оных нь аудитууд хийгдээд, энэ 7 хоногт дуусаад, тэгээд дараа 7 хоногт бид нар нэг хэлэлцээр хийх гээд ингээд бэлдээд байгаа юм. Тэр дээр гүйцэтгэлээр санхүүжүүлж байгаа тарифаар нь оччихсон санхүүжилтийг 1 төгрөг ч битгий буцааж ав. Бүгдийг нь тэнд нь үлд ээ. Төсвийн шууд захирагч цэцэрлэгийн багш байна уу, одоо Эрүүл мэндийн төвийн дарга байна уу, хэн нь байна, тэр нь мэдээд хэдийг яаж манаачдаа хувааж өгөх вэ, хэдийг нь яаж сувилагчид нь хувааж өгөх вэ гэдгээ тэд нар өөрсдөө тэндээ шийддэг болохоор. Ер нь анхнаасаа Засгийн газрын энэ гүйцэтгэлээр санхүүжүүлэх энэ реформ маань өөрөө яг энэ рүү л чиглэж байсан. Тэгэхээр тэрийг дундаас нь сугалж аваад ингээд буцааж ерөөсөө болохгүй. Тэгэхээр Засгийн газар бол тэр дээрээ хатуу байгаа. Аудитынхантайгаа учраа олох юм байна. Аудитынхан ч бас өөрсдөө хуулиа бариад бас ингээд тайлбар тавиад байгаа. Тэгэхдээ энэ дээр хэлэлцээр хийгээд учраа ололчих байх. Тэгээд 1 мөр болчих байх гэж бодож байна. Тэрнээс биш санхүүжилт дээр бол учир явдал бол ерөнхийдөө

багассан шүү. Тэндээс бол болохгүй юм бол багассан. Өнгөрсөн жил манай 2 нэлээн тохируулга хийсэн. Яг анхан шатны лавлагаа эмчилгээний шатны эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүд дээр суурь зардлуудыг нь бол сайн нэмээд өгчихсөн. Тийм учраас тэр зарим газар нь малгай нь томдоод байна гээд байгаа юм. Зарим газар нь хэмнэлт үүсээд байгаа байхгүй юу. Тэгэхдээ ер нь ихэнх дээр нь. Тэр хэмнэлтийг нь үлдээ л гэж байгаа юм.

**Г.Занданшатар:** Одоо болно гэж байна. 4 номер. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Цогтгэрэл.

**С.Цогтгэрэл:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Хөх морь төслийн хувьд бол энэ усны нөөцийн хуримтлалыг хуримтлуулж, усан хангамжийн эх үүсвэрийг бүрдүүлэх тухай энэ бүлэг 33 орчим төслийг хамардаг ийм төслийн нэришл байгаа. Тэгээд Хөх морь төсөл хэрэгжих ёстой юу гэвэл мэдээж хэрэгжих ёстой. Энэ бол говийн бүсэд хэрэгжиж байгаа томоохон төсөл хөтөлбөрүүд болон мөн тэр бүсэд амьдарч байгаа иргэдийг найдвартай усан хангамжийн эх үүсвэрээр хангахад чухал ач холбогдолтой ийм төсөл байгаа. Энэ төслийг хэрэгжүүлэхэд бол мэдээж санхүүгийн маш их эх үүсвэрүүд шаардлагатай байгаа.

Хамгийн ойрын хугацаанд хэрэгжих боломжтой Орхон Онги, Хэрлэн Тоонот 2 төслийн талаар бас тодруулж асуусан. 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд бол Онги Цагаан бургастайн төслийн асуудал тусгагдсан байгаа. Энэ төслийн ТЭЗҮ бол Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар “Гидро дизайн инноац” гэдэг компани бол хийсэн байгаа. 2025 онд бол Онги Цагаан бургастай төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ төсвийн талаар төслийг хийнэ. 3,9 тэрбум төгрөг шаардлагатай байгаа. Тус төслийн хүрээнд бол 663 сая м3 эзлэхүүнтэй ус хуримтлуулах 2 усан сан

барина. Орхон голоос Мандал-Овоо сумын Улаан нуур хүртэл 307км ус дамжуулах далд шугам хоолойг 5-8 жилийн хугацаанд барьж байгуулах ийм ажил байгаа. Тэгээд 874 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай гэж ингэж үзэж байгаа. Ер нь бол энэ Орхон Онги төслийг нийтэд нь хэрэгжүүлэхэд бол нийтдээ 1,1 их наяд орчим төгрөг шаардлагатай гэсэн ийм тооцоолол байгаа.

Хэрлэн тоонот төслийн хувьд бол Эрдэнэс Оюутолгой компанитай бид нар бас хамтарч ажиллаж байгаа. Эрдэнэс Оюутолгой компанид санал хүргүүлсний үндсэн дээр бол Хэрлэн тоонот төслийн ТЭЗҮ-ийг боловсруулахад шаардагдах төсвийн асуудлыг хөрөнгийн асуудлыг шийдсэн. Одоо тэгээд тендер шалгаруулалтын ажил явагдаж байгаа. Үнэлгээний хороо байгуулагдсан байгаа. Энэ ажлыг бас хийж хэрэгжүүлэхэд урьдчилсан байдлаар бол бас 1,6 их наяд орчим төгрөгийн төсөв шаардлагатай гэсэн ийм тооцоолол гарсан байдаг. Тэгээд төслийг хэрэгжүүлснээр 1,3 тэрбум м3 эзлэхүүн бүхий усан сан байгуулж, Цагаан суваргын зэс молибден, Оюутолгойн усны хэрэглээг хангах боломжтой гэж үздэг байгаа.

**Г.Занданишатар:** Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя.

**Н.Наранбаатар:** Тэгээд энэ 2025 оны төлөвлөгөө дээр чинь тийм үг үсгээрээ юм байхгүй байна шүү дээ. Суулгаж болохгүй байгаа юм уу. Орхон Онги, Хэрлэн Тоонт гэсэн үг, үсэг байхгүй байна лээ шүү дээ. Төлөвлөгөө дээр чинь. Яагаад суулгаж болохгүй байгаа юм.

**Г.Занданишатар:** 4 номер.

**С.Цогтгэрэл:** 2025 оны төлөвлөгөөнд бол Онги Цагаан бургастайн төслийн талаар бол тусгасан байгаа. 5.2.3.1-д. Хэрлэн тоонот төслийн тухайд бол ТЭЗҮ-ийг нь Оюутолгой компанитай хамтраад

хийхээр тэндээс санхүүжилтийн эх үүсвэр нь бүрэн шийдэгдэж байгаа. Тэгээд ТЭЗҮ гарсны дараагаар, төслийг хэрэгжүүлэх талаар дараа жилийн хөгжлийн төлөвлөгөөнүүдэд тусгаад явахаар ийм байгаа юм.

**Г.Занданишатар:** Сүхбаатарын Цогтгэрэл наад асуудлаа тодорхой, дэлгэрэнгүй бичгээр хариултыг Наранбаатар гишүүнд өгөөрэй.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтаа явуулах уу. Хэлэлцэх эсэх. Чинзориг гишүүний саналаар Байнгын хороо руу шилжүүлж болохгүй. Үг хэлэх гишүүн байхгүй учраас “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

17.50 цаг.

Чуулганы хуралдааныг сунгаж хуралдана. Бид нар чинь 7 хоног. Эм ярихгүй ээ. Эм дараагийн асуудал байгаа. Одоо Цэргийн 2 хууль байгаа.

**Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Индэрт урьж байна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Энэ Тамгын газар яагаад ингээд худлаа бичээд байна.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,



Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж, хуулийн төслүүдийг зүйл тус бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно. Байнгын хорооны хуралдаанаар дээрх төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан зарчмын зөрүүтэй 5 саналын томъёолол ирүүлсэн бөгөөд уг саналуудыг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт болон Байнгын хорооны

гишүүдийн дэмжсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгийг танилцуулж протоколд тэмдэглэе. Гүрсэдийн Сайханбаяр Батлан хамгаалахын сайд, Дагвадоржийн Ганхуяг Бацлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бригадын генерал, Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал, Чулуунборын Гандирваа Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал. Хурандаа Гомбосүрэнгийн Энхболд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 5 санал байгаа. Санал хураалтад бэлдье.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт



оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол 5 байна.

Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 7.1.22 дахь заалтын “урамшууллыг” гэсний өмнө “мөнгөн” гэж, 2 дахь заалт буюу 8.1.11 дэх заалтын “дарамт шахалт” гэсний дараа “үзүүлэх” гэж тус тус нэмж, мөн заалтын “гадуурхалтаас ангид байх” гэснийг “гадуурхах” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт явуулна. Жавхлан сайд суугаарай. Сайд нараа дуудаарай. Өөрсдийнхөө асуудлыг хэлэлцчихээр тэгээд гараад явцгаачих юм. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Энэ саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Мөнхбаатар дарга, Тогтохсүрэн дарга ирцээ анхаараарай. Бүртгэлийн санал хураалт. Чинзориг сайд эсрэг дарах юм бол дараа нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг унагаана. Тэгээд санал хураалт явуулчихъя. Сая бүртгэлийн санал хураалт явуулсан. Байнгын хорооны саналын томъёолол би уншиж танилцуулчихсан байгаа. Аюулгүй байдал гадаад болон байнгын хорооны дэмжсэн 1 дэх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “нисэх бүрэлдэхүүн,” гэсний дараа “алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар,” гэж нэмсүгэй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Алдагдсанд тооцогдсон

цэргийн анги салбар гэх юм уу. Энэ найруулга нь алслагдсанд тооцогдсон гэж унших нь байна шүү. Энэ чинь ингээд буруу биччихсэн байна шүү. Тийм зүгээр л тооцогдоод байх байсан юм. Алслагдсан цэргийн анги салбар л гэхих. Найруулга дээр алслагдсан цэргийн анги салбар гээд. Үгүй ээ, үгүй та тооцогдсон гэж нэмчхээд байна. Түүнийгээ эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.3 дахь заалтын “...хилийн отряд, застав болон...” гэснийг “алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар болон хилийн цэргийн анги,” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Цэдэвийн Сэргэлэн генерал хаачив.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ

5.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

*Дараагийн асуудалд орно.*

**Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлын 2024 оны 5 сарын 02-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж, хуулийн төслүүдийг зүйл тус бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан хууль санаачлагчаас төслийн талаар асуулт асууж, хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангаас зарчмын зөрүүтэй 12 санал, найруулгын 2 саналын томъёоллын бичгээр ирүүлсэн бөгөөд саналыг тус бүрээр хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт болон Байнгын хорооны гишүүдийн дэмжсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданишатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 26 санал байгаа. Гишүүд суудалдаа сууя.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

**Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн санал**

1. Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3. “цэргийн болон цагдаагийн баг” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон бүтэц, орон тооны дагуу бие бүрэлдэхүүн болон зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгслээр хангагдсан, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нэгжийг;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Протоколд тэмдэглүүлэх ажлын хэсэг өмнөх хуулийн төслийн ажлын хэсэг дээр нэмэх нь Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Лхамдоржийн Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Гадаад харилцаа энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Байгалийн Эрдэнэдалай.

Чинзориг сайд битгий үймүүлээд бай. Ингээд санал хураалт явуулахаар. Санал хураалт. 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “тохиролцсоны дагуу” гэснийг “тохиролцож, саналыг бичгээр авсаны дагуу” гэж өөрчилж, төслийн “4.5.Энэ хуулийн 4.4-т заасан тохиолдолд эрх

бүхий албан тушаалтан тухайн цэргийн алба хаагчид мэдэгдэж, саналыг бичгээр авна.” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “бусад” гэснийг хасаж, 5.3.5 дахь заалтын “хууль тогтоомж, зан заншлыг хүндэтгэн дагаж мөрдөх” гэснийг “хууль тогтоомжийг мөрдөх, зан заншил” гэж, 5.3.6 дахь заалтын “үүрэг гүйцэтгэлтийн онцлогт нийцсэн” гэснийг “үүрэг гүйцэтгэх үеийн” гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “төсөвт тусган, цэрэг, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах” гэснийг “төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “Монгол Улсаас оролцох боломжтой энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэл, тусламж, дэмжлэгийн” гэснийг, мөн 8.1.2 дахь заалтын “Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаа, энэ талаархи сургалт, бэлтгэлд оролцуулах болон хангалт, үйлчилгээтэй холбогдсон” гэснийг тус тус “энхийг дэмжих ажиллагаатай холбоотой” гэж өөрчилж, 8.1.3 дахь заалтын “энхийг дэмжих” гэсний өмнө “гадаад улсад” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. Яагаад ингээд санал хураалт явуулдаггүй юм. 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “эгүүлэн татах” гэснийг “эгүүлэн татах ажлыг зохион байгуулах” гэж, 10.1.6 дахь заалтын “оролцуулах цагдаагийн баг, бие бүрэлдэхүүнийг” гэснийг “оролцох цагдаагийн алба хаагч, багийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн байгуулагдсан олон үндэстний цэргийн хүчний командлал” гэснийг “томилогдсон олон үндэстний цэргийн хүчний командлагч” гэж өөрчилж, 14.8 дахь хэсгийн “аливаа улстай байгуулсан” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 17 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.1.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагч, багийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан . 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэн тэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

### Найруулгын санал.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “хаагчийг” гэснийг “хаагчдыг” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “цэрэг, цагдаагийн” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч,” гэж, 5.5 дахь хэсгийн “алба хаагч болон цэрэг, цагдаагийн баг” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч, баг” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “амь насаа алдсан” гэснийг “нас барсан” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “алба хаагч, цэргийн” гэснийг “цэргийн алба хаагч,” гэж, 9.1.5 дахь заалтын “байдлыг” гэснийг “талаар” гэж, 9.1.11 дэх заалтын, мөн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтын “бие бүрэлдэхүүний” гэснийг “алба хаагчийн” гэж тус тус, 9.1.6, 9.1.9 дэх заалтын, 10.1.4 дэх заалтын “7.1.7-д” гэснийг “7.1.6-д” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Батлан хамгаалахын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын” гэснийг “батлан хамгаалахын болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэж тус тус өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын, мөн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “эсхүл” гэснийг хасах.

2.Төслийн “цэрэг, цагдаагийн алба хаагч” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч” гэж, “цэрэг, цагдаагийн баг” гэснийг “цэргийн болон цагдаагийн баг” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. Болоогүй ээ, Пүрэвдорж гишүүн ээ. Дуусаагүй байна. 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхдээ энэ хүний юм хийж өгч байгаа кноподсон юм шиг ярьдаг л их буруу ойлголт юм байгаа юм шүү дээ. Ард түмний тодорхой хэсэгт асуудал шийдэж Улсын Их Хурлын гишүүний үүргээ биелүүлж байгаа хууль, эрх зүйн орчин бүрдүүлж байгаа.



**Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.**

**Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн санал.**

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

**“1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.3.26 дахь заалт нэмсүгэй.**

**“5.3.26.Цагдаагийн хөгжлийн сан.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. суудалдаа сууя. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.**

**Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн санал

1.Төслийн 2 дугаар зүйлийн “эрүүл мэнд” гэснийг “чөлөөлөгдсөн” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

18.16 цаг

Одоо дараагийн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Улсын Их Хурлын гишүүд энэ хуулийн төслийг хэлэлцэхийн тулд Улсын Их Хурлын чуулганыг сунгаж хуралдах саналтай байна. 6 цаг болж чуулганы дэгийн хугацаа өнгөрсөн учраас олонхын саналаар дэмжинэ. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөх үү. Үргэлжлүүлж хэлэлцэх үү. Ингээд чуулганы хуралдааныг сунгаж хуралдахаар шийдэв үү.

**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Пүрэв-Очирын Анужин танилцуулна.

**П.Анужин:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн



хуралдаанаараа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж дараах санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1.Төслийн нэр томъёоны тодорхойлолт болон Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай зөвшөөрөлтэй холбогдсон зарим зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэн өөрчилж, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдолд хуульд заасан зохистой дадлын стандартыг үндэслэн сунгах зохицуулалтыг нэмэхээр,

2.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, эм хадгалалт, түгээлт, эмийн сан, лаборатори, эмийн жорын зохистой дадлын стандартыг Стандартчилал техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлахаар,

3.Эмийн зах зээлд гарах зөвшөөрлийг бүртгэл болгон өөрчилж, худалдах тусгай зөвшөөрөл эзэмшигч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээс бусад эмийг цахим жор болон захиалгын дагуу хүргүүлэхээр,

4.Үйлдвэрлэлийн зохистой дадлын стандартыг дотоодын уламжлалт эмийн үйлдвэр 2029 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр, мөн үйлдвэрлэх экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч, дотоодын үйлдвэрлэгч, биоэквалент судалгаа, өвчин, эмийн бүртгэл, бүртгэлгүй эм, өндөр, дунд эрсдэлтэй эмийн хэрэгслийг

улсын хилээр нэвтрүүлэх заалтыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх шилжилтийн үеийн зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгалаа.

Түүнчлэн ажлын хэсэг эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах түр хорооноос баталсан тогтоолын саналыг хуулийн төсөлд хэрхэн тусгагдсан талаар нэг бүрчлэн хэлэлцэж, хуулийн төсөлтэй нийцүүлсэн болно.

Ажлын хэсгээс Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 36 санал, найруулгын шинжтэй 1 санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 9 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн хуулийн төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан эмийн үнийн өсөлт шалтгаан нөхцөлийн талаарх Улсын Их Хурлын тогтоолд орсон эм болон хүнсний аюулгүй байдлыг хангасан, өртөг зардал багатай, эдийн засгийн үр өгөөжтэй үндэсний лавлагаа лабораторийн тогтолцоотой болоход анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл хуулийн төслийн 47 дугаар зүйлтэй холбогдуулан эм худалдан авах үйл явцад төр бүхэлд нь оролцох, хувийн хэвшилтэй өрсөлдөх нь зах зээлийн тогтолцооноос ухралт болох тул төр зах зээлийн эрэлт өрсөлдөөнийг бий болгож, чанартай, өргөн сонголттой эмийг иргэдэд хүргэхэд хяналтаа тавих талаар саналаа илэрхийллээ.

Мөн Их Хурлын гишүүн Чинбүрэнгээс хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан зах зээл дээрх

эмийн чанарыг санамсаргүй түүврийн аргаар шалгахтай холбогдуулан гарах санхүүжилтийг тодорхой болгох талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Оюунчимэг нараас хуулийн төслийн 47 дугаар зүйлтэй холбогдуулан эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, үнийн зохицуулалт, ханган нийлүүлэлттэй холбоотой зарчмын зөрүүтэй 2 санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй. Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа, Ганхуяг нараас хуулийн төслийн 41 дүгээр зүйлтэй холбогдуулан шинээр зөвшөөрөл олгохоор зохицуулалт тул 41.1.1 дэх заалтыг хасах талаар зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх мөн дэмжээгүй болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн

хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Ажлын хэсгийн гишүүдийг анилуулъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Пүрэвийн Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Намдагийн Гэрэлт-Од, Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Ганхуягийн Түвшинбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Дүгэрсүрэнгийн Баясгалан, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Шаравнямбуугийн Энхтуяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Лиценз зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Ламжавын Зэндмаа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Даваасүрэнгийн Оюун-Эрдэнэ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Тогтохын Мөнхтуул, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Рэнцэнгийн Энхсүрэн, Төрийн худалдан

авах ажиллагааны газрын дарга Цэдэнбалын Батзул, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн эм, био бэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч Максимын Пүрэвсүрэн, Эрүүл мэнд реформ ТББ-ын гишүүн Маашбаатарын Халиунаа, Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн эм холбооны гүйцэтгэх захирал Иваны Балжинням, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн Мятавын Бат-Эрдэнэ.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 51 санал байгаа. Чинзориг сайд ирцээ бүрдүүл. Тэр хооронд энэ хэн хариулах юм нэг асуулт байна.

Уг нь бол эм эмнэлгийн хэрэгсэлтэйгээ хамт биш энэ хүнстэйгээ хамт олон улсын стандарт бол хүний хоолойгоор давж байгаа л зүйл болохоор эм хүнсний хяналт хамт явдаг. Тэгвэл лаборатори нь ч гэсэн одоо нэгдсэн арай л зардал чирэгдэл, үйл ажиллагаа, ачааллын хувьд ч гэсэн үр ашигтай ажиллах бололцоотой food and drug administration гэж байгаа шүү дээ. Одоо энэ хоол хүнс чинь мэргэжлийн хяналт байхгүй болсноос хойш ямар мах идэж байгаа юм. Эбомек тариад сарын дараа мал уг нь төхөөрөх ёстой. Тэгтэл одоо тэгээд л тарган гэх мэтчилэн энэ хүнсний хяналт, эмийн хяналт 2-ын бодлого алдагдаад байгаа чинь нэгдсэн ийм хяналтаар лаборатори ч гэсэн илүү үр ашигтай ажиллана шүү дээ. Тиймээс эмнэлгийн хэрэгсэл бол мэдээж хоолойгоор давахгүй боловч тусдаа стандартаар хянан шалгаад байж болно. Лабораторийн нарийн шинжилгээнүүдээс нэг их шаардахгүй. Ийм учраас бол тийм стандарт руугаа явах ёстой юм биш үү. Тийм тогтолцоогоо хийхгүй бол тэгээд л энэ лиценз, тусгай зөвшөөрөл гээд л дэлхийд бүртгэгдсэн эмийг баахан хээл хахууль авлига л юм байна гээд. Эмийн хяналтын сонсголоор Чинбүрэн гишүүн бол 67 хувь нь холбогдолтой байна гээ биз дээ тээ. Энийг хэн хариулах вэ. Сайд л хариулна

даа. Чинзориг сайд. Оюунцэцэг хариулна. Пүрэвийн Оюунцэцэг. Энэ Шаравнямын Энхтуяа хариулсан нь зөв юм байна. 5 номер.

**Ш.Энхтуяа:** Занданшатар даргын асуултад хариулъя. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Энхтуяа байна. Тэгэхээр эмнэлгийн хэрэгслийн тухайд бол хуучин яг манай хууль дээр эмнэлгийн хэрэгсэл гэж байгаа ч гэсэн яг эмнэлгийн жижиг хэрэгслүүд хуулиараа голцуу зохицуулагдаад явдаг байсан. Ер нь бол олон улсад бол эмнэлгийн хэрэгсэл гэдэг дотроо медикал девайс буюу эмнэлгийн жижиг хэрэгслээс эхлээд тоног төхөөрөмж хүртлээ орж байгаа. Тэгээд тэр агуулгаараа эмнэлгийн хэрэгслийг бол тодорхой хяналттай, зохицуулалттай байлгах нь зүйтэй гэдэг агуулгаар энэ хуульдаа оруулж ирж байгаа.

Хүнсний тухайд бол Хүнсний тухай хуулиараа бас давхар явж байгаа. Саяын даргын хэлж байгаагаар бол Эм, хүнсний агентлаг гээд тийм чиг үүрэг ярьж байх шиг байна. Тэгэхээр Монгол Улсад бол эмийн зохицуулалтын байгууллага байгуулсан шийдвэр бол яг зөвхөн эмээрээ бол одоо явж байгаа. Яг хүнс нь бол бас тусдаа Хүнсний хуулиар зохицуулагдаж байгаа болохоор энэ 2 хуулиараа бас давхар хянагдаад явж байгаа гэсэн үг.

**Г.Занданшатар:** Хүнс чинь өөрөө эм болчихсон шүү дээ одоо орчин үед. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

**Ж.Чинбүрэн:** Занданшатар даргын энэ яг онилж хэлж байгаа зүйл бол энэ хамгийн чухал сэдвийг бид хөндөж байна. Яагаад гэхээр бид зах зээл дээр байгаа эмээ хянах тогтолцоо чанартай эм байлгах хамгийн үндсэн том түлхүүр. Тэгэхээр энэ лабораториуд нь тусдаа ХАБУЛ гээд хүнсний аюулгүй байдлыг шинжилдэг лаборатори тусдаа, эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг шинжилдэг лавлагаа лаборатори тусдаа. Энэ 2

тусдаа нэг байр дотор байгаа. Түр хорооны шалгалтаар нэг илэрсэн зүйл бол бүр байр сав нь хүртэл ХАБУЛ нь эмийн лабораториосоо түрээсийн мөнгө нэхээд өрөөг суллаж өг энэ тэр гээд хоорондоо уялдахгүй байгаа.

Монгол Улс шиг хүний нөөц, техник, тоног төхөөрөмж ийм хязгаарлагдмал улсад бол аль болох нэгдсэн удирдлагатай байж, мэргэжилтнүүд нь дотроо хамт ажилладаг, тус тусдаа эм реактивын шинжилдэг бодисуудаа тусдаа тендер зарж авдаг байх нь дэндүү үрэлгэн тогтолцоо. Өнөөдөр шинжлэх ухааны хурал, чуулган доор боллоо. Монгол Улсын Ерөнхийлөгчийн. Тэнд илтгэл дотор Боловсролын сайдын илтгэл дотор Монгол Улсад 305 лабораториуд ажиллаж байгаа. 305. Лаборатори болгон л үнэтэй багаж авъя гэж хүсэлт тавьдаг. Тэгтэл дундаа хэрэглэж болох зүйлээ хамтраад хэрэглэж чадахгүй байгаа нь өөрөө хүний нөөцийн хомсдол, үрэлгэн тогтолцоо, тэгээд систем өөрөө ажиллахгүй байх ийм буруу зүйл байгаад байгаа юм. Тийм учраас Байнгын хороо дээр би бол зориуд протоколд тэмдэглүүлсэн. 19 дүгээр зүйл дээр хүнс, эм 2-оо цуг оруулах ийм саналтай би байсан. Тэгээд энэ бол орсонгүй. Гэхдээ ажлын дэд хэсэгт ажиллаж байгаа Эрүүл мэндийн яамны түшмэлүүдийн хэлснээр бол бид тэртээ тэргүй Засгийн газар, Их Хурлаас тогтоол гаргаад өгчихсөн учраас Засгийн газрын тогтоолоороо нэгдсэн лаборатори болгоод явчихъя гэсэн ийм тайлбар хэлсэн учраас би зарчмын зөрүүтэй саналаа татаж авсан.

Ер нь бол Занданишатар дарга таны хэлж байгаа яг зөв. Энэ хүнс яагаад гэвэл шинжилж байгаа аргууд нь адилхан байхгүй юу. Нэг их зөрөөд өөрчлөлттэй тийм зөрүүтэй зүйл биш. Тийм учраас энэ дээр бас бид онцгой анхаарч энэ тал дээр бас бодох ёстой.

**Г.Занданишатар:** Санал хураалт явуулъя. Санал хураалт явуулахын өмнө

бас өнгөрсөн 7 хоногт төрсөн өдөр нь тохиосон 5 дугаар сарын 10-нд төрсөн Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржид төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлъя. Пүрэвдорж айлын 4 дэх хүү болж, Доржсүрэнгийн Бөхчулуун, Батын Сүрэнхүү нарын 4 дэх хүү болж эхээс мэндэлжээ. Пүрэвдорж гишүүн ээ, тэгээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүл Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Ер нь энийг сая Чинбүрэн гишүүн ч гэсэн хэлж байгаа. Энэ эм, хоол хүнсний хяналт бол өдөр тутмын хяналт байхгүй юу. Эмнэлгийн хэрэгслийн хяналт бол импортын үед нь, үйл ажиллагааных нь үед нь өдөр тутмын биш хяналт. Тийм учраас яг үйл ажиллагааны хувьд нэг ийм импортын хяналт зөвшөөрөл лиценз өгдөг л байгууллага болчих юм бол энэ хүний эрүүл мэндийг хангах, эдгээх энэ үндсэн эрхэм зорилготойгоо л нийцэхгүй болчих вий л гэж байгаа юм.

### **Нийгмийн бодлогын байнгын хорооноос дэмжсэн санал**

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10.г дэд заалтыг, мөн зүйлийн 4.1.18 дахь заалтын “, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн” гэснийг хасаж, 4.1.27 дахь заалтын “иргэн,” гэсний дараа “гадаад, дотоодын” гэж нэмж, мөн зүйлийн 4.1.14 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэл” гэж, 4.1.17 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэлтэй” гэж, 4.1.32 дахь заалтын “, бэлтгэх арга, зааврыг тодорхойлон” гэснийг “хэрэглэх аргыг заан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужин, Бадарчийн Жаргалмаа, Мөнхөөгийн Оюунчимэг,



Даваажсанцангийн Сарангэрэл, Жигжидсүрэнгийн Чинбүрэн /цаашид “ажлын хэсэг” гэнэ/. Санал хураалт. Санал хэн гаргах билээ. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Саяын заалтыг дэмжиж санал өгсөн боловч сөрөг, эсрэг гарчихлаа. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

**Г.Занданишатар:** Идэрбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Карт уншигдаагүй байна. Яагаад алга болчхов. Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

**Ш.Адьшаа:** Саяын санал хураалт дээр дэмжсэн санал өгсөн. Энэ төхөөрөмж ажиллахгүй эсрэгээрээ гараад байх юм. Дахиж санал хураалт явуулж өгөх үү.

**Г.Занданишатар:** Төхөөрөмж бол ажиллагаа нь ажиллаж байгаа. Энэ уншигдахгүй бол байж магадгүй. Ширнэнбандийн Адьшаа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Тогтохоо дарга аа, санал хураалт. 57,5 хувийн саналаар өмнөх санал хураалт хүчингүйд тооцогдлоо. Тэгэхээр санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас Байнгын хорооны саналын томъёоллыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.2 дахь хэсгийг хасах:

“6.1.1.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл;

6.1.2.эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 22 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ ингээд л мансууруулах эм, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, бүгд нэг саванд л ингээд бүгд орчхож байгаа юм уу. Асуулт асуухгүй л дээ. Дэмжсэн, дэмжээгүй үг л хэлж болно. Түүрүүн бол нэлээн үг хэлчихсэн юм. Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлнэ. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн үг хэлнэ. Та хоёроор тасаллаа. Энэ яг ингээд үзэл баримтлал нь сонин болчихоод байгаа юм.

**Х.Ганхуяг:** Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дээр энгийн болон тусгай зөвшөөрлүүд байдаг. Тэгээд яг энэ агуулгыг нь харах юм бол энэ зөвшөөрлийн тоо нэмэгдэхээр ороод ирчихсэн байна. Тэгсэн мөртөө ард тал дээрээ зөвшөөрлийн хууль дээрээ хөндөлт хийгээгүй. Тэгээд энэ юу гэсэн үг вэ гэхээр зэрэг өөрийнхөө салбарын хуулиа баримтлаад баахан зөвшөөрлийн тоо л нэмэгдэхээр харагдаад байна. Тэгэхээр энэ гүйцээн боловсруулах чиглэл өгөөд дарга аа, энэ зөвшөөрлийн хуультай нийцүүлэхгүй бол таслал болгоноор энэ чинь 1 зөвшөөрөл нэмэгдээд байгаа байхгүй юу. Эм гэдэг дээр тусгай зөвшөөрөл, үйлдвэрлэх, экспортлох, уламжлалт эм гээд тусдаа, био бэлдмэл гээд тусдаа, тэдгээрийн түүхий эд гээд тусдаа, мансууруулах эм гээд тусдаа, сэтгэцэд нөлөөтийн эм гээд тусдаа, эмнэлгийн тоног төхөөрөмж гэж тусдаа, лабораторийн оношилгооны хэрэгсэл гээд тусдаа, эмнэлгийн хэрэглэгдэхүүн гээд дахиад тусдаа зөвшөөрөл байгаа байхгүй юу. Энэ чинь. Яг энэ заалтаараа 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10 зөвшөөрөл дарга аа задалж байна. Зөвшөөрлийн хуулиар зөвшөөрлийг задлахыг нь хориглочихсон байгаа дарга аа. Энэ тэгэхээр ерөөсөө нөгөө өмнөх



хийсэн юмаа дандаа ингэж баллуурдаг, балладаг, яг одоо эдний энэ зөвшөөрлийн хэлтсийнх нь бол дандаа ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс байдаг. Ингээд л зөвшөөрлөө задлаад ороод ирж байгаа байхгүй юу. Энэ чинь тэгээд л энэ болгон дээр хүнд суртал, тэгээд л авлига.

**Г.Занданишатар:** Яг зөв. 17, 18 тусгай зөвшөөрөл ингээд л шууд нэмчихлээ. Зөвшөөрлийн тухай хуулиар салбар хуулиудаар зөвшөөрлийг нэмэхгүй гээд заачихсан юм. Зөвхөн Зөвшөөрлийн хуулиар зохицуулна. Энэ хууль зүйн техникийн хувьд ч гэсэн зөрчилтэй болчихлоо. Энэ хэрэгжихгүй л дээ. Тэгээд энэ тусгай зөвшөөрөл болгоны цаана л маш их хүнд суртал, авлига, хээл хахууль асуудал байгааг эмийн сонсголын үеэр одоо бүгд холбоотой, тэгээд л үүний цаана чинь маш олон асуудал яригдсан шүү дээ. Тийм ээ. Дахиад л баахан тусгай зөвшөөрөл олгох юм байна. Энийг хураагаагүй л дээ. Тийм учраас энэ саналыг ажлын хэсэг татаж авах хэрэгтэй байна. Та чинь ажлын хэсэг билүү. Чинбүрэн гишүүн энэ саналыг татаад авчих. Та ажлын хэсгийн төлөөлөөд. Гүйцээн боловсруулж болохгүй л дээ. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

**Б.Энх-Амгалан:** Эсрэг байр суурьтай санал. Би бол Ганхуяг гишүүнтэй яг санал нэг байна. Энэ одоо ингээд хууль зүйн хэллэгээр наадах чинь ингээд таслал болгоноороо нэг зөвшөөрөл байхгүй юу. Тэгээд сая Эмийн сонсголын хуулиар танай эрүүл мэндийн салбар дээр чинь ашиг сонирхлын зөрчилтэй, харилцан хамааралтай ийм хүмүүс Эрүүл мэндийн яам дээрээ 70 хувь, ЭМДҮЗ дээрээ 100 хувь гээд ингээд гараад эхэлсэн. Тэгэхээр та нар өөрсдөө хяналт зохицуулалтаа хийдэг. Өөрсдөө тусгай зөвшөөрлөө өгдөг. Өөрсдөө экспорт, импортоо хийдэг. Өөрсдөө тэгээд зардаг. Тэгээд дахиад өөрсдөдөө зөвшөөрөл өгөөд. Нэг ёсондоо өгдөг зөвшөөрлөө өөрсдөдөө нэмчихээд, өрсөлдөгчдөө бүгдийг нь хааж хаяад, тэгээд нэг ийм том хүнд суртлын юм үүсгэх гэж байгаа байхгүй юу. Тийм

учраас би бол энэ саналыг дэмжиж чадахгүй. Энийг би бол дэмжихгүй байр суурьтай хэлж байгаа юм.

**Г.Занданишатар:** Дэмжихгүй 2 үг хэллээ. Тэгээд дэмжихгүй үгнүүд хэлж байгаа учраас энийг гүйцээн боловсруулах, эсвэл дахин санал хураалт татаж авах. Тэгээд энийг татаад авчих уу. Содномын Чинзориг гишүүн.

**С.Чинзориг:** Үгүй ээ, үгүй. Энийг бол унагааж болохгүй гишүүд ээ. Энэ эрүүл мэндийн салбар, ялангуяа энэ эмийн салбар гэдэг чинь өөрөө стратегийн бүтээгдэхүүн. Эм гэдэг чинь бэлдмэл чинь. Энэ дээр нэлээн тийм нарийн бодлоготой хандахгүй бол хамаагүй тэгээд ганцхан зөвшөөрөл олгоно гээд ямар хүнсний бараа худалдаалах ганц зөвшөөрөл өгч байгаа биш ингэж бол болохгүй ээ. Энэ сэтгэцтэй холбоотой эм, эд нар чинь бол тусдаа байна. Эд нар чинь одоо бол хуульдаа байгаа юм дарга аа, одоо хуульдаа байгаа юм. Одоо бол байна шүү дээ харин 4 зөвшөөрөл байсныг бид нар 3 болгож байгаа юм. Импортлох, ханган нийлүүлэх, худалдаалах, экспортлох гээд 4 зөвшөөрөл байсныг нь бид нар одоо харин 3 зөвшөөрөл болгож цөөрүүлж оруулж ирж байгаа юм. Байгаа юм аа. Байгаа юм. Тэгээд одоо бол бид нар 4 зөвшөөрөл байгааг нь 3 зөвшөөрөл болгож байгаа юм. Тэгээд тэр мансууруулах сэтгэцийн нөлөөлөх юутай холбоотой асуудлыг тусгай зөвшөөрөл өгөхгүй бол тэр ерөөсөө болж өгөхгүй Ганхуягаа. Чи энэ салбарын онцлогийг нь мэдэхгүйгээр ингээд ерөөсөө бүгдийг нь бөөндүүлээд ганцхан зөвшөөрөлтэй болгож ерөөсөө болохгүй. Бас энэ салбарын онцлогоо бас авч үзэх хэрэгтэй Ганхуяг аа.

Харин чи бол тэр Зөвшөөрлийн хууль дээрээ энэ нөгөө био бэлдмэлтэй холбоотой асуудлыг бүртгэл ч үгүй болгоод дэндүү дампууруулсан шүү. Би харин дуугарахгүй юм хэлэхгүй яваа шүү. Тэр био бэлдмэл чинь бол яг тэр хүнсний бүтээгдэхүүн шиг хэрэглэж болдоггүй

юм шүү дээ. Нэмэлт бүтээгдэхүүн чинь. Тэрийг чинь ерөөсөө зөвшөөрөл ч үгүй, бүртгэл ч үгүй болгож байгаа шүү дээ. Тэрийг хүнсний бүтээгдэхүүн шиг хэрэглэж болдоггүй юм байна лээ. Энэ салбарынх нь онцлогийг мэдэж байж яахгүй бол ингээд ерөөсөө зөвшөөрөл байж болохгүй гээд хавтгайруулж болохгүй. Тэр нэмэлт бүтээгдэхүүн чинь зөвшөөрөлгүй болгочихсон. Одоо бүртгэлгүй болно гэж байгаа юм. Тэр чинь дозоосоо, граммаасаа хамаараад хүний биед гаж нөлөө үзүүлдэг, сөрөг нөлөө үзүүлдэг, бүр гормоны ч өөрчлөлт оруулах асуудал асар их байдаг юм байна лээ шүү дээ. Тэрийг чи яг одоо чихэр шиг зөвшөөрөлгүй, бүртгэгчгүй болго гэж байгаа шүү дээ. Энэ салбарынхаа онцлог энэ стратегийн бүтээгдэхүүн үндэсний аюулгүй байдалтай холбоотой стратегийн бүтээгдэхүүнд холбоотой асуудал дээр болгоомжтой хандахгүй бол Ганхуяг аа ингэж болохгүй. Салбарын онцлогийг нь бас авч үзэхгүйгээр ингэж хамаагүй хандаж, туйлширч болохгүй Ганхуягаа. Энэ харин 4 зөвшөөрөл байсныг нь манайх 3 болгож байгаа шүү дээ. Цөөлж байгаа юм. Цөөлж байгаа юм.

**Г.Занданшатар:** Энэ санал хураалт түрүүн бол хүчингүй болгох санал хураалт явуулсан. Энэ санал хураалт маргаантай байгаа учраас зөвшөөрлийн хуулийн зөрчилтэй учраас хууль зүйн техникийн хувьд Зөвшөөрлийн хуультай зөрчилдөж байгаа учраас гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Энийг дахиж ярих хэрэгтэй.

Дараагийн асуудал бас мөн адилхан. Энэ Зөвшөөрлийн тухай хуулийг шууд хөндөөд, хууль зүйн хүрээнд гэснийг хасаад, энэ техникийн зохицуулалтын асуудал, энэ стандартчилал, техник энэ тэртэй холбоотой асуудлууд ч гэсэн бусад хуультайгаа уялдах ёстой. Энэ хуулийн заалтыг хойшлууллаа.

Энэ чинь сонсгол хийгээд улам сайжруулна гэсэн чинь нуухыг нь авах

гээд нүдийг нь сохолчихож байгаа юм биш биз.

4.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авсан” гэснийг “бүртгүүлсэн” гэж, 8.2.4 дэх заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж, мөн заалтын “худалдах” гэснийг “ханган нийлүүлэх” гэж тус тус өөрчилж, 8.1.6 дахь заалтын “улсын бүртгэл” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

**Л.Мөнхбаатар:** 5.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 9.4.6 дахь заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж, мөн заалтын “худалдах” гэснийг “ханган нийлүүлэх” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд саналаа өгөөрэй.

Саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Миний төхөөрөмж ажилласангүй. Уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Адьшаа гишүүн горимын санал гаргая. Адьшаа гишүүн горимын санал гаргая

**Ш.Адьшаа:** Миний төхөөрөмж ажилласангүй ээ. Дахиж санал хураалт явуулж өгнө үү. Энэ Чинзориг жоохон чимээгүй баймаар байна. Үглэхээ болимоор байна. Ингээд хурал үймүүлээд өөрийнх нь хууль хэлэлцэж байхад чинь ингээд үглээд байх юм. Ямар ядаргаатай юм.

**Л.Мөнхбаатар:** Адьшаа гишүүн санал гаргасан уу. Улсын Их Хурлын гишүүн Адьшаагийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. 59 хувиар санал дэмжигдлээ.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Үндсэн санал хураалтыг

явуулъя. Санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “эмнэлгийн” гэснийг “эрүүл мэндийн байгууллагын” гэж, 10.4 дэх хэсгийн “жоргүй олгох эмийг цахимаар болон утсаар авсан” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээс бусад эмийг цахим жор болон” гэж, 10.8.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 10.8.10 дахь заалтын “үнээр” гэснийг “хувь хэмжээгээр нэмэгдүүлж” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “болон сумын эрүүл мэндийн төв” гэснийг, 10.8.1 дэх заалтын “улсын бүртгэлд бүртгэгдээгүй” гэснийг, 10.8.4 дэх заалтын “, үйлчлэх” гэснийг, 10.8.9 дэх заалтын “хаяг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Энэ сумын Эрүүл мэндийн төв гэдгийг хассан байна. Энэ их зөв болсон байна. Яагаад гэвэл яг энэ Засгийн газраас орж ирсэн дээрээ болохоор сумын эмнэлэг аптектай байхаар ийм заалт орж ирсэн. Энэ бол чөлөөт зах зээлийг боомилсон, өөрөөр хэлбэл олон жилийн туршид энэ сум, орон нутагтаа ажлын байр бий болгоод, тэдний ард иргэдийнхээ эрүүл мэндийн манаанд бас аптекийн хамт олон бас зүтгэдэг. Тэгээд энэ хүмүүсийн бизнесийг булааж авах ийм заалт болоод ороод ирсэн байсныг нь харин Тогтохсүрэн дарга энэ тэр бас нэлээн санаачлаад энийг болиулсан байна. Энэ бол зөв. Тэгэхгүй бол одоо энэ чинь ер нь бол ингээд харж байхад аль болох л төр бизнес хийе, аль болох л төр бүх зүйлийг авдаг ийм зүйл чинь хууль болгоноор орж ирээд байхаар энэ чөлөөт зах зээлийн нийгэм гэдэг чинь ерөөсөө байхгүй болчих гээд байна. Тийм учраас энэ бол зөв болсон байна гэдгийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** Гэхдээ Пүрэвдорж гишүүн ээ, ийм агуулга байна. Тогтохсүрэн гишүүн ээ. Сумын эмнэлэг бол дэргэдээ аптекгүй байх нь байна. Тийм ээ. Гэхдээ улсын чанартай 2 дахь, 3 дахь шатлалын эмнэлгүүд бол аптектай байж болно гэсэн энэ агуулгаар байна шүү. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүд ээ. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “байгуулах,” гэсний дараа “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 11.1.7 дахь заалт нэмэх:

“11.1.7.эм, эмнэлгийн хэрэгслийн цувралын дугаар, стандарт код, тоо хэмжээг тухай бүр цахим санд оруулсан байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Адьшаа горимын санал гаргая. Адьшаа гишүүн та өөрийнхөө суудал дээр суу.

**Ш.Адьяа:** Энэ миний төхөөрөмж ажилласангүй. Дарсан байхгүй юу. Би эндээс нь. Худлаа яриад байгаарай Пүрэвдорж оо чи..

**Л.Мөнхбаатар:** Адьяа гишүүн өөрийнхөө төхөөрөмжийг дарвал ер нь бол санал амжилттай болохоор л байна. Адьяа гишүүний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт хүчингүйд тооцогдсон. Үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад энэ хуулийн 8-11 дүгээр зүйлд заасан үүрэг, шаардлага, Эрүүл мэндийн тухай хуулийн 19.17-д заасан нөхцөлийг хангасан эсэх талаарх дүгнэлтийг үндэслэнэ.” Санал санал гаргасан ажлын хэсэг. Үг хэлж гэж байгаа юм уу. Санал хураалтыг түдгэлзүүллээ. Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлье.

**Х.Ганхуяг:** Ер нь Зөвшөөрлийн хууль дээр хяналт тавих эрх бүхий байгууллага нь угаасаа энэ зөвшөөрлөө олгож байгаа. Зөвшөөрлийн хугацаанд байнга хяналтаа тавиад явж байгаа. Зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй байвал түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхүүд нь бүгдээрээ байгаа. Тэгээд бид нар тийм хууль Зөвшөөрлийн хууль гэж баталсан болохоор энэ сунгалтыг нь аль болох хялбаршуулах байдлаар энэ зөвшөөрлийн хууль бичигдсэн юм. Тэгсэн энд яг сунгалтыг нь дахиад л хүндрүүлэхээр ийм нөхцөл ороод ирсэн байна л даа. Тэр чинь ингээд байнга л нөгөө байгууллага нь хяналтад байж байгаа. Тэгээд ямар нэгэн асуудал үүсвэл нөгөө эрх бүхий байгууллага нь түдгэлзүүлж болж байгаа, хүчингүй болгож болж байгаа юм. Гэтэл ингээд сунгуулах гэхээр танайх энэ шаардлагаа хангаж байгаа эсэх эд нар дүгнэлт бичиж авч ир гээд л дахиад л хүндрүүлэх юм ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Эднийх ер нь ингээд байж болох бүх л хүнд суртлын нэмэгдүүлэхээр юмнууд оруулж ирээд байна л даа. Үгүй ээ, тийм болоод л ингээд дуугараад байгаа юм. Тэгэхээр энэ заалтыг нэг бол буцаамаар байна. Эсвэл гүйцээн боловсруулмаар байна. Тэр хууль дээр чинь хангалттай орчихсон байхгүй юу. Ийм болохгүй шүү дээ. Одоо бид нар аль болох нөгөө хувийн хэвшилээ дэмжинэ л гээд байдаг. Тэгээд зөвшөөрлийг чинь бол сунгахдаа та нар ингээд хялбархан байдлаар сунгуулаарай гээд уг нь хуулиа баталчхаад байдаг. Тэгээд ингээд дахиад л нэг нугалаа үүсгээд байгаа байхгүй юу.

**Л.Мөнхбаатар:** Хассуурийн Ганхуяг гишүүний яриад байгаа зүйл

байна шүү дээ. Тусгай зөвшөөрлөө олгочихсон. Тодорхой шалгуурыг хангаад олгочихсон байхад нь сунгахдаа ахиад мөн адил бичиг баримтуудыг бүрдүүлэх шаардлагатай байна гэж үзээд байгаа юм байна шүү дээ. Тийм ээ. Тийм учраас энд бас ийм давхардсан хийгээд, хүнд суртал үзүүлсэн ийм зүйл байж болзошгүй байна. Тийм учраас Байнгын хороогоороо хэлэлцэхдээ хэлэлцэх нь зүйтэй. Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

9.Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “Эм, эмийн үйлчлэгч бодисыг бүртгэх” гэж, 15.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 15.2 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, мөн зүйлийн 15.2.2 дахь заалтын “зөвшөөрөл олгох” гэснийг “бүртгэл” гэж, 15.3 дахь хэсгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөл олгоход” гэснийг “Эм, эмийн үйлчлэгч бодисыг бүртгэхэд” гэж, 15.3.2 дахь заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 15.5 дахь хэсгийн, 15.5.4 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “эм, эмийн үйлчлэгч бодисын бүртгэлийг” гэж тус тус өөрчилж, 15.4 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 57,9 хувиар дэмжигдлээ.

10.Төслийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан” гэж, 16.9 дэх хэсгийн “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэж бүртгэсэн” гэж, 16.10 дахь хэсгийн “энэ хуулийн 16.9-д зааснаар” гэснийг “түргэвчилсэн байдлаар” гэж, 16.11, 16.12 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж тус тус өөрчилж, 16.11 дэх хэсгийн “импортын” гэсний өмнө “Энэ хуулийн 16.10-д зааснаас бусад” гэж нэмж, мөн зүйлийн 16.15 дахь хэсгийг хасах. Санал гаргасан



ажлын хэсэг. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авахад шаардагдах бүтээгдэхүүний” гэснийг “бүртгэлийн” гэж, 17.1.6 дахь заалтын “онцгой” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн ноцтой” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 18 дугаар зүйлийн гарчгийн, 18.1, 18.2 дахь хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, 18.1 дэх хэсгийн “Шинэ эм” гэснийг “Эм” гэж, 18.3 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, мөн хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан” гэж, 18.4 дэх хэсгийн “зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 18.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн” гэсний дараа “байгууллага, эсхүл гадаад улсын эрх бүхий” гэж, 18.3 дахь хэсгийн “баримт бичиг,” гэсний дараа “Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, эсхүл гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,3 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “лабораторийн зохистой дадлын стандарт хангасан” гэж, 19.2 дахь хэсгийн “лаборатори” гэсний дараа “итгэмжлэгдсэн байх бөгөөд” гэж, 19.4 дэх хэсгийн “Ерөнхий” гэсний өмнө “Дотоод болон гадаадын” гэж тус тус нэмж, 19.5 дахь хэсгийн “шинэ эм, уламжлалт” гэснийг “анхдагч” гэж өөрчилж, мөн зүйлийн 19.10 дахь хэсгийн “эсхүл иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлын дагуу яаралтай шинжлэх дээж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд сууж саналаа өгөөрэй. Баттөмөр

гишүүн. Адьшаа гишүүн. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж, 20.12 дахь хэсгийн “зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 20.9 дэх хэсгийн “вакцин,” гэсний дараа “биобэлдмэл” гэж, 20.12 дахь хэсгийн “тандалт” гэсний дараа “судалгаа” гэж тус тус нэмж, 20.11 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Өнөөдөр угаасаа явуулахгүй бол амжихгүй. Цаг сунгаад чуулган хуралдуулахаар шийдчихсэн байгаа шүү. 59 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “үйлдвэрлэгч, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “улсын төсвөөс” гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн. Санал хураалт 53,8 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “дархлаажуулалтын дараах” гэснийг хасаж, 21.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 30.1-д заасан” гэснийг “Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн,” гэж, 21.4 дэх хэсгийн “нөлөөг нягтлан дүгнэлт гаргаж, эмийн гаж нөлөөний талаар” гэснийг “нөлөөний үнэлгээг холбогдох зөвлөлийн шийдвэрээр баталгаажуулан,” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 22 дугаар зүйлийн гарчгийн, 22.2, 22.8 дахь хэсгийн “Шинэ” гэснийг “Анхдагч” гэж, мөн зүйлийн 22.4.5 дахь заалтын “биошингэц” гэснийг “биохүрэхүй” гэж, 22.6 дахь хэсгийн “биошингэцийг” гэснийг “биохүрэхүйг” гэж, 22.7.4 дэх заалтын “үйлчлэлийг” гэснийг “үйлдлийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Нэр томъёоны л ийм байх шиг байна. 56,4 хувиар санал дэмжигдлээ.



18.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “хэвлэлээр” гэснийг “хэвлэл, албаны ёсны цахим хуудсаар” гэж өөрчилж, 26.5.5 дахь заалтын “чухал, цорын ганц, маш өндөр идэвхтэй,” гэснийг, мөн заалтын “хамгийн сайн,” гэснийг тус тус хасаж, 26.5.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.5.10.эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг өвчнийг оношлох, эмчлэх үйлдэлтэй гэж олон нийтийг төөрөгдөлд оруулсан байдлаар сурталчлах;” гэсэн байна. Нэмэлт бүтээгдэхүүнийг өвчнийг оношлох, эмчлэх үйлдэлтэй гэж олон нийтийг төөрөгдөлд оруулсан байдлаар сурталчилгааг хориглох юм уу. Тийм ээ. Тийм заалт юм байна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 27 дугаар зүйлийн 27.4.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.4.4 дэх заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.4.6 дахь заалт нэмэх:

“29.4.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид бага насны хүүхдийн эмийг олгохдоо онцгойлон анхаарч эмийн зохистой хэрэглээний талаарх мэдээлэл өгөх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,3 хувиар санал дэмжигдлээ.

22. Төслийн 33 дугаар зүйлийн гарчгийн “хэрэгсэл зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “хэрэгслийн бүртгэл” гэж, 33.1 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 33.2 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг энэ хуулийн 15.3.1, 15.3.7 дахь заалт болон үйлдвэрлэгч улсдаа зах зээлд гаргасныг харгалзан үзэж,” гэж, 33.6 дахь хэсгийн “лабораторийн” гэснийг “лаборатори, эсхүл төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн үндэсний итгэмжлэгдсэн лавлагаа лабораторийн” гэж, 33.7 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийн” гэснийг “улсын бүртгэлийн” гэж, 33.9 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “бүртгэл” гэж, 33.9.4 дэх заалтын “маш бага” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-д заасан байгууллагад хэрэглэгдэх” гэж, 33.9.6 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл авахад шаардагдах бүтээгдэхүүний” гэснийг “бүртгэлийн” гэж, 33.9.9 дэх заалтын “хэрэглэгдэхүүн, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж” гэснийг “хэрэгсэл” гэж тус тус өөрчилж, 33.4 дэх хэсгийг, 33.9.5 дахь заалтын “эмнэлзүйн” гэснийг тус тус хасаж, 33.5 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “өндөр, дунд эрсдэлтэй” гэж, 33.9.4 дэх заалтын “оношилгооны” гэсний дараа “өвөрмөц” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.9 дэх хэсэг нэмэх:

“33.9.Өндөр, дунд эрсдэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, загвар, эсхүл бүтээгдэхүүний дугаар тус бүрээр нь жагсаалтад оруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “сөрөг нөлөө,” гэсний дараа “аюулгүй байдал,” гэж нэмж, 35.5 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрлийг” гэснийг “бүртгэлийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж горимын санал гаргая.

**Б.Пүрэвдорж:** Би энэ Алтанхуяг даргын суудал дээр андуурч суугаад кнопоо буруу дарчихлаа. Тэгээд би саяын саналыг хүчингүй болгоод, би дэмжих ёстой байсан. Тэгээд санал хураалт явуулж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд байраа эзлээрэй. 51,3 хувиар санал дэмжигдлээ. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Үндсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүд ээ. 59 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “, эсхүл Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-д заасан байгууллага” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.4 дэх заалтын “серийн” гэснийг “цуврал, эсхүл бүтээгдэхүүний” гэж, 38.4 дэх хэсгийн “сав, баглаа боодол дээрх” гэснийг “гадна талд байрлах” гэж, 38.5.3 дахь заалтын “техникийн үзүүлэлт” гэснийг “загварын нэр” гэж, 38.8 дахь хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлд” гэснийг “бүртгэлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 38.4.5 дахь заалтын “, сар, өдөр” гэснийг, 38.5.4, 38.5.7, 38.5.8, 38.5.9, 38.5.10 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 38.6 дахь хэсэг нэмэх:

“38.6.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэрэглэгчийн гарын авлага монгол, эсхүл англи хэлээр байх бөгөөд дараах мэдээллийг агуулна:

38.6.1.бүтээгдэхүүний нэр;

38.6.2.үйлдвэрлэгчийн нэр;  
38.6.3.загварын нэр;  
38.6.4.техникийн үзүүлэлт;  
38.6.5.ашиглалтын заавар;  
38.6.6.хадгалах болон

тээвэрлэх нөхцөл;

38.6.7.ашиглалтын нөхцөл;  
38.6.8.аюулгүй ажиллагаа;  
38.6.9.суурилуулалт хийх

зааварчилгаа;

38.6.10.засвар үйлчилгээ хийх зааварчилгаа;

38.6.11.холбоо барих үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага;

38.6.12.ариутгал, халдваргүйжүүлэлтийн нөхцөл;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг түдгэлзүүллээ. Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням уг хэлье. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

**Г.Дамдинням:** Дарга аа энэ 38.6 дээр найруулга дээр нь энэ “эсхүл” гээд энэ үгийг нь аваад хаячихвал яадаг юм бэ дээ. Монгол, Англи аль алинаараа байвал дээр шүү дээ. Аль алинаараа явчихсан нь зөв байхгүй юу. Яагаад гэвэл бид нар чинь одоо бас аялал жуулчлалыг дэмжинэ. Олон жуулчин авна гээд л ингээд л явж байгаа. Тэгээд боловсролдоо хүртэл бас англи хэлийг оруулаад л явж байна. Тэгэхээр бид нар энэ эсхүл гэдэг үгийг нь аваад тэгээд аль алинаар нь явахаар Монгол, Англи байна гэдгээр нь явчихвал зүгээр санагдаад байх юм. Харин тийм эсхүл гэж хуульд ямар юм байдаг юм. Монгол, Англи гээд л орчихвол болно шүү дээ. Тэгвэл одоо аль алинаар нь оруулчих л гээд байна шүү дээ. Хэрэглэгчдэд хэрэгтэй л байхгүй юу. Үгүй ээ, нөгөө хоёуланг нь тавина л гэсэн үг шүү дээ. Тэгээд хоёуланг нь л тавьчихгүй юу. Болно шүү дээ. Мэдэхгүй одоо Чинзориг сайдын л үг юм байлгүй. Тэгээд найруулгын хувьд энэ дээр нэг засаад өгчихвөл яасан юм бэ.

**Л.Мөнхбаатар:** 2 л агуулга болно шүү дээ. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн гарын авлага нь монгол хэл дээр байж болох нь байна. Эсхүл

англи хэл дээр байж болно. Үгүй бол энийг бол хоёулангаар нь хийх юм бол гадаадын төхөөрөмж чинь бүгдээрээ монгол хэл дээр орчуулагдаж ирсэн байхыг шаардана гэсэн үг агуулга шүү дээ. Ийм агуулга шүү. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Адьшаа горимын санал гаргая.

**Ш.Адьшаа:** Дэмжсэн санал өгсөн. Төхөөрөмж гацлаа. Дахиж санал хураалт явуулж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьшаагийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Тэмүүлэн гишүүн суудалдаа суугаарай. Санал хурааа. 51,3 хувиар санал дэмжигдлээ.

Үгүй ээ үгүй яах вэ. Саяынх чинь бол бас юу шүү Дамдинням гишүүн ээ. Нөгөө гадаадаас тоног төхөөрөмжүүд ирэхээр чинь англи хэл юм уу монгол хэл дээр байж болно. Тэгэхээр заавал монгол хэл дээр байна гээд заачих юм бол нөгөө англи хэл дээр чинь монгол хэл дээр үйлдвэрээсээ хүртэл бүх юунууд нь ирэх нь байна шүү дээ. Шаардлагууд нь тийм болчихно. Тэгэхээр хүндрэл үүсэх вий л гэдэг агуулгаар хэлж байгаа юм байна. Тэгэхээр аль аль нь байж болно л гэсэн үг байна шүү дээ. Гарын авлага биш. Энэ чинь өөрөө 8 төрлийн нөхцөл байгаа юм. Яг гарын авлага бол огт биш шүү. Тийм гарын авлага бол огт биш. Санал хураалтыг хүчингүйд тооцсон. Санал хураалт явуулъя. Үндсэн санал хураалтыг явуулъя. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “хэвлэлээр” гэснийг “хэвлэл, албан ёсны цахим хуудсаар” гэж, 39.5.4 дэх заалтын “чухал, цорын ганц, маш өндөр үйлчилгээтэй,” мөн заалтын “хамгийн” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “бусад байгууллага” гэсний дараа “үндсэн, эсхүл гэрээт” гэж, 40.1.4 дэх заалтын “төхөөрөмжийн” гэсний дараа “хэрэглэгчийн гарын авлагад үндэслэн” гэж тус тус нэмж, 40.7 дахь хэсгийн “хэсгээс” гэснийг “хэсэгт заасан баталгаат хугацаанаас” гэж өөрчилж, 40.1.4 дэх заалтын “эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” гэснийг, 40.2 дахь хэсгийн “болон лабораторийн” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “, бүртгэлд өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг түдгэлзүүллээ. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг үг хэлье.

**Х.Ганхуяг:** Энэ дээр дарга аа, гүйцээн боловсруулах чиглэлийг ажлын хэсэгт өгүүлмээр байгаа юм. Энэ дээр яагаад вэ гэхээр Зөвшөөрлийн хуулиар зөвшөөрлийн шинж чанартай ямар нэгэн бүртгэл, захиргааны акт, тогтоол гаргахыг хориглочихсон байгаа. Тэгээд энэ дээр болохоор яачихсан бэ гэхээр эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх асуудлыг эмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн баталгаажуулна гэхихсэн байгаа байхгүй юу. Эмийн зөвлөл гэдэг нь хэдэн сард 1 удаа хуралдана. Тэгээд нөгөө ашиг сонирхлын зөрчилтэй нөхдүүд дандаа орчихсон байдаг. Нөгөө эм дээр гардаг асуудал чинь яг энэ витамин дээр гарах байхгүй юу. Бид нар витамин дээр дарга аа, өмнөх зөвшөөрлийн хууль баталж байхдаа жагсаалтаас санал хураагаад хасчихсан юм. Одоо витамин зөвшөөрөлгүй байна гэхихсэн байхад одоо ингээд бүртгэл нэрээр дахиад зөвшөөрөл бол болгоод оруулаад ирж байгаа байхгүй юу. Энэ дээр дарга аа яг гүйцээн босуулах чиглэл өгүүлмээр байна.

**Л.Мөнхбаатар:** Төслийн энэ 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг дээр Улсын

Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн гаргасан саналыг бас тодорхой үндэслэл байна гэж үзээд гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Байнгын хороон дээрээ яриарай.

29.Төслийн Төслийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй эм,” гэснийг “бүртгэлгүй эм, өндөр, дунд эрсдэлтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 43.3.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл,” гэснийг хасаж, 43.8 дахь хэсгийн “байгууллагын” гэсний дараа “эмийн асуудал хариуцсан улсын байцаагч” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1.1, 44.1.2, 44.1.3 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 44.4.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрлийн гэрчилгээ” гэснийг “бүртгэлийн дугаар” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 44.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“44.7.Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд бүртгэлгүй эм, эмнэлгийн хэрэгслийг импортлоход Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага импортын мэдүүлэг олгоно:

44.7.1.гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн;

44.7.2.эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсэж орлуулан хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл байхгүйгээс эмнэлгийн тусламж, үйлчилгээнд доголдол үүссэн.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

Чинзориг сайдыг тиймэрхүү нөхцөл байдал үүсгэхийг оролдоод байвал нь Эмийн хуулийг Шүүхийн хуулийн дараа хэлэлцэнэ. Хойшлуулна шүү. Дамдинням

гишүүний хэлснийг анхааралдаа авна. Яг хамгийн сүүлийнх нь заалтыг нь батлахгүй, хойшлуулаад тавьчихъя. Тэгье.

31.Төслийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.3, 46.9, 46.10 дахь хэсгийн “тусламж, төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 46.10.1 дэх заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 46.10.6 дахь заалтын “эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэснийг “эмийг” гэж, 46.14.2 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж тус тус өөрчилж, 46.11 дэх хэсгийн “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасаж, мөн хэсгийн “40.10.6” гэсний дараа “46.10.7” гэж нэмж, 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зориулан эм, эмнэлгийн хэрэгслийг хандив, тусламж хүлээн авахдаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, гадаад, дотоодын хуулийн этгээдээс хандив, тусламж хүлээн авахдаа эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал гаргах хүн байгаа юм уу Байхгүй бол санал хураагдсан юман дээр өгөхгүй л дээ. Санал дэмжигдсэнгүй.

Нийгмийн бодлогын байнгын хороон дарга Анужсин горимын санал гаргая.

**П.Анужсин:** Дарга аа, төхөөрөмж ажилласангүй ээ. Саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Та ажилласангүй юу, төхөөрөмж ажилласангүй юу. Ямар ч байсан аль нэг нь ажилласангүй боллоо. Анужсин даргын гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд



тооцох санал хураалт явуулъя. 59 хувиар санал дэмжигдлээ. Уг санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Одоо үндсэн санал хураалтыг явуулах уу. Чинзориг сайд аа та энэ юмаа нэг бүгдийг нь нэгтгэж оруулж ирэхгүй бол бараг зүйл бүр дээр чинь, санал хураалт бүр дээр чинь ийм асуудал үүсээд байна шүү. Гэхдээ энэ дээр ингэх хэрэгтэй. Та хэд ямар нэг байдлаар энэ дээр болохоороо тусгай зөвшөөрөл бас бий болж болзошгүй байна. Нөгөөтээгүүр бас тодорхой хүнд суртал үүсгэх бас тодорхой зүйл заалтууд байна гэж гишүүд үзэж байгаа учраас энийг нягтлан үзэх нь зүйтэй гэж үзээд, төслийн 32 дугаар зүйлийг бүхэлд нь 32 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. 31 дүгээр саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

32.Төслийн 50 дугаар зүйлийн 50.1.5 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох,” гэснийг “бүртгэх” гэж, 50.1.7 дахь заалтын “өөрчлөх” гэснийг “нэмэлт оруулах” гэж, 50.1.10 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл” гэснийг “бүртгэл, үйлдвэрлэлийн зохистой дадал” гэж, 50.1.12 дахь заалтын “эм, зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй” гэж, 50.1.17 дахь заалтын “жижиг хэрэгслийн” гэснийг “хэрэглэгдэхүүний” гэж, 50.2 дахь хэсгийн “Зах зээлд гарах зөвшөөрөлгүй” гэснийг “Бүртгэлгүй” гэж тус тус өөрчилж, 50.1.4, 50.1.6 дахь заалтын “өөрчлөх” гэснийг хасаж, 50.1.22 дахь заалтын “үйлдвэрлэхээс” гэсний дараа “хэрэглэх” гэж, 50.1.24 дэх заалтын “байгууллагаар” гэсний дараа “гэрээний үндсэн дээр” гэж тус тус нэмэх. Асуулт байхгүй. Үг хэлж болно. Санал хураалтыг түр түдгэлзүүлж байна. Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир үг хэлье.

**Ц.Сандаг-Очир:** Энэ 50.1.22 дахь заалтыг би тодруулмаар байгаа юм. Энэ заалт сая эмийн түр хороо сонсгол хийхэд ер нь цаанаасаа үйлдвэрлэгчээс эмийг хэдээр аваад манай Монгол Улсад орж ирэхдээ хэд дахин нэмэгдэж орж

ирж байгааг мэдэх боломжгүй байгаа юм өнөөдөр. Тэгэхээр эм ер нь ямар үнэтэй байна вэ гэдгийг иргэд ерөөсөө мэдэхгүй байгаа юм. Бид нар энийг эмийн түр хороо дээр асуудлыг яриад, энэ гаалиар орж ирж байгаа хэд дахин нэмэгдэж орж байгаа гэдгийг мэдэхийн тулд энэ гааль дээр бүртгэл судалгааг нь ингэж хийх ёстой юм байна. Ингэж байж энэ эмийн үнийн хяналтыг тавих, үнийг бууруулах иргэдийг бас мэдээллээр хангах энэ бололцоо боломж үүснэ гэж ингэж ярьж байсан. Тэгээд энэ 50.1.22 дахь заалт тэр заалт мөн үү, үгүй юу. Тэгэхээр цаашидаа энэ иргэд эмийг ямар үнэтэй орж ирсэнд хяналт тавих бололцоо боломжийг бүрдүүлэх үүднээс бид нар энэ түр хороо дээр энийг ярьсан юм. Тэгэхгүй бол өнөөдөр бол бүгд мэдэхгүй байгаа байхгүй юу. Энэ эм 3 мянган төгрөгөөр зарагдаж байхад цаанаасаа хэдэн төгрөгийн үнээр орж ирсэн юм бэ гэдгийг мэдэх ямар ч боломжгүй байгаа юм. Тэгээд та нар энэ дээр нэг тайлбарлаад өгөөч. Тайлбар байхгүй юу. Энэ дээр л нэг тайлбар авчихмаар байх юм.

**Л.Мөнхбаатар:** Дэгээрээ тайлбар байхгүй. Гэхдээ Чинзориг сайд 50.1.22 дахь заалтаа та хараад орхи доо. Сая Сандаг-Очир гишүүний ярьж байгаа асуудал чинь их чухал асуудал ингээд байна шүү дээ. Анхдагч үнийн асуудлыг нь яриад байгаа юм байна. Тэгээд энэтэй холбоотой асуудал нь тэр 50.1.22-оор чинь зохицуулж байгаа юм уу гэж асуугаад байна. Дараа нь бас энэ 50.1.24 дэх заалт байна. Эдгээр заалтууд чинь үүнтэй холбоотой зохицуулалт чинь мөн байна уу гэж асуугаад байна. Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Чинзориг үг хэлье.

**С.Чинзориг:** 50.1.22 чинь бол энэ эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх, үйлдвэрлэхээс хэрэглэх, устгах хүртэлх үе шатыг хамруулсан нэгдсэн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, аюулгүй байдал, нууцлалыг хангах, мэдээлэл солилцох эд нар гээд бүх л нөгөө мэдээллийг нь бид нар цахим



болгож байгаа юм. Энэ бол иргэдийн нөгөө ямар үнээр орж ирж байгаа юм бэ хилээр гэдгийг нь ил тод болгож байгаа юм. Нэг дэх асуудал.

2 дахь зохицуулалт нь энэ дээр чинь бид нар Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд 2 шат бүр дээрээ Сандагаа гишүүн ээ, ханган нийлүүлэх, жижиглэн худалдаалах шат бүр дээрээ үнэ ер нь дээд тал нь хэдэн хувиар нэмэгдэх вэ гэдгийг нь үнийн хязгаарыг нь нэмэгдэх хувийг нь Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаалаар шийддэг байна гэсэн ийм зохицуулалт бол оруулж өгсөн шүү дээ. Энэ заалт чинь бол яг хилээр орж ирж байгаа үнэ ямар үнэтэй орж ирж байгаа юм гэдгийг иргэд өөрсдөө мэддэг байх тэр боломжийг нээж өгч байгаа юм. Тэр зохицуулалт мөн.

**Л.Мөнхбаатар:** Та хэд энэ ойлголтоо нэгтгээд орхи Сандаг-Очир гишүүн ээ. Ойлголтуудаа нэгтгэчих. Одоо санал хураалтууд явагдаж дууссаны дараа Шүүх байгуулах тухай хуулийг хэлэлцэнэ. Нийтдээ 27 саналтай. Энэ хуулийг хэлэлцсэний дараа чуулганы нэгдсэн хуралдаан завсарлана. Тийм учраас гишүүд тогтвортой сууж хуралдаа оролцоно. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “дүрэм, гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргах” гэснийг, 51.4 дэх хэсгийн “иргэний төлөөлөл, эрүүл мэндийн салбарын тэргүүлэх мэргэжилтнээс” гэснийг, 51.5 дахь хэсгийн “, магистраас дээш зэрэгтэй” гэснийг, 51.13 дахь хэсгийн “үндэсний” гэснийг, 51.14.4 дэх заалтын “үйлдвэрлэх” гэснийг, мөн зүйлийн 51.14.5 дахь заалтыг, 51.15.3 дахь заалтын “, эмнэлгийн хэрэгслийн нөхцөлт зөвшөөрөл олгох” гэснийг, 51.15.4 дэх заалтын “эмнэлзүйн” гэснийг, 51.16.3 дахь заалтыг, 51.18.1 дэх заалтын “, үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон” гэснийг, 51.18.3 дахь заалтын

“бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө” гэснийг тус тус хасаж, 51.4 дэх хэсгийн “захиргааны байгууллага,” гэсний дараа “эрүүл мэндийн байгууллага,” гэж, мөн хэсгийн “сургуулийн” гэсний дараа “төлөөллөөс” гэж, 51.9 дэх хэсгийн “дарга,” гэсний дараа “нарийн бичгийн даргыг шууд,” гэж, 51.18 дахь хэсгийн “хэрэгслийн зөвлөл,” гэсний дараа “түүний салбар зөвлөлийн” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 51.14.3 дахь заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөл олгох” гэснийг “бүртгэх” гэж, 51.15.5 дахь заалтын “хөрөнгө оруулалтын асуудлаар шийдвэр” гэснийг “асуудлаар төлөвлөлтийн санал” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 57 дугаар зүйлийн 57.1.3 дахь заалтын “зах зээлд гарах зөвшөөрөлгүй” гэснийг “бүртгэлгүй,” гэж, 57.1.5 дахь заалтын “итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтэд” гэснийг “үр дүнд” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

35.Төсөлд орж дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

**“60 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

60.1.Энэ хуулийн 8.1.2, 15.3.2-т заасан стандартыг дотоодын уламжлалт эмийн үйлдвэр 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

60.2.Энэ хуулийн 16.14 дэх хэсэгт заасныг үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч дотоодын үйлдвэрлэгч 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ.

60.3.Энэ хуулийн 16.10 дахь хэсэгт заасан өнчин эмийн бүртгэлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хийнэ.

60.4.Энэ хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт өнчин эмийн бүртгэл гэсэн энэ хууль зүйн нэр томъёо байдаг юм уу. Эмийн хуульдаа байдаг юм уу. Тэрийгээ өнчин гэж нэрлэдэг юм уу. Тэгвэл хуульд байгаа нэр томъёо юм байна гэж ойлголоо.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл гишүүн горимын санал гаргая.

**Д.Сарангэрэл:** Уучлаарай дарга аа, сая арай амжиж дарсангүй. Саяын саналыг хүчингүй болгоод дахин саналаа хурааж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэлийн гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай саналаа өгье. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд горимын санал гаргая. Гишүүд сууж саналаа өгье.

**Н.Энхболд:** Энэ сая миний кноп ажилласангүй л дээ. Би дараад дараад хуруу бараг хугарчих шахлаа. Тэгээд тийм дахиад санал хураалгаж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд сууж саналаа өгөөрэй. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. Гишүүд сууя. Пүрэвдорж гишүүн сууя. Суудлаа эзлээрэй. Өөр ямар гишүүн байна.

Гишүүдийг оруулж ирье. Идэрбат гишүүн горимын санал гаргая.

**Ц.Идэрбат:** Энэ дэмжиж санал өгсөн боловч эсрэг гарсан байна. Тэгээд хүчингүй болгож дахиж явуулж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Пүрэвдорж гишүүн бол сая саналаа өгсөн байсан байна. Идэрбат гишүүний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. 55,5 хувиар санал дэмжигдлээ. Хүчингүйд тооцлоо. Үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

2.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал байна.

1.Төслийн Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “, холбогдох баримт бичиг, түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг. Санал хураалт. Энэ түрүүний зүйлтэй адилхан тийм ээ. Түрүүн гүйцээн боловсруулах чиглэл өгчихсөн учраас энэ 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн учраас хойшлууллаа.

Дараагийн саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

2. Төслийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.1.Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг сонгохдоо дараах зарчмын баримттална:

47.1.1.эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг, эсхүл эмийн зардалд өндөр хувь эзэлж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл;

**47.1.2.тусламж,**

үйлчилгээнд нэн шаардлагатай, тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.3.төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийг болон хөнгөвчлөх эмчилгээний эм.” гэсэн байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн. Чинбүрэн гишүүн үг хэлье. Дараа нь Пүрэвдорж гишүүн үг хэлье. Чинзориг гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн үг хэлье.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Энэ их чухал заалт байгаа. Энэ ер нь хуулийн ерөөсөө гол амин сүнс энэ 47 дугаар зүйл буюу төр, хувийн хэвшил хоорондоо яаж ажиллах вэ гэдгийн үндсэн гол зарчим энэ дээр дурдагдаж байгаа. Тэгэхээр бид нарын түр хорооноос явуулсан гол бодлого бол хувийн хэвшлийнхний бизнесийг хумихгүй. Харин төр хянаана. Шалгана. Үнийг нь зохицуулна гэдгийг бид түр хорооноос бол зөвлөмж болгож, тогтоолын дагуу гаргасан. Энэ хуучин хууль дээр болохоор бүр улсын эмнэлгүүд, өрхийн эмнэлгүүд бүгд өөрийнхөө шаардлагатай эм, эмнэлгийн эрсдэлүүдээ бүгдийг нь худалдан авах боломжтой болгоод өг өгч байгаа нь хэт их төр, хувийн хэвшлийнхний бизнес рүү хэт орж байгаа нэг ийм юм байгаа юм. Тэгээд Чинзориг сайд бол бас энэ дээр та нар буцаад хувийн хэвшлийнхний лобби хийгээд байна гэж байгаа юм. Үгүй ээ, тийм биш. Бид яг л одоо энэ зах зээлийн зарчмаараа шударга өрсөлдөх боломжийг нь гаргаж өгч байгаа ийм том хуулийн үндсэн концепц. Түүнээс бид одоо хувийн хэвшлийнхний хийж байгаа бизнесийг хумьж авах гээд байгаа юм биш. Харин хянадаг байя, чанартай байлгая, шударга өрсөлддөг байлгая гэдэг л энэ зарчим. Тийм учраас миний санал бол энэ 47.1 дээр ийм 3 зүйл дээр төр өөрөө худалдан авах үйл ажиллагаа явуулъя. Тэгээд та бүгдийг кноп дарахгүй байгаад энийг дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна.

**Л.Мөнхбаатар:** яах юм Пүрэвдорж гишүүн адилхан л агуулгатай юм уу. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Сүүлийн 8 жилийн туршид энэ эдийн засгийн салбарт төрийн оролцоо 30 хувиас 60 хувь руу оччихсон. Энд очсон шалтгаан нь яасан бэ гэх дээр ерөөсөө ингээд нэг ийм салбарын хуулиудаар, янз янзын хуулиудаар энэ төрийн шийдвэрлэх, төрийн бизнес хийх тэр бүх зүйлүүдийг дэмжиж, хуульд өөрчлөлт оруулсны үр дүнд л ийм үр дүн гараад байгаа юм. Тэгээд одоо ингээд хар даа. Ерөөсөө бүх зүйлийг л төр хийнэ гэдэг болчихсон. Би л бүгдийг нь хийнэ гэдэг ийм зарчмаар энэ заалт орж ирж байгаа байхгүй юу даа. Энэ хувийн хэвшил чинь өчнөөн олон жил ингээд энэ салбартаа эм, эмнэлгийн хэрэгслийг ингээд авчраад оруулаад явж байсан энэ зүйлүүдийг бүр ингээд жижиг хэрэгсэл рүү орох хүртлээ жижигэрч байна шүү дээ төр. Ингэж болохгүй байхгүй юу даа. Тэгээд энэ дээр бол олон олон эмийн үйлчилгээ эрхэлдэг компаниуд болон бусад аптекууд бүх хүмүүс гомдол гаргаж байна. Энэ бол маш тийм урхагтай зүйл. Ер нь бол зүгээр явж байсан юмыг яагаад ингээд зүгээр байлгахгүй, ингээд л заавал ингээд л төр бүхнийг хийдэг, төр бүхнийг зохицуулдаг ийм болгоод байгаа юм бэ. Тэгэхээр хийх ёстой юмаа л хий л дээ. Тэгэхээр хувийн хэвшил рүү хэтэрхий их дайрдаг, тэдний үйл ажиллагаа явуулдаг салбар луу ингээд л дайраад ороод ирнэ гэдэг чинь болохгүй байхгүй юу даа. Тэгээд бүгдийг нь худалдаж аваад л, тэгээд л явах нь л дээ. Тэгэхээр энэ дээр бол 47.1.1, 47.1.3, 47.1.4 энэ тэр гээд энэ бүх зүйлүүд дээр бүгд дээр нь ингээд л төр бүгдийг нь худалдаж аваад л зохицуулах ийм зүйлийг оруулж ирж байна. Энэ бол чөлөөт зах зээл рүүгээ дайрч байгаа ийм маш том урхагтай зүйл.

Тийм учраас энэ дээр одоо ингээд Байнгын хороогоор хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явчихсан. Тэгэхээр энэ дээр Чинбүрэн гишүүн бас зөв санал гаргасан байна. Арай бас нэг жоохон тэр жижиг

хэрэгсэл рүү орохгүй, бас нэг тодорхой яг энэ зохицуулалттай байх ийм зүйлүүд дээрээ бас санал гаргасан байна. Тийм учраас Их Хурлын гишүүд кноптоо гар хүрэхгүйгээр энэ хувийн хэвшлийгээ дэмжиж, энэ чөлөөт зах зээлийгээ дэмжиж энэ саналыг өгөөрэй гэж хүсэж байна.

Бусад хөндөгдсөн заалт байхгүй болохоор бусад асуудлууд дээр чинь бүгд дээр нь ярьж болохгүй байна шүү. Тэгээд манай энэ эрүүл мэндийн бизнес эрхэлдэг энэ компани ААН-үүд хэтэрхий орой, өөрөөр хэлбэл энэ чуулган руу орж ирсэн үед нь энэ саналыг хэлсэн. Хэрвээ Байнгын хороо дээр энэ асуудлыг ярьсан бол арай өөрөөр шийдвэрлээд зарчмын зөрүүтэй саналаар шийдвэрлээд явах ийм боломжууд нь байсан. Тэгэхээр яг энэ дээр бол ялангуяа одоо манай эмнэлгийн салбарт, эм, эмнэлгийн салбарт ажиллаж байгаа хувийн хэвшлийнхэн энэ дээрээ бас нэлээн хариуцлагатай байгаарай. Ер нь бас нэг зүйл нь бас яагаад байна гэхээр нэг талдаа та нарыг бас чөлөөтэй бизнесээ эрхэл гэж хэлээд дэмжээд явах боловч буцаагаад та бүхэн чинь хэтэрхий их өндөр үнэтэй ард түмэндээ эм, эмнэлгийн хэрэгсэл хэрэгсэл авчирч нийлүүлдэг. Эндээс чинь бас тодорхой хэмжээний бухимдал иргэдээс бий болж байгаа учраас бас төр ингэж бизнесийг чинь булааж авах гээд зүтгээд байгаа шүү. Тийм учраас энэ дээр ялангуяа хэтэрхий их өндөр ашиг олдог энэ зүйлээсээ бас нэг жоохон яг тэр бизнесийг чинь зохицуулах шаардлага бид нарт тийм үүрэг байхгүй. Тэгэхдээ бол энэ иргэдээс энэ Их Хурлын гишүүдэд ирдэг энэ саналыг бас хүндэтгэж үзэж бас тэр борлуулж байгаа үнэ тариф дээр бас жоохон анхааралтай байгаарай. Тэгэхгүй бол хууль болоод л ингээд ороод байх нь байна шүү дээ. Тийм учраас Их Хурлын гишүүд ядаж л энэ дээр бүрэн өөрчлөлт хийх боломжгүй юм байна. Тийм учраас Чинбүрэнгийн энэ гаргасан саналыг дэмжинэ гэхээр яах вэ гэхээр кноптоо гар хүрэхгүй байвал ядаж л тэр төр чинь тэр жижиг эм, эмнэлгийн хэрэгсэл, тэгээд л одоо юу байдаг юм.

47.1.4-д өрх өрхийн эрүүл мэндийн төвийн өдрийн эмчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн жижиг хэрэгсэл гээд л бүх юм руу орох шаардлагагүй болно шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Дэмжсэн 3 хүртэл, дэмжээгүй 3 хүртэл гишүүд үг хэлэх дэгтэй. Дэмжихгүй үг хэлэх гэж байгаа юм уу. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьшаа үг хэлье.

**Ш.Адьшаа:** Энэ ер нь энэ эмнэлгийн тоног төхөөрөмжийг худалдаж борлуулдаг энэ монопол байдал чинь ерөөсөө энэ эрүүл мэндийн салбарт бол өнөөдөр үнэхээр гамшигийн хэмжээнд очсон асуудал байгаа шүү дээ. Ийм учраас энэ Чинбүрэн, Пүрэвдорж 2-ын саналын эсрэг бодолтой байна би. Яагаад гэхээр өнөөдөр хувийн хэвшлээ хамгаалж байна гэдэг нэрийн доор өнөөдөр бүх булхай, луйвар, ашиг бизнес чинь өнөөдөр тэр эрүүл мэндийн салбарын тэр том мафийн систем байгаа шүү дээ. Энэ төр ингэж бас мэдэх ёстой юмаа мэдэх ёстой. Зөв. Би бас энэ эрүүл мэндийн салбарын хувийн эрүүл мэндийн салбарт манай гэр бүл ийм бизнес хийдэг юм. Үнэхээр дарамттай. Өнөөдөр ингээд том үе үеийн эрүүл мэндийн салбарын удирдлагууд ийм хүний эрүүл мэндээр бизнес хийдэг ийм мафийн систем бий болсон энэ нөхцөлийг бас төр анхааралдаа авч ингэх ёстой. Энийг бол энэ Байнгын хорооны санал бол зөв санал байна л гэж бодож байгаа. Тэрнээс биш бүх юм буруу, төр буруу бүх юм хувийн хэвшил зөв байна гэдэг хувийн хэвшилээ дэмжинэ гэдэг нэрийдлийн дор өнөөдөр ингэж хүний эрүүл мэндээр бизнес хийдэг тэр хамгийн их шахаа хийдэг энэ асуудлыг бас Монголын төр зохицуулах ёстой. Энэ дээр бол төр харин хяналттай байж, энд ийм зарчимгүй асуудлыг бас зогсоох цаг болсон гэсэн ийм байр суурьтай байгаа шүү би.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Чинзориг үг хэлье.



**С.Чинзориг:** Энэ заалт гишүүд ээ, энэ хуулийн гол амин сүнс нь байгаа юм. Ер нь бол эм гэдэг маань Үндэсний аюулгүй байдалтай холбоотой, стратегийн бүтээгдэхүүн. Стратегийн бүтээгдэхүүн учраас төрийн оролцоо, хяналт, зохицуулалт, нөгөө талдаа төрийн дэмжлэг ч байх хэрэгтэй. Ний нуугүй хэлэхэд бид нар 30 жил энэ стратегийн бүтээгдэхүүнийг зөвхөн хувийн хэвшил дээрээ даатгаад, төрийн оролцоо, хяналт, зохицуулалт, төрийн дэмжлэг байхгүй явж ирсэн нь энэ бол бодлогын том алдаа л гэж би бодоод байгаа юм. Ийм өөр стратегийн бүтээгдэхүүн учраас төрийн тодорхой хэмжээний оролцоо, зохицуулалт, хяналт бол байх хэрэгтэй. Өнгөрсөн жил гишүүд минь ээ бид нар ийм загасны ой санамжтай байж болохгүй. Өнгөрсөн жил бид нар төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд Чинбүрэн, Пүрэвдоржоо би юм хэлж байна. Энэ Төрийн болон орон нутгийн өмчөөр ажил, үйлчилгээ худалдан авах хуульд өөрчлөлт оруулаад, олон улсын стандарт шаардсан юмыг олон улсын үйлдвэрээс нь болон олон улсын шууд худалдан авалтын системийг ашиглаж худалдан авалт хийнэ гээд тендерийн хуульдаа оруулчихсан. Би бол энэ зарчмаасаа бид нар маш том ухралт хийж байна л гэж бодож байна. Чинбүрэн гишүүн өөрөө эмийн сонсгол хийж, эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөл гэж асар их юм ярьсан. Чанаргүй эм гэж асар их ярьсан. Эм өндөр байна гэж асар их ярьсан. Өөрөө баахан ийм юм ярьж, нийгэмд ийм ойлголт өгчхөөд одоо тэгээд энийг нь төр өөрөө жоохон оролцъё, зохицуулъя, хяналт тавьдаг болгоё гэхээр эсрэгээр юм ярьж байгаад нь би бол гайхаж байна. Одоо миний бодол бол төрийн эрүүл мэндийн байгууллагуудын хэрэглэж байгаа эм, даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эмийг төр бизнес хийхгүй Пүрэвдорж гишүүн ээ, олон улсын НҮБ-ын НҮБ-ын хүүхдийн сангийн дэлхий нийтээр худалдан авалт хийдэг энэ системийг ашиглаж би худалдан авалт

хийе л гэж байгаа юм. Төр өөрөө бизнес хийхгүй. НҮБ-ын хүүхдийн сангийн худалдан авалтын системийг ашиглаж худалдан авалт хийе. Чанарын асар том ахиц гаргана. Үнэ дээр асар том өөрчлөлт гарна гэж би ингэж бодож байгаа юм. Чинбүрэн гишүүний орж ирж байгаагаар бол тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм, эмнэлгийн эрсдэлийг авна гэдэг чинь бараг л цөөхөн нэр төрлийн. Бараг л нөгөө онцгой байдал шиг нийгмийн ноцтой эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн цар тахлын дэгдэлтийн үе шиг ийм юм руу хумих гэж байгаа юм. Ингэж хүрээг нь хумьж болохгүй ээ. Би төрийн эрүүл мэндийн байгууллагуудын хэрэглэж байгаа эм, даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эмийг л би НҮБ-ын худалдан авалтын системийг ашиглаж худалдан авъя гэхлээр юунаас нь эсэргүүцээд байгаа юм. 30 жил энэ эм ханган нийлүүлэлтийн байгууллагын нуруун дээр энэ эм чинь явж ирлээ. Тэгээд тэр чанартай эм чинь хаана байгаа юм. Хямдхан үнэ чинь хаана байгаа юм. Энийг тэгээд жоохон НҮБ-ын худалдан авалтын системийг ашиглаад жоохон өөрчлөлт хийчихье гэхээр одоо нэг их ханган нийлүүлэлтийн байгууллагуудын эрх ашиг бодож, ингэж ханган нийлүүлэлтийн байгууллагуудын лоббид автаж болох болохгүй Пүрэвдорж оо. Энэ бол нийтдээ миний хэлж байгаа эм бол нийт эмийн импортын 30 хувиас хэтрэхгүй. 30 хувийг яагаад Төр НҮБ-ын хүүхдийн сангийн худалдан авалтын системийг ашиглаад худалдан авч болохгүй байгаа юм бэ.

Тэгээд та энийг хүрээг нь хэтэрхий хумьчих гээд байна шүү дээ. Нэг дэх заалт чинь болохоор түүгээмэл хэрэглэгддэг эсхүл эмийн зардалд өндөр хувь эзэлж байгаа эмийг авна гээд хүрээг нь хумьчихаж байгаа юм. Өндөр үнэтэй гээд. Дээр нь тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм гээд ингээд хумьчихаж байгаа юм Би одоо таныг эрүүл мэндийн салбарын хүн гэж ойлгодог. Гэхдээ ингэж төр НҮБ-ын худалдан авалтын системийг ашиглаад төр энийг төрийн эрүүл мэндийн байгууллагуудын хэрэглэж



байгаа эм, даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр авч байгаа эмийг авдаг болъё гэхээр эсэргүүцээд ингээд байгаа юм. Би бол гайхаж байна. Та одоо тэгээд сонсгол хийчхээд тэрнийхээ эсрэг юм яриад сууж байгаад гайхаж байна. Би харин тэгж 2 нүүр гаргахгүй шүү чам шиг.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд аятайхан байгаарай. Энэ хууль хэлэлцэх эсэхийг эхлээд, түүнээс гадна анхны хэлэлцүүлгүүд нь яваад ороод ирж байгаа хууль шүү дээ. Байнгын хороо дээрээ сайтар та нар ярих ёстой байсан. Тэгээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар ингээд маргаантай асуудлууд оруулж ирээд байгаа нь их зохимжгүй байна. Одоо тэгээд санал хураалтыг явуулна. Ирц байна. 51,4 хувь байна. Тэр өөрийн чинь бүрэн эрхийн асуудал. Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явагдана. Гишүүдийг оруулъя, Тогтохсүрэн дарга аа, гишүүдээ оруулъя. Ирц бол байна. Санал хураалт явагдана. Тогтохсүрэн дарга ирцээ бүрдүүлчих. Тэгээд санал хураалтаа явуулъя.

Эрүүл мэндийн яамныхан, Нийгмийн бодлогын байнгын хорооныхон, дээр нь энэ хуулийн ажлын хэсгийнхэн энэ асуудлаа сайтар ярь. Ингээд оруулж ирж байгаа энэ асуудал чинь санал хураалт бүр дээр ингээд маргаантай Засгийн газраас оруулж ирсэн асуудлууд чинь Байнгын хороо гишүүд ингээд санал нэгдэхгүй яваад байна шүү дээ. Тэгээд энэ чинь өөрөө энэ чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлээд явуулахад их бэрхшээл учруулаад байна. Ийм учраас энэ асуудлуудаа өнөөдөр та бүгд цэгцлэх нь зүйтэй. Өнөөдөр ажлын хэсэг сууж хуралдаад ойлголтуудаа нэгтгэ. Тэгээд маргааш өглөө санал хураалтыг явуулна. Маргааш өглөө 10 цагаас санал хураалт явуулна. Маргааш өглөө 10 цагаас санал хураалтыг үргэлжлүүлэн явуулна.

Зарим тогтоолын эцсийн найруулгыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол.

“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 92 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Энэ тогтоолыг 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлөж байна. Гишүүдэд баярлалаа.

20.01 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ